Чех улс
Гадаадын иргэдэд зориулсан
мэдээллийн нийтлэл

Праг 2011

© Чех улсын Дотоод Явдлын Яам, 2011
ISBN 978-80-7312-072-6

АГУУЛГА:

1. оршил 5
2. чех улсын тухай нийтлэг оршил 7
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 9
3. Хууль тогтоомж, гүйцэтгэх захиргаа болон шүүх, улсын захиргааны бүтэц удирдах зарчим ... 10
3. 1. Чех улсын парламент 10
3. 2. Гүйцэтгэх засаг /эрх/ 10
3. 3. Шүүх, Улсын прокурар 10
3. 4. Захиргаа албан байгууллага 11
3. 5. Чех улс дахь eGovernment 13
3. 6. Албан ёсны хэл 14
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 14
4. чу/шенгений орнуудад гадаадын иргэн оршин суух болон улсын иргэншил 16
4. 1. Гадаадын иргэд оршин суух талаархи үндсэн мэдээллүүд 16
4. 2. ЧУ/Шенгений нутаг дэвсгэрт түр оршин суух 16
4. 3. ЧУ-д байнга оршин суух 25
4. 4. Биометрийн өгөгдөлтэй оршин суух зөвшөөрлийн үнэмлэх 29
4. 5. Бусад хэрэгтэй мэдээллүүд 31
4. 6. Регистрийн дугаар 33
4. 7. Чех улсын иргэн 34
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 35
5. тусламж хэрэгтэй үед хандах газрууд 37
5. 1. Өмгөөлөгч хуульчид 37
5. 2. Нийтийн (хүний) эрхийг хамгаалагч 37
5. 3. Хэрэглэгчидийн эрхийг хамгаалах,Чехийн худалдааны байцаан шалгах газар 37
5. 4. Авилгал хээл хахууль 37
5. 5. Онцгой байдлыг шийдвэрлэх 38
5. 6. Бусад онцгой байдлуудыг шийдвэрлэх 39
6. сургуулийн систем болон боловсролыг хүлээн зөвшөөрөх 42
6. 1. Сургуулийн өмнөх боловсрол 43
6. 2. Ерөнхий эрдмийн боловсрол 44
6. 3. Дунд сургуулийн боловсрол 44
6. 4. Мэргэжлийн дээд сургуулийн боловсрол 45
6. 5. Гадаадад эзэмшсэн ерөнхий, дунд, мэргэжлийн дээд боловсролуудыг зөвшөөрөх 46
6. 6. Дээд сургууль 47
6. 7. Гадаадын дээд сургуулийн боловсрол ба мэргэшлийг хүлээн зөвшөөрөх 47
6. 8. Мэргэшсэн мэргэжлийг хүлээн зөвшөөрөх 47
6. 9. Боловсрол эзэмших бусад хэлбэрүүд: хэлний курс, чех хэлний курс болон насанд хүрэгчидийн боловсрол эзэмших 49
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 49
7. эрүүл мэндийн болон эрүүл мэндийн даатгалын систем 51
7. 1. Бүх нийтийн эрүүл мэндийн даатгал 51
7. 2. Зорчигчийн эрүүл мэндийн даатгал 53
7. 3. Заавал хийгдэх урьдчилан сэргийлэх тарилгууд 55
7. 4. ЧУ дахь эрүүл мэндийн хангамжийн байгууллагуудын систем 55
7. 5. Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон дэмжлэг үзүүлэх 56
7. 6. ЧУ дахь шалзан хорхойн тархалт 57
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 58
8. ажил хөдөлмөр эрхлэх 60
8. 1. Гадаадын иргэдийг ажиллуулах – явц 60
8. 2. Ажил хууль эрхийн харилцаа 62
8. 3. Ажилчны эрх үүрэг 63

8. 4. Ажил зуучлах болон ажиллуулахтай холбоотой бусад үйлчилгээнүүд 65
8. 5. Ажилчидын холбоо 65
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 66
9. чу-д хувиараа эрхлэх 67
9. 1. Хувиараа аж ахуй эрхлэх 67
9. 2. Худалдааны компаниуд 68
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 69
10. нийгмийн хангамж 70
10. 1. Нийгмийн хангамжийн байгууллагын удирдлага зохион байгуулалт 70
10. 2. Нийгмийн даатгал 70
10. 3. Амьжиргааны доод түвшин 75
10. 4. Улсын нийгмийн тусламж 76
10. 5. Нийгмийн тусламж 78
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 81
11. байрлах 82
11. 1. Хувийн байранд болон байшинд байрлах 82
11. 2. Хөлсний байранд байрлах 82
11. 3. Хоршооллын байранд байрлах 83
11. 4. Цахилгаан ашиглах, хог хаягдлын төлбөр болон байрны бусад үйлчилгээ 83
11. 5. Байргүй болох 83
11. 6. Бусад ашигтай мэдээллүүд 84
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 84
12. зам тээвэр 85
12. 1. Хотын тээвэр 85
12. 2. Хот хоорондийн тээвэр 85
12. 3. Жолооны эрх 85
12. 4. Гадаадын жолооны үнэмлэхийг ЧУ-ын жолооны үнэмлэхээр солих 86
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 91
13. гэр бүл, гэрлэлт, амьдралын үйл явдлууд 92
13. 1. Иргэний бүртгэл мэдээллийн товчоо түүний үйл ажиллагаа 92
13. 2. Гэрлэлт (шаардлагууд); хамтран амьдрагчидын бүртгэл (шаардлагууд) 93
13. 3. Салалт 94
13. 4. Гадаадын иргэний хүүхэд төрөх 94
13. 5. Ойр төрлийнхөний нас баралт 95
Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл 95
14. чехийн ард түмний тухай сонгомол мэдээлүүд 97
14. 1. Ярианы болон харилцааны онцлог 97
14. 2. Өдөр тутмын дэглэм 98
14. 3. Чех хоол 98
14. 4. Ёс заншил уламжлал 99
14. 5. Шашин шүтлэг 100
14. 6. Үндсэн соёлын байдал 100
15. интеграчны төвүүд 102
15. 1. Интеграчны төвүүдийн контактууд 103
16. гадаадын иргэдийн интеграчлалын хүрээнд ажиллаж байгаа төрийн бус ашигт бус байгууллагуудтай (тбаб) харьцах контактууд 106
17. захиргаа албан байгууллагуудтай харьцах контактууд 112
17. 1. Гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн байгууллага 112
17. 2. Хөдөлмөрийн товчоонууд 118
17. 3. Крайн (аймгийн) захиргаанууд 118
17. 4. Дотоод Явдлын Яамны Цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллага 118
18. бусад ашигтай мэдээлэл болон ишлэлүүд 126

1. ОРШИЛ

Таны гарт гадаадын иргэдийн интеграчлалын хүрээнд Чех улсын Дотоод Явдлын Яам бусад яамнуудтай, төрийн бус ашигт бус байгууллагуудтай хамтран хэргэжүүлж буй „Чех улс дахь гадаадын иргэдэд зориулсан мэдээллийн нийтлэлийг“ хүргэж байна. Энэ нь Европын холбооны (ЕХ), Европын холбооны хамтын аж ахуйн орнууд(ЕХАО), Швейцар зэрэг орнуудын иргэдээс бусад гуравдагч орны иргэдэд зориулагдсан. Нийтлэл нь зөвхөн ганцаарчилан олон улсын хамгаалалтанд орох өргөдөл гаргагчид болон олон улсын хамгаалалт олгогдсон иргэдэд зориулагдсан бус мөн энэхүү нийтлэлийг гадаадын иргэдтэй хамтран ажиллагчид гарын авлага болгон ашиглаж болох юм.

Нийтлэлийн хүрээ нь хязгаарлагдмал учраас ЧУ-ын талаархи өргөн дэлгэрэнгүй мэдээллийг дурьдах боломжгүй юм. Нийтлэлийн зорилго нь **Чех улсын талаархи үндсэн мэдээллүүдийг** Чех улсад интеграчны процесын хүрээнд амьдарч байгаа гуравдагч орны иргэдэд хүргэх зорилготой. Чех улсын талаархи үндсэн мэдээллүүдээс гадна захиргаа албан газруудын бүтэц байгууламж болон ажиллах зарчим, онцгой байдлыг шийдвэрлэх, сургууль боловсролын систем, эрүүл мэндийн болон нийгмийн хангамж, ажил хөдөлмөр эрхлэх, байр орон сууц, зам тээвэр гм..бусад мэдээллүүдийг дурьдсан болно. Мөн нийтлэлд гадаадын иргэдийн интеграчлалын төвүүдийн жагсаалт (интеграчны төв-15-р бүлгээс үз), гадаадын иргэдийн интеграчлалыг хариуцаж буй төрийн бус ашигт бус байгууллагуудын жагсаалтууд (16-р бүлгээс үз) агуулагдсан.

Нийтлэлийг мөн интернетийн „Мэдээллийн материалууд болон гарын авлага“ хэсгийн http://www.cizinci.cz буюу http://www.imigracniportal.cz эсвэл англи хэлээр http://www.immigrationportal.cz хуудаснуудаас татаж авч болно.

Чех хэлнээс гадна англи, украйн, орос, вьетнам, монгол хэлүүдээр танилцаж болно. Нийтлэлийг мөн бусад хүрээнд дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл болгон ашиглаж болно. Чех улс нь „21-р зууны мэдээллийн нийгэмлэг“-ийг бүтээн байгуулж байгаа учраас, бие даасан байгууллага албан газрууд ердийн мэдээллийн сувгуудаас (хэвлэмэл материалууд, шуудан, Утас:) гадна олон нийтийн өргөн хүрээт мэдээллүүдийг ашиглаж байгаа ба цаг ирэх тутамд өөрийн гэсэн хувийн интернетийн хуудастай болж байгаа нь олширч байна. Эдгээрээс сэдэв бүрийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж болно. Чухал хэрэгцээний мэдээллүүдийг Чех улсын албан байгууллагуудын ерөнхий интернетийн хаягаас мэдэж болно:

http://portal.gov.cz

Нийтлэлд дэлгэрэнгүй мэдээллийн ишлэлийг энэ тэмдэглэгээгээр тэмдэглэсэн байгаа:

Бусад бүлэг бүрд тухайн интернет хуудсыг энэ тэмдэглэгээгээр тэмдэглэсэн „►“.

Хэрэв өдөр тутамд баялаг мэдээллүүдтэй интернеттэй харьцах боломжгүй ч гэсэн түүнийг ашиглахыг аль болхоор хичээхийг зөвлөж байна, учир нь интернет нь чухал мэдээллийн ишлэл байхаас гадна мөн хувийн болон албаны ажлыг хурдан түргэн гүйцэлдүүлэх боломжтой. Хэрэв интернет дээр ажиллах мэдлэг дадлага дутагдвал интеграчны төвд болон гадаадын иргэдийн интеграчлалын асуудлыг хариуцсан төрийн бус ашигт бус байгууллагуудад хандаарай. Эхний ээлжинд клентүүдийг үнэгүй интернетээр хангах хэрэгтэй. Чех улсын бүх номын сангийн сүлжээнд үнэгүй мөн интернет кофены газрууд хямд (1 цагт 40-100корун) үнээр интернетээр хангаж байна.

Олон нийт хүн ардын амьдрал болон хууль тогтоомжууд зогсолтгүй өөрчлөгдөж байгаагаас шалтгаалж энд дурьдсан интернетийн ишлэлүүд, **нийтлэлд агуулагдсан мэдээллүүд 2011. 1. 1-ний өдрөөс эхлэсэн** гэдгийг анхааруулж байна (өөр он сар өдрийг дурьдсан тохиолдолд тухайн мэдээлэлтэй цуг бичигдсэн байх болно). Бас **энэ өдрөөс хойш өөрчлөгдсөн зарим нэгэн өөрчлөлтүүдийг нийтлэлд тэмдэглэгдээгүй** тохиолдол байж болзошгүй.

Энэхүү мэдээллийн нийтлэлийн шинж болон илгээхээс шалтгаалж зарим нэгэн хэсгүүдэд **товчлох ерөнхийжүүлэх** зэрэг үйлдлүүд хийгдсэн. Мөн хуулиар хамгаалагдсан хэсгүүдийн байр суурийг эзлүүлэх боломжгүй. Тэгхээр энэхүү нийтлэлийг хууль тогтоомжийг орлуулж болохгүй ба **албан ёсны хууль тогтоомжийн ишлэл нь хүчин төгөлдөр буй хуулийн эмхтгэлүүд юм**. Хэрэв энэхүү нийтлэлийн аль нэгэн сэдвийг дэлгэрэнгүй болон тодорхой тайлбарлуулхыг хүсвэл таны асуудлыг шийдвэрлэж байгаа холбогдох байгууллагатай харьцаарай. Мөн гадаадын иргэдийн интеграчлалыг хариуцсан интеграчны төв болон төрийн бус ашигт бус байгууллагуудын үйлчилгээг ашиглаж болно. **Интеграчны төв болон Төрийн бус ашигт бус байгууллагууд нь өөрсдийнхөө клентүүдэд Чех улсад тохиолдож болзошгүй асуудалтай тулгарсан тохиолдолд тэдэнд үнэгүйгээр, халуун сэтгэлээр туслах болно**.

Энэ бүлгийн нийтлэл нь үндсэн болон нийтийн танил баримтын шинж тэмдэгтэй гэдгийг зайлшгүй авчрах буюу илэрхийлж байна. Харин Чех улсад соёлын хол зөрөлдөөнтэй улс орны иргэд ирж байгаа нь энэхүү үндсэн зүйлүүдийг ойлгоход хүндрэлтэй байж болзошгүй гэдгийг ухаарах хэрэгтэй. Бичиглэл нь ерөнхийдөө дундыг барьсан түгээмэл шинж чанартай. Тэгхээр хэлний болон соёлын талаар хамгаалалттай тодорхой бүлэг гадаадын иргэд хэрэглэх боломжгүй юм.

Чехийн ард түмний дунд хоёр дахь нутгаа болгон түр зуурын болон байнга оршин сууж буй интеграчлалын олон гадаадын иргэд нь шинэ мэдлэг эзэмшиж, чех хэлийг сурч амьдарлын үндсэн асуудлуудыг шийдвэрлэх болон албан газруудад, энгийн хүн ардын дунд ойлголцож тэдэнтэй харьцах зэрэг нь хүнд бэрхшээлтэй даалгавар гэдгийг бид бүрэн ойлгож байна. Энэхүү нийтлэл нь чехийн ард түмний дунд орох хүчитгэсэн интеграчлалтай хамт амьдралын үр ашигтай туслагч байх болно гэдэгт бид бүрэн найдаж байна.

2. ЧЕХ УЛСЫН ТУХАЙ НИЙТЛЭГ ОРШИЛ

- **Улсын албан ёсны нэр:** Чех улс (товчилсон ЧР /ČR/, олон улсын код СЗЭ /CZE/); товчилсон хэллэг Чех /Česko/

- **Албаны хэл:** чех хэл

- **Хүн ам:** ойролцоогоор 10 сая хүн амтай
  Ихэнх хүн амын (ойролцоогоор 60 %) шашин шүтдэггүй, хүн амын ойролцоогоор 30 % ямар нэгэн шашин шүтдэг. Уламжлалт шашин Хрисотос шашин. Ихэнх нь Ром католик шашин шүтэх байдалтай.
  Хүн амын баргалж 95 % чех үндэстэн, бусад нь Болгар, Хорват, Унгар, Герман, Польш, Румын, Русин (под карпатын орос), Орос, Грек, Словак, Серб, Украйн болон бусад үндэстэнгүүд.

- **Улсын зохион байгуулалт:** улс, ардчилсан парламент
  Гүйцэтгэх засаг /эрх/ ерөнхийлөгч болон засгийн газрыг сонгоно, Чех улсын хоёр танхимтай хууль эрхийн Парламент (бүтэц нь Их хурлын төлөөлөгчид болон Сенат).

- **Мөнгөн тэмдэгт:** Чех корун (Kč, CZK)
  Нэг корун (1 Kč) 100 халер. Төмөр мөнгөн тэмдэгтүүд нь 1 корун, 2 корун, 5 корун, 10 корун, 20 корун, 50 корун, дэвсгэртүүд нь 100 корун, 200 корун, 500 корун, 1 000 корун, 2 000 корун, 5 000 корун (2011. 4. 1-нээс).
  Коруны ханш–КОРУН/ЕВРО 25,27; КОРУН/АМ ДОЛЛАР19,17 (2010 оны).

- **Газар нутаг:** Чех улс нь төв Европд оршдог, 3 түүхэн газар нутагтай – Чех (баруун хэсэг; заримдаа Бохемиа гэж нэрлэж магадгүй), Морав (зүүн хэсэг), Чех Слезск (зүүн хойд хэсэг). 4 улстай хиллэнэ: баруун талаараа Герман, хойд талаара Польш, зүүн талаараа Словак урд талаараа Австри улсуудтай.
  Чехын газар нутаг нь хоёр уулсуудын бүлгийн дунд оршино. Баруун ба төв хэсэгт Чех Высочина, нутгийн зүүн хэсэг Баруун Карпатын уулсууд хүрсэн. Том голууд Лабэ, Влтава голууд, Моравт Морава, Дыий голууд, Слезск-д Одра, Опава голууд.

- **Засаг захиргааны нэгж:** өөртөө засан захирах 14 krай (аймаг) буюу хоттой (суурин, итгэмжлэгдсэн захиргаатай болон салбар захиргаатай суурин).

- **Нийслэл хот:** Праг (Praha) (хамгийн том хот – ойрлцоогоор 1 сая хүн амтай)
  Чех улсын төв хэсэгт Влтава голын эрэг дээр оршдог. Хотын төвийн түүхэн хэсэг олон улсын түүх дурсгалын хамгаалалт УНЕСКО (UNESCO)-д тэмдэглэгдсэн.

- **Бусад том хотууд**: Брно (Brno) (Чех улсын хоёр дахь том хот, Моравын түүхэн нийслэл; уг хот нь олон тооны байгууллага институттэй, жнь: Захиргааны шүүх), Острава (Ostrava), Плзень (Plzeň), Оломоуц (Olomouc), Ческэ Будеиовицэ (České Budějovice) гэх мэт.

- **Цагийн бүс:** УТЦ /UTC/ (Дэлхий нийтийн цаг) + 1 цаг (зун + 2 цаг)

- **Улсын болон бусад баярууд:**
  Улсын болон бусад баярууд ажлын өдөртэй давхцах тохиолдол байдаг (энэ өдрүүдэд зөвхөн онцгой тохиолдолд л ажиллана).

  <u>Улсын баярууд:</u>
  1 сарын 1-ний өдөр – Чех улсын тусгаар тогтонол
  5 сарын 8-ны өдөр – Ялатын баяр (1945)
  7 сарын 5-ны өдөр – Слованчуудын Цырил /Cyrila/, Методе /Metoděje/-ын өдөр
  7 сарын 6-ны өдөр – Мистр Ян Хус /Jan Hus/-ыг шатаасан өдөр (1415)
  9 сарын 28-ны өдөр – Чех улс байгуулагдсан өдөр
  10 сарын 28-ны өдөр – Чехословак улсын тусгаар тогтнол (1918)
  11 сарын 17-ны өдөр – Эрх чөлөө ардчиллын тэмцлийн өдөр (1989)

Бусад баярууд:
1 сарын 1-ний өдөр – Шинэ жил
Улаан өндөгний баяр, даваа гариг – хавар болдог тогтоосон өдөргүй
5 сарын 1-ний өдөр – Хөдөлмөрийн баяр
12 сарын 24-ний өдөр – Өглөгийн өдөр (Хиростосын мэндэлсэн өдөр)
12 сарын 25-ны өдөр – Зул сарын баяр (Хиростосын мэндэлсэн баяр)
12 сарын 26-ны өдөр – Зул сарын баяр (Хиростосын мэндэлсэн баяр)

• **Товч түүх:**

Түүхэнд тэмдэглэгдсэн хамгийн эртний оршин суугчид энд 4-р зууны эхэн үед Келтүүд байсан. 6-р зуунаас эхлэн словен үндэстэнгүүд сууршиж эхлэсэн, тэд 7-р зуунд Самын хэмээх эзэнт гүрнийг байгуулсан. 820 оноос хойш одоогийн улсын газар нутгийн зарим хэсгүүдийг үүсгэн тогтоосон, анхны улсын шинж чанартайгаар Их Молравын (Velkomoravská) эзэнт гүрнийг байгуулсан, энэ газар нутгийн Христос шашинтангууд үүнтэй холбоотой байсан. Энэ гүрнийг мөхсний дараа 10-р зууны эхээр Чех рүү улсын чанар шилжиж ирсэн. 995 онд Пршемыслов (Přemyslovci) овгийн ван Чех улсыг нэгтгэсэн.

12-р зууны дунд үеээс эхлэн Германы клончлогчидын дэмжлэг түрэлтээр аж ахуй соёлын эрчимтэй хөгжил эхлэсэн. 13-р, 14-р зуунуудад Чех улс нь дотоод байдлаа бэхжүүлж, аж ахуйгаа хүчитгэн өөрийнхөө түүхэнд газар нутагтаа хөгжлийн хамгийн дээд үед хүрсэн. Боловсролын хөгжлийн баримт нь 1348 онд крал /хаан/ IV Карел Праг-д их сургууль байгуулсан (өнөөгийн Карлын их сургууль /Universita Karlova/).

Бүх Европ-д бас Чехэд их хямрал үүсэж Чех улсын дотоодод 13-14-р зууны шилжилтээр шашны шинэчлэлийн төлөө Хусист хөдөлгөөн үүсэж улам даамжирсаар ард түмний зэвсэгт тулаанд хүргэсэн-Хусистын дайн. Дундад зуунаас хойш гол түүхэн газар нутгийн хил хязгаарт баргалж өөрчлөлт ороогүй, Чех улсад харьяалагдаж байсан бусад газар нутаг зөвхөн цаг зуурын хугацаатай байсан. 1526 оноос эхлэн Чехийн газар нутаг Хабсбуркын эзэнт засаглалд орсон. Эзэнт засаглал мөхсний дараа дэлхийн I дайны нөлөөгөөр 1918 онд түүхэн чехийн газар нутаг (Чех, Морава, Слезско) тэр үеийн Унгарын хаант засаглалын хэсэгтэй (Словак, Под Карпатын орос) холбогдон Австри-Унгарын гүрнээс тасарч Чехословак улс үүссэн (анхны ерөнхийлөгч Т. Г. Масарыка /T. G. Masaryka/).

1939. 9. 29-ний Мниховын гэрээгээр Чехийн хил хязгаарыг Фашистын Германууд эзлэсэн (үүнд Чехословак улсын нутаг дэвсгэрт Германы бага үндэстэнгүүд зүйг баримтлалгүй нэвтрэн орж сууршисан нь дэмжлэг болсон), дараа нь 1939. 3. 15-нд үлдсэн газар нутгийг эзлэн авч Чех, Морава хараат улс гэж зарласан.

Словакыг Фашистын Германы дагуул болгон бие даасан Словак улс гэж зарласан. 1945 онд дэлхийн хоёр дугаар дайн дуусаны дараа дахин Чехословак улсыг сэргээсэн (Подкарпатын Оросгүйгээр) ба мөн зохион байгуулалттай шилжин сууршисан гурван сая Германы бага үндэстэнгүүдийг хөөн гаргасан.

1948 онд комунист нам төрийн эргэлт хийж дэг журмаа тогтоосон. Жараад оны үеэр комунист дэглэмийн эсрэг эсэргүүцэл гарсныг 1968 оны найман сард ЗХУ болон бусад Варшавын гэрээний орнуудын цэргийн хүчээр зогсоосон.

1989 оны арван нэгэн сард комунист дэглэм унаж („саметын хувьсгал“ гэж нэрлэгдсэн) олон ургалч ардчиллыг сэргээх боломж гарч ирсэн. 1989 оны арван хоёр сард 1948 оноос хойшхи анхны комунист бус ерөнхийлөгчөөр Харта 77 хөдөлгөөнийг үндэслэгч Вацлав Хавел сонгогдсон. Дараагийн жилүүдэд зөвлөлтийн цэргүүд гарч улсын дотоодод ардчилсан шинэчиллүүд эхлэсэн.

1992 оны сүүлээр Чех, Словакын холбооны улсын хооронд хэлэлцээр болж хоёр тусдаа бие даасан улсууд болцгоосон. 1993 оны 1 сарын 1-нээс холбооны улсаас салж бие даасан Чех улс болж, 1999 оны гурван сарын 12-нд НАТО-гийн орны гишүүнээр элсэж, 2004 оны таван сарын 1-нд Европын холбоонд элссэн. 2007 оны арван хоёр сарын 21-нээс Чех улс нь Шенгений бүсэд харьяалагдаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- Чехийн статистикын байгууллага (Чех улсын нийгмийн, эдийн засгийн, экологийн хөгжлийн талаархи өргөн хүрээтэй статискын мэдээллүүдийг цуглуулж, боловсруулж эдгээр мэдээллүүдээр хангана) – http://www.czso.cz
- Чех улс дахь хот суурин – http://epusa.cz/
- Олон нийтийн мэдээллийн портал (Чех улс дахь улсын захиргаа, бие даасан захиргаануудын дэлгэрэнгүй хаяг, хууль тогтоомж, амьдарлын байдал, интернетээр харьцах, гадаадын иргэдэд зориулсан мэдээллүүд– ► /Cizinec/ Гадаадын иргэн) – http://portal.gov.cz/

3. Хууль тогтоомж, гүйцэтгэх захиргаа болон шүүх, улсын захиргааны бүтэц удирдах зарчим

„Засгийн эрхийг зөвхөн гаргасан хуулийн дагуу ба тухайн тогтоосон хуулиар ашиглана“.
(үндсэн эрх болон эрх чөлөө 2-р хуудас 2- догол мөр)

3. 1. Чех улсын парламент

Хууль тогтоомжийн засаглал – засаглал нь Чех улсад хуулийн санал дэвшүүлэх болон хүлээж авна – Улсын их хурал, Сенат гэсэн хоёр танхимтай Парламенттай. Их хурлын төлөөлөгчидийн болон Сенатын хуралдаан нь ихэвчлэн нээлттэй болдог. Чех улсын Парламентын хүлээн авсан хуулиуд нь Хуулийн эмхтгэлд олон нийтэд хэвлэгдсэн байна.

➢ **Их хурал (доод танхим)**

Их хурлаар хуулийн талаар санал дэвшүүлэх, хэлэлцэх, батлах зэрэг хэлэлцээрүүдийг хийнэ, дараа нь Сенат; оролцож засгийн газрыг шийдвэрлэнэ, улсын ерөнхийлөгчийг сонгоно. Их хурал нь 200 төлөөлөгчидтэй, 4 жилээр сонгогдоно. Сонгууль нь нууц байдлаар саналыг авч олон нийтийн, тэгш эрхээр шууд сонгуулийн эрхээр явагдана.

Их хурлын төлөөлөгчид нь дараахь намуудаас сонгогдсон: Иргэний ардчилсан нам (ODS), Чехийн социал демократ нам (ČSSD), Чех, Моравын Комунист нам (KSČM), Нийтийн үйлс / Věci veřejné /(VV) а ТОП 09 (2011 нэг сарын 1-ний байдлаар).

➢ **Сенат (дээд танхим)**

Сенат Их хурлын оруулсан хуулийг авч хэлэлцэнэ. Сенат 81 гишүүнтэй, 6 жилээр сонгогдоно (хоёр жил тутамд гуравны нэг хувь гишүүд нь сонгогдоно). Сонгууль нь нууц байдлаар саналыг авч олон нийтийн, тэгш эрхээр шууд сонгуулийн эрхээр явагдана.

Чех улсын хуулийн үндэслэл нь ЧУ-ын үндсэн хууль юм.

3. 2. Гүйцэтгэх засаг /эрх/

➢ **Ерөнхийлөгч**

Чех улсын ерөнхийлөгч нь улсын удирдагч. Парламентаар 5 жил тутамд сонгогддог. Одоогийн байдлаар ерөнхийлөгчийн сонгуулийг шууд ард түмнээр сонгуулах талаар яригдаж байна (дараагийн сонгуулиас эхлэн 2013 оноос). Түүний эрхүүдэд бас засгийн газрыг сонгох, хуулинд гарын үсэг зурах, олон улсын хэлэлцээрт оролцох болон авч хэлэлцэх, сонгуулийг зарлах, өршөөл хэлтрүүлэл үзүүлэх зэрэг багтана.

➢ **Засгийн газар**

Засгийн газар нь гүйцэтгэх засгийн хамгийн дээд байгууллага юм. Засгийн газрын тэргүүлэгч, засгийн газрын орлогч дарга, сайдууд зэргээс бүрдэх ба эдгээр нь ерөнхийлөгчийг сонгоно. Засгийн газар нь бүхэлдээ улсыг удирдах, хууль тогтоох, улсын апаратын үйл ажиллагааг удирдах, хууль хэрэгжүүлэх болон түүний дагуу тушаал гаргах зэргийг хариуцаж байдаг. Засгийн газар нь Их хурлын төлөөлөгчид Засгийн газрын итгэлгүй байдлыг зарлахад түүний хариуцлагыг хүлээнэ.Засгийн газрын эвсэл холбоо нь 2010 оны долоон сарын 13-наас Иргэний ардчилсан нам (ODS), ТОП 09, Нийтийн үйлс (VV). зэрэг намуудаас бүрдэж байна.

3. 3. Шүүх, Улсын прокурар

„Хуулинд өөрөөр заагаагүй бол нийтийн захиргаа байгууллагаар эрхийг дутуу шийдвэрлэсэн тохиолдолд хуулийг шинжлэн судлахыг шүүхэд хандаж болно.Эрх зүйн үүднээс шүүх нь албан бичигт бичигдсэн үндсэн эрх болон эрх чөлөө хөндөгдсөн эсэх шийдвэрийг шинжлэн шалгаж үзхийг татгалзаж болохгүй.“ (үндсэн эрх болон эрх чөлөө 2-р хуудас 36-р догол мөр)

Шүүх

Шүүх нь хүний эрхийг хамгийн чухал баталгаагаар хамгаалсан байдаг. Хотын шүүхүүд иргэний хэргийг хариуцдаг (худалдааны, гэр бүлийн, өвлөх), эрүүгийн болон албан ёсны арга хэмжээний асуудлыг шүүх хэрэг зөрчил гаргасан тохиолдолд шийднэ.

Шүүхийн гол баримтлал нь улсад захирагдахгүй. Шүүхийг Шүүх яамнаас хариуцаж байдаг ба харин шүүхийн шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцож болохгүй. Шүүх нь шүүгдэлцэж байгаа хоёр этгээдийн нэг нь улсын байгууллага жнь: шүүхийн удирдах газар байх жишээтэй асуудлуудыг ч хүртэл шийдвэрлэнэ.

Шүүхийн шийдвэрийн эсрэг уг шийдвэр гаргасан шүүхийн дээд зэрэглэлийн шүүхэд ихэвчлэн давж заалдаж болно. Хотын шүүхийн бүлэгт Дээд шүүх, Захиргааны дээд шүүх, Крайскы / аймгийн/, Окресний /сумын/ шүүхүүд багтана. Ихэвчлэн анхан шатны асуудлыг Окресний шүүх шийдвэрлэнэ.

Шүүгчидийг хугацааны хязгааргүйгээр улсын ерөнхийлөгч сонгоно.

➢ **Захиргааны шүүх**

Захиргааны шүүх нь хотын шүүхийн бүлэгт хамаарахгүй, ба энэ нь албан байгууллагуудын хэргийг шиийднэ. Хуулийг болон түүний зарим хэсгийг, байгууллагуудын гомдол саналыг, байгууллагын зүгээс шалтгаалан эрх хөндөгдсөн, бүхий л хуулийн эрхийг эдлэх эрх бүхий хувь хүний асуудлуудыг, Үндсэн эрх болон эрх чөлөөний бичиг, Чех улсын бусад захиргааны хуулийн дагуу (гомдол гаргсан этгээд заавал хуульчаар төлөөлүүлэн шүүхийн үйл ажиллагаанд оролцоно) шийдвэрлэнэ.

➢ **Улсын прокурор**

Улсын прокурорын үүрэг нь улсыг төлөөлөн олон нийтийн эрх ашгийн үүднээс:

– улсын нэрийн өмнөөс хэрэгтэн этгээдийг хэрэгт татах, мөн улсыг төлөөлөн шүүхийн үйл ажиллагаанд оролцоно,

– эрүүгийн хэргийг илрүүлэх буюу мөрдөн байцааж байгаа цагдаагийн

болон мөрдөн байцаах байгууллагагуудын үйл ажиллагаанд хяналт тавих,

– хорих газруудын үйл ажиллагаанд хяналт тавих (шорон, засан хүмүүжүүлэх газар гм...).

Улсын прокурор нь бие даасан байгууллага бус, Шүүх яамны удирдлаганд байдаг. Улсын прокурорын байршил нь шүүхийн байршилтай адил байна.

3. 4. Захиргаа албан байгууллага

Захиргаа албан байгууллага нь улсын болон бусад байгууллагуудаар дамжуулан олон нийтийн эрх ашгийн үүднээс үйл ажиллагаа явуулдаг. Улс нь өөрийнхөө эрхийг өөрийнхөө гүйцэтгэх байгууллагуудад итгэмжлэн өгч тодорхой олон нийтийн асуудлуудыг захиргааны үйл ажиллагаар гүйцэтгэнэ (**улсын захиргааны** тухай). Өөр олон нийтийн эрх ашгийн асуудлуудыг бие даасан байгууллагад итгэмжлэн даалгана (**өөртөө засах захиргаа).**

➢ **Улсын захиргаа**

Улсын захиргааны байгууллагын төв нь (Чех улсын үндсэн хууль нь захиргааны төв байгууллагуудыг тогтоодог) яамнууд юм. Улсын захиргааны орон нутгийн байгууллагууд нь жнь: хөдөлмөрийн товчоо, санхүүгийн байгууллага зэрэг юм. Онцгой чухал улсын захиргааг **край /аймаг/** (карйн /аймгийн/ захиргаагаар дамжуулан) мөн **хот суурин** (хот суурингийн захиргаагаар дамжуулан) гүйцэтгэдэг. Улсын захиргааны гүйцэтгэх хүрээнд мөн өргөн хүрээний эрхэт хот суурин мөн өөрийн салбар итгэмжилсэн захиргаатай хот суурин багтана.

➢ **Өөртөө засах захиргаа**

Хот суурин

Хот суурин нь иргэдийн орон нутгийн үндсэн өөртөө засах захиргаа юм.

Хот суурингийн бүрэлдхүүн нь:

– хотын төлөөлөгч (хот суурингийн өөртөө засах нөлөөний хүрээнд хамгийн чухал эрхийг гүйцэтгэдэг хамгийн дээд байгууллага),

– хотын зөвлөх (гүйцэтгэх байгууллага),

– хотын дарга,
– хотын захиргаа,
– бусад асуудлыг шийдвэрлэдэг тусгай байгууллага.

Край /аймаг/
Чех улс нь 14 крайтай. Нийслэл Прага нь крайд мөн хотод тооцогдоно.

Край /аймаг/	**Төв**	**Край /аймаг/**	**Төв**
Нийслэл хот Прага Hlavní město Praha	Прага Praha	Оломоуцын Olomoucký	Оломоуц Olomouc
Өмнөд чехийн Jihočeský	Ческэ Будеиовицэ České Budějovice	Пардубицын Pardubický	Пардубицэ Pardubice
Өмнөд Моравын Jihomoravský	Брно Brno	Плзений Plzeňský	Плзень Plzeň
Карловарын Karlovarský	Карловы Вары Karlovy Vary	Төв Чехийн Středočeský	Прага Praha
Краловехрадецкы Královehradecký	Храдец Кралове Hradec Králové	Устын Ústecký	Усти над Лабем Ústí nad Labem
Либерецийн Liberecký	Либерец Liberec	Высочины Vysočina	Ийхлава Jihlava
Моравскослезскы Moravskoslezský	Острава Ostrava	Злиний Zlínský	Злин Zlín

Крайн /аймгийн/ бүрэлдхүүн нь:
– крайн төлөөлөгч (крайн дотоод асуудлыг шийдвэрлэдэг хамгийн дээд байгууллага),
– крайн зөвлөх (гүйцэтгэх байгууллага),
– хеитман /hejtman/,
– kарайн захиргаа,
– бусад асуудлыг шийдвэрлэдэг тусгай байгууллага.

Праг нийслэл хотын бүрэлдхүүн нь:
– Нийслэл хот Прагийн төлөөлөгч,
– Нийслэл хот Прагийн зөвлөх,
– Нийслэл хот Прагийн захирагч,
– Нийслэл хот Прагийн захиргаа,
– Нийслэл хот Прагийн тусгай байгууллага,
– Нийслэл хот Прагийн Хотын цагдаа.

3. 5. Чех улс дахь eGovernment

Албан байгууллагын цахим мэдээллийн хөгжил дэвшилийн- eGovernment – нь удаан хугацааны, үе шаттай процес ба түүний зорилго нь албан байгууллага захиргааны үйлчилгээг чанаржуулж, олон нийтийн захиргааны нөлөөг дээшлүүлж олон нийтэд хүргэх зорилготой. Цахим харилцааны шинэ боломжийг ашиглах нь зөвхөн албан байгууллагын мэдээллийг хүлээн авхыг хялбарчлаад зогсохгүй мөн албан байгууллагатай интернетээр дамжуулан харьцах боломжтой.

Гадаадын иргэдэд зориулсан албан байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг албан байгууллагын Порталын хуудаснаас мэдэж болно-http://portal.gov.cz/ (► /Cizinec/Гадаадын иргэн). Энэхүү ишлэл нь зарим хэсэг нь англи хэлээр, Чех улсад оршин суухыг сонирхож буй гадаадын иргэдэд зориулсан үндсэн мэдээллийг агуулсан болно. Ишлэл нь бас дэлгэрэнгүй мэдээлэлтэй албан байгууллагын төв байгууллагын ишлэлийн жагсаалтыг агуулсан болно.

Чех улсын албан байгууллагын үйл ажиллагааны талаархи бүхий л чухал мэдээллүүдийг түүний вэбийн хуудаснаас олж болно. Шуурхай жагсаалтыг http://portal.gov.cz/ (► /Adresář/Хаяг), эсвэл албан байгууллагын цахим порталын хуудас ePUSA - http://www.epusa.cz, энэ хуудсанд Чех улсын бүх крайн, хотын болон суурингийн захиргаануудын ишлэлийг дэс дараалан жагсаасан байгаа.

Байгууллага бүр өөрийн вэбийн хуудсандаа „энгийн“ болон цахим харилцаандаа өөрсдийнхөө харьцах мэдээллийг нийтлэсэн байгаа. Энэ нь интернетээр байгууллагатай харьцаж (алсаас харьцах) болох ба жнь: Чех улсаас өөр улсад байгаа тохиолдолд.

Байгууллага бүрийн вэбийн хуудас цахим албаны самбар хэмээгчийг агуулсан байх ба үүнд шуурхай чухал мэдээллүүд, магадгүй зарим тохиолдолд гадаадын иргэдэд зориулсан баталгаат албан захиа илгээсэн талаархи мэдээлэл зэргүүд нийтлэгдсэн байна (Олон нийтийн зарлал - ... нь хүрэлцэн ирж албан бичиг хүлээн авна уу), жишээ үз. http://www.mvcr.cz.

eGovernment үйлчилгээний хөгжил дэвшил нь хэд хэдэн салбарт чиглэсэн. Гол чиглэл нь албан байгууллагатай интернетээр харьцах боломж ба 300/2008 тоот цахим үйлдлээр бичиг баримтыг ажилбар болгох хууль. Энэ хууль нь 2009. 7. 1-нээс эхлэн үйлчилж байгаа ба цахим бичиг баримт болон хуудсан бичиг баримтуудын адил тэгш байдлыг тогтоож, тэднийг төрөл бүрийн албан байгууллагуудтай хэлцэл хийх боломжийг олгож байна. Мөн хууль нь энгийн хуудсан бичиг баримтаас цахим бичиг баримтанд шилжүүлэн хэрэглэж, цахим хэлбэрээр албан газарт хүргэх боломжийг олгосон. Баталгаатай, аюулгүйгээр албан газартай харьцхад мэдээллийн агуулагч хэмээхийг суулгасан. Бичиг баримтыг мэдээллийн агуулагч руу илгээснээс хойш 10 хоногийн дараа түүнийг хүлээн авснаар тооцно гэж заасан (фикцэ /fikce/).

Албан байгууллагатай харьцах шалтгаан гарсан тохиолдолд Czech POINT үйлчилгээг ашиглаж болно. Энэ нь доорхи байдлаар тэмдэглэгдсэн (лого):

Czech POINT-нь Чех улсын албан байгууллагуудтай харьцуулах үйлчилгээний газар юм. Czech POINT-нь хотын болон суурингийн захиргааанд, холбоонд, Аж ахуйн танхимын албан конторт, зарим нэгэн нотратын газар, гадаадад буй Чех улсын төлөөний газруудад байна. Czech POINT-ын байгаа газруудын жагсаалтыг энэ хуудаснаас олж болно http://www.czechpoint.cz (► /Kontakty/Контактууд).

Энэ үйлчилгээ олон тооны үйлчилгээгээр хангана. Хамгийн их хэрэглэж байгаа нь гэмт хэргийн бүртгэл, үл хөдлөх хөрөнгө катастрын, худалдааны бүртгэлүүд болно. Эдгээр үйлчилгээнүүдээс гадна аж ахуйн хуулийн (72-р зүйл) дагуу энд мөн өгч, илгээж болно. Энгийн хуудсан бичгээс цахим хэлбэрт шилжүүлэн эсвэл цахим хэлбэрээс бичгэн хуудсанд шилжүүлэн илгээж болох шинэ боломжууд байна.

Czech POINT –ын хангах үйлчилгээнүүд (2009. 7. 1-нээс):

- **Үл хөдлөх хөрөнгө катастрын бүртгэлийн ишлэл**
- **Худалдааны бүртгэлийн ишлэл**
- **Хувиараа аж ахуй эрхлэгчин бүртгэлийн ишлэл**
- **Гэмт хэргийн бүртгэлийн ишлэл**
- **Хувиараа аж ахуй эрхлэгчидийн хуулийн дагуу илгээх (72-р зүйл)**
- **124/2008 Sb тоот хуулийн дагуу гэмт хэргийн бүртгэлийн ишлэл болон хуулбар авах өргөдөл**
- **Жолоочийн онооны үнэлгээний ишлэл**
- **Мэрэгшсэн нийлүүлүүлэгч байгууллагын нэрсийн жагсаалт**
- **ISOH хуучин машиныг устгах бүртгэлд бүртгүүлэх**
- **Дампуурлын бүртгэлийн ишлэл**
- **Зохиогдсон баримт бичигний хэлцэл болон мэдээлэл агуулагч (300/2008 Sb. тоот хуулийн дагуу)**
- **Czech POINT E-SHOP – ишлэл бичгийг холбоогоор**

Czech POINT үйлчилгээ нь зогсолтгүй өрөгжиж байгаа ба түүний танилцуулгын жагсаалт нь http://www.czechpoint.cz. хаягт байна. Czech POINT үйлчилгээг интернетээр өөрийн сонгосон газраас сонгосон үйлчилгээр үйлчлүүлж ашиглах боломжтой.

eGovernment хүрээнд мөн үндсэн бүртгэлийн төсөл 2012 оны 7 сарын 1-нээс эхлэн явагдах ба энэ нь Чех улсад амьдарч худалдаа, хувийн үйлдвэрлэл аж ахуй эрхлэж буй хүмүүсийн, оршин сууж буй газрын мэдээлэл (хаяг, үл хөдлөх хөрөнгө катастрын бүртгэл), Чех улсын хуульчлал зэргүүдийг агуулсан мэдээлэлтэй танилцах боломжтой. Энэхүү бүртгэл нь бүртгэлийн үндсэн мэдээллүүдийг агуулсан байх ба мөн албан байгууллагын нийтийн мэдээлэлд байх учраас албан байгууллагаас дахин давтан тухайн мэдээллүүдийг өгхийг шаардах явдалгүй болно.

Дижитал газрын зураг төсөл нь Чех улсын газрын зурган дээр үндэслэн тухайн газрыг хайж олно http://www.mvcr.cz/clanek/digitalni-mapa-verejne-spravy.aspx. хаягт үз

Төсөл тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг энэ хаягаас үзнэ http://www.egoncentrum.cz.

3. 6. Албан ёсны хэл

Чех улсад албан ёсны хэл нь Чех хэл юм. Албан газар захиргаанууд шаардсан тохиолдолд бүхий л гадаад хэлээр бичигдсэн бичиг баримтын эх хувиас Чех хэлэнд албан ёсны бичгэн орчуулга хийгдсэн байх шаардлагатай. Хэрэв албан газруудтай хэлцэл хийх үедээ хангалттай сайн ойлголцохгүй гэсэн тохиолдолд албан ёсны орчуулагч авах эрхтэй ба зарим үед түүний зардлыг өөрөө төлнө (зарим үед гэдэг нь жнь: заавал орлцох үүрэгтэй захиргааны үйл ажиллагаа--зөрчилийн үйл ажиллагаа болон бусад захиргааны арга хэмжээнүүд).

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- Чех улсад буй гадаадын иргэдэд зориулсан үндсэн мэдээллүд http://www.mvcr.cz/sluzby-pro-verejnost-informace-pro-cizince.aspx
- Цагаачлалын газар дахь асуудлууд http://www.mvcr.cz/o-nas-azyl-a-migrace.aspx
- Албан газруудын төв байгууллагын ишлэлтэй гадаадын иргэдэд зориулсан мэдээллүүд (Чех, Англи хэлээр) **Албан газруудын портал** http://portal.gov.cz/ (► Гадаадын иргэн /Cizinec/)
- Албан газруудын жагсаалт http://portal.gov.cz/

- Чех улсын крайн /аймгийн/, хотын, суурингийн захиргаануудын портал болон ишлэл http://www.epusa.cz/
- Гадаадын иргэнд албан ёсны баталгаат бичиг ирсэн тухай мэдээ (Олон нийтийн зар - та…...…… нь хүрэлцэн ирж албан бичиг хүлээн авна уу) http://www.mvcr.cz/
- Czech POINT-той харьцах газрын мэдээ http://www.czechpoint.cz (► /Kontakty/ Контакт)
- Албан газруудын дижитал газрын зураг – төслийн талаархи мэдээлэл http://www.mvcr.cz/clanek/digitalni-mapa-verejne-spravy.aspx
- Төсөл тус бүрийн мэдээлэл http://www.egoncentrum.cz
- Улсын их хурал, төлөөлөгчид, Их хурлын баримт бичгүүд хуулийн хамт гэх мэтийн дэлгэрэнгүй мэдээллүүд болон үйлажиллагааг Чех улын парламентбн их хурлын интернетийн хуудаснаас олж болно– http://www.psp.cz
- Чех улсад бүртгэлтэй улс төрийн намууд болон хөдөлгөөнийг энэ хаягнаас http://www.mvcr.cz (► Олон нийтэд зориулсан үйлчилгээ /Služby pro veřejnost/ ► Улс төрийн намуудын жагсаалт /Seznam politických stran/)
- Сенат, түүний байгууллагууд, үйл ажиллагаа, баримт бичиг зэргийн дэлгэрэнгүй мэдээллийг энэ хаягт – http://www.senat.cz
- Чех улсын ерөнхийлөгчийн интернет хуудаснаас ерөнхийлөгчийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг – http://www.hrad.cz
- Засгийн газрын интернет хуудаснаас засгийн газрын үйл ажиллагаа, яам тус бүрийн интернет хуудсуудын ишлэл – http://www.vlada.cz
- Хуулийн бичиг, олон улсын гэрээ http://portal.gov.cz (► Хуулиуд/Zákony/)
- Шүүх яамны интернет хуудаснаас шүүх тус бүрийн ишлэлийг – http://www.justice.cz (► Шүүх /Soudy/)
- Байгууллагын шүүхийн дэлгэрэнгүй мэдээллүүд болон үйл ажиллагааг http://www.concourt.cz
- Шүүх яамны интернет хуудаснаас Улсын прокурор тус бүрийн дэлгэрэнгүй ишлэлийг – http://www.justice.cz (► Улсын прокурор/Státní zastupitelství/)
- Суурин (хотуудын) нэрсийн жагсаалтыг http://epusa.cz
- Хэрэв тодорхой суурин эсвэл хот хайвал энэ хуудаснаас http://epusa.cz
- Край (аймаг) тус бүрийн мэдээллүүдийг энэ хуудаснаас http://www.kr-urady.cz
- Шүүх яамны интернет хуудаснаас крайн шүүхэд бртгэгдсэн албан ёсны орчуулагч нарын жагсаалтыг – http://www.justice.cz (► Бусад /Ostatní/ ► Шинчээчид болон орчуулагчид /Znalci a tlumočníci/)
- Албан газрын порталаас албан газар тус бүрийн байрлалт, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллүдийг – http://portal.gov.cz (► Хаяг /Adresář/) эсвэл http://www.statnisprava.cz энэ интенет хуудаснаас
- Czech POINT-ын байрлалт бололн үйлчилгээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг (3-р, 5-р бүлэгт үз) http://www.czechpoint.cz
- Гадаадын иргэд ажиллах дэлгэрэнгүй мэдээллүүдийг http://portal.mpsv.cz/sz/zahr_zam

4. ЧУ/ШЕНГЕНИЙ ОРНУУДАД ГАДААДЫН ИРГЭН ОРШИН СУУХ БОЛОН УЛСЫН ИРГЭНШИЛ

4. 1. Гадаадын иргэд оршин суух талаархи үндсэн мэдээллүүд

Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд оршин суух талаар Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд оршин суух тухай 326/1999 тоот хуулиар шийдвэрлэнэ (цаашид зөвхөн „гадаадын иргэдийн хууль“). Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гадаадын иргэдийн хуулийг Дотоод Явдлын Яамны интернет хуудаснаас мэдэж болно www.mvcr.cz/cizinci (► /Podmínky vstupu a pobytu cizinců na území České republiky/ Чех улсын нутаг дэвсгэрт нэвтрэх шаардлага болон гадаадын иргэд оршин суух ► /Zákony a předpisy/ Хууль дүрэм ► /zákon o pobytu cizinců na území České republiky/ Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд оршин суух тухай хууль).

Гадаадын иргэдийн хууль нь гадаадын иргэдийг доорхи бүлэгт ангилна

a) **ЕХ-ны иргэд** (ЕХАО: Норвеги, Исланд, Лихтенштейн, Швейцарын иргэдтэй адил эрхийг эдлэнэ) болон тэдний гэр бүлийн гишүүд,

b) **гуравдагч орны иргэд**, эдгээр нь ЕХ/ЕХАО болон Швейцар улсуудын бус иргэд (энэ талаар гуравдагч орны иргэдийн оршин суух талаархи бүлэгт дурьдсан).

Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд байрлахыг ЕХ/ЕШ –ний хууль дүрэм удирдана. Визний харьцаатай бүс нутагт (ЕШ)-ний Зөвлөхийн 539/2001 тоот тушаалаар хэлцэгдэх ба (энэ хуулинд тусгагдсан), иргэд нь хамгийн гадна хилийг визтэй нэвтрэх үүрэгтэй гуравдагч орны нэрсийн жагсаалт болон иргэд нь визний үүргээс чөлөөлөгдсөн орнуудын нэрсийн жагсаалтыг гаргасан байна.

2007. 12. 21-ний өдрөөс эхлэн ЧУ-д Шенгений acquis хэмээх хууль мөрдөгдөж байгаа бөгөөд учир нь энэ өдрөөс эхлэн Чех улс нь Шенгений орнуудын бүлэгт хамрагдаж байна.

4. 2. ЧУ/Шенгений нутаг дэвсгэрт түр оршин суух

➢ **ЧУ/Шенгений нутаг дэвсгэрт түр хугацаагаар оршин суух-90 хоног хүртэл**

Шенгений улсууд нь өөрсдийнхөө хамтарсан газар нутагт нэвтрэх болон түр хугацаагаар байрлах шаардлагыг нэгтгэсэн.

Шенгений оронд ЕХ-ны улсууд хамрагдах ба үүнээс Их Британ, Ирланд, Кипр, Болгар, Румин, Лихтенштейн эдгээр улсууд хамрагдахгүй; шенгений оронд Швейцар, Исланд Норвеги улсууд (ЕХ-ны гишүүн бус улсууд) багтана. Лихтенштейн 2011 оны сүүлээр шенгений оронд элсэх магадлалтай байна.

○ **ЧУ/Шенгений нутаг дэвсгэрт гуравдагч орны иргэд визгүй байрлах**

(ЕШ)-ний Зөвлөлийн 539/2001 тоот тушаалаар „цагаан жагсаалт“ хэмээх нэрсийн жагсаалтанд бичигдсэн гуравдагч орны иргэд ЧУ/Шенгенд визгүй байрлах боломжтой (иргэд нь ЧУ-д визгүй байрлаж болох орнуудын нэрсийн жагсаалтыг Дотоод Явдлын Яамны интернет хуудаснаас мэдэж болно: www.mvcr.cz (► /O nás/ Бидний тухай ► /Azyl a migrace/ Цагаачлал ► /Migrace/ Шилжин суурьших ► /Vízová politika/ Визийн бодлого ► /Přehled přechodného pobytu cizince na území ČR bez víza/ ЧУ-ын нутагт түр хугацаагаар визгүй байрлах улсууд). Тухайн гадаадын иргэн нь түр хугацаагаар визгүй байрлах хугацаандаа ашигт үйл эрхлэх нь хязгаарлагдмал байхаар тохиролцсон.

ЧУ-ын болон Шенгений бусад орнуудын газар нутагт визгүй байрлах улсын иргэд Шенгений хилийг нэвтэрсэн өдрөөс хойш хагас жилийн хугацаатай 3 сараар визгүй байрлаж болно (шенгений орны улс болгон байрласан хугацааг тоолно). Тухайн Шенгений улсын хуулийн дагуу зөвхөн ажил хөдөлмөр эрхлэх эрхтэй тохиолдолд ажиллаж болно.

ЧУ-ын нутаг дэвсгэрт визгүй байрлаж болох бусад боломжуудыг гадаадын иргэдийн хуулийн 18-рт дурьдсан болно.

○ **ЧУ/Шенгенд гадаадын иргэд байрлах богино хугацааны виз**

Богино хугацааны виз (шенгений нэгдсэн виз)

Богино хугацааны виз олгох шаардлага, түүний олгогдоогүй шалтгаан, богино хугацааны визний хугацаа сунгах шаардлага, түүний хугацааг хүчингүй болгосон шалтгууд зэргийг 2009 оны 7 сарын 13-ны өдрийн 810/2009 тоот Европын холбооны-Европын парламентын захиргаа болон (ЕШ)--ний Зөвлөхийн 2010 оны 4 сарын 5-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Холбооны визийн кодексийн (цаашид зөвхөн „визийн кодекс“) тухай хууль эрхийн дүрмийг ашиглан шууд тогтооно. Гадаадын иргэн нь богино хугацааны визийн олгогдоогүй шалтгууд эсвэл түүний хугацааг хүчингүй болгосон талаар мэдээлэгдсэн байх болно. Визийн кодексийн хаяг нь http://www.mvcr.cz/cizinci (► /Podmínky vstupu a pobytu cizinců na území České republiky/Гадаадын иргэд Чех улсын нутаг дэвсгэрт нэвтрэх болон байрлах шаардлагууд ► /Zákony a přepisy/ Хууль, дүрэм ► /Nařízení Evropského parlamentu a Rady (ES) č. 810/2009)/ Европын парламентын захиргаа болон (ЕШ)-ний Зөвлөхийн 810/2009 тоот тушаал).

Гишүүн орнуудын газар нутгаар дамжин өнгрөх эсвэл эдгээр газар нутагт шенгений хилийг нэвтэрсэн өдрөөс хойш зургаан сарын хугацаанд гурван сараас доош хугацаатай байрлах эсвэл гишүүн орнуудын нэг болон түүнээс дээш нисэх буудлуудын транзит заалнуудыг дамжин өнгөрсөн (нисэхийн дамжин өнгрөх виз) тохиолдолд гадаадын иргэн нь дээр дурьдсан захирамжийн шаардлагыг биелүүлсэнд тооцогдон Шенгений нэгдсэн виз олгогдоно.

ЧУ-нь доорхи нөхцлүүдэд шенгений нэгдсэн виз олгоно

a) ЧУ-нь өргөдөл гаргагчийн зорьсон очих газар,
b) нэгээс дээш тооны зорьсон газруудын гол зорьсон газар нь ЧУ байгаа тохиолдолд,
c) өргөдөл гаргагч нь гол зорьсон газраа товлоогүй, ЧУ-нь түүний шенгений анхны нэвтрэсэн улс байгаа тохиолдолд.

Гадаадын иргэн ЧУ-ын нутгаас эхлэн хэд хэдэн гишүүн орныг дамжин өнгрөх зорилготой байвал ЧУ-нь шенгений нэгдсэн виз олгох эсхийг авч хэлэлцэнэ. Нисхийн дамжин өнгрөх визийг мөн үүнтэй адил шийдвэрлэнэ.

Өргөдлийг тухайн өргөдөл гаргагчийн оршин суух буй гишүүн орны консулын газар авч хэлэлцэх ба шийдвэрлэнэ. Холбогдох гишүүн улсын консул нь түүний харъяалалд байх эрхтэй, харин оршин суух зөвшөөрөлгүй, ямар учраас оршин суух зөвшөөрөлгүй байрлаж байгаа шалтгаанаа өгсөн гуравдагч орны иргэний өргөдлийн шийдвэрийг гаргана.

Визийн кодексийн 8-р бүлэгтэй зохицож зарим нэгэн гуравдагч оронд Чех улс нь богино хугацааны виз олгохдоо өөр гишүүн орноор төлөөлүүлсэн байж болно. Визийн өргөдлийг өгхөөс өмнө тухайн өргөдөл өгч буй гишүүн орны консул тань харъяалалтай эсэх, тухайн гуравдагч оронд байгаа эсэх, өөр улсаар төлөөлүүлсэн эсэх зэргийг мэдсэн байх хэрэгтэй. Дэлгэрэнгүй мэдээллүүдийг http://www.mzv.cz (чех хэлээр: ► /Informace pro cizince/Гадаадын иргэдэд зориулсан мэдээ ► /Obecné vízové informace/Визийн ерөнхий мэдээ ► /Zastupování při udělování schengenských víz/Шенгений виз олгохдоо өөр улсаар төлөөлүүлсэн; англи хэлээр: Information for Foreigners ► General visa information ► Representation Arrangements for Schengen Visa Issuance).

Хагас жилийн хугацаанд гурван сарын хүрээнд зарим нэгэн гуравдагч орны иргэд ЧУ болон Шенгений хилийг нэвтрэхээс өмнө хийсэн хоёр талын хэлэлцээрийг үндэслэн зөвхөн Чех улсын нутаг дэвсгэрт байрлах ба онцгой тохиолдолд гадаадын иргэдэд зөвхөн Чех улс болон бусад Шенгений улсад байрлаж болхуйц хязгаарлагдмал хугацаатай виз олгож болно.

Шенгений нэгдсэн визийн өргөдлийг гадаад орон дахь ЧУ-ын консулын газар (90 хоногийн виз) **өгөх** ба өргөдөл өгсөнөөс 15 хоногийн дотор шийдвэр гаргана.

Визийн кодексийн 35-р, 36-р бүлгүүдийн тогтоосон шаардлагуудыг хангаснаар богино хугацааны визийн өргөдлийг хамгийн гадна хил дээр өгч болно. Ийм тохиолдолд виз нь 15 хоногийн байрлах хугацаатай байх ба өөрөөр хэлбэл энэ хугацаа нь дамжин өнгрөх шаардлагатай хугацаа юм.

Нисэхийн (дамжин өнгрөх) виз – энэ нь гадаадын иргэдийг ЧУ-ын нутаг дэвсгэрт болон Шенгений орнуудын олон улсын нисэх буудлын дамжин өнгрөх талбарт, гадаадын иргэн нь

нислэг солих эсвэл олон улсын нислэгийн түр буултын хугацаанд байх эрхийг олгоно. Визийн кодексийн IV хавсралтанд иргэд нь гишүүн орнуудын олон улсын нисэх буудлын дамжин өнгрөх талбарт дамжин өнгрөх визтэй байх бүх улсуудын нэрсийн жагсаалтыг заасан байна. Гишүүн орнуудын улсууд тус бүрдээ гадаадын иргэдэд дамжин өнгрөх талбарт байх тодорхой заасан шаардлагын хүрээг тогтоосон байдаг ба Чех улс зөвхөн нисхийн визийг үндэслэж байлгана. Энэ нь ЧУ-д 428/2010 тоот тогтоолоор тогтоосон.

➢ **ЧУ-д удаан хугацаагаар оршин суух: удаан хугацааны виз (90 хоногоос дээш хугацаатай виз)**

ЧУ-ын нутаг дэвсгэрт гадаадын иргэн 3 сараас дээш хугацаагаар байрлах визийг Дотоод Явдлын Яам олгоно. Энэ нь жнь: **ажиллах, хувийн үйлдвэрлэл, худалдаа, аж ахуй эрхлэх, суралцах, эрдэм шинжилгээний ажлаар** гэх мэт шалтгаануд байна. Өргөдлийг ЧУ-ын төлөөний газар өгнө (гадаадын иргэний хуулийн 53-р зүйл); гадаадын иргэний хуулийн 182-р зүйлийн 1-р догол мөрийн f)-д (2010 оны 12-р сарын 21-ний өдрийн 429/2010 тоот тогтоол) заасныг үндэслэн Дотоод Явдлын Яамны тогтоолд тусгагдсан улсуудын иргэд нь өөрсдийн харьяат бус, тэр улсдаа зорчих бичиг баримттай өөрөөр хэлбэл тэр улсдаа оршин суух зөвшөөрөлтэй эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд тухайн улсад байгаа төлөөний газар өргөдөл өгч болно.[1] 429/2010 тоот тогтоол нь дээр дурьдсан улсуудын нэрсийн жагсаалтыг агуулсан байгаа, жишээ нь энэ хаягт http://www.mvcr.cz (/Legislativa/Хууль тогтоох ► /Sbírka zákonů/Хуулийн эмхтгэлүүд).

ЧУ-ын нутаг дэвсгэрт зөвхөн хуулинд тогтоосон дагуу визийн өргөдөл гаргана (гадаадын иргэний хуулийн 33-р зүйл– хүлээлгийн виз).

Виз гүйцэтгэх үйл ажиллагааны хугацаа нь өргөдөл өгсөн өдрөөс хойш 90 хоног, онцгой тохиолдолд 120 хоног байна (гадаадын иргэний хуулийн 170-р зүйл 6-р догол мөр). Удаан хугацааны виз, сургах багшлах болон эрдэм шинжилгээний зориулалттай визийн гүйцэтгэх хугацаа нь өргөдөл өгсөн өдрөөс хойш 60 хоног байна. 30 хоногоор хүлээлгийн визийн хугацааг тогтоосон.

Дипломат виз, тусгай виз эсвэл удаан хугацааны визийг оршин суух зөвшөөрөл болгох өргөдлийг ГЯЯ (Гадаадын Явдлын Яам)-нд өгөх ба ГЯЯ-наас 60 хоногийн дотор виз олгоно (гадаадын иргэний хуулийн 170-р зүйл 5-р догол мөр).

Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн 265/2010 тоот тушаалаар өөрчлөгдөн гүйцэтгэгдэж байгаа Шенгений гүйцэтгэх хэлэлцээрт **гадаадын иргэн нь зургаан сарын хугацаанд гурван сар хүртлэх хугацаанд хүчинтэй зорчих бичиг баримттай, удаан хугацааны визтэй бусад шенгений орны нутгаар зорчиж болно** гэж заасан.

Гадаадын иргэн нь өргөдөлтэй цуг доорхи бичиг баримтыг бүрдүүлж өгнө:

- гадаад паспорт (гадаадын иргэдийн хуулийн 108-р зүйл),
- ямар шалтгаанаар байрлаж байгаа бичиг баримт - жнь.:

– **ажлын гэрээгээр** – гадаадын иргэн нь ажлын зөвшөөрлөө өгөх эсвэл харьяа газрын тань хөдөлмөрийн товчооны ажлын зөвшөөрлийн өргөдлийн дугаарыг өргөдөлдөө бичнэ-хөдөлмөрийн хуулийн дагуу ажлын зөвшөөрөл шаардлагагүй ажил эрхлэж байгаа тохиололд ажлын зөвшөөрлийг шаардахгүй (435/2004 Sb.тоот хуулийн 98-р зүйл),

– **хувиараа эрхлэх** – гадаадын иргэн нь холбогдох бртгэлүүдэд бүртгэгдсэн баримт бичгүүдийг өгнө-эдгээр нь хувиараа эрхлэх аж ахуйн бүртгэлд, худалдааны бүртгэлд, өөр хууль дүрмийн дагуу хувиараа эрхлэгч нь бүртгэлд эсвэл жагсаалтанд бичигдсэн баримт бичгүүд болно (2011 оноос хойш өөрчлөлт орж гадаадын иргэн нь хувиараа аж ахуй эрхлэх тухай хуулийн дагуу хувиараа эрхлэх шалтгаантай удаан хугацааны визийн

*1 Эдгээр улсуудын иргэд нь холбогдоох төлөөний газар визийн өргөдөл гаргах **шаардлагагүй**: Албани, Андорра, Антигуы болон Барбуды, Аргентына, Австрали, Бахам, Барбадос, Венесуэл, Босни Герцегонив, Бразили, Бруней, Гэгээн Криштофын холбооны улс болон Невесэ, Гватемал, Гондурас, Чили, Хорват, Израль, Япон, Канад, Солонгос улс, Косторика, Македон улс, Малайз, Маврики улс, Монако, Никарагуа, Шинэ Зеланд, Панам, Парагвай, Черна Хора, Салвадори, Сан Марина, Сейшел, Сингапур, АНУ, Мексик, Срб, Ватикан, Тайвань, Уругвай, Гонконг, Маца (2011. 6. 1-ний байдлаар).*

өргөдөлтэй хамт хувиараа эрхлэх аж ахуйн байгууллагад бүртгүүлсэн дугаар болон хувиараа аж ахуй эрхлэх эрхийн бичигний /лиценз/ дугаарыг өгхөд хангалттай– хувиараа эрхлэх үйл ажиллагааг үүнээс өмнө зогсоосон байсан ч гэсэн визийг олгоно),

- оршин суухад хэргэлэгдэх хэрэглэгээний хэмжээг (гадаадын иргэдийн хуулийн 13-р зүйл)-амин зуулгын түвшингийн доод хэмжээгээр 110/2006 тоот хуулиар тогтооно.
- Оршин суух зөвшөөрлийн хугацаанд байрлах байрны бичиг (гадаадын иргэдийн хуулийн 31-р зүйл)-энэ бичгийг хуулиар тогтоосон байна (байрны болон байшингийн эзний тодорхойлолт, байр болон байшингийн эзний зөвшөөрлөөр эсвэл тодорхойлолт бичигтэй байр буюу байшинг эзмших эрх бүхий тодорхойлолт, эдгээр бичигүүд нь гадаадын иргэнийг тэнд байрлахыг зөвшөөрч эзэд нь гарынхаа үсгийг нотратаар батлуулсан байна); Хууль нь байрлах байрыг тусгай хууль дүрмийн дагуу тогтоох ба (энэ нь Дотоод Явдлын Яамны 326/2000 тоот тогтоол, гудамжны нэр, бусад нийтийн барилга байгууламжууд, байшингийн дугаар болон тэмдэглэгээ байшингийн дугаарын солигдол болон шинээр дугаарлалт, дугаарыг бичиг баримтанд бичигдсэн тухай) байшин байр нь тус бүрдээ дугаарлагдсан эсвэл бүртгэгдсэн, нийтлэг дугаарлагдсан, барилга байгууламжийн хуулиар амьдрах, байрлах, амралтын журмаар байрлах зэрэг зориулалтын байх ёстой,
- 2 хувь зураг, хэрэв гадаадын иргэн нь өргөдөл өгөх үедээ зурган тэмдэглэл өгсөн үед үйлчлэхгүй.

<u>Гадаадын иргэн нь өргөдөл өгөх үедээ бүрдүүлэх бусад бичиг баримтууд:</u>

a) гадаадын иргэн нь харъяа улсын эсвэл сүүлийн гурван жилд 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй байрлаж байсан улсын гэмт хэрэг хийж байсан эсэх гэмт хэргийн бүртгэлийн бичиг (гадаадын иргэдийн хуулийн 174-р зүйл), хэрэв тухайн улс нь ийм бичиг баримт үйлддэггүй тохиолдолд албан ёсны мэдэгдэл (15 наснаас эхлэн энэ бичиг баримтыг шаардана) – гадаадын иргэдийн хуулийн 31-р зүйлийн 5-р догол мөрийн а),

b) гадаадын иргэдийн хуулийн 31-р зүйлийн 5-р догол мөрийн b)-д зааснаар хүнд өвчнөөр өвчлөөгүй эсэх эмчийн бичиг (өвчний жагсаалтыг Эрүүл Мэндийн Яамны 274/2004 тоот тогтоолоор тогтоосон).

Удаан хугацааны виз гархаас өмнө гадаадын иргэн нь Чех улсын нутаг дэвсгэрт байрлах хугацаандаа зорчигчийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан бичиг баримт, даатгалын төлбөрийг хийсэн бичиг баримтуудыг өгөх хэрэгтэй (энэ үүргээс чөлөөлөгдөх эсхийг гадаадын иргэдийн хуулийн 180-р зүйл 4-р догол мөрд үз). Зорчигчийн эрүүл мэндийн даатгалын үйлчлэх хүрээ болон доод төлбөрийн хэмжээг гадаадын иргэдийн хуулийн 180-р зүйл 1-р, 6-р догол мөрүүдэд дурьдсан.

Удаан хугацааны визийг татгалзах тохиолдлууд (гадаадын иргэдийн хуулийн 53-р зүйл 3-р догл мөр),

- гадаадын иргэн нь хуулиар тогтоосон өргөдөлтэй хамт өгөх зүйлүүдийг дутуу өгсөн (гадаадын иргэдийн хуулийн 31-р зүйл),
- өргөдөл нь зориулалтын хэвлэмэл хуудсанд бичигдээгүй буюу орон нутгийн холбогдох төлөөний байгууллагад өгөөгүй, эсвэл
- хэрэв гадаадын иргэн нь хурууны хээ, гэрэл зурган тэмдэглэл өгхийг татгалзсан.

Эдгээр тохиолдолд төлөөний байгуллага гадаадын иргэнд бүх өгсөн бичиг баримтуудыг, төлсөн төлбөрүүдийг буцаан өгч өргөдөл буцаасан шалтгааныг тодорхой мэдэгдэнэ (гадаадын иргэдийн хуулийн 53-р зүйл 4-р догол мөр).

Хэрэв удаан хугацааны виз олгохыг татгалзсан тохиолдолд гадаадын иргэнд Дотоод Явдлын Яам татгалзсан шалтгааныг бичгээр мэдэгдэнэ. Мөн гадаадын иргэнд удаан хугацааны виз татгалзсаны эсрэг 15 хоногийн дотор давж заалдах эрхтэй гэдгийг мэдэгдэнэ– гадаадын иргэдийн хуулийн 180-р зүйлийн е-д дурьдсан.

Удаан хугацааны визээр оршин сууж байх хугацаанд визийн хугацааг давтан сунгаж болох ба хамгийн дээд хугацаа нь энэ визийн дуусах хугацааг хүртэл байх (энэ нь хамгийн дээд хугацаа нь 6 сар) ба оршин суух шалтгаан нь адил байсан нөхцөлд. Гадаадын иргэдийн байрлах хугацааг сунгах болзлууд, шаардагдах өргөдлийг гадаадын иргэдийн хуулийн 35-р зүйлээр тогтоосон.

Оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгах өргөдлийг Дотоод Явдлын Яамны холбогдох орон нутгийн салбар газруудад өгнө. Өргөдөл өгсөн өдрөөс хойш 14 хоногийн дотор визийг гаргана. Дотоод Явдлын Яам нь 90 хоногоос дээш хугацаатай хүлээлгийн виз эсвэл ийм визийн хугацааг сунгах өргөдлийн шийдвэрийг өргөдөл өгсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргана.

➢ **Удаан хугацаагаар оршин суух: удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл**

Гадаадын иргэд нь доорхи болзлыг хангасан тохиолдолд (гадаадын иргэдийн хуулийн 42-р зүйл) удаан хугацааны оршин суух зөвшөөрөл хүсэх эрхтэй:

– ЧУ-ын нутаг дэвсгэрт удаан хугацааны визээр оршин сууж буй нөхцөлд,
– 6 сараас дээш хугацаагаар түр хугацаагаар байрлахаар шийдсэн тохиолдолд
– адил шалтгаанаар оршин суух.

<u>Удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн өргөдөлд шаардагдах зүйлүүд</u>

Удаан хугацааны визийн өргөдөл өгсөн гадаадын иргэдийн шаардагдах зүйлүүд үндсэндээ удаан хугацааны оршин суух зөвшөөрлийг хүсэж буй гадаадын иргэнтэй адил байна (46-р зүйл 1-р догол мөр, 31-р зүйл 1-р догол мөр, 34-р зүйл)– шаардагдах зүйлүүд:

- гадаад папорт,
- оршин суух шалтгааны баримт бичиг,
- оршин суухад зориулагдсан хэрэглэгээнүүд,
- байрны бичиг,
- 2 хувь зураг,
- гадаадын иргэний хуулийн 180-р зүйлийн 4-р догол мөрд зааснаас өөр тохиолдолд зорчигчийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан бичиг баримт, зорчигчийн эрүүл мэндийн даатгалын төлбөр хийсэн бичиг.
- хүнд өвчингүй гэсэн эмчийн бичиг; зөвхөн хүнд өвчтэй байж магадгүй гэсэн тохиолдолд эмчийн бичиг өгнө.

Хэрэв „**оршин суух шалтгааны бичиг**“-ийн тухайд бол, гадаадын иргэдийн хууль нь зарим нэгэн оршин суух хэлбэрийг ямар байдлаар нотлох болон бусад шаардагдах зүйлүүдийг тогтоосон байна (доор үз). Бусад тохиолдолд гадаадын иргэн нь холбогдох байгууллагад ийм бичгийг заавал бүрдүүлж өгнө.

❖ Оршин суух шалтгаан **ажиллах:**

Гадаадын иргэн нь **ажиллах шалтгаанаар** удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдөлтэй хамт <u>ажиллах зөвшөөрлийн шийдвэр</u> эсвэл <u>ажиллах зөвшөөрлийн сунгалтын шийдвэрийг</u> (гадаадын иргэдийн хуулийн 46-р зүйл 6-р догол мөр), мөн 31-р зүйлийн 1-р догол мөрийн a), d), e)-д заасны дагуу шаардагдах зүйлүүдийг өгнө

Гадаадын иргэдийн хуулийн 178b-д энэхүү ажиллах шалтгааны хуулийг тодотгож байна:

„Энэхүү хуулинд дурьдсан ажиллах гэдэг нь гадаадын иргэн нь ямар нэгэн хөдөлмөр эрхлэж түүний шалтгаанаар ажлын зөвшөөрөл, ногоон эсвэл хөх карт авна. <u>Ажиллах гэдэгт бас хуулийн этгээд компаний нэрэн доор өөрийнхөө үүргийг гүйцэтгэх, худалдааны компаний хэргээр хууль зүйн байгууллага эсвэл хууль зүйн байгууллагын гишүүн байгууллага эсвэл худалдааны компаний бусад худалдааны компаниуд эсвэл хууль зүйн байгууллагын гишүүн байгууллага эсвэл бусад хоршооллын байгууллагууд, эдгээрийн гүйцэтгэх үйл ажиллагаануудыг бас ажиллахад тооцно</u>.“

❖ Оршин суух шалтгаан **хувиараа эрхлэх:**

Хувиараа эрхлэх шалтгаанаар удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдөлтэй хамт доорхи зүйлүүдийг бүрдүүлнэ (гадаадын иргэдийн хуулийн 46-р зүйл 7-р догол мөр):

- 31-р зүйл 1-р догол мөрийн a), d), e)-д заасны дагуух шаардагдах зүйлүүд
- <u>сарын нийт цалингиийн</u> хэмжээ нь уг гадаадын иргэний болон хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн тогтоосон амьжиргааны түвшингээс доошгүй, уг гадаадын иргэн

болон түүний гэр бүлийн гишүүдийн байрны зардал нь тусгай хуулинд заасан эсвэл тогтоосон хэмжээнд хангалттай зэргүүдийг нотлосон бичиг баримт,

- холбогдох бүртгэл болон жагсаалтанд бичигдсэн талаархи нотолгоо бичиг,
- холбогдох санхүүгийн байгууллагын өргүй гэсэн тодорхойлолт, окресний нийгмийн хангамжийн захиргааны нийгмийн даатгалын, улсын ажилгүйдлийн тэтгэмжийн болон бусад талаар өр төлбөргүй гэсэн тодорхойлолт. Хэрэв гадаадын иргэн нь татвар төлөгч бус, нийгмийн болон улсын ажилгүйдлийн тэтгэмжийн даатгал төлөгч бус тохиолдолд эдгээр нотлох бичиг баримтыг санхүүгийн байгууллага (finanční úřad) эсвэл окресний нийгмийн хангамжийн газар (okresní správa sociálního zabezpečení) үйлдэж өгнө,
- хэрэв гадаадын иргэн нь худалдааны компаний эсвэл хоршооллын байгууллага, түүний гишүүн байгууллагын хууль зүйн этгээд байгаа тохиолдолд холбогдох санхүүгийн байгууллага энэ худалдааны компани болон хоршоолол өргүй гэсэн тодорхойлолтыг, окресний нийгмийн хангамжийн захиргаа нийгмийн даатгалын, улсын ажилгүйдлийн тэтгэмжийн болон бусад талаар өр төлбөргүй гэсэн тодорхойлолтуудыг тус тус хийж өгнө,
- цалингийн татварын хэмжээний тодорхойлолт.

Өргөдөлтэй хамт өгч буй оршин суух шалтгаан нь ЕХ-ны холбогдох хууль дүрмээр тогтоогдсон (жнь. гэр бүлийн, суралцах гэх мэт шалтгаанууд), энгийн шалтгаануудаас гадна тусгай шалтгаанууд байдаг, үүнд:

❖ Оршин суух шалтгаан **гэр бүлийн:**

– төрлийн харьцааг нотлох бичиг баримт;
– эцэг эхийн, хүүхэд ЧУ-д байрлаж байх үеийн хуулиар төлөөлсөн төлөөлөгчийн эсвэл асран халамлагчийн, эцэг эхээсээ тусдаа амьдарч байгаа тохиолдолд түүний хуулийн төлөөлөгч эсвэл асран халамжлагчийн зөвшөөрөл (хэрэв гадаадын иргэн нь түүний зүгээс бус шалтгаанаар энэ нотлох бичгийг өгч чадахгүй эсвэл хүүхэд ЧУ-д байрлаж байгаа тохиолдолд үүнд хамаарагдахгүй);
– хуулиар тогтоогдсон доод түвшингээс дээш хэмжээтэй сарын цалингийн тодорхойлолт (гадаадын иргэдийн хуулийн 42b-д үз).

Тайлбар: хэрэв гэр бүлийн харьцааны эрх эзэмшигч нь цагаачлал олгогдсон тохиолдолд цагаачлал олгох шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс 3 сарын дараа гэр бүлийн шалтгаанаар удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгөх ба өргөдөлтэй хамт зөвхөн гадаад паспорт, гэрэл зураг, төрлийн харьцааг нотлох бичиг баримт зэргийг өгнө.

❖ **ЕХ-ны өөр гишүүн орны байнга оршин суугч:**

– Европын холбооны гишүүн орны байнга оршин суугч гэсэн нотлох бичиг баримт;
– өргөдөл гаргагч болон түүний гэр бүлийн хамт амьдрагч гишүүдийн сарын цалингийн тодорхойлолт (42c-р зүйл о3, 4-р догол мөрүүд).

Тайлбар: Гадаадын иргэдийн хуулинд зөвхөн ажлын шалтгаантай ЕХ-ны гишүүн орны оршин суугчийн асуудлыг шийдвэрлэнэ–гадаадын иргэн нь ажлын зөвшөөрөл (ажлын зөвшөөрөл хүссэн хөдөлмөрийн товчоонд өгсөн өргөдлийн дугаарыг өгнө) мөн ажиллуулагчийн ажиллуулж буй нь үнэн гэсэн тодорхойлолт зэргийг өгнө

❖ Оршин суух шалтгаан **суралцах:**

– эцэг эхийн болон өөр асран хамгаалагчийн зөвшөөрөл (хэрэв насанд хүрээгүй бол);
– дээд сургуульд суралцаж байгаа эсвэл цалингүй мэргэжлийн дадлага хийж буй үед оршин суухад хэрэглэгдэх хэрэглэгээ (бусад тохиолдолд гадаадын иргэний оршин суух зардлыг дотоодын хариуцагч байгууллага даана гэсэн бичиг баримт байна) – гадаадын иргэдийн хуулийн 42d-р зүйл 2-р догол мөр.

❖ Оршин суух шалтгаан **эрдэм шинжилгээний:**

– урилгын гэрээ (агуулгыг нийтийн эрдэм шинжилгээний институтын тухай 341/2005 тоот хуулийн 30с-р зүйлээр тогтооно–гэрээг эрдэм шинжилгээний ажлын болзлын болон хуулийн ажилтан тогтооно);
– эрдэм шинжилгээний ажилтны оршин суухтай холбоотой зардал, буцах замын зардал зэргийг эрдэм шинжилгээний байгууллага хариуцна (гадаадын иргэдийн 42f-р зүйл 3-р догол мөрөөс үз).

Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг Дотоод Явдлын Яаманд өгнө. Үүнээс гадна гадаадын иргэн нь хуулиар тогтоосноор удаан хугацаагаар оршин суух өргөдлийг гадаадад буй Чех улсын төлөөний газар өгөх эрхтэй, жнь гэр бүлийн визийн өргөдөл (гадаадын иргэдийн хуулийн 42а-р зүйл), суралцах шалтгаантай, (гадаадын иргэдийн хуулийн 42d-р зүйл), эрдэм шинжилгээний талаар (гадаадын иргэдийн хуулийн 42f-р зүйл) гэх мэт.

Оршин суух зөвшөөрлийн өргөдлийг гадаадын иргэн нь өөрөө өгөх үүрэгтэй. Төлөөний газар нь тодорхой шалтгаантай тохиолдолд өөрөө өгөх үүргээс чөлөөлж болно (гадаадын иргэдийн хуулийн 169-р зүйл 14-р догол мөр).

429/2010 тоот тогтоолд дурьдагдаагүй улсын иргэд нь өөрийн харъяат улс, гадаад паспорт олгосон улс, удаан хугацааны зөвшөөрөлтэй болон байнга оршин сууж буй улсдаа байгаа төлөөний газарт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгнө.

Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг 60 хоногийн дотор шийдвэрлэнэ [гадаадын иргэдийн хуулийн 169-р зүйл 1-р догол мөрийн е)]. Гэр бүлийн визийг өргөдөл өгсөн өдрөөс 270 хоногийн дотор шийдвэрлэнэ [гадаадын иргэдийн хуулийн169-р зүйл 1-р догол мөрийн с)], ЕХ-ны гишүүн орнуудын байнга оршин суугч болон түүний гэр бүлийн гишүүдийн удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг 120 хоногийн дотор шийднэ [гадаадын иргэдийн хуулийн 169-р зүйл 1-р догол мөрийн а)].

<u>Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн тогтоосон хугацаа</u>

Оршин суух шалтгаан тус бүрийг харгалзан оршин суух зөвшөөрлийн хугацааг хуулиар тогтооно (гадаадын иргэдийн хуулийн 44-р зүйлд үз).

❖ **<u>Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгах:</u>**

– Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хугацааг давтан сунгаж болно.
– **Шаардлагууд нь** удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдөлтэй зохицож байх болно (гадаадын иргэдийн хуулийн 44а-р зүйл 3 -11-р догол мөрүүд).
– **Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн тогтоосон сунгах хугацааг** хуулинд гадаадын иргэний оршин суух шалтгаанууд тус бүрд зохицуулж тогтоосон (гадаадын иргэдийн хуулийн 44а-р зүйлд үз).

❖ **<u>Оршин суух шалтгааны өөрчлөлт:</u>**

Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй иргэн нь өөр шалтгаанаар шинэ оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгч болно:

– „**хувиараа эрхлэх**“ (2011оноос шинээр гарсан) – гадаадын иргэн нь хувиараа эрхлэх шалтгаанаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгч болох ба, ийм тохиолдолд **Чех улсын нутаг дэвсгэрт 2 жилээс дээш хугацаагаар удаан хугацааны оршин суух зөвшөөрлөөр байрласан байх шаардлагатай**,
– хууль **зарим онцгой тохиолдлуудын оршин суух шалтгаануудыг** тогтоосон, жнь: гэр бүлийн харьцаагаар оршин сууж байгаа гадаадын иргэдийн (гадаадын иргэдийн хуулийн 45-р зүйлд үз, мөн оршин суух зөвшөөрлийн шалтгааны өөрчлөлтийн өргөдөлд шаардагдах зүйлүүдийг тогтоосон).

<u>Тайлбар:</u> Удаан хугацаагаар оршн суух зөвшөөрлийн сунгалт, өөрчлөлт хийхэд шинэ „оршин суух зөвшөөрлийн“ үнэмлэх олгож шийдвэрлэж байна.

<u>Шенген – шенгений улсуудаар зорчих</u>

Шенгений гэрээний 21-р бүлэгт зарим нэгэн гишүүн орны удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй болон зорчих бичиг баримттай гадаадын иргэд **шенгений бусад орноор чөлөөтэй зорчиж болно** (зургаан сарын турш 3 сараас доош).

Болзол нь, гадаадын иргэн нь улсын дотоод бүртгэлд холбогдох шенгений улсад нэвтрэхийг хориглосноор бүртгэгдээгүй, Шенгений хилийн кодексийн шаардлагыг хангаж байгаа (5-р бүлэг 1-р догол мөрийн а/, с/, е/), ялангуяа хүчинтэй зорчих бичиг баримттай болон зорчиход хангалттай хэргэслэлтэй байх шаардлагатай.

Ажил эрхлэхдээ тухайн шенгений улсын хууль дүрэмтэй зохицолдуулан тэр улсад ажиллаж болно.

- **<u>Ногоон карт</u> – Тусгай ажиллах шалтгаантай удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл** (гадаадын иргэдийн хуулийн 42g-р зүйл)

Ногоон карт олгох өргөдлийг иргэд нь ногоон картны өргөдөл өгөх эрхтэй улсуудын нэрсийн жагсаалтанд бичигдсэн улсуудын иргэд (461/2009 Sb.тоот тогтоолоор тогтоосон), сул ажлын байрны бүртгэлийн төвд бүртгэгдсэн ногоон картыг ээмшигч ажиллаж болхуйц нэг ажлын сул байранд ажиллаж ЧУ-ын нутаг дэвсгэрт ажлын шалтгаанаар оршин суух иргэд (*ажил хөдөлмөр эрхлэх тухай* 435/2004 Sb *тоот хуулийн* 37а-р зүйл – цаашид зөвхөн „ажиллах хууль“), боловсрол болон мэргэжил нь шаардлагыг хангаж тухайн мэргэшилд дүйцсэн иргэд өгч болно. Дэлгэрэнгүй мэдээллүүдийг дээр дурьдсан тогтоолоор тогтоогдсон улсуудын нэрсийн жагсаалтын хамт энэ хаягаас мэдэж болно http://www.mvcr.cz/cizinci (► /str.2/ 2-р нүүр ► /Zelené karty/Ногоон карт). Одоогийн байдлаар эдгээр улсуудын иргэд ногоон картны өргөдөл өгч болно Австрали, Черна Хора, Хорват, Япон, Канад, Солонгос улс, Шинэ Зеланд, Босни Герцегинов, Македон, АНУ, Серб, Украйн. Ногоон картыг олгох шийдвэрийг Дотоод явдлын яам шийдвэрлэнэ.

Ногоон картыг олгох зориулалт:

a) дээд боловсролтой мэргэшсэн ажилтан, зонхилох боловсон хүчин– бүлэг „A“
b) тухайн ажлын шаардсан мэргэжилд суралцсан– бүлэг „B“
c) бусад ажилчид – бүлэг „C“

Дотоод явдлын яамны 429/2010 тоот тогтоолд бичигдээгүй улсуудын иргэд нь ногоон картны өргөдлийг зөвхөн өөрийн харъяат улс, гадаад паспорт олгосон улс, удаан хугацааны зөвшөөрөлтэй болон байнга оршин сууж буй улсдаа байгаа төлөөний газарт өгнө. Чех улсын нутаг дэвсгэрт ногоон карт олгох өргөдлийг Дотоод Явдлын Яаманд

– ногоон картаар оршин сууж байгаа гадаадын иргэн, шинэ картны өргөдлийг хамгаалах хугацаа хэмээх хугацаанд өгнө (гадаадын иргэдийн хуулийн 46е-р зүйл 3-р догол мөрөөс үз),
– ногоон картаар хамгийн бага нь 1 жил оршин суусан, эсвэл
– удаан хугацаагаар оршин суух визээр эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлөөр тасралтгүй хамгийн бага нь 2 жилээр оршин суусан гадаадын иргэн өгөх эрхтэй.

Ногоон картын заасан хугацаанд гадаадын иргэн нь ЧУ-ын нутаг дэвсгэрт оршин суух болон ажиллах эрхтэй. Ногоон карт олгоход хуулийн эрх байхгүй.

<u>Гадаадын иргэн нь ногоон карт олгох өргөдөлтэй хамт доорхи зүйлүүдийг өгнө:</u>

- гадаад паспорт,
- гэрэл зураг, зургийн тэмдэглэлээ өгсөн иргэнд үйлчлэхгүй,
- тухайн ажлын байранд шаардагдаж байгаа боловсрол мэргэжлийн бичиг баримтууд.

Мөн өргөдөл өгч буй гадаадын иргэн нь „хүнд өвчнөөр“ өвчлөөгүй эсэх эмчийн бичгийг өгөх үүрэгтэй (өвчний жагсаалтыг Эрүүл Мэндийн Яамны 274/2004 тоот тогтоолоор тогтоосон).

Өргөдөлтэй эсвэл ЧУ-ын нутаг дэвсгэрт байрлах хугацаандаа нэвтэрч орж ирсэн өдрөөс эхлэн 2 сарын дотор гадаадын иргэн нь харьяа улсын эсвэл сүүлийн гурван жилд 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй байрлаж байсан улсын гэмт хэрэг хийж байсан эсэх гэмт хэргийн бүртгэлийн бичгийг өгөх ба хэрэв тухайн улс нь ийм бичиг баримт үйлддэггүй тохиолдолд энэ талаархи албан ёсны мэдэгдлийг өгөх үүрэгтэй.

Ногоон картны 90 хоногоос дээш хугацааны визийг ирж авхыг мэдэгдхээс өмнө гадаадийн иргэн нь ЧУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн өдрөөс нийтийн эрүүл мэндийн даатгалын хууль (48/1997 Sb.тоот хууль) үйлчилж эхлэх үеийг хүртлэх зорчигчийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан бичиг баримт, зорчигчийн эрүүл мэндийн даатгалын төлбөр хийсэн бичгийг өгөх үүрэгтэй.

- **<u>Хөх карт</u> – Өндөр мэргэжилд ажиллахтай холбоотой оршин суух зөвшөөрөл** (гадаадын иргэдийн хуулийн 42-р зүйл)

Хөх карт нь өндөр мэргэжилд ажиллахтай холбоотой оршин суух зөвшөөрлийн шинэ хэлбэр юм (гадаадын иргэдийн хуулийн 42-р зүйл). Хөх карт нь гадаадын иргэний оршин суух эрхийг олгохоос гадна бас ажиллах эрхийг олгоно, энэ нь гадаадын иргэн тусгай ажлын зөвшөөрөл хэрэггүй.

Хөх карт олгох өргөдлийг гадаадын иргэн нь ЧУ-ын нутаг дэвсгэрт 3 сараас дээш хугацаагаар оршин суухаар шийдсэн тохиолдолд өгч болох ба энэ нь Европын холбооны бус иргэн, хуулийн дагуу ажлын байр нь гадаадын иргэн ажиллаж болхуйц, **өндөр мэргэжил шаардагдсан ажлын байранд ажиллана.**

Өндөр мэргэжил гэдэг нь **бүрэн дүүргэсэн дээд боловсрол эсвэл хамгийн бага нь 3 жил суралцсан мэргэжлийн дээд боловсролыг хэлнэ.**

Хөх картны өргөдлийг төлөөний газар, зарим тохиолдолд орон нутагт Дотоод Явдлын Яаманд өгнө. Хөх картны өргөдлийг Дотоод Явдлын Яам 90 хоногийн дотор шийдвэрлэнэ.

<u>Хөх картны өргөдөлд бүрдүүлэх зүйлүүд</u> (гадаадын иргэдийн хуулийн 42j-р зүйл)

- Гадаад паспорт,
- Чех улсад оршин суух хугацаанд байрлах байрны бичиг,
- зураг,
- хуулиар тогтоогдсон долоо хоногийн ажлын өдөртэй**, хамгийн бага нь нэг жилийн хугацаатай, Хөдлмөр Нийгмийн Хангамжийн Яамнаас тогтоосон сарын болон жилийн дундаж бохир цалингаас 1,5 дахин их цалингийн хэмжээг агуулсан,** өндөр мэргэжлийн шаардлагатай **ажлын гэрээ**,
- өндөр мэргэжлийг нотлох бичиг баримт,
- хэрэв тухайлсан мэргэжил байвал энэ мэргэжлийн шаардлагыг хангасан бичиг баримт (тайлбар: яам нь хөх карт олгохыг холбогдох хүлээн зөвшөөрөгч байгууллагын саналаар шийдвэрлэнэ),
- хэрэв уг гадаадын иргэн нь хөх картны өргөдөл өгхөөс өмнө Европын холбооны өөр гишүүн орны хөх картыг эзмшиж байсан тохиолдолд **гэр бүлийн сарын орлогын нотолгоо бичиг баримт**,
- **зорчигчийн эрүүл мэндийн даатгал** – ЧУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн өдрөөс нийтийн эрүүл мэндийн даатгалын хууль (48/1997 Sb.тоот хууль) үйлчилж эхлэх үеийг хүртлэх зорчигчийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан бичиг баримт, зорчигчийн эрүүл мэндийн даатгалын төлбөр хийсэн бичгийг.

<u>Хөх картны өргөдөлтэй хамт бүрдүүлэх бусад зүйлүүд:</u>

- **гэмт хэргийн бүртгэлийн хугацаат бичиг баримт**,
- хүнд өвчнөөр өвчилсөн эсэх **эмчийн тодорхойлолт** (өвчтэй байж магадгүй гэсэн тохиолдолд).

Хөх картыг ажлын гэрээний хугацаанаас 3 сараар илүү хугацаагаар олгоно, хамгийн урт хугацаа нь 2 жилээр. Хөх картыг сунгаж болно.

<u>Хөх карт эзмшигчийн үүрэг:</u>

- хөх картны хүчинтэй хугацаанд хөх карт эзэмшигчийн **ажиллах хугацаа дуусан** тохиолдолд,энэ байдлыг тогтоосон хугацаанд ДЯЯ-д мэдэгдэх хэрэгтэй,
- **ажил болон ажлын байрны өөрчлөлтийг заавал мэдэгдэнэ** (Эхний хоёр жилд энэ өөрчлөлтийг ДЯЯ-ны зөвшөөрлөөр хийнэ. Хоёр жил болсноос хойш энэ өөрчлөлтийг ажлын 3 өдрийн дотор заавал мэдэгдэнэ.),
- оршин суух талаархи чухал байдлыг мэдэгдэх

➢ **Гарах тушаал** (гадаадын ирэдийн хулийн 50-р зүйл)

Анхаар, энэ оршин суухтай холбоотой эрхийг ЧУ-аас **зөвхөн ямар ч асуудалгүй гаргах** зорилгоор хэрэглэнэ!

Хэрэв гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд гарах тушаалыг цагдаагийн байгууллага болон тогтоосон үед Дотоод Явдлын Яам эсвэл Гадаад Явдлын Яам гаргана (жнь. визийн хугацааг хүчингүй болгох, удаан хугацааны болон байнгын оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгох, албан ёсоор албадан гаргах). Гарах тушаал нь гадаадын иргэнд **түр хугацаагаар ЧУ-д байрлаж, заасан хугацаанд тушаалыг дагаж мөрдөх үүргийг хүлээлгэнэ** (хамгийн дээд хугацаа 60 хоног). Гадаадын иргэн нь **заасан хугацаанд ЧУ--ын нутаг дэвсгэрээс гарах үүрэгтэй**.

4. 3. ЧУ-д байнга оршин суух

ЧУ-д байнга оршин суудаг гадаадын иргэд нь амьдралын ихэнх байдлаараа ЧУ-ын иргэнтэй адил түвшинтэй байдаг.

➢ **ЕХ буюу ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүний байнга оршин суух зөвшөөрөл**

Гадаадын иргэн – ЕХ-ны болон гуравдагч орны иргэн, гадаадын иргэдийн хуулийн 15-р зүйлийн а/-д дурьдсанаар ЕХ-ны буюу ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүний хүрээн дэх иргэн, энэ нь

a) нөхөр,

b) эцэг эх, 21-ээс доош настай ЕХ-ны иргэнийг асран халамжилж, нэг гэрт цуг амьдарч байгаа,

c) 21-ээс доош настай хүүхэд эсвэл ЕХ-ны иргэний нөхрийн хүүхэд

d) ЕХ-ны иргэний нөхрийн өөрийгөө тэжээх чадваргүй шууд болон шууд бус төрлийн холбоотон

эдгээр ЕХ-ны иргэний гэр бүлийн гишүүд Дотоод Явдлын Яаманд байнга оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгч болно. Өргөдлийн шийдвэрлэх хугацаа. ЕХ-ны буюу ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүнд зөвхөн гэр бүлийн гишүүн гэж үзсэнээр байнга оршин суух зөвшөөрөл олгочихгүй бас гадаадын иргэдийн хуулийн 87h-р зүйлд зааснаар бусад шаардлагуудыг биелүүлсэн байх шаардлагатай.

Эдгээр шаардлагууд нь, ялангуяа:

a) гадаадын иргэдийн хуулийн дагуу түр хугацаагаар тасралтгүй 5 жил байрласан байх (87h-р зүйл 1-р догол мөрийн a)

b) ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүнээр, ЧУ-д байнга рошин суугч эсвэл ЕХ-ны өөр улсын иргэний гэр бүлийн гишүүнээр хамгийн бага нь 1 жилийн хугацаатай байсан өргөдөл гаргагч нь тасралтгүй 2 жил түр хугацаагаар байрласан байх (гадаадын иргэний хуулийн 87h-р зүйл 1-р догол мөрийн b)-д)

ЕХ-ны болон ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүний байнга оршин суух зөвшөөрлийг олгох бусад болзол нөхцлүүд гадаадын иргэдийн хуулийн 87h-р зүйл 1-р догол мөрийн c), d)-д дурьдсан байна.

Эдгээр байнга оршин суух зөвшөөрлийг олгох шалтгаануудад хуулийн эрх үйлчлэх ба Дотоод Явдлын Яам нь зөвхөн гадаадын иргэний хуулийн 87k-р зүйлийн дагуу нарийн тодорхой нөхцөлд л өргөдлийг татгалзана. ЕХ-ны буюу ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүн нь мөн гадаадын иргэдийн хуулийн 87h-р зүйлийн 2-р догол мөрийн b)-д зааснаар хүмүүнлэгийн шалтгаанаар байнга оршин суух зөвшөөрлийг хүсэж болно. Ийм тохиолдолд байнга оршин суух зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд хуулийн эрх үйлчлэхгүй. ЕХ-ны буюу ЧУ-ын иргэний гэр бүлийн гишүүн нь оршин суух зөвшөөрлийн албан ёсны төлбөрөөс чөлөөлөгдөнө.

ЧУ-ын иргэн буюу ЕХ-ны улсын иргэний гэр бүлийн гишүүний байнга оршин суух зөвшөөрлийн **өргөдөлд шаардагдах** зүйлүүдийг гадаадын иргэдийн хуулийн 87i-р зүйлээр тогтоосон. Эдгээр нь гадаад паспорт, 2 хувь зураг, байрны бичиг болон гадаадын иргэдийн хуулийн 87g-р зүйлийн 1-р догол мөр эсвэл 87h-р зүйлийн 1-р догол мөрд заасны дагуу өргөдөл өгч байгаа тохиолдолд энэ тогтоолын шаардлагыг биелүүлсэн бичиг.

- **ЕХ-ны иргэн бус түүний гэр бүлийн гишүүн бус гадаадын иргэний ЧУ-ын нутаг дэвсгэрт тасралтгүй оршин суух болзолгүй байнга оршин суух зөвшөөрөл** (гадаадын иргэдийн хуулийн 66-р зүйл)

Зарим нөхцөлд гадаадын иргэн ЧУ-ын нутаг дэвсгэрт урьд өмнө нь байрлахгүйгээр байнга оршин суух зөвшөөрлийг хүсэж болно. Ийм тохиолдолд өргөдлийг гадаадын иргэдийн хуулийн 66-р зүйлийн 1-р догол мөрийн d)-д зааснаас өөрөөр авч хэлэлцэх ба харин байнга оршин суух зөвшөөрөл олгоход хуулийн эрх үйлчлэхгүй. Ийм байнга оршин суух зөвшөөрлийн өргөдлийг гадаад улсад буй ЧУ-ын төлөөний газар өгнө. ЧУ-ын нутаг дэвсгэрт Дотоод Явдлын Яаманд өргөдөл өгч болох ба, болзлуудыг гадаадын иргэдийн хуулийн 69-р зүйлд заасан.

- **ЕХ-ны иргэн бус түүний гэр бүлийн гишүүн бус гадаадын иргэний ЧУ-ын нутаг дэвсгэрт тасралтгүй оршин суух болзолтой байнга оршин суух зөвшөөрөл** (гадаадын иргэдийн хуулийн 68-р зүйл)

*Гадаадын иргэн бүр 90хоногоос дээш хугацаатай виз/удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлөөр тасралтгүй **5 жил** оршин суусны дараа байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгөх эрхтэй. Гадаадын иргэний улсын нутаг дэвсгэрээс гадна байрласан хугацааг тооцох талаар дэлгэрэнгүйгээр гадаадын иргэдийн хуулийн 68-р зүйлийн 2-р, 3-р догол мөрүүдэд бичсэн; хэрэв суралцах шалтгаанаар оршин сууж байсан бол тэр тасралтгүй оршин суусан хугацааг хагасаар тооцно.*

ЕХ-ны иргэн бус эсвэл түүний гэр бүлийн гишүүн гадаадын иргэний байнга оршин суух зөвшөөрлийн **өргөдөлд шаардагдах** зүйлүүдийг гадаадын иргэдийн хуулийн 70-р зүйлийн 2-р догол мөрд тогтоосоон. <u>Доор дурьдсан зүйлүүд:</u>

- 2 хувь зураг,
- гадаад паспорт,
- Чех улсын нутаг дэвсгэрт байрлах шалтгааны нотолгоо бичиг баримт, жишээ нь төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа эсвэл төрлийн холбоог нотлосон бичиг баримт, гадаадын иргэн нь урьд өмнө нь Чех улсын иргэн байсан бол түүнийг нотлох бичиг, энэ нь хэрэв гадаадын иргэн нь гадаадын иргэдийн хуулийн 68-р зүйлийн дагуу байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгч байгаа бол үүнд хамаарахгүй,
- Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суухад хэрэглэгдэх хэрэглэгээний бичиг,
- гадаадын иргэн нь харьяа улсын эсвэл сүүлийн гурван жилд 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй байрлаж байсан улсын гэмт хэрэг хийж байсан эсэх гэмт хэргийн бүртгэлийн хугацааг бичиг эсвэл хэрэв тухайн улс нь ийм бичиг баримт үйлддэггүй тохиолдолд энэ талаархи албан ёсны мэдэгдэл; гадаадын иргэдийн хуулийн 70-р зүйлийн 2-р догол мөрийн е)-д энэ үүргээс чөлөөлсөн нөхцлийг заасан (энэ үүрэгт хамаарагдахгүй нөхцөл нь, 15-аас доош настай гадаадын иргэн; гадаадын иргэдийн хуулийн 68-р зүйлийн дагуу байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгч байгаа гадаадын иргэн нь хэрэв шаардсан тохиолдолд энэ бичгийг өгөх үүрэгтэй),
- Чех улсын нутаг дэвсгэрт байрлах байрны бичиг,
- эцэг эхийн, хүүхэд ЧУ-д байрлаж байх үеийн хуулиар төлөөлсөн төлөөлөгчийн эсвэл асран халамлагчийн, байнга оршин суух зөвшөөрөлтэй хүүхэд эцэг эхээсээ тусдаа амьдарч байгааа тохиолдолд түүний хуулийн төлөөлөгч эсвэл асран халамжлагчийн зөвшөөрөл; хэрэв гадаадын иргэн нь түүний зүгээс бус шалтгаанаар энэ нотлох бичгийг өгч чадахгүй эсвэл хүүхэд ЧУ-д байрлаж байгаа тохиолдолд үүнд хамаарагдахгүй,
- Чех хэлний шалгалт өгсөн бичиг (гадаадын иргэдийн хуулийн 70-р зүйлийн 5-р догол мөрд дурьдсаны дагуу энэ бичгийг шаардахгүй)

Чех хэлний шалгалтын бичгийг гадаадын иргэдийн хуулийн 70-р зүйлийн 2-р догол мөрийн h)-д тогтоосны дагуу (гадаадын иргэдийн хуулийн 70-р зүйлийн 5-р догол мөрийн с)-д хамаарахгүй) Сургууль Боловсрол, Хүүхэд залуучууд, Биен тамирын Яамнаас тогтоосон шалгалт авах эрх бүхий сургуулиудын жагсаалтанд бүртгэгдсэн сургууль, 348/2008 тоот Чех

улсын байнга оршин суух зөвшөөрлийн сургалт болон шалгалтын талаархи тогтоолын дагуу олгоно. Шалгалтын хүрээ нь тогтооолоор тогтоогдсон байна. Энэ нь Европын холбооны хэл ярианы хүрээн дэх ишлэлийн дагуу А1 түвшинтэй Чех хэлний шалгалтыг амжилттай өгөх үүрэг юм. Чех хэлний шалгалтын бичиг, мөн шалгалт авах эрх бүхий сургуулийн нэрсийн жагсаалт зэрэг нь дурьдсан тогтоолын хавсралтанд бичигдсэн байгаа.

Чех хэлний шалгалтын бичгийг гадаадын иргэдийн хуулийн 70-р зүйлийн 5-р догол мөрд зааснаар доор дурьдсан гадаадын иргэдээс **шаардахгүй**

– 15 нас хүрээгүй,
– байнгын оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгөх хүртэл 20 жилийн дотор хамгийн багаар тасралтгүй 1 хичээлийн жилд ерөнхий боловсролын болон дунд сургуульд сурагчаар байсан эсвэл 1 жил чех хэлний сургалттай дээд сургуульд суралцаж байсан эсвэл чех хэлний сонгон сургалттай програмтай дээд сургуульд суралцаж байсан,
– өөр сургуульд тооцож болхуйц чех хэлний шалгалтыг өгсөн, тэр шалгалт нь Сургууль Боловсрол, Хүүхэд залуучууд, Биен тамирын Яамны тогтоосон шалгалтын түвшинд хүрхүйц [182а-р зүйл 2-рдогол мөр а)], энэ шалгалтыг өгсөн нь Сургууль Боловсрол, Хүүхэд залуучууд, Биен тамирын Яамнаас тодорхойлогдсон,
– гадаадын иргэдийн хуулийн 66-р эсвэл 67-р зүйлийн дагуу байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгсөн эсвэл гадаадын иргэдийн хуулийн 87-р зүйлийн 7-р догол мөрийн а)-гийн 4-д заасны дагуу байнга оршин суух эрх нь хүчингүй болсон,
– биеийн болон эрүүл мэндийн байдал нь яриа харьцаанд нөлөөлсөнийг нотлосон, эсвэл
– 60 нас хүрсэн.

Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суухаар шийдсэн гадаадын иргэн нь тогтоолын хавсралтын нэрсийн жагсаалтанд дурьдагдсан аль нэгэн сургуульд Чех хэлний шалгалтыг өгхөөр бүртгүүлж болно. Зарим гадаадын иргэдэд анхны шалгалтын төлбөрийг улс төлнө, энэ нь шалгалтанд орхоос өмнө Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллагаас олгосон үнэмлэхийг үндэслэнэ (Праг-д байнга оршин суух зөвшөөрөл олгох газар – Nad Vršovskou horou 88/4, Praha 10-Bohdalec). Үнэмлэхийг зөвхөн нэг удаа олгоно. Хэлний шалгалтын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг http://www.msmt.cz/mezinarodni-vztahy/cestina-pro-cizince; http://cestina-pro-cizince.cz англи хэлээр http://check-your-czech.com. Энэ вэбийн хуудсан дахь мэдээллүүд нь Чех хэлнээс гадна англи, украйн, орос, вьетнам, монгол, хятад, араб, франц хэлүүдээр бичигдсэн байна.

Байнга оршин суух зөвшөөрлийн талаархи **I. үе шатны шийдвэрийг Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллага** шийдвэрлэнэ(гадаадын иргэдийн хуулийн 165j-р). Өргөдлийг гадаадын иргэн нь өөрийнхөө байрлаж байгаа газрын харьяаны Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллагад өгнө (дэлгэрэнгүйгээр эдгээр газруудын жагсаалт, хаяг, харилцах мэдээллүд 17.4.бүлэгт бичигдсэн байгаа). Шийдвэрийн эсрэг давж заалдах өргөдлийг 15 хоногийн дотор өгч болох ба шийдвэрийг гадаадын иргэдийн оршин суух талаар шийдвэрлэдэг Комис шийдвэрлэнэ. Хэрэв энэ шийдвэр мөн татгалзсан байвал шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор Праг дахь хотын шүүхэд давж заалдаж болно.

Байнга оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгөх үеэр:

– *гадаад паспортыг, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ, зураг, чех хэлний шалгалт өгсөн бичиг зэргийг заавал өгөх ба бусад шаардлагатай бичиг баримтууд 180 хоногоос хуучин байж болохгүй,*
– *хүнд өвчтэй байж магадгүй гэсэн тохиолдолд заавал эмчийн бичиг өгнө,*
– *холбогдох байгууллага шаардсан бүх гадаад хэл дээр бичигдсэн бичиг баримтууд чех хэлэнд албан ёсны орчуулга хийгдсэн байх ёстой.*



* Тайлбар: Одоогийн байдлаар ЕХ-ны иргэний гэр бүлийн гишүүн гуравдагч орны гадаадын иргэн, ЕХ-ны иргэний гэр бүлийн гишүүний оршин суух картны хэлбэрээр түр оршин суух зөвшөөрөл олгогдсон буюу байнга оршин суух зөвшөөрөл олгогдсон тохиолдолд.

4. 4. Биометрийн өгөгдөлтэй оршин суух зөвшөөрлийн үнэмлэх

2011 оны 7 сарын 4-нөөс эхлэн ЧУ биометрийн хэмээх өгөгдөл агуулсан оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгож байна – **нүүрний зураг** болон **хуруунуудын хээ** зэргийг тусгай тоног төхөөрөмжөөр авч байна. Энэхүү европын хууль зүйгээс үүдэн гарсан хэрэгжил нь Чех улсын нутаг дэвсгэрт **удаан хугацааны болон байнга оршин суух зөвшөөрлөөр** байрлаж байгаа **гуравдагч орны иргэдэд**, мөн олон улсын хамгаалалтын хэлбэрээр оршин суух зөвшөөрлийг эзэмшигчидэд (цагаачлал/нэмэгдэл хамгаалалт) олон төрлийн өөрчлөлтүүдийг авчирч байна – ЕХ-ны иргэн болон түүний гэр бүлийн гишүүнд хамаарахгүй. Одоохондоо ЧУ-д визээр байрлаж байгаа гуравдагч орны иргэдэд бас хамаарахгүй.

Яагаад биометрийн өгөгдлийг үйлдэж байна вэ?

Биометрийн өгөгдлийг буулгаж авах нь оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний болон эзмшигчийн үнэн зөвийг нотлоно – техникийн төхөөрөмжийн тусламжаар гуравдагч орны иргэний биеийн байцаалтыг шалгах явцад биометрийн мэдээллийг агуулсан ялтсан өгөгдөлийг мэдээллийн системээр удирдлагатай мэдээлэлтэй тулган үзэж эсвэл биометрийн мэдээллийг агуулсан ялтсан өгөгдөлийг үнэмлэх эзэмшигчийн одоогийн биометрийн өгөгдөлтэй тулган үзнэ. 2011 оны 5 сарын 20-ноос эхлэн ЕХ-ны гишүүн орнууд нь оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг гуравдагч орны иргэдэд олгохдоо биометрийн өгөгдлийг үүрэг болгож байна.

Биометрийн өгөгдлийг тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон **Дотоод Явдлын Яамны – зарим – цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллага** авч байна. Эдгээр газруудын нэрсийн жагсаалт нь Дотоод Явдлын Яамны 17. 4. бүлэгт, „BIO“ гэсэн товчилсон тэмдэглэгээгээр тэмдэглэгдсэн байгаа. Гадаадын иргэд нь биометрийн өгөгдлөө өгсөн газраа дараа нь тогтоосон хугацаанд ирж оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ хүлээж авна. Эдгээр газрууд нь гадаадын иргэдийн энгийн өргөдөл өгдөг өөрөөр хэлбэл ЧУ-д оршин суухтай холбоотой энгийн зүйлүүдийг шийдвэрлэдэг газруудаас ялгаатай.

Биометрийн өгөгдөлтэй холбоотой гадаадын иргэдийн үүрэг:

Хэрэв удаан хугацаагаар оршин суух/байнга оршин суух зөвшөөрлийн өргөдлийг гадаадад өгсөн бол удаан хугацааны виз олгосны дараа **удаан хугацаагаар эсвэл байнга оршин суух зөвшөөрлийг ирж авахдаа**, заавал өөрөө ЧУ-д орж ирсэн өдрөөс 3 ажлын өдрийн дотор Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллагад хүчинтэй гадаад паспорттай, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгох зориулалтын мэдээллүдийг (биометрийн өгөгдөлтэй) өгөх бэлтгэлтэй ирнэ. Оршин суух зөвшөөрлийн удаан хугацааны визийг төлөөний газар ирж авхад оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг олгох газруудын тодорхой хаягийг тэнд мэдэгдэнэ.

Оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг олгох тодорхой газарт очих өдрөө гадаадаас утсаар захиалж болох ба гадаадын иргэдэд бас удаан хугацааны виз олгох явцад оршин суух зөвшөөрлийг ирж авхыг мэдэгдэнэ.

Хэрэв гадаадын иргэн нь утсаар захиалах боломжгүй бол энгийн дараааллаар хүлээн авах ба тухайн газрын их ачааллаас шалтгаалж оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний биометрийн өгөгдлийг өгөх боломжгүй тохиолдолд хамгийн ойрхон дараагийн боломжтой хугацааг захиална.

ЧУ-аас удаан хугацааны/байнгын оршин суух зөвшөөрөл хүссэн тохиолдолд Дотоод Явдлын Яамны дуудлагаар **Дотоод Явдлын Яамны тухайн салбар газар өөрийн биеэр хүрэлцэн ирж** биометрийн өгөгдөл болон дижитал ажилбарын зориулалттай гарын үсэгнийхээ хэлбэрийг өгнө.

ЧУ-ын хууль дүрмийг баримтлан мөн шууд ЕХ-ны хууль дүрмийн дагуу гадаадын иргэд нь өөрсдийн биометрийн өгөгдөл болон дижитал ажилбарын гарынхаа үсгийг заавал өгөх үүрэгтэй. Дараа нь тогтоосон хугацаанд, энэ нь биометрийн өгөгдөлийг өгснөөс хойш 60 хоногийн дотор Дотоод Явдлын Яамны газар өөрийн биеэр хүрэлцэн ирж оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ хүлээн авна (үнэмлэх ирж авхыг мөн холбогдох байгууллага мэдэгдэнэ).

Хамгийн гол нь өргөдөл өгч байх үедээ эсвэл дараа нь биометрийн өгөгдлөө өгч байх үедээ ***Утас:ныхаа дугаарыг*** *эсвэл Э-майл хаягаа үлдээх хэрэгтэй ба Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллагын ажилтан таны үлдээсэн харьцаагаар биометрийн өгөгдлийг ирж өгөх(өргөдлийг зөвхөн ЧУ-д өгсөн тохиолдолд) буюу оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг ирж авах өдрийг мэдэгдэнэ. Хэрэв та харилцах харьцаагаа үлдээгээгүй, таньтай харьцах боломжгүй байсан тохиолдолд биометрийн өгөгдлийг ирж өгөх (өргөдлийг зөвхөн ЧУ-аас гадна байхдаа өгсөн тохиолдолд) буюу оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг ирж авах өдрийг бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд хүрэлцэн ирхээ* ***өмнө нь утсаар захиалга өгнө – /kontakty/ контактууд 17. 4-р бүлгээс үз***

Анхааруулах нь: Хэрэв хүчинтэй визийн үеэр оршин суух зөвшөөрлөө (энэ тохиолдолд бас байнга оршин суух зөвшөөрөл хамаарагдана) онцгой шалтгаангүйгээр ЧУ-д ирж аваагүй, ЦШХСБ--д оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгох болон хугацаагий нь сунгуулах үеэр, биометрийн өгөгдлөө ирж өгөөгүй эсвэл оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ ирж аваагүй тохиолдолд таны өргөдлийн үйл ажиллагааг зогсооно. Хэрэв өргөдлөө ЧУ-ын нутаг дэвсгэрт өгч, байнга оршин суух зөвшөөрлийн шийдвэрийг хүлээн авсны дараа эсвэл байнга оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний хугацааг сунгах шийдвэрийн дараа **биометрийн өгөгдөлөө ирж өгөөгүй эсвэл бэлэн болсон үнэмлэхээ ирж аваагүй тохиолдолд 10 000 коруны торгууль хүлээлгэнэ**.

Биометрийн өгөгдөлгүй оршин суух зөвшөөрлийн үнэмлэх

2011 оны дөрвөн сарын сүүл хүртэл хуулийн дагуу олгогдсон үнэмлэхүүд **хүчинтэй хугацаагаа дуустал эсвэл түүнд ямар нэгэн өөрчлөлт хийгдэх үе хүртэл хүчинтэй байна**.

Өөрийгөө төлөөлүүлэх боломжууд

Биометрийн өгөгдөл өгөх эсвэл оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг хүлээлгэн өгхөд **өөр хүнээр төлөөлүүлж болохгүй**.

Биометрийн өгөгдлийг өгхийг татгалзаж болох уу?

Удаан хугацаагаар оршин суух эсвэл байнга оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг олгохтой холбогдон бүх гуравдагч орны иргэд (ЕХ-ны иргэний гэр бүлийн гишүүдэд хамаарагдахгүй) биометрийн өгөгдлүүдийг заавал өгөх үүрэгтэй учраас татгалзаж болохгүй.

Ямар шалтгаануудтай үед биометрийн өгөгдлийг үйлдэхгүй вэ?

Тодорхой байдлаас шалтгаалж хурууны хээ авахгүй – энэ нь хэрэв анатомын болон биеийн өөрчлөлт, тодорхойлбол гарын хуруу гэмтэлд өртсөн тохиолдолд. Ийм тохиолдолд оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний биометрийн өгөгдөлд зөвхөн нүүрний зургийг авна.

Хүүхдүүдэд ямар дүрэм журам үйлчлэх вэ?

6 нас хүртлэх хүүхдүүдийн зөвхөн нүүрний зургийг авна.

Урьд өмнө олгосон миний оршин суух зөвшөөрлийн үнэмлэх биометрийн өгөгдөл агуулаагүй – би шинэ үнмэлэхний өргөдөл өгөх үүрэгтэй юу?

Одоогийн таны үнэмлэх тань хугацаагаа дуустал хүчинтэй. Биометрийн өгөгдөлтэй үнэмлэхийг доорхи нөхцөлд олгогдоно:

- удаан хугацааны оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг сунгуулах (өргөдлийг хугацаа дуусхаас өмнө хамгийн эрт нь 90 хоног хамгийн цаад хугацаа нь 14 хоногийн өмнө өгнө) эсвэл
- байнга оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг сунгуулах (өргөдлийг хугацаа дуусхаас 90 хоногийн өмнө өгнө) эсэвл
- оршин суух үнэмлэх шинээр хэрэгтэй болсон тохиололд (жнь. одоогийн үнэмлэхэнд дурьдсан зүйлүүдийн зарим нь өөрчлөгдсөн тохиолдолд)

Гадаадын иргэдийн биометрийн өгөгдлийн мэдээллийг яах вэ?

Та бүхний оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгохтой холбоотой биометрийн мэдээллийн өгөгдлүүдийг оршин суух зөвшөөрлийн үнэмлэхэн дэх ялтсан мэдээлэл агуулагчид суулгасан

байгаа. Хадгалагдсан мэдээллүүд нь хувийн мэдээлийг хамгаалах хуулиар хамгаалагдсан ба Дотоод Явдлын Яам биометрийн мэдээллүдийг гадаадын иргэдийн мэдээлийн системд оруулж(158а-р зүйл 5-р догол мөр) тэнд архивт хадгалагдах ба оршин суух зөвшөөрлийн **үнэмлэхний хугацаа дуусан эсвэл хугацааг хүчингүй болгосноос 60 хоногийн дараа устгагдана** (160/7-р зүйл). Биометрийн мэдээллийг оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний болон таны биеийн байцаалтын үнэн зөвийг нотлоход ашиглах ба энэ нь техникийн төхөөрөмжийн тусламжаар таны биеийн байцаалтыг шалгах явцад биометрийн мэдээллийг агуулсан ялтсан өгөгдлийг мэдээллийн системээр удирдлагатай мэдээлэлтэй тулган үзэж эсвэл биометрийн мэдээллийг агуулсан ялтсан өгөгдлийг таны одоогийн биометрийн өгөгдөлтэй тулган үзнэ. Та өөрийн эзэмшсэн оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ биеийн байцаалтын шалгалтын үеэр шалгаулах боломжгүй, эсвэл оршин суух зөвшөөрлийн үнэмлэхний биометрийн өгөгдөлтэй мэдээлэл агуулагч ажиллахгүй тохиолдлуудад таны хурууны хээг дахин авч гадаадын иргэдийн мэдээллийн системийн биометрийн өгөгдөлтэй тулган үзнэ.

Ялтсан мэдээлэл агуулагч ажиллаж байгаа эсхийг шалгаж үзэж болох уу?

Болно, та Дотоод Явдлын Яаманд ялтсан мэдээлэл агуулагчийг ажиллаж байгаа эсхийг шалгуулах эрхтэй. Хэрэв таны зүгээс шалтгаалаагүй ялтсан мэдээлэл агуулагч нь ажиллахгүй тохиолдолд та төлбөргүй шинэ үнэмлэх олгох өргөдөл гаргах эрхтэй.

Албан төлбөр

Албан төлбөрийн тухай хуулийн дагуу биометрийн өгөгдөлтэй үнэмлэх олгохтой холбоотой доорхи албан төлбөрүүдийг авна (төлбөрийг татварын наадаг тэмдэгт (kolek) хэлбэрээр үйлдэх ба үүнийг бүх шуудангийн газар худалдаж авч болно):

- **удаан хугацаагаар оршин суух** зөвшөөрлийн үнэмлэх олгох эсвэл түүний хугацааг сунгуулхад: 2500 корун (1000 корун 15-аас доош насны хүүхдүүдэд),
- **байнга оршин суух** зөвшөөрлийн үнэмлэх олгох эсвэл түүний хугацааг сунгуулхад: 2500 корун (хүүхдүүд насны ангилалгүй, бас 15-аас доош насны хүүхдүүд ч гэсэн мөн адил),
- оршин суух зөвшөөрлийн **үнэмлэх дэх өөрчлөлтөнд**: 1000 корун,
- гэмтсэн, устгагдсан, гээгдсэн, хулгайд алдагдсан, үнэмлэхний ялтсан мэдээлэл агуулагч ажиллахгүй болсон зэргүүдээс шалтгаалж шинэ үнэмлэх нөхөн олгоход: 4000 корун (2500 корун 15-аас доош насны хүүхдүүдэд).

4. 5. Бусад хэрэгтэй мэдээллүүд

➢ **Зорчигчийн эрүүл мэндийн даатгал**

<u>90 хүртлэх хоног байрлахад</u> хэрэгтэй зорчигчийн эрүүл мэндийн даатгалын шаардлагуудыг визийн кодекс тогтооно. Гадаадын иргэдийн хуулийн 180i-р зүйлийн 2-р догол мөрд тогтоосон нөхцөлд зорчигчийн эрүүл мэндийн даатгалын бичиг баримтыг шаардахгүй. Шенгений визтэй тохиолдолд даатгал нь бүхий л Шенгений орнуудад хүчин төгөлдөр байх шаардлагатай.

<u>90 хоногоос дээш хугацаагаар оршин суух үед</u> (удаан хугацааны виз, удаан хугацаагаар оршин суух) гадаадын иргэний эрүүл мэндийн даатгал нь шаардлагатай анхан шатны эрүүл мэндийн эмчилгээ үзлэг, зөөвөрлөхтэй холбоотой бүхий л зардал, нас нөхцөн тохиолдолд шарилыг нь гадаад паспортынх нь харъяа улсад эсвэл оршин суух зөвшөөрөлтэй өөр улсад хүргэх зэрэг зардлуудыг хариуцаж болхуйц шаардлагатай байна. Дээр дурьдсан даатгалын хариуцах лимит нь нэг даатгалын хугацаанд хамгийн бага нь 60 000 евроны хүрээтэй байх ба харин энэ нь дээр дурьдсан зардлуудад даатгуулагч хамтран оролцохгүй..

<u>90 хоногоос дээш хугацаатай оршин суух</u> үед хэрэглэгдэх Зорчигчийн эрүүл мэндийн даатгалын газар нь:

a) даатгалын тухай хуулийн дагуу даатгах эрх бүхий, Чех улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байх,
b) Европын холбооны гишүүн орнуудад эсвэл Европын аж ахуйн талбар1-ийн гэрээтэй орнуудад эсвэл гадаадын иргэний гадаад паспортын харъяат улсад, эсвэл гадаадын иргэний оршин суух зөвшөөрөлтэй өөр улсуудад даатгалын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байх.

Хэрэв гадаадад даатгуулсан, даатгалын бичгүүд гадаад хэлээр байгаа тохиолдолд гадаадын иргэн нь даатгалын гэрээ, нийтийн даатгалын болзол зэргийг Чех хэлэнд албан ёсоор орчуулга хийлэгсэн байх шаардлагатай ба энэ нь даатгалд даатгуулсан гэрээ, ялангуяа 60 000 евроны лимиттэй үйлчлэх хүрээ, гэрээг даатгуулагчийн хамтарсан оролцоогүйгээр байгуулсан, ЧУ--ын нутаг дэвсгэрт байрлах үед даатгалын төлбөр хийгдсэн бичиг зэргүүдийг нотлосон байх шаардлагатай.

Даатгалын болзлуудыг 180j-р зүйлд дурьдсан

➢ **Оршин сууж буй газрын бүртгэл (гадаадын иргэдийн хуулийн 93-р зүйл)**

Гадаадын иргэдийн тухай хуулийн дагуу гадаадын иргэн нь **Чех улсын нутаг дэвсгэрт нэвтэрч орж ирсэн өдрөөс 3 ажлын өдрийн дотор өөрийнхөө байрлаж байгаа** газрыг оршин сууж байгаа газрынхаа харьяа цагдаад бүртгүүлэх үүрэгтэй. Энэ үүрэг нь 15-аас доош настай гадаадын иргэдэд, Гадаад Явдлын Яамнад бүртгэлтэй төлөөний газрын албаны ажилчид, эсвэл ЧУ-д суугаа төрийн албаны элчин сайдын яамны ажмлчид, тэдний гэр бүлийн гишүүд эсвэл ЧУ--ын Дотоод Явдлын Яамнаас байрлуулж байгаа гадаадын иргэдэд хамааралгүй. Мөн энэ үүрэг нь байрлуулагчидад үүргээ биелүүлсэн, жнь зочид буудалд байрлаж байгаа гадаадын иргэдэд хамааралгүй (гадаадын иргэдийн хуулийн 103-р зүйлийн b/).

Байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд нь **оршин сууж буй газраа өөрчилж,** энэ өөрчлөгдсөн газраа 180 хоногоос дээш хугацаагаар байрлана гэж тооцсон тохиолдолд өөрчлөлт гарсан өдрөөс **30 ажлын өдрийн** дотор Дотоод Явдлын Яаманд бүртгүүлэх үүрэгтэй (98-р зүйл 1-р догол мөр).

Чех улсын нутаг дэвсгэрт 90 хоногоос дээш хугацааны визтэй эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд нь оршин сууж буй газраа өөрчилж, энэ өөрчлөгдсөн газраа 30 хоногоос дээш хугацаагаар байрлана гэж тооцсон тохиолдолд өөрчлөлт гарсан өдрөөс 30 өдрийн дотор Дотоод Явдлын Яаманд бүртгүүлэх үүрэгтэй (98-р зүйл 3-р догол мөр). ЧУ-ын нутаг дэвсгэрт визгүй байрлаж болох гадаадын иргэд нь оршин сууж буй газраа өөрчилж, энэ өөрчлөгдсөн газраа 90 хоногоос дээш хугацаагаар байрлана гэж тооцсон тохиолдолд өөрчлөлт гарсан өдрөөс 30 өдрийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй (98-р зүйл 4-р догол мөр).

Европын холбооны иргэн нь ЧУ-д 30 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар шийдвэрлэсэн тохиолдолд ЧУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор оршин сууж буй газраа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй; энэ үүрэг нь ЧУ-д байрлаж байгаа **Европын холбооны иргэний гэр бүлийн гишүүдэд бас хамааралтай**. Оршин сууж буй газраа бүртгүүлэх үүрэг нь байрлуулагчидад үүргээ биелүүлсэн гадаадын иргэдэд хамаарахгүй.

➢ **Бичиг баримт хүлээн авах хаяг**

Гадаадын иргэдийн хуулийн 158-р зүйлийн 3-р догол мөрд зааснаар гадаадын иргэний өөрийнх нь хүсэлтээр гадаадын иргэний хууль эсвэл тусгай хууль дүрмээр бичиг баримт илгээх хаягийг бүртгэж болно. Энэ хаягаа өөрчилсөн эсвэл хүчингүй болгосон тохиолдолд гадаадын иргэн нь цагдаагийн байгууллагад эсвэл Дотоод Явдлын Яаманд мэдэгдэнэ.

➢ **Үнэмлэхэн дээрх өөрчлөлтийг мэдэгдэх**

Тухайн үнэмлэхэн дээр өөрчлөлт гарсан тохиолдолд (жнь: овог) өөрчлөлт гарсан өдрөөс **3 ажлын өдрийн дотор** өөрчлөлтийг яаманд мэдэгдэх үүрэгтэй.

Оршин сууж буй газар өөрчлөгдвөл (байрны хаяг) – дээр дурьдсан: „Оршин сууж буй газрын бүртгэл“ хэсэгт үз.

➢ **Албан бичиг баримтуудын баталгаажуулалт**

Визийн буюу оршин суух зөвшөөрлийн өргөдөлтэй цуг өгч буй бүх гадаад улсын бичиг баримтуудыг

– **дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгох** ба эсвэл хуулийн нэмэлт бичиг хавсаргана, үүнийг гадаадад буй ЧУ-ын төлөөний газар үйлдэнэ. Тухайн бичиг баримт нь эрх бүхий албан хаагч/байгууллагаар олгогдсон буюу батлагдсан, мөн энэ албан бичгэн дээрх гарын үсэг, албаны тамга зэргийн үнэн зөвийг баталгаажуулж байна гэдгийг тодорхойлно; эсвэл

– **Апостилле /Apostille/ хэмээх хавсралт хийх** (бичиг баримтанд албан тодорхойлолт холбож хавсаргах) – энэ тохиолдолд бичиг баримт нь гадаадад буй ЧУ-ын төлөөний газраар баталгаажуулагдсан байх ба харин хамгийн сүүлийн баталгаажуулалтыг бичиг баримтыг олгосон улсын апостилны /apostilní/ байгууллага хийнэ. Тухайн бичиг баримт нь эрх бүхий албан хаагч/холбогдох байгууллагаар олгогдсон буюу батлагдсан, мөн энэ албан бичгэн дээрх гарын үсэг, албаны тамга зэргийн үнэн зөвийг баталгаажуулж байна гэдгийг хуулийн хавсралт тодорхойлно. Апостиллег /Apostille/-г зөвхөн 1961 оны 10 сарын 5-ны өдрийн Хааг-д хийгдсэн гадаадын албан бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг хүчингүй болгосон тухай гэрээнд оролцсон улсууд олгоно. Гэрээний хуудас болон Апостиллег /Apostille/ олгох байгууллагуудын танилцуулгыг англи, франц хэлээр олон улсын хүний эрхийн Хаагийн бага хурлын вэбийн хуудсанд танилцуулсан www.hcch.net (► Conventions ► All Conventions ► 12. Convention of 5 October 1961 Abolishing the Requirement of Legalisation for Foreign Public Documents ► Status table/Authorities); эсвэл

– хэрэв улс хоорондын хүчинтэй гэрээ тогтоосон, ЧУ болон тухайн улсад үзүүлбэр болгон танилцуулагдан хавтаслагдсан бичиг баримтыг **дээд баталгаажуулалт хийлгэхээс чөлөөлнө**.

Бичиг баримтыг дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгох эсэх, апостилли /apostilly/-ийн хавсралт хийх эсэх эсвэл шаардлагатай баталгаажуулах эсэх мэдээллүүдийг ЧУ-ын төлөөний газраас утсаар асууж болно.

Мэдээллүүдийг ЧУ-ын Дотоод Явдлын Яамны вэб хуудаснаас мэдэж болно www.mzv.cz (► /Cestujeme/Зорчих ► /Ověřování listin/Бичиг баталгаажуулах – /informace referátu legalizace odboru konzulárních činností/Консулын газрын үйл ажиллагааны хууль зүйн мэдээллийн хэлтэс) эсвэл ЧУ-ын Шүүх яамны www.justice.cz (► /Ministerstvo spravedlnosti/ Шүүх яам ► /Odborné činnosti a služby veřejnosti/Мэргэжлийн үйл ажиллагаанууд болон нийтийн үйлчилгээнүүд ► /Ověřování listin do ciziny/Гадаадад хэрэглэгдэх бичиг баримтууд).

!!! АНХААРУУЛГА !!!

*Гадаадын иргэдийн оршин суух талаар маш хурдан хуулийн өөрчлөлт болж байгаагаас үүдэж гадаадын иргэдийн тухай хууль нь ихээр шинэчлэгдэж байна. Тэгхээр та бүхэнд хамгийн ойрхон(орон нутгийн)**ДоЯ-ны гадаадын иргэдийн оршин суухыг хариуцсан газар**(17. 4.бүлэгт үз),гадаадын иргэдэд туслах **төрийн бус байгууллагуудад** (16-р бүлэгт үз)хандаж энгийн мэдээллүүдийг авхыг зөвлөж байна. Мөн энэ утсыг ашиглаж болно: ДоЯ-ны гадаадын иргэдэд зориулсан мэдээлийн шугам**: утас: 974 832 421, 974 832 418** э-майл: **pobyty@mvcr.cz***

*Дотоод Явдлын Яамны вэб хуудас**: www.mvcr.cz/cizinci***

4. 6. Регистрийн дугаар

Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй эсвэл 90 хоногоос дээш хугацаатай түр оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд эсвэл Чех улсын нутаг дэвсгэрт 3 сараас дээш хугацаагаар байрлахыг шийдсэн Европын холбооны иргэдэд оршин суугчидын бүртгэлийн тухай 133/2000 тоот хуулийн 14-р зүйлийн d)-гийн 5-д зааснаар **Дотоод явдлын яамны эрх бүхий байгууллагаас регистрийн дугаар олгоно**(гадаадын иргэдэд цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллага). Регистрийн дугаар олгох талаархи шаардлагуудын (жнь: хэрэгтэй бичиг баримтууд, олгогдох хугацаа гм..) мэдээллүүдийг гадаадын иргэдэд оршин суух зөвшөөрөл олгодог Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллагаас авч болно.

Өргөдөл өгөх, бөглөх маягтын талаархи мэдээллүүдийг http://www.mvcr.cz (► /Služby pro veřejnost/Нийтийн үйлчилгээ ► /Rady a služby/Зөвлөлгөө, үйлчилгээ ► /Občan na úřadě/Иргэн байгууллагад ► /Rodná čísla/Регистрийн дугаар).

4. 7. Чех улсын иргэн

Чех улсад төрснөөр ЧУ-ын иргэн болох үндсэн шалтгаан (хүүхдийн эцэг эх хоёрын нэг нь ЧУ-ын иргэн байвал, эсвэл Чех улсад төрсөн хүүхдийн эцэг эх нь аль ч улсын иргэн бус, тэдний аль нэг нь ЧУ-д байнга оршин суух зөвшөөрөлтэй тохиолдолд хүүхдийг улсын иргэн болгож болно) юм.

Гадаадын иргэдийн өргөдлийн дагуу Дотоод Явдлын Яам Чех улсын иргэншлийг (улсын иргэншлийг олгоход хуулийн эрх үгүй) олгох ба доорхи шаардлагуудыг хангасан байх ёстой:

- ЧУ-д хамгийн бага нь таван жил байнга оршин суух зөвшөөрөлтэй байх (энэ хугацаанд гадаадын иргэд нь ЧУ-д тасралтгүй оршин суусан байх). **Дутуу хугацааг** онцгой тохиолдолд Дотоод Явдлын Яам хэлтрүүлж болно.
- ЧУ-ын иргэн болохдоо одоогийн улсынхаа иргэнээс хасуулна, эсвэл одоогийн улсын иргэнээс хасуулсан гэсэн нотолгоо баримт өгнө. Гадаадын иргэн нь иргэнээс хасуулсан баримт бичгийг эхлээд өргөдөлтэй цуг өгхийн шаардлагагүй. Энэ бичгийг ЧУ-ын иргэн болох амлалт хэмээх албан ёсны үйл ажиллагааны дараа өгч болно. Зарим тохиолдолд одоогийн улсын иргэнээс хасуулсан нотолгоо бичиг баримтыг хэлтрүүлж болно.
- сүүлийн 5 жилд ЧУ-д санаатайгаар эрүүгийн гэмт хэргээр шүүн таслагдаагүй байх. Энэ шалтгааныг хэлтрүүлж болохгүй.
- Чех хэлний шалгалт өгнө. Энэ шаардлагыг Дотоод Явдлын Яам маш онцгой нөхцөлд хэлтрүүлнэ (жнь: өндөр настай, эрүүл мэндийн шалтгаанаас).
- гадаадын иргэдийн хуулийн дагуух эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, татвар, төлбөр төлөлт зэрэг үүргийн биелэлтүүд (жнь: эрүүл мэндийн даатгалд өргүй, цаг тухайд нь татвар төлөгдсөн, тайлан мэдээллүүдийн үүргийг биелүүлсэн). Энэ шаардлагыг Дотоод Явдлын Яам маш онцгой нөхцөлд хэлтрүүлнэ.

Чех улсын иргэн болох болон иргэнээс хасуулах тухай хууль нь өргөдөлд шаардагдах зүйлүүдийг тогтооно. Гадаадын иргэн нь улсын иргэн болох өргөдлийг Дотоод Явдлын Яаманд хаяглан өөрийн байнга оршин сууж буй газрынхаа харъяат крайн /аймгийн/ (Праг-д Праг-1-ээс Праг-22 хүртлэх хотын захирганууд, Брно Остравад эдгээр хотын захиргаануудад, Плзень-д Плзень-3 дүүргийн хотын захиргааны) захиргааны өгнө. Гэр бүлийн хоёр цуг өргөдлөө өгч болох ба 18 хүртлэх насны хүүхдүүдийг өргөдөлдөө хамруулж болно.

Өргөдөл гаргагчтай цуг Крайн захиргаа анкет бөглөж, чех хэлний мэдлэгийг нь ярилцлага хийж нотлож, улсын иргэн болох өргөдлийг өөрийн саналтай, өргөдөл гаргагчийн оршин сууж буй газрын суурингийн болон хотын захиргааны саналтай, бусад бичиг баримттай хамт өргөдөл өгсөн өдрөөс 30 хоногийн дотор гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн байгууллагад илгээх ба цагдаагийн байгууллага бас өөрийн саналаа хавсарган Дотоод Явдлын Яаманд илгээх бөгөөд Дотоод Явдлын Яам өргөдлийн шийдвэрийг гаргана.

Дотоод Явдлын Яам шийдвэрийг 90 хоногийн дотор гаргах ба өргөдлийг хэлэлцэж байх хугацаанд ихэнх тохиолдлуудад хувийн ярилцлаганд дуудна. Хэрэв яам нь улсын иргэн болох өргөдлийг **татгалзсан** тохиолдолд шийдвэрийг хүлээж авсан өдрөөс 15 хоногийн дотор **Дотоод Явдлын Яаманд** давж заалдах **(задлах)** өргөдөл өгч болно. Хэрэв Дотоод Явдлын Яамнаас татгалзсан хариу ирвэл үүний эсрэг 2 сарын дотор Праг дахь Хотын шүүхэд гомдол гаргаж болно.

Хэрэв зөвшөөрсөн шийдвэр ирвэл гадаадын иргэн нь суурингийн болон хотын захиргааны нарийн бичгийн даргын өмнө улсын иргэний амлалт өргөх ба амлалтын дараа түүнд ЧУ-ын иргэн болсон Бичиг гардуулна. Гадаадын иргэн нь амлалт өргөсний дараа ЧУ-ын иргэн болно. **18 хүртлэх насны хүүхдүүд** эцэг эхтэйгээ цуг улсын иргэн болно. Улсын иргэн болох албан ёсны төлбөр нь 10 000 Чех корун. Дотоод явдлын яам нь улсын эрх ашгийн үүднээс онцгой тохиолдолд төлбөрийг **1 000 Чех корун** хүртэл багасгаж болно.

Улсын иргэн болох өргөдлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг http://www.mvcr.cz (► /Služby pro veřejnost/Нийтийн үйлчилгээ ► /Rady a služby/Зөвлөлгөө, үйлчилгээ ► /Státní občanství České Republiky/Чех улсын иргэн).

Одоогийн байдлаар Дотоод явдлын яам Чех улсын иргэн болох болон иргэнээс хасуулах талаар шинэ хуулийн саналыг бэлдэж байгаа ба Чех улсын иргэн болох өргөдөл өгсөн гадаадын иргэдийн талаархи зарим шинэ тодорхой болзлуудыг бэлдэж байна. Энэ шинэ хуулийг 2013. 1. 1-нээс эхлэн мөрдөх төлөвлөгөөтэй байна.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- Одоогийн мөрдөж байгаа **гадаадын иргэдийн тухай хуулийг** Дотоод Явдлын Яамны интернет хуудаснаас http://www.mvcr.cz/cizinci (► /Podmínky vstupu a pobytu cizinců na území České republiky/Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд нэвтрэн орох болон оршин суух болзлууд ► /Zákony a předpisy/Хууль дүрмүүд) мэдэж болно.
- 429/2010 тоот тогтоол нь улсын иргэд нь өөрийн харъяат улс, гадаад паспорт олгосон улс, удаан хугацааны зөвшөөрөлтэй болон байнга оршин суух зөвшөөрөлтэй улсаас өөр улсад байгаа төлөөний газарт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгч болох улсуудын нэрсийн жагсаалтыг тогтоосон, эдгээрийн нэрсийн жагсаалтыг энэ хаягаас олж болно http://www.mvcr.cz (/Legislativa/Хуульчилал ► /Sbírka zákonů/Хуулийн эмхэтгэлүүд).
- ЕХ-ны иргэд болон тэдний гэр бүлийн гишүүд Чех улсад оршин суух талаархи мэдээллүүдийг
  - http://www.mvcr.cz/cizinci (► /Informace o pobytu pro občany EU a jejich rodinné příslušníky/ЕХ-ны иргэд болон тэдний гэр бүлийн гишүүдийн оршин суух мэдээллүүд) мэдээллийн товхимол байдлаар Чех, Англи, Герман, Болгар, Румын хэлүүдээр; эсвэл
  - http://www.mvcr.cz/cizinci (► /Podmínky vstupu a pobytu cizinců na území ČR/ Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд нэвтрэн орох болон оршин суух болзлууд ► /Občané EU, Islandu, Norska, Lichtenštejnska a Švýcarska a občané třetích zemí - rodinní příslušníci občanů EU, Islandu, Norska, Lichtenštejnska a Švýcarska/ЕХ-ны, Исланд, Норвег, Лихтенштейн, Швейцар, гуравдагч орны иргэд- ЕХ-ны, Исланд, Норвег, Лихтенштейн, Швейцар улсуудын иргэдийн гэр бүлийн гишүүд)
- Шенген/ЧУ-д гуравдагч орны иргэд оршин суух талаархи мэдээллүүдийг:
  - http://www.mvcr.cz/cizinci
  - http://www.mvcr.cz (► /EU/EX ► /Schengen/Шенген)
  - http://www.euroskop.cz/schengen бас Шенген ЧУ гэсэн хүснэгтэнд
- ЧУ визийн харьцааг хүчингүй болгосон гэрээ байгуулсан улсуудын нэрсийн жагсаалтыг энэ интернет хуудаснаас мэдэж болно: http://www.mvcr.cz (► /O nás/Бидний тухай ► /Azyl a migrace/Цагаачлал шилжин суурших ► /Migrace/Шилжин суурших ► /Vízová politika/ Визийн бодлого ► /Přehled přechodného pobytu cizince na území ČR bez víza/ЧУ-д визгүй түр хугацаагаар оршин суух гадаадын иргэдийн талаар)
- **Шенгений визийн өргөдөлийн** хэлбэр, түүнийг Чех, Англи хэлээр бөглөх заавруудыг энэ интернет хуудаснаас мэдэж болно http://www.mvcr.cz/cizinci (► /SOUVISEJÍCÍ ODKAZY/ХОЛБОГДОХ ИШЛЭЛҮҮД ►/Formuláře/Маягт ►Žádost o udělení schengenského víza/ Шенгений визийн өргөдөл)
- **Оршин суух зөвшөөрлийн өргөдлийг бөглөх маягт**, эдгээр нь одоогийн байдлаар Чех, Англи, Украйн, Вьетнам, Орос, Монгол хэлээр орчуулагдсан ба үүнийг энэ интернет хуудаснаас мэдэж болно http://www.mvcr.cz/cizinci (► /SOUVISEJÍCÍ ODKAZY/ ХОЛБОГДОХ ИШЛЭЛҮҮД ►/ Formuláře/Маягт ► /Žádost o povolení k pobytu/Оршин суух зөвшөөрлийн үнэмлэх)
- Байнга оршин суух зөвшөөрлийн шаардлагуудын дэлгэрэнгүй мэдээллүүдийг http://www.mvcr.cz/cizinci (► /Trvalý pobyt na území České republiky/Чех улсад байнга оршин суух)
- Дотоood Явдлын Яамны интернетийн хуудаснаас мөн доорхи мэдээллүүдийг мэдэж болно http://www.mvcr.cz/cizinci жнь:

- Маягтын болон өргөдлийн бөглөх загвар (► /SOUVISEJÍCÍ ODKAZY/ ХОЛБОГДОХ ИШЛЭЛҮҮД ► /Formuláře/ Маягт)
- Гадаадын иргэдийн их асуудаг асуултын хариу (► /Často kladené otázky/Олонтаа асуудаг асуултууд)

○ иргэд ЧУ-ын нутаг дэвсгэрт нэвтэрч орж ирэх болон оршин суух талаархи мөрдөгдөх хууль тогтоолуud (► /Podmínky vstupu a pobytu cizinců na území ČR/Гадаадын иргэд ЧУ-д нэвтрэн орж ирэх болон оршин суух талаархи шаардлагууд ► /Zákony a předpisy/Хууль дүрмүүд)

- Гадаад Явдлын Яамны интернет хуудаснаас визийн асуудалтай талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас мэдэж болно (http://www.mzv.cz) (► /Informace pro cizince/Гадаадын иргэдэд зориулсан мэдээлэл)
- **ЧУ-ын гадаадад суугаа төлөөний газруудын, ЧУ-д суугаа гадаадын орнуудын төлөөний газруудын хаягуудыг** ГаЯ-ны интернет хуудаснаас мэдэж болно– http://www.mzv.cz (► /Ministerstvo/Яамнуудын тухай ► /Diplomatické mise/Дипломат төлөөлөгч)
- Гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн байгууллагын хуудаснаас гадаадын иргэдийн оршин суух талаархи мэдээллүүдийг мэдэж болно (http://www.policie.cz) (► /Útvary Policie ČR/ЧУ-ын цагдаагийн байгууллага ► /Celorepublikové útvary/Улсын бүх байгууллагууд ► /Služba cizinecké policie/Гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн байгууллагын үйлчилгээ ► /Informace pro pobyt cizinců/Гадаадын иргэдийн оршин суух талаархи мэдээллүүд)
- Гадаадын орны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг хүчингүй болгосон гэрээнд элссэн орнуудын, эдгээр орнуудтай ЧУ-нь хуулийн тусламж, албан бичиг баримтыг дээд баталгаажуулалтаас чөлөөлөх талаархи хоёр талын гэрээг хийсэн орнуудын нэрсийн жагсаалтыг www.justice.cz (►/Ministerstvo spravedlnosti/Шүүх яам ► /Odborné činnosti a služby veřejnosti/Мэргэжлийн үйл ажиллагаа, нийтийн үйлчилгээ ► /Ověřování listin do ciziny/ Гадаад руу гарах баталгаажуулсан бичиг баримтууд)
- **Нотратуудын нэрсийн жагсаалт**, бичиг баримтын хуулбарыг эх хувьтай нь албан ёсоор баталгаажуулах ба эдгээрийг энэ хаягаас олж болно http://www.nkcr.cz (► /Seznam notářů/ Нотратын нэрсийн жагсаалт)
- Шүүх яамны интернет хуудаснаас гэмт хэргийн бүртгэлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас мэдэж болно– http://www.justice.cz (► /Rejstřík trestů/Гэмт хэргийн бүртгэл) эсвэл аль нэгэн Czech POINT – http://www.czechpoint.cz
- Ногоон картын тухай, иргэд нь ногоон карт хүсэж болох тогтоолоор тогтоосон улсуудын нэрсийн жагсаалт, зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас мэдэж болно http://www.mvcr.cz/cizinci (► /str. 2/хуудас 2 ► /Zelené karty/Ногоон карт)
- Улсын иргэн болох талаархи дэлгэрэнгүй мэдээллийг энэ хаягуудаас мэдэж болно
  - Албан газруудын портал – http://portal.gov.cz (► /Životní situace/Амьдарлын байдал ► /Cizinec/Гадаадын иргэн ► /Státní občanství/ Улсын иргэн), мөн
  - Дотоод Явдлын Яамны интернет хуудаснаас – http://www.mvcr.cz (► /Služby pro veřejnost/Нийтийн үйлчилгээ ► Rady a služby/Зөвлөлгөө үйлчилгээ ► /Občan na úřadě/Иргэн албан газарт ► /Státní občanství České Republiky/Чех улсын иргэн)
- **Регистрийн дугаарын өргөдөл** өгөх дараалал, маягтын талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас http://www.mvcr.cz (► /Služby pro veřejnost/Нийтийн үйлчилгээ ► /Rady a služby/Зөвлөлгөө үйлчилгээ ► /Občan na úřadě/Иргэн байгууллагад ► /Rodná čísla/Регистрийн дугаар)
- Байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгхөд шаардлагатай Чех хэлний шалгалтын талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг Чех, Англи хэлнээс гадна Украйн, Орос, Вьетнам, Монгол, Хятад, Араб, Франц хэлүүдээр энэ хаягаас мэдэж болно
  - http://www.msmt.cz/mezinarodni-vztahy/cestina-pro-cizince;
  - http://cestina-pro-cizince.cz англи хэлээр (http://check-your-czech.com).

5. ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ ҮЕД ХАНДАХ ГАЗРУУД

5. 1. Өмгөөлөгч хуульчид

Өмгөөлөгчид (хуульчид) нь өөрийн клентүүдээ шүүхийн болон өөр байгууллагуудын үйл ажиллагаанд, гэмт хэргийн үед өмгөөлөх, бүхий л хууль зүйн талаар зөвлөлгөө өгөх буюу бичиг баримтанд бичхэд төлөөлөн орлцоно (гэрээ гм...). Өмгөөлөгчидийн хууль зүйн үйлчилгээ нь төлбөртэй. Бүх өмгөөлөгчид нь Чех улсын өмгөөлөгчидын танхимд нэгдсэн ба энэ танхим нь тэдний үйл ажиллагааг хянаж байдаг учраас хэрэв өмгөөлөгчийн үйлчилгээнд сэтгэл хангалуун бус байвал үүнд гомдол гаргаж болно.

5. 2. Нийтийн (хүний) эрхийг хамгаалагч

Нийтийн эрхийг хамгаалагч (Омбудсман)-нь хувь хүнийг улсын захиргааны алба гүйцэтгэж буй албан газар болон бусад байгууллагуудтай харьцах үед тэдгээр байгууллагуудын харьцаа нь хуульд харшилсан эсвэл доголдолтой буюу буруу, ардчилсан хуульт улсын зарчимд болон сайн захиргааны зарчимд зохицохгүй хэмээх харьцаа гаргах эсвэл эдгээр байгууллагууд нь үйл ажиллагаагаа гүйцэтгэхгүй нөхцөлд хамгаална. **Хувийн харьцаа болон зөрчилдөөнд орлцож болхгүй,** шүүхийн шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох ба түүний шийдвэрийн эсрэг давж заалдах тал биш.

Омбудсман нь мөрдөн шалгах үйл ажиллагаанд хамааралгүй тус бүрчилсэн үйл ажиллагааг үйлдэх эрхтэй ба харин хууль түүнд улсын албан захиргааны албыг орлох эрх олгоогүй учраас түүний шийдвэрийг **өөрчлөх буюу хүчингүй болгож болохгүй.** Харин ямар нэгэн алдаа илэрвэл албан газруудаас буюу байгуулагуудаас гаргасан алдааг засхыг шаардаж болно.

5. 3. Хэрэглэгчидийн эрхийг хамгаалах,Чехийн худалдааны байцаан шалгах газар

Чехийн худалдааны байцаан шалгах газар (цаашид зөвхөн ЧХБ)-нь тогтоосон чанарын аюулгүй байдлыг мөрдөж байгаа эсэх, хүнсний бус бүтээгдхүүний болон үйлчилгээний эрүүл мэндийн доголдол болон аюулгүй байдал, мөн бүтээгдхүүний талаар хангалттай мэдээллүүдээр хангасан эсэх, хэрэглэгч сэтгэл хангалуун, үнэн зөв, бүрэн дүүрэн бүтээгдхүүн буюу үйлчилгээ эдлэсэн эсэх зэргийг шалгана. Хэрэглэгчидэд ЧХБ шалгах газар бүрд **зөвлөлгөө болон мэдээллийн үйлчилгээгээр** хангагдсан байгаа. Тэнд шалгуулах, гомдол гаргах эсвэл зөвлөлгөө авах, юм худалдаж авах үед буюу үйлчилгээгээр үйлчлүүлэх үед гарах асуудалд яаж хандах зэрэг асуудлуудыг шийдвэрлэнэ.

Чехийн худалдааны байцаах газар хүнсний худалдаанд зөвхөн үнэнч үйлчилж байгаа эсхийг шалгана, хүнс болон түүхий эд түүний үйлдвэрлэлийг Улсын хөдөө аж ахуй хүнсний бүтээгдхүүний байцаан шалгах газар шалгана.

Бусад хэрэглэгчидийг хамгаалах хүрээн дэх хяналтын байгууллагууд нь нийтийн эрүүл мэндийг хамгаалсан байгууллага, мал эмнэлгийн байгууллага, хотын хувиараа аж ахуй эрхлэх байгууллага, гаалийн байгууллага (хэрэглэгчидийг хамгаалах тухай 634/1992 тоот хуулийн 23-р зүйлд үз) зэргүүд юм.

Мөн хэрэглэгчидийн эрхийг хамгаалхад чиглэгдсэн төрийн бус ашигт бус байгууллагуудын зөвлөлгөө үйлчилгээг ашиглаж болох ба эдгээрээс хэрэглэгчидийн эрхийн талаархи мэдээллүүдийг авч болно. Зориулалтын зөвлөлгөө өгөх газар болон интернетийн үйлчилгээгээр тодорхой хэрэглэгчийн асуудлын талаар харьцаж болно.

5. 4. Авилгал хээл хахууль

Дотоод Явдлын Яамны цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллага гадаадын иргэдэд зориулсан авилгалын эсрэг шугам ажиллуулж байна. Гадаадын иргэд нь **ямар нэг авилгалын хэлбэртэй тохиолдсон үед энэ шугаманд мэдэгдэнэ, жнь: оршин суух зөвшөөрлийн үйл ажиллагааны үед.**

☏ ***974 847 704 – Авилгалын эсрэг гадаадын иргэдэд зориулсан шугам***

Даваа, Лхагва: 8:00–17:00
Мягмар, Пүрэв: 8:00–15:00
Баасан: 8:00–14:00

Энэ ажлын хугацаануудаас өөр үеэр шугамны дуу хадгалгчид өөрийнхөө яриаг бичлэг болгон үлдээж болох ба дараагийн өдөр нь оператор яриаг тань ажилбар хийнэ. Ярианы бичлэгийг ямар ч хамаагүй хэлээр бичнэ.

Оператор, цагаачлал шилжилт хөдөлгөөн суурьшилын байгууллагын ажилтан тухайн авилгалд өртсөн гадаадын иргэнтэй харьцаж, Чех Англи хэлээр ярилцлага хийнэ. Шугамны тариф нь байнгын Утас:ны шугамны үнэтэй адилхан байна.

Авилгалын гэрч болсон эсвэл авилгалд өртсөн тохиолдолд юу хийх, яаж хандах зэрэг хэрэгтэй зөвлөлгөө, мэдээллүүдийг **Дотоод Явдлын Яамны авилгалтай тэмцэх интернет хуудаснаас** үзэж болно – http://www.korupce.cz. Вэб нь их хэмжээний мэдээллүүд, хуулиуд, баримтууд, авилгалтай тэмцэх байгууллагын зөвлөлгөө болон контакт зэргийг агуулсан.

Чех улсад бас **199 дугаартай авилгалын эсрэг шугам** байдаг ба мөн үүнийг ашиглаж болно. 199 дугаарт хуулийн зөвлөгчөөр хангах ба эдгээр нь урьд өмнө нь албан газрын болон хувийн байгууллагуудын талд авилгал илрүүлж байсан хуульчид байна. 199 тоот шугаманд Утас:дхад үнэгүй бусад хуулийн зөвлөлгөөгөөр хангахад ч гэсэн үнэгүй. Энэ шугамыг чехийн төрийн бус ашигт бус Transparency International байгууллага ажиллуулдаг ба энэ нь авилгалд өртсөн хүмүүст хуулийн зөвлөлгөө өгөх олон жилийн туршлагатай байгууллага юм. 199 тоот шугаманд хэзээ ч хамаагүй хаанаас ч хамаагүй Утас:даж болно. Дэлгэрэнгүй мэдээллүүдийг http://www.linka199.cz.

5. 5. Онцгой байдлыг шийдвэрлэх

ЧУ-д байрлах үеэр янз бүрийн асуудлын гэрч болох эсвэл тэр асуудлуудад өртсөн тохиолдолд зөвлөлгөө тусламж хэрэг болно. Ийм тохиололд аль байгууллагад хандаж тусламж хүсэх талаархи товчхон танилцуулгыг энэ бүлгээс үзнэ үү.

!!!** Удаан хугацаагаар үргэлжилсэн асуудлыг яаралтай шийдвэрлэх үед энэ шугаманд Утас: дана **!!!

☏ ***112 – Онцгой үед утас: дах Европын нэгдсэн дугаар***

(утасдхад үнэгүй – өөрөөр ашигласан үед шийтгэлтэй, Англи, Герман хэлээр харьцаж болно)

Энэ дугаарт онцгой үед Утас:дахдаа мэдээлэх гол зүйлүүд:

- яг юу болсон, болсон үйл явдал ямар хүрээнд байгаа (жнь: юунд аюул учирсан эсвэл өртсөн, хэдэн хүн өртсөн),
- яг хаана болсныг (хаяг – хот суурин, гудамж, дугаар болон чиглэлийн дугаар, замын дугаар, километр, явах чиглэл, ойр байх чөлөөтэй газар),
- өөрийнхөө талаархи мэдээллүүд (нэр, Утас:ны дугаар, газар, хаанаас Утас:дсан).

Онцгой үеийн дуудлагын дараа хариу Утас:даж болсон үйл явдлыг болон зарим хэсгүүдийг тододгож асууж магадгүй, жнь: очих зам гм...

ЧУ-д онцгой үед Утас:дах дугаарууд нь:

➢ **150 – ЧУ-ын гал сөнөөгч аврах багийн**

Онцгой нөхцөлд энэ дугаарт Утас:дана (түймэр, хорт бодис асгарах осол гм.), энэ нь хүн, эд хөрөнгө, байгаль орчин зэргүүдэд аюул учруулсан тохиолдолд.

➢ **155 – Эрүүл мэндийн түргэн тусламж**

Хэрэв ЧУ-д оршин сууж байх үеэр таны эрүүл мэнд, амь насанд аюул учирсан, таны ойр тойрны болон бусад хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж хэрэгтэй болсон тохиолдолд

энэ дугаарт дуудна. Гэнэтийн хүнд өвчлөлт болон гэмтэл, өвчтөн өөрөө эмчид хүрч очих боломжгүй, өвчтөнг шаардлагатай эмнэлгийн газар хүргэж эмчлэх, өвчтөнгийн эрүүл мэндийн байдал улам муудаж болзошгүй эсвэл амь насанд нь аюул учирч болзошгүй үеүүдэд эрүүл мэндийн түргэн тусламжийн алба үйлчилдэг.

➢ **158 – Чех улсын цагдаагийн байгууллага**

Бидний хэн ч гэсэн амьдралдаа ямар нэгэн байдлаас шалтгаалж өөр бусдаас хуулийн эсрэг үйлдэл хүлээх, тухайн байдлыг мэдээлэгч, хохирогчоор, гэрч болох зэрэг асуудалтай тулгарч болзошгүй. **Эрүүгийн гэмт хэрэг** буюу хуулийн эсрэг хүнд хэргүүдийг эрүүгийн хуулинд бичсэн (2010. 1. 1-нээс хүчин төгөлдөр болсон эрүүгийн хуулийн 40/2009 тоот хууль нь, үүнээс өмнө хүчин төгөлдөр байсан эрүүгийн хуулийн 140/1961 тоот хуулийг шинэчлэн орлосон) байгаа. Эрүүгийн гэмт хэргийн хариуцлагыг 15-аас дээш насанд хүлээнэ. Эрүүгийн гэмт хэргийг илрүүлэх, хэрэгтэнг хэрэгт татах зэрэг нь цагдаагийн байгууллагын болон улсын прокурорын үүрэг юм.

Бага хэмжээгээр хууль зөрчсөн, гэмт хэргийн зүйл ангид заагдаагүй хэргийг **зөрчил** гэж нэрлэнэ. Зөрчлийг мөн цагдаа илрүүлнэ, ихэнх нөхцөлд хотын захиргаа шийдвэрлэнэ.

Хэрэв та ямар нэгэн гэмт хэргийн эсвэл зөрчлийн гэрч буюу хохирогч болж, өөрт тань болон ойрын хүмүүст аюул учруулж болзошгүй тохиолдолд өөрийн оршин суугаа газрын ойролцоох, эсвэл өөр шалтгаанаар байрлаж байгаа газрынхаа ойролцоох цагдаагийн газарт мэдэгдэх буюу эсвэл дээр дурьдсан Утас:ны дугаарт Утас:дана. Цагдаа нар таны дуудлагыг хүлээн авч тэмдэглэх үүрэгтэй. Цагдаагийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус тохиолдолд гомдол гаргаж болно. Гомдлыг ЧУ-ын Цагдаагийн удирдах газрын шалгалт гомдлын хэсэгт өгнө. Хэрэв цагдаагийн ажилтан таньд болон таны ойр тойрныхны эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байгаа тохиолдолд Цагдаагийн байцаан шалгах газарт хандаж болно.

➢ **156 – суурингийн (хотын) цагдаа**

Хотын цагдаа нь хотын захиргааны хүрээнд хотын болон нийтийн эмх журмыг хариуцаж байдаг байгууллага юм. Хотын цагдаагийн ажилчидад хүн бүр хандах эрхтэй; хотын цагдаа өөрийнхөө хүрээнд тэдэнд туслах үүрэгтэй. Хотын цагдаа нар үүргээ гүйцэтгэх үедээ Чех улсын цагдаатай хамтарч ажиллана. Хотын цагдаагийн үйл ажиллагаатай сэтгэл хангалуун бус байсан тохиолдолд гомдол гаргаж болно. Гомдлыг тухайн хотын төлөөлөгч зохион байгууллагчидад өгнө.

5. 6. Бусад онцгой байдлуудыг шийдвэрлэх

Дээр дурьдсан тохиолдож болзошгүй үйл явдлуудаас гадна өөр сөрөг үйл явдал тохиолдож болзошгүй жнь: гэрийн хүчирхийлэл, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдэд, мансууруулах бодисонд донтох, хүний худалдаа, ДОХХ/ХДХВ, байрлах байрны асуудал, хувийн болон гэр бүлийн асуудал зэргүүд.

Дээр дурьдсан асуудлууд тулгарвал тусгай мэргэжлийн байгууллагын тусламж авч болох ба тэдэнтэй харьцах контактыг энэ вэб хуудаснаас мэдэж болно http://www.zachranny-kruh.cz (► / Kdo Vám pomůže/Хэн таньд туслах вэ).

Эдгээр тусгай мэргэжлийн байгууллагуудад жнь:

БАЙГУУЛЛАГЫН НЭР	КОНТАКТ	ТУСЛАМЖ НЬ ХЭНД ХЭРЭГТЭЙ
LINKA DŮVĚRY CENTRA KRIZOVÉ INTERVENCE	284 016 666 – nonstop	Хувийн хямралд орсон нийгмийн сэтгэцийн тусламж
RIAPS (ambulantní psychosociální služby) (нийгмийн сэтгэцийн амбултори)	Chelčického 39, 130 00 Praha 3 222 586 768 (8:00–16:00 цаг) 222 582 151 (16:00–8:00 цаг) http://www.csspraha.cz/krizove-centrum-riaps	Амьдарлын хүнд нөхцөл дэх хүмүүс

LINKA BEZPEČÍ	116 111 – үнэгүй дуудлага, nonstop pomoc@linkabezpeci.cz www.linkabezpeci.cz	Хүүхэд залуучуудад
DĚTSKÉ KRIZOVÉ CENTRUM SPONDEA	Sýpka 25, 613 00 Brno krizovapomoc@spondea.cz 541 235 511, 608 118 088 www.spondea.cz	Тарчилган зовоогдсон, хүчирхийлэгдсэн хүүхдүүд, гэрийн хүчирхийлэлд өртөгсөд, Брно
DĚTSKÉ KRIZOVÉ CENTRUM	241 484 149 – nonstop www.dkc.cz	Тарчилган зовоогдсон, хүчирхийлэгдсэн хүүхдүүд, Праг
LINKA DŮVĚRY DIAKONIE	Diakonie ČCE – Středisko křesťanské pomoci v Praze Varšavská 37, 120 00 Praha 2 Даваа-баасан: 9:00–20:00 цаг 222 514 040, 222 521 912 777 734 173, 728 047 416 linka.duvery@diakoniecce.cz http://skp.diakoniecce.cz/	Хүнд амьдралтай хүмүүст, хүнд амьдралтай хүүхэдтэй эхчүүдийг байрлуулах
SDRUŽENÍ PODANÉ RUCE	Francouzská 36, 602 00 Brno 545 247 535 www.podaneruce.cz	Мансууруулах бодисонд өртсөн, Морава
LINKA K-CENTRUM	724 246 771, 487 831 545 k-centrum http://www.k-centrum-cl.cz	Мансууруулах бодисонд өртсөн, Чех
NÁRODNÍ LINKA PREVENCE AIDS	800 144 444 – үнэгүй дуудлага даваа-баасан 13-18цаг http://www.aids-hiv.cz	ХДХВ, ДОХХ
BÍLÝ KRUH BEZPEČÍ	257 317 100 (Праг) - nonstop 2 51 51 13 13 (Dona linka – гэрийн хүчирхийлэлд тусламж) www.bkb.cz	Тарчилган зовоогдсон, хүчирхийлэгдсэн хүүхдүүд, гэрийн хүчирхийлэлд өртөгсөдөд тусламж
LA STRADA ČR	INFO a SOS – шугам: 222 71 71 71, чехээр, мөн: – даваад 10:00–14:00 бас орос хэлээр – мягмарт 10:00–16:00 бас англи хэлээр – лхагвад 12:00–20:00 бас орос румын хэлүүдээр 800 077 777 – үнэгүй дуудлага лхагвад 12:00–20:00 Тохиролцоогоор бусад хэлээр. pomoc@strada.cz Байгууллагын Утас: 222 721 810 www.strada.cz	Хүний худалдаа болон хүн ашиглах байдалд өртөгдөгсөдөд туслах нийгмийн үйлчилгээ. Гадаадын иргэдийн оршин суух байдлыг харгалзахгүй туслах үйлчилгээ; тусламжийг нууцлаг байдлаар хүргэж болно.

ELEKTRA	272 911 110, 603 812 361 poradna@centrumelektra.cz www.centrumelektra.cz	Хүүхэд насандаа хүчирхийлэгдэж байсан эмэгтэчүүдэд тусламж
ROSA	Podolská 25, 147 00 Praha 4 241 432 466, 602 246 102 www.rosa-os.cz	Гэрийн хүчирхийлэлд өртөгсөдийн төв
INTERVENČNÍ CENTRUM PLZEŇSKÉHO KRAJE A TERÉNNÍ KRIZOVÁ SLUŽBA	Cukrovarská 16, 301 00 Plzeň Non-stop Утас: 777 167 004 www.dchp.cz	Гэрийн хүчирхийлэлд өртөгсөдөд тусламж, амьдралын хямралын болон онцгой үеийн тусламж
CHARITA ČESKÁ REPUBLIKA	Хямралын үеийн тусламж MAGDALA 251 552 790 (Praha), 516 417 351 magdala@charita-adopce.cz www.charita.cz	Хүний худалдаанд өртсөн хүмүүст тусламж, хүнд нөхцөлтэй гадаадын ирэгэдэд тусламж
LINKA DŮVĚRY	800 200 007 – үнэгүй дуудлага	Өндөр настангуудад зориулсан итгэл найдварын шугам

Тусламж хүссэн өргөдөл, амьдралын янз бүрийн байдлын асуудлын талаар зөвлөлгөө авах зэрэгт (**občanské poradny**) **иргэдэд зөвлөлгөө өгөх газарт** бас хандаж болно. Үнэгүй зөвлөлгөөг нийгмийн хүнд асуудлууд, гэр бүлийн болон хүмүүсийн хоорондын харьцаа, хүний эрх, ажил хөдөлмөрийн-хуулийн харьцаа, байр, хөрөнгө хуулийн харьцаа, даатгал, санхүү эдийн засгийн асуудал, эрүүл мэнд, хэрэглэгчидийн эрхийг хамгаалах зэрэг асуудлуудад өгнө. Нийгмийн үйлчилгээний талаархи мэдээллийг 10. 5-р бүлэгт дурьдсан.

6. СУРГУУЛИЙН СИСТЕМ БОЛОН БОЛОВСРОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

„Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Сургуульд суралцахыг хуулиар тогтоосон.“
(үндсэн эрх болон эрх чөлөө 33-р хуудас 1-р догол мөр)

Сургуулийн хууль болон дээд сургуулийн хуулиар сурч боловсрох үндсэн хууль дүрмийг тогтоосон байдаг. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын, дунд, мэргэжлийн дээд сургуулийн, бусад болвсрол эзэмших тухай 561/2004 тоот хууль (сургуулийн хууль), дээд сургуулийн тухай 111/1998 тоот хууль болон бусад мөрдөгдөж буй чухал хууль дүрмүүдийг Сургууль Боловсрол Хүүхэд залуучууд Биен тамирын яам (цаашид зөвхөн Боловсорлын яам БЯ)- ны http://www.msmt.cz (► /Dokumenty/Бичиг баримт ► /Zákony/Хуулиуд) болон (► /Vzdělávání/Боловсрол ► /Vysoké školství/Дээд сургууль ► /Dokumenty/Бичиг баримт ► /Legislativa/Хуульчлал ► /Legislativní normy a související předpisy/Хуульчилалын норм, холбогдох хууль дүрэм) буюу ДоЯ-ны http://www.mvcr.cz (► /Legislativa/Хуульчлал ► /Sbírka zákonů/Хуулийн эмхтэглүүд) интернет хуудаснуудад дурьдсан байгаа.

Боловсрол олгоход тэгш эрх, хавчин гадуурхалгүй, боловсролын хэрэгцээг тус бүрд нь анхаарсан, харилцан хүндлэх, хүндэтгэл, үзэл бодлын нийцлэл, эв нэгтэй, сурч боловсроход орлцогчид бүхэнд хүндэтгэл үзүүлэх зэрэг байдлуудаас үндэслэгдсэн. Чех улсын иргэн, Европын холбооны гишүүн орнуудын иргэд нь улс, край, хот суурин, эсвэл суурингийн холбоо зэргүүдээс удирдагдаж байгаа ерөнхий боловсролын болон дунд сургуулиудад үнэ төлбөргүй суралцана. Боловсролын систем нь хүн бүрийг бүхий л амьдралынхаа турш суралцах эрхийг олгоно. Боловсролын систем нь боловсролын түвшин олгох ба мөн тодорхой түвшингүй (урлаг урлалын ерөнхий боловсролын сургууль, хэлний сургууль, сонирхолын болон бусад боловсролууд) болон сургуулийн үйлчилгээний боловсрол олгоно. Боловсролын систем нь мөн тодорхой мэргэжлийн боловсрол, хүмүүжүүлэх, засан хүмүүжүүлэх болон халамжлан хамгаалах боловсролуудыг олгоно.



věk – нас	péče v rodině (péče mimo vzdělavací soustavu) – гэрийн асаргаа (боловсролын системээс гадуурх асаргаа)
VOŠ (absolutorium) – Мэргэжлийн дээд сургууль (сургууль дүүргэсэн тухай бичиг баримт)	konzervatoř (absolutorium na konzervatoři) – консерватори (консерваторийн абсолютори/ консерватори дүүргэсэн тухай бичиг баримт/)
nástavby SOU – мэргэжлийн тусгай дунд сургуулийн мэргэжил дээшлүүлэх	stupeň vzdělání – боловсролын түвшин

gymnázium (maturita) – гимнази (аттестат)	vyšší odborné – мэргэжлийн дээд
SOŠ (maturita) – мэргэжлийн дунд сургууль (аттестат)	zkracená studia – богиносгосон сургалт
SOU (maturita vyučeni) – мэргэжлийн тусгай дунд сургууль (аттестат мэргэжлийн үнэмлэх)	střední – дунд
2. stupeň zakladní školy – суурь сургуулийн 2-р шат	s maturitou – аттестаттай
1. stupeň zakladní školy – суурь сургуулийн 1-р шат	s vyučením – мэргэжлийн үнэмлэхтэй
mateřská škola – цэцэрлэг	zakladní – суурь

Боловсролын түвшин нь сургуулийн хуулиар: ерөнхий боловсролын, дунд сургуулийн, мэргэжлийн үнэмлэхтэй дунд сургуулийн, бүрэн дунд сургуулийн, дуу хөгжмийн дээд сургууль дахь мэргэжлийн дээд сургуулийн, мэргэжлийн дээд сургуулийн түвшингүүдийг олгоно (Дээд сургуулийн боловсрол 111/1998 тоот дээд сургуулийн тухай хуулиар мөрдөгдөнө).

Сургуулиудын төрөлд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дунд сургууль (гимнази, мэргэжлийн дунд сургууль, мэргэжлийн сургууль), дуу хөгжмийн дээд сургууль, мэргэжлийн дээд сургууль, ерөнхий боловсролын урлаг урлалын сургууль, улсын хэлний шалгалттай хэлний сургууль зэргүүд багтана.

Эдгээр сургуулиудийн тоног төхөөрөмж нь сурган хүмүүжүүлэгчид (багш нар) – ийн боловсрол олгох зориулалтын, сургуулийн зөвлөлгөөний, сургуулийн сонирхолтой болон бусад боловсрол эзэмших, сургуулийн хэрэгцээний, хүмүүжлийн болон байрлуулах, сургуулийн гал тогооны, сурган хүмүүжүүлэх асран халамжлах зориулалтын зэрэг тоног төхөөрөмжүүд юм.

Сургалт нь 9 сарын 1-нээс эхлэн дараагийн жилийн 7 сарын 30-нд дуусах сургуулийн жилд явагдана. Сургуулийн жилд сургалтын хугацаа, сургуулийн амралтын хугацаа хамрагдана. Сургуулийн сургалтын хугацаа 9 сарын 1-нээс эхлэн дараагийн жилийн 7 сарын 30-нд дуусах (хамгийн ойрхон ажлын өдөр эсвэл бусад байдлаас шалтгаалж тодорхой хугацааг тогтооно) ба хоёр хагас жилтэй. Сургуулийн амралтуудад намрын амралт, зул сарын баярын амралт, хагас жилийн амралт, хаврын амралт, улаан өндөгний баярын амралт, их амралт зэрэг амралтууд багтана. Долоо хоногт таван өдрийн сургалтын өдөртэй.

Гадаадын иргэдэд боловсрол олгох нь сургуулийн хуулийн 20-р зүйлээр шийдэгдэнэ. Чех улсын иргэн бус иргэд нь Чех улсын нутаг дэвсгэрт сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын, дунд сургуулийн, мэргэжлийн дээд сургуулийн боловсролыг эзэмших эрхтэй ба Чех улсын иргэдтэй адилхан болзлыг хангах бөгөөд мөн адилхан сурган хүмүүжүүлэх, халамжлан хүмүүжүүлэх боловсролыг эзэмших эрхтэй. Гадаадын иргэд нь сургуулийн хуулийн тогтоосон заалтыг биелүүлж, сургуулийн захиралд өөрсдийнхөө Чех улсын нутаг дэвсгэрт оршин суух эрхтэй гэдгээ нотолсон тохиолдолд тухайн сургуулийнхаа хүүхэд, сурагч, оюутан болно. Ерөнхий боловсролын сургуульд орход оршин суух зөвшөөрлөө нотлох шаардлагагүй. Европын холбооны иргэн нь Чех улсын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрлөө нотлох шаардлагагүй. Чех улсын иргэн бус, гадаадад эзмшсэн дунд болон мэргэжлийн дээд сургуулийн боловсролтой, Чех улсын дунд болон мэргэжлийн дээд сурууль элсэлтийн шалгалт өгч буй иргэний өргөдлөөр, тухайн сургуулийн элсэлтийн шалгалтанд нь чех хэлний улсын шалгалт хамрагдаж байгаа тохиолдолд тэр шалгалтыг хэлтрүүлж болно. Энэ сургуульд болвсрол эзэмшихэд чех хэл нь зайлшгүй шаардалагатай бол, тухайн тохиолдолд сургууль чех хэлнийх нь мэдлэгийг ярилцлагаар нотлож болно.

6. 1. Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол нь заавал эзмших боловсрол биш, **цэцэрлэгийг улс, край, хот суурингийн эсвэл хувийн байгууллагууд** удирдан зохион байгуулж болно. **Цэцэрлэг нь хувийн болон компанийх байж болох ба, ийм тохиолдолд хэрэв Сургууль болвсролын яамны сургуулийн бүртгэлд бүртгэгдсэн байвал мөн адил сургуулийн хууль үйлчилнэ**. Сургуулийн өмнөх боловсролд гурван наснаас зургаан нас хүртлэх хүүхдүүд хамрагдана. Цэцэрлэгт хүүхдүүдийг эцэг эхийн (хуулиар хариуцсан хүн) өргөдлийн дагуу бүртгэнэ. Дараагийн сургуулийн жилийн цэцэрлэгийн байр, хугацаа, цэцэрлэгт бүртгүүлэх өргөдлийн хугацаа зэргийг удирдан зохион байгуулагчтай цэцэрлэгийн захирал тохиролцоогоор тогтоох

ба **захирал** хүүхдийг цэцэрлэгт авах эсхийг шийдвэрлэх бөгөөд хэрэв туршилтын байдлаар хүүхдийг цэцэрлэгт авсан тохиолдолд тэр хугацаа нь 3 сараас дээш байж болохгүй. Сургуулийн өмнөх насны сүүлийн жилийн хүүхдийг цэцэрлэгт түрүүлж авна. Цэцэрлэгт хүүхдийг сургуулийн жилийн дундуур авч болно. **Сургуулийн өмнөх боловсролын төлбөрийг цэцэрлэгийн захирал тогтоох ба сүүлийн жилдээ явж байгаа 6 нас хүрсэн хүүхдийг төлбөргүй явуулна (сургуулийн хуулийн 123-р зүйл 2-р догол мөр).**

Сургуулийн өмнөх боловсрол нь сургуулийн өмнөх насны хүүхдийн хувийн дэвшилт, эрүүл саруул, ойлголт болон биеийн хөгжилт, хүмүүжлийн суурь журам, амьдарлын үндсэн дүгнэлт болон хүмүүстэй харьцах харьцаа зэргийг олгоно. Сургуулийн өмнөх болвсрол нь цаашид суралцах үндэс суурийг бүрдүүлдэг. Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийг сургуульд орхоос өмнө түвшинг тогтоож, тусгай сурган хүмүүжүүлэх мэргэжлийн сургалт болон хэрэгцээгээр хангахад туслана.

Цэцэрлэгт боловсрол олгох, үйл ажиллагааны шаардлага, хоол хүнсний талаар, эрүүл мэндийн болон аюулгүй байдлын талаар дэлгэрэнгүйгээр Сургууль Боловсролын яамны 14/2005 тоот тогтоолоор, сургуулийн өмнөх боловсролын тухай 43/2006 тоот тогтоолоор, **410/2005 тоот хүүхэд залуучуудын боловсрол эзэмшихэд хэрэглэгдэх байр тоног төхөөрөмжийн ариун цэврийн шаардлагыг хангах тухай тогтоолоор мөн 343/2009 тоот тогтоолуудаар тогтоосон.**

6. 2. Ерөнхий эрдмийн боловсрол

Ерөнхий болон дунд боловсролуудыг **үнэ төлбөргүй эзмших эрхийг** Үндсэн эрх болон эрх чөлөөний жуух бичигт тусгагдсан. Хувийн сургуулиудад үнэ төлбөртэй суралцаж болно. Үүрэгт ерөнхий боловсролын сургалт нь есөн жил байх ба хойшлуулаагүй тохиолдолд зургаан наснаас эхлэн суралцана. Үүрэгт боловсрол гэдэг нь ерөнхий суурь боловсролын түвшин юм. ЧУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөлтэй бүх гадаадын иргэд нь ерөнхий боловсрол эзэмших боломжтой.

Хүүхдийн эцэг эх эсвэл хуулиар хариуцагч нь хүүхдийг **сургуульд бүртгүүлнэ**. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэл нэг сарын 15-наас хоёр сарын 15-ны хооронд явагдана. Бүртгэлийн хугацааг сургууль тус бүр мэдээлнэ. Сургуулийн болзол шаардлагыг хүүхдийн байнга оршин суух газрын харъяа, сургууль удирдан зохион байгуулж байгаа хот суурин эсвэл тэдгээрийн харъяа суурин газрууд тогтооно. Хот суурин газрын, хот суурингийн хэсэг дүүрэг, эсвэл хэд хэдэн суурингийн нутаг дэвсгэрт орших сургуулиуд нь тус тусдаа тухайн хот суурингаар удирдагдана. Сургуулиуд нь хүүхдүүдийн оршин суугаа харъяалал хамаарахгүйгээр бүртгэнэ.

Ерөнхий боловсролын сургууль нь бага анги, ахлах анги гэсэн хоёр бүлэгтэй. **Бага анги нь** 5 жил суралцана (нэгдүгээр ангиас тавдугаар анги), **ахлах анги нь** дөрвөн жил суралцана (зургаадугаар ангиас есдүгээр анги). Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийг амжилттай дүүргэсэд бага бүлгийн зургаан жилийн эсвэл найман жилийн гимназид үргэлжлүүлэн суралцаж болно. **Эрүүл мэндийн доголдолтой, тусгай сургалтын програмтай ангийн эсвэл сургуулийн сурагчид нь яамны зөвшөөрлөөр арван жил суралцаж болох ба энэ нь бага анги нь нэгдүгээр ангиас зургадугаар анги, ахлах анги нь долоодугаар ангиас аравдугаар анги хүртэл суралцана.**

Ерөнхий боловсролыг сурагч нь ерөнхий боловсролын сургалтын програмыг эсвэл бага бүлгийн зургаа эсвэл найман жилийн гимназийг эсвэл найман жилийн сургалтын програмтай дүйцхүйц сургалттай дуу хөгжмийн зэрэг сургалтуудыг амжилттай дүүргэсэн тохиолдолд эзэмшинэ. Ерөнхий боловсролын түвшинг бас ерөнхий боловсролын сургууль болон дунд сургуулиуд хэрэгжүүлж байгаа ерөнхий боловсролын сургалтын курсыг бүрэн дүүргэснээр эзэмшиж болно.

2007 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулиуд өөр өөрсдийнхөө сургалтын програмаар сургаж байна. Сургуулиуд улсаас баталгаажуулсан сургалтыг сургах үүрэгтэй ба мөн бусад үүрэгт бус сургалтыг сургаж байна. Сургуулиудын хооронд сургалтын болон сургалтын хэлбэр маш их зөрөлдөөнтэй байж болох юм.

ЧУ-д оршин сууж буй бүх гадаадын иргэдийн хүүхдүүд сургуульд суралцах <u>үүрэгтэй</u>. Энэ үүргийг биелүүлээгүй тохиолдолд хүүхдийн хуулиар хариуцагчидад хариуцлага хүлээлгэнэ.

6. 3. Дунд сургуулийн боловсрол

Ерөнхий боловсролын сургуулийг дүүргэсний дараа **дунд сургуульд (гимназ, мэрэгжилийн дунд сургууль, мэрэгжилийн дунд сургалт)** эсвэл **дуу хөгжмийн сургуульд** үргэлжлүүлэн суралцаж болно. Дунд сургууль нь сурагчидыг дараагийн сургуульд суралцуулах эсвэл ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэнэ. Сургалт нь өдрөөр, ичнээгээр, оройгоор эсвэл хослуулсан хэлбэрээр явагдана. Суралцагч нь сургалтын програмын дагуу дунд боловсрол, мэргэжлийн үнэмлэхтэй дунд боловсрол, улсын шалгалттай дунд боловсрол зэргийг эзэмших ба улсын шалгалттай дунд боловсрол нь дээд сургуульд элсэж болно.

Дунд сургуульд элсүүлхийг тухайн сургуулийн элсэлтийн шалгалтын хүрээнд сургуулийн захирал шийднэ. Дунд сургууль болон дуу хөгжмийн сургуулийн **элсэлтийн болзол шаардлагыг** хууль дүрмээр тогтооно.

Дунд сургууьд элсэхдээ бүртгэлийн өргөдлийг өгөх хэрэгтэй. Дунд сургуулийн бүртгэлийн өргөдлийг элсэлтийн анхан шатанд насанд хүрсэн сурагч өөрөө, насанд хүрээгүй бол хуулиар хариуцсан хүн тухайн сургуулийн захиралд, яамнаас бичигдсэн хэвлэмэл хуудсан дээр бичиж, 60b-р зүйлээр тогтоогдсон хугацаанд өгнө.

Өдрөөр сургах сургалтын бүртгэлийн өргөдлийг дунд сургуулийн захиралд гурван сарын 15-ныг хүртэл, мэргэжлийн авъяас билгийн шалгалттай бүртгэлийн өргөдлийг арван нэгэн сарын 30 хүртэл өгнө.

Өдрийн сургалтаас өөр хэлбэрийн сургалтын өргөдлийг дунд сургуулийн захиралд гурван сарын 20-ныг хүртэл, мэргэжлийн авъяас билгийн шалгалттай бүртгэлийн өргөдлийг арван нэгэн сарын 30-ныг хүртэл өгнө.

Өдрийн сургалттай сургалтын анхан шатны бүртгэлийг гурван сургуульд өгч болно.

Гадаад улсад ерөнхий боловсрол эзэмшсэн сурагчаас тухайн элсэх гэж буй сургууль нь, гадаадын сургуулиар олгогдсон боловсролын үнэмлэх, гадаадын сургуулиар олгогдсон гадаадын сургуулийн үнэмлэхтэй харьцуулсан үнэмлэх, гадаадад хүлээн зөвшөөрөгдөх эсэх баталгааны шийдвэр зэргийг шаардвал эдгээр бичиг баримтыг бүрдүүлж өгөх хэрэгтэй.

Гимназид боловсрол эзэмших нь дээд сургуульд элсэх бэлтгэл юм. Сургалт нь дөрвөн жилийн, зургаан жилийн, найман жилийн сургалттай байдаг. Зургаан жил, найман жилийн гимназид ерөнхий боловсролын сургуулийн бага ангийг төгссөн сурагчидыг элсүүлдэг, дөрвөн жилийн гимназид ерөнхий боловсролын сургуулийн есдүгээр ангийг төгссөн сурагчид элсдэг.

Мэргэжлийн дунд сургууль (МДС), Техник мэргэжилийн сургууль (ТМС) – нь сурагчидад боловсролын түвшингийн хамт ажил хөдөлмөр эрхлэх мэргэжлийн болон мэргэшлийн үнэмлэх олгох ба мөн дээд болон мэргэжлийн дээд сургуульд элсэх бэлтгэл болдог. МДС болон ТМС--нь ойролцоогоор 240 **мэргэжлийн боловсрол** олгох ба сургалтын үргэлжилсэн хугацаанаас шалтгаалж боловсролын түвшинг ангилж болно. Хоёр жилийн сургалтаар дунд боловсрол, гурван жилийн сургалтаар **мэргэжлийн үнэмлэхтэй** дунд сургууллийн боловсрол, дөрвөн жилийн сургалтаар **улсын шалгалттай** дунд боловсролыг тус тус эзэмшинэ. Улсын шалгалттай дунд боловсролыг зарим гурван жилийн сургалттай мэргэжлийн үнэмлэхтэй дунд боловсролтой сурагчидыг **өргөжүүлсэн сургалтаар** эзэмшүүлж болно. Хоёр жилийн, гурван жилийн дунд сургуулийн боловсрол нь мэргэжилтэй ажилчны мэргэшлийг эзмэшүүлнэ, улсын шалгалттай дунд боловсрол нь техникч, менежер болон бусад мэргэшлийг эзэмшүүлнэ. Дунд сургуулиуд нь мэргэжлийн үнэмлэхтэй эсвэл улсын шалгалттай дунд мэргэжлийн боловсролтой, өөр мэргэжилд мэргэжлийн үнэмлэх болон улсын шалгалттай дунд мэргэжил эзэмшихийг хүсэгчидэд **түргэвчилсэн сургалтаар** хангаж болно. Сургалт нь 1-ээс 2 жил өдрөөр явагдана.

Урлагийн сургуулийн боловсрол нь ерөнхий боловсролын болон урлагийн ерөнхий боловсролийн сургуульд сурагчидын эзэмшсэн мэдлэг, туршлага, бусад чадварыг хөгжүүлж дээшлүүлэх ба нийтийн боловсролоор хангаж, сурагчидийг урлагийн түвэгтэй мэргэжил эсвэл хөгжим, бүжиг, дуу, хөгжмийн жүжгийн урлагуудын хүрээнд урлагийн багшийн мэргэжилтэн болход бэлтгэнэ. Урлагийн сургуулийн боловсрол нь цаашид хувийн болон иргэний бүрэн эрхийг эдлэж үргэлжлүүлэн суралцаж ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ. Урлагийн сургуулийн зургаан жилийн анхны жилийн сургалтанд албан журмаар суралцах үүргээ биелүүлсэн эсвэл ерөнхий

боловсролын сургуулийг амжилттайгаар албан журмаар суралцах хугацаанаас өмнө дүүргэсэн сурагчидыг элсүүлнэ. Урлагийн сургуулийн найман жилтэй сургалтанд ерөнхий боловсролын сургуулийн тав дугаар ангийг амжилттай төгссөн, урлагийн сургуулийн элсэлтийн шалгалтаар өөрийн чадвар, сэтгэхүй, сонирхол, эрүүл мэндийн чадвар зэргээ нотлосон сурагчидыг элсүүлнэ. Урлагийн сургуулийн элсэлтийн шалгалт нь авьяас билгийг шалгаруулах хэлбэрээр явагдана.

Амжилттай дүүргэсэн урлагийн боловсролын програм нь **улсын шалгалттай дунд боловсрол** эсвэл **урлагийн сургуулийн дээд мэргэжлийн боловсролын** хэмжээнд хүргэнэ.

6. 4. Мэргэжлийн дээд сургуулийн боловсрол

Мэргэжлийн дээд боловсрол нь дунд сургуульд оюутнуудын эзэмшсэн мэдлэг, чадварыг хөгжүүлж гүнзгийрүүлэх ба нийтийн болон мэргэжлийн боловсролоор хангаж, түвэгтэй ажил мэргэжилд бэлтгэнэ. Тухайн боловсролын програмыг дүүргэсний дараа мэргэжлийн дээд боловсролыг эзэмшинэ. Мэргэжлийн дээд боловсрол нь дадлагын хугацаатай хамт өдрийн сургалтаар 3 жил, эрүүл мэндийн салбарт 3,5 жил байна.

Мэргэжлийн дээд сургуульд улсын шалгалттай дунд боловсролыг дүүргэсэн, элсэлтийн шалгалтаар өөрийн чадвар, сэтгэхүй, сонирхол, эрүүл мэндийн чадвар зэргээ нотлосон оюутнуудыг элсүүлнэ.

Мэргэжлийн дээд боловсролыг дипломтой төгсөнө. Төгсөгчидийн Мэргэжлийн дээд боловсролын бичиг баримт нь диплом юм. Мэргэжлийн дээд сургуулийн төгсөгчийн дипломон дээрх нэрнийх нь хойно “мэргэжлийн дипломтон” гэж тэмдэглэсэн байна (товчилж “DiS.”).

6. 5. Гадаадад эзэмшсэн ерөнхий, дунд, мэргэжлийн дээд боловсролуудыг зөвшөөрөх

Гадаадад эзэмшсэн ерөнхий боловсролын, дунд эсвэл мэргэжлийн дээд боловсролын бичиг баримтуудыг крайн захиргааны боловсролын хэлтэст:

- гадаадын боловсролын гэрчилгээг ЧУ-ын гэрчилгээний түвшинд хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ олгох,
- ЧУ-д гадаадын гэрчилгээг хүчин төгөлдөр болгох шийдвэр („нострификац“) гаргах өргөдлүүдийг өгч болно.

Гадааддын гэрчилгээг ЧУ-д хүлээн зөвшөөрөх гэрчилгээг крайн захиргаа олгох ба зарим тохиолдолд ЧУ олон улсын гадаадын гэрчилгээг хүлээн өзвшөөрөх тухай гэрээтэй улстай гэрээ хийсэн тэр улсад олгоно. Хэрэв гадаадын гэрчилгээнд сургалтын хичээлүүд дутуу байвал гадаадын иргэн нь мэргэжлийн боловсролын агуулга, тэр боловсролыг эзэмшсэн гэдэг нотолгоог өгнө. Өргөдөлтэй хамт холбогдох бичиг баримтыг албан ёсоор орчуулуулан крайн захиргааны боловсролын хэлтэст өгөх ба холбогдох маягтыг бөглөж мөн цуг өгнө.

Хэрэв ЧУ тухайн улс хоёрын хооронд гадаадын гэрчилгээг хүлээн зөвшөөрөх гэрээ байхгүй бол тухайн гэрчилгээний эх хувь эсвэл нотратаар батлуулсан хуулбарын албан ёсны Чех хэлэнд орчуулсан орчуулгыг үндэслэн крайн захиргаа нострификацаар шийдвэрлэнэ. Хэрэв гадаадын гэрчилгээнд сургалтын хичээлүүд дутуу байвал гадаадын иргэн нь мэргэжлийн боловсролын агуулга, тэр боловсролыг эзэмшсэн гэдэг нотолгоог өгнө. Хэрэв ЧУ тухайн улс хоёрын хооронд хуулийн туслалцааны тухай гэрээ байхгүй бол гадаадын гэрчилгээг дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгох эсвэл апостиллээр баталгаажуулна (4. 4-р бүлэгт үз).

Крайн захиргаа гурван янзаар шийдэж болно:

1. хэрэв гадаадын сургуульд эзэмшсэн боловсрол нь агуулга болон хүрээгээрээ ЧУ-ын боловсролын програмтай нийцэж байгаа бол **эергээр** шийдвэрлэж гадаадын иргэнд ЧУ-д гадаадын гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн нострификацын баталгаа өгнө,
2. хэрэв нострификацын явцад гадаадын сургуульд эзэмшсэн боловсрол нь агуулга болон хүрээгээрээ ЧУ-ын боловсролын програмтай нийцэхгүй байвал өргөдлийг **татгалзана**, эсвэл
3. хэрэв гадаадын сургуульд эзэмшсэн боловсролын агуулга болон хүрээний хэсэг нь нийцэхгүй эсвэл гадаадын иргэн нь мэргэжлийн боловсролын агуулгыг өгөөгүй тохиолдолд крайн захиргаа **нострификацын шалгалт** өгөх заалт гаргана. Энэ шалгалт нь гадаадын иргэний тухайн боловсролын програмын дагуу эзэмшсэн боловсролын зорилго болон агуулгын мэдлэг чадвартай эсхийг тогтоож энгийн шалгалт маягаар явагдана.

Гадаадын иргэн нь ностирфикацын шалгалтыг чех хэл, уран зохиолоор өгөх шаардлагагүй. Шалгалтын дүгнэлтийг хамгийн бага нь гурван хүний бүрэлдхүүнтэй комис шийдвэрлэнэ.

Гадаадын боловсролыг хүлээн зөвшөөрөх талаархи дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн тухай 561/2004 тоот хуулийн 108-р зүйл, Сургууль боловсролын яамны 12/2005 тоот тогтоолуудаас мэдэж болох ба түүнд ностирфикацын шалгалт, гадаадын боловсролын бичиг баримтын түвшинг хүлээн зөвшөөрөх, нострификацын хавсралт зэргийн талаар дэлгэрэнгүй дурьдсан.

Хэрэв гадаадын боловсролыг хүлээн зөвшөөрөх талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хувиараа өөрийнхөө оршин сууж буй газрын харъяа крайн захиргааны сургууль боловсролын хэлтсээс утсаар асууж болно.

6. 6. Дээд сургууль

ЧУ дахь **дээд сургуулиуд нь** (цаашид зөвхөн ДС) **нийтийн, улсын** (цэргийн, цагдаагийн), **хувийн** гэсэн ангилалтай. Бүх дээд сургуулиудад элсэлтийн шалгалт явагдана. ДС-д суралцхад (урлагийн ДС-д хамаарагдахгүй) бүрэн дунд боловсрол эсвэл мэргэжлийн бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх шаардлагатай. Дээд сургуульд гадаадын иргэд суралцхад ЧУ-ын иргэнтэй адил нөхцөл болзолтой. Нийтийн болон улсын дээд сургуулиудад үнэ төлбөргүй суралцана, хувийн дээд сургуулиудад төлбөртэй суралцах ба төлбөрүүд нь янз янз байна. Гадаадын иргэд нь ЧУ-д өөр хэлээр нийтийн дээд сургуульд суралцвал төлбөрийг хувиараа төлнө. Дээд сургуульд суралцхад өдрөөр, (өдөр бүрийн сонгосон хичээлүүдийн дагуу), ичнээгээр (ичнээгээр сард тогтоосон өдрүүдэд ирж суралцана) мөн хослуулсан хэлбэрээр явагдаж болно.

6. 7. Гадаадын дээд сургуулийн боловсрол ба мэргэшлийг хүлээн зөвшөөрөх

Гадаадын иргэн – гадаадын дээд сургуулийг төгсөгч гадаадын дээд сургуулийн боловсрол болон мэргэшлийг хүлээн зөвшөөрөх өргөдөл өгч болно. Харин гадаадын дээд сургуулийг төгссөн бичиг баримттай эсвэл суралцаж төгссөн байх хэрэгтэй. Өргөдлийг бичгээр доорхи байгууллагуудад өгнө:

- нийтийн дээд сургуулийн ректорын газарт, энэ нь цаг үеийн сургалтын програмыг боловсруулдаг;
- Цэргийн яаманд, хэрэв дээд сургуулийн боловсролыг цэргийн хүрээнд эзэмшсэн бол;
- Дотоод явдлын яаманд, хэрэв дээд сургуулийн боловсролыг аюулаас хамгаалах албаны хүрээнд эзэмшсэн бол;
- Сургууль боловсролын яаманд, хэрэв дээд сургуулийн боловсролыг Афганистан, Болгар, Словин, Босни Герцегонив, Унгар, Польш, Гүрж, Молдав, Туркменстан, Тажикстан зэрэг улсуудад эзэмшсэн бол.

Дээр дурьдсан байгууллагуудад гадаадын боловсрол мэргэжлийг хүлээн зөвшөөрөх талаар **бичгээр өргөдөл** өгөх (тогтоосон маягт байхгүй, Сургууль боловсролын яамны нийтийн дээд сургуулиудын интернет хуудаснуудын өргөдлийн хэлбэрүүдийг ашиглаж болно) ба өргөдөлд төрсөн он сар өдөр, байнга оршин суугаа хаяг, гадаадын дээд сургуулийн нэр, хаяг, сургалтын програмын болон сургалтын салбарын нэр, сургалт эхлэсэн болон дуусан он сар өдөр зэргийг агуулсан байх ёстой. Өргөдөлтэй хамт дипломын нотратаар батлуулсан, чех хэлэнд албан ёсоор орчуулсан хуулбарыг, өгсөн шалгалтуудын танилцуулга эсвэл дипломын нэмэлт хавсралт („Diploma Supplement“)-ыг өгнө. Хавсралтыг апостилл баталгаажуулалт хийгдсэн эсвэл дээд зэргийн хуулийн хүчин төгөлдөр болгосон байх хэрэгтэй (4. 4-р бүлгээс үз).

Өргөдлийг 30 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ. Татгалзсан шийдвэрийн хариуд, хэрэв хүлээн зөвшөөрөх шийдвэрийг нийтийн дээд сургууль, сургууль боловсролын яам зэрэг газрууд шийдвэрлэсэн бол Сургууль боловсролын яаманд давж заалдах өргөдөл өгч болно.

6. 8. Мэргэшсэн мэргэжлийг хүлээн зөвшөөрөх

ЧУ-д зарим ажил хөдөлмөр эрхлэхэд тодорхой мэргэшлийн мэргэжил эзмшсэн байх шаардлагатай байдаг. Эдгээр **тохируулсан мэргэжил болон үйл ажиллагаа** гэдэг нь ЕХ-ны

гишүүн орнуудын хууль дүрмээр түүний гүйцэтгэх үйл ажиллагааны үеэр тодорхой болзлыг шаардсан, эдгээр шаардлагыг хангаагүйгээр тухайн ажил мэргэжлийг гүйцэтгэж болохгүй гэсэн ойлголттой (жнь: боловсролын түвшин болон мэргэжил, дадлага, гэмт хэрэг үйлдэж байгаагүй, эрүүл мэндийн чадвартай, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байх хугацаанд гаргасан хохиролын даатгалд даатгуулсан гм...). Гишүүн орнууд тус бүрдээ өөр өөрсдийн нөхцөлд зохицуулан мэргэжлийн болон үйл ажиллагааны тохиргоог тогтооно. Үүнийг гишүүн улс тус бүрдээ өөр өөр тооны мэргэжил болон үйл ажиллагаанд тохируулна, энэ тохирогооны хүрээ нь өөр өөр байна, тохиргоотой мэргэжил болон үйл ажиллагаа бүрийн шаардлага янз бүр байна. **Чех улс ойролцоогоор 390 мэргэжлийн ажилд тохиргоо тогтоосон**. Мэргэшлийн мэргэжлийг хүлээн зөвшөөрөх тухай 18/2004 тоот хууль нь мэргэшлийн мэргэжлийг хүлээн зөвшөөрөх тухай 2005/36/ ES тоот удирдамжийг хэрэгжүүлж, багa хэмжээний зөрөөтэй захиргааны дүрэмтэй холбоотой мэргэшлийн мэргэжлийн хүлээн зөвшөөрөх тухай ерөнхий үйл ажиллагааг мөрдөж байна.

Мэргэшлийг хүлээн зөвшөөрөх нь тухайн хүний мэдлэг чадварыг мэргэшлийн хэлбэрийн бичиг баримтаар нотлож болох боловч (боловсрол болон бэлтгэл), бас тухайн үйл ажиллагааны бодит гүйцэтгэлийн бичиг баримт эсвэл өөр бичиг баримтаар шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Мэргэжлийн хүлээн зөвшөөрөх процесийн дүгнэлт нь тухайн эзэмшигч нь хангалттай мэдлэг чадвартай, тухайн ажил мэргэжлийг хангалттай хийж гүйцэтгэх эсхийг дүгнэсэн тухай шийдвэр юм.

Энэхүү хүлээн зөвшөөрөх нь ЧУ-д хувиараа эрхлэх эсвэл ажиллахыг шийдсэн ЧУ-аас өөр ЕХ--ны, бусад ЕХАО-ны, Швейцар зэрэг улсуудад мэргэжил эзэмшсэн болон эсвэл эдгээр улсуудаар хүлээн зөвшөөрөгдсөн ЕХ-ны иргэн, бусад ЕХАО-ны иргэд, Швейцарын иргэд болон тэдний гэр бүлийн гишүүдэд хамааралтай. Мөн мэргэшил мэргэжлийг хүлээн зөвшөөрөх тухай хуулийн 1-р зүйлийн 2-р догол мөрд зааснаар гуравдагч орны иргэдэд бас хамааралтай ба ялангуяа:

- байнга оршин суугч, эсвэл
- ЧУ-д буюу ЕШ-ний бусад оронд Европын холбоогоор олгогдсон удаан хугацаагаар оршин суух хуулийн байршилтай байнга оршин суугч болон удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй тэдний гэр бүлийн гишүүд, эсвэл
- ЧУ-д эсвэл ЕХ-ны бусад оронд эрдэм шинжилгээний шалтгаанаар оршин суугч болон удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй тэдний гэр бүлийн гишүүд, эсвэл
- суралцах шалтгаантай оршин суугч.

18/2004 тоот шинэ хуулийн хүрээнд бас **хөх карт эзэмшигчийг хамруулах** бэлтгэл хийж байна – энэ нь өндөр мэргэжлийн ажилтай холбоотой оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн юм.

Мэргэжлийг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаанд яаж хандах вэ? Эхлээд өргөдөл гаргагч нь Чех улсад үйл ажиллагаагаа явуулах гэж буй ажил мэргэжил нь тохируулсан буюу тохируулаагүй ажил мэргэжлийн алинд нь багтаж байгааг тогтооно – доор дурьдсан ЧУ-дахь тохируулсан мэргэжлийн ишлэлийн агуулгад үз.

Хэрэв гадаадын иргэн Чех улсын нутаг дэвсгэрт тохируулаагүй ажил хөдөлмөр эрхлэх болсон тохиолдолд, Чех улсын нутаг дэвсгэрт тэр ажил хөдөлмөрийг гүйцэтгэх эрхтэй ба түүний мэргэжлийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Ийм ажил хөдөлмөрийг зөвхөн тухайн ажиллуулагчтай тохиролцоноор гүйцэтгэнэ.

Хэрэв гадаадын иргэн Чех улсын нутаг дэвсгэрт тохируулсан ажил хөдөлмөр эрхлэх болсон тохиолдолд, Чех улсын холбогдох хүлээн зөвшөөрөх байгууллагад өөрийнхөө мэргэжлийг хүлээн зөвшөөрөх өргөдлийг өгнө.

Хүлээн зөвшөөрөх байгууллага нь тухайн мэргэшлийн мэргэжлийг хүлээн зөвшөөрөх шийдвэрийг гаргах эрхтэй ба энэ нь тохируулсан мэргэжилд зохицож буй эсвэл зохицол нь ойр төстэйгөөр тохируулдаг Чех улсын захиргааны төв байгууллага юм. Хэрэв өргөдөл гаргагч нь тохируулсан ажил хөдөлмөрт хувиараа аж ахуй эрхлэх эсвэл хувиараа аж ахуй эрхлэх эрхийн доор хариуцагч төлөөний алба гүйцэтгэх тохиолдолд хүлээн зөвшөөрөх байгууллага нь Үйлдвэр худалдааны яам байна. Хэрэв тусгай хууль дүрмийн дагуу мэргэжлийн танхим тохируулсан ажил хөдөлмөр эрхлэх талаар шийдвэрийг гаргасан тохиолдолд зөвшөөрөгч байгууллага нь мэргэжлийн танхим байна.

Тохируулгатай ажил мэргэжлийн бүх жагсаалт, түүний хүлээн зөвшөөрөх байгууллагууд болон тэдний тодорхой хүлээн зөвшөөрөх мэргэжлүүдийн танилцуулгуудыг энэ вэб хуудаснаас

мэдэж болно http://www.msmt.cz (► /EU a zahraničí/ЕХ болон гадаад улс ► /Uznávání kvalifikací a vzdělání v EU/Мэргэжил хүлээн зөвшөөрөх болон ЕХ-д боловсрол эзэмших ► /Uznávání kvalifikací/Мэргэжил хүлээн зөвшөөрөх ► /Databáze regulovaných povolání/Тохируулгатай мэргэжлийн мэдээллийн сан ► /Databáze regulovaných povolání a činností v ČR/ЧУ дахь тохируулгатай ажил мэргэжлийн мэдээллийн сан).

6. 9. Боловсрол эзэмших бусад хэлбэрүүд: хэлний курс, чех хэлний курс болон насанд хүрэгчидийн боловсрол эзэмших

➢ Хэлний боловсрол

Улсын шалгалт авах эрх бүхий хэлний сургууль нь сургуулиудын бүртгэлд бүртгэгдсэн байх ба үйл ажиллагаа нь сургуулийн хуулиар удирдагдаж байдаг. Улсын шалгалтын эрх бүхий хэлний сургууль нь хувийн хэлний сургуулиудаас эдгээр онцлогуудаараа ялгаатай: 1-рт хэлний боловсрол олгох чанар нь улсаас тодорхойлогдсон баталгаатай, 2-рт улсын хэлний шалгалтыг авна, 3-рт багш нар нь сургуульдаа харьалагдах ба хуульд зааснаар мэргэжлийн болзлыг хангасан байх шаардлагатай.

Энэ вэб хуудсанд http://www.vuppraha.cz улсын шалгалтын эрх бүхий хэлний сургуулиудын танилцуулга байна (► /Rámcové vzdělávací programy/Боловсролын програмын ерөнхий төлөвлөгөө ► /Jazykové vzdělávání/Хэлний боловсрол).

Одоо үед хэлний сургалтууд нь маш их байна. Маш олон хэлний сургуулиуд, агентурууд олон янзын хэлбэрээр хэл сургах санал тавьцгааж байна – ганцаарчилсан, бүлгээр нь, онцгойлсон, сарын, хагас жилийн, үдээс өмнөх, үдээс хойшхи мөн оройн курсууд гэх мэтчилэн. Бас хэл тус бүрийн сургалтууд нь маш их, үндсэн хэлүүд нь, Англи, Герман, Орос, Франц, Испань хэлүүд байна. Төлбөр нь сургалтын хугацаа онцлогоос шалтгаалж өөр өөр байна (мэдээжий хэрэг хэдэн мянган корунаар тооцож бодох хэрэгтэй).

➢ Чех хэлний дамжаа

Чех хэлний дамжааг гадаадын иргэдэд зориулан хэлний сургуулиуд, хэлний агентурууд, зарим нэгэн интеграчны төвийн төрийн бус ашигт бус байгууллагууд зохион байгуулж байна (15-р, 16-р бүлэгт үз). Анхан шатны сургалтаас эхлээд мэргэжлийн (жнь: худалдааны чех хэл) сургалт хүртэл янз бүрийн хугацаатай болон онцлогтой зарим нь улсын шалгалттай төгсөж байна. Зарим хэлний сургуулиуд гадаадын иргэдийг бэлтгэл дамжаатай чех хэлний улсын шалгалттай дамжаанд сургаж байна. Ихэнх дээд сургуулиуд нь гадаадын иргэдэд хэлний бэлтгэлийн сургуулиар хангаж байна, эдгээр сургуулиудын зарим нь мөн оюутан бус хүмүүст хэлний сургалт явуулж байна. Гадаадын иргэдэд зориулсан Чех хэлний сургалтыг, ЧУ-д удаан хугацаагаар албан ёсоор суурьшисан гадаадын иргэдийн интеграчлалын програмын хүрээнд улсын төв байгууллагуудаас санхүүгийн төсөв хэлбэрээр дэмжиж, төрийн бус байгууллагуудын болон интеграчны төвийн зохион байгуулалтаар явуулж байна. Байнга оршин суух зөвшөөрөл олгох үед зарим тохиолдолд шаардлагатай Чех хэлний шалгалт өгөх хэргэтэй байдаг (4-р,3-р бүлгээс үз).

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- Боловсрол эзэмших талаархи хууль дүрмийг (сургуулийн хуультай хамт) Сургууль боловсролын яамны интернет хуудаснаас олж мэдэж болно – http://www.msmt.cz (► /Dokumenty/Бичг баримт)
- **Цэцэрлэгүүдийн хаягуудыг** энэ хуудаснаас http://www.msmt.cz (► /Vzdělávání/Боловсрол ► /Rejstřík škol a školských zařízení/Сургууль болон Сургуулийн төхөөрөмжийн бүртгэл). Мэдээллүүдийг бас цэцэрлэгийн захиралаас буюу оршин сууж буй газрынхаа хот суурингийн захиргаанаас авч болно.
- ЧУ-ын **ерөнхий боловсролын сургуулиудын** дэлгэрэнгүй мэдээллүүдийг Сургууль боловсролын яамны интернет хуудаснаас мэдэж болно – http://www.msmt.cz (► /Vzdělávání/Боловсрол ► /Rejstřík škol a školských zařízení/Сургууль болон сургуулийн төхөөрөмжүүдийн бүртгэл)
- ЧУ-ын дунд сургуулиудын дэлгэрэнгүй мэдээллүүдийг Сургууль боловсролын яамны интернет хуудаснаас мэдэж болно – http://www.msmt.cz (► /Vzdělávání/Боловсрол ► /Rejstřík škol a škol-

ských zařízení/Сургууль болон сургуулийн төхөөрөмжүүдийн бүртгэл) мөн бусад ашигтай мэдээллүүдийг Боловсролын талаархи мэдээлэл олгох байгууллагуудын интернет хуудаснаас мэдэж болно – http://www.uiv.cz

- Мэргэжлийн боловсролын талаархи мэдээллүүдийг Мэргэжлийн боловсролын үндэсний байгууллагын интернет хуудаснаас мэдэж болно www.nuov.cz сургуулиудын мэдээллийн сан (http://www.infoabsolvent.cz) мөн албан тушаалын зөвлөх (http://www.nuov.cz ► /Vzdělávání a trh práce/Боловсрол болон хөдөлмөрийн бирж)
- Албан байгууллагуудын портал – http://portal.gov.cz (► /Životní situace/Амьдралын байдал ► /Občan/Иргэн ► /Vzdělání, věda a výzkum/Боловсрол, шинжлэх ухаан ► /Střední a vyšší školy/Дунд, дээд сургуулиуд)-аас боловсролтой холбоотой амьдралын янз бүрийн байдлыг яаж шийдвэрлэх талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг мэдэж болно.
- Сургууль боловсролын яамны интернет хуудаснаас – http://www.msmt.cz бас сонирхолтой мэдээллүүдийг мэдэж болох ба мөн **нийтийн, хувийн ДС** мөн ДС-ийн сургалтын програмтай(► /Vzdělávání/Боловсрол ► /Vysoké školství/Дээд сургууль ► /Přehled vysokých škol/Дээд сургуулиудын танилцуулга),мөн дээд сургуулийн талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдтэй танилцаж болно (►/Vzdělávání/Боловсрол ► /Vysoké školství/Дээд сургууль ► /Dokumenty/Бичг баримт ► /Legislativa/Хуульчлал).
- Хэрэв **гадаадын боловсролыг хүлээн зөвшөөрөх талаархи дэлгэрэнгүй мэдээлэл** хэрэгтэй бол оршин сууж буй газрынхаа харъяа крайн захиргааны сургууль боловсролын хэлтэстэй утсаар болон хувиараа харьцаж болно (крайн захиргаануудын хаягийг энэ интернет хуудаснаас олж болно www.portal.gov.cz (►/Adresář/Хаяг►/Kraje/Край), нийслэл Праг хотын захиргааны http://skoly.praha-mesto.cz/79209_Uznavani-rovnocennosti-a-nostrifikace-vysvedceni-vydanych--zahranicnimi-skolami) эсвэл http://magistrat.praha.eu (► /Jak si zařídit/Яаж гүйцэтгэх вэ ► /Školství/Сургууль ► /Uznávání rovnocennosti a nostrifikace vysvědčení vydaných zahraničními školami/Гадаадын сургуулиар олгогдсон гэрчилгээний түвшинг хүлээн зөвшөөрөх болон нострификацын баталгаа)
- **Гадаадын боловсролыг хүлээн зөвшөөрөх** талаархи дэлгэрэнгүй мэдээллийг бас Сургууль боловсролын яамны хуудаснаас – http://www.msmt.cz мөн Боловсролын үнэмлэх бичиг баримтны түвшин тогтоох төвийн – Дээд сургуулийн сургалтыг – http://www.csvs.cz энэ хуудаснаас мэдэж болно.
- **Тохируулгатай ажил мэргэжлийн бүх жагсаалт,** түүний хүлээн зөвшөөрөх байгууллагууд болон тэдний тодорхой хүлээн зөвшөөрөх мэргэжлүүдийн танилцуулгуудыг энэ вэб хуудаснаас мэдэж болно http://www.msmt.cz (► /EU a zahraničí/ЕХ болон гадаад улс ► /Uznávání kvalifikací a vzdělání v EU/Мэргэжил хүлээн зөвшөөрөх болон ЕХ-д боловсрол эзэмших ► /Uznávání kvalifikací/Мэргэжил хүлээн зөвшөөрөх ► /Databáze regulovaných povolání/Тохируулгатай мэргэжлийн мэдээллийн сан ► /Databáze regulovaných povolání a činností v ČR/ЧУ дахь тохируулгатай ажил мэргэжлийн мэдээллийн сан).
- Гадаадын иргэдэд зориулсан Чех хэлний дамжааны талаар энэ хуудаснаас http://www.migraceonline.cz/e-knihovna/?x=2131271
- Хэлний боловсролын институдын талаархи мэдээллүүдийг энэ хуудаснаас http://jazykove-skoly.cz/ эсвэл http://www.jazykovky.cz/
- Энэ вэб хуудсанд http://www.vuppraha.cz улсын шалгалтын эрх бүхий хэлний сургуулиудын танилцуулга байна (► /Rámcové vzdělávací programy/Боловсролын програмын ерөнхий төлөвлөгөө ► /Jazykové vzdělávání/Хэлний боловсрол

7. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН СИСТЕМ

Үндсэн эрх болон эрх чөлөөний жуух бичгийн 31-р бүлэгт зааснаар бүх хүн эрүүл мэндээ хамгаалах эрхтэй. Иргэд нь бүх нийтийн эрүүл мэндийн даатгалыг үндэслэж 48/1997тоот нийтийн эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар тогтоогдсон болзлоор (цаашид зөвхөн 48/1997 тоот хууль) үнэ төлбөргүй эрүүл мэндийн хангамж ба эрүүл мэндийн хэрэгслүүдийг ашиглах эрхтэй. Ихэвчлэн эрүүл мэндийн хангамжийг бүх нийтийн эрүүл мэндийн даатгалыг үндэслэж олгоно. Хэрэв бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, эрүүл мэндийн хангамж нь бүх нийтийн эрүүл мэндийн даатгалаас төлөгдөөгүй бол гарсан зардлыг өөрөө төлнө.

Эрүүл мэндийн салбарын ажилтан бүр яаралтайгаар хүн бүрд анхны тусламж үзүүлж, энэ тусламжгүйгээр амь насанд нь аюул учирсан эсвэл эрүүл мэндэд нь хүнд аюул тулгарч, хойшлуулж боломгүй цаг хугацаа тулгарсан үед хэрэгцээнийх нь дагуу мэргэжлийн эрүүл мэндийн хангамжаар хангана (жнь: эмнэлгийн газар хүргэх).

Эрүүл мэндийн хангамж нь 20/1966 тоот хүний эрүүл мэндийн тухай хуулийн дагуу хангагдана. Энэ нь амбулторийн мөн эмнэлгийн хангамж ба өвчтөнгийн эрүүл мэндийн байдлаас шалтгаална. Иргэд болон өвчтөнгүүдэд эрүүл мэндийн хангамжийн системд **Өчтөнд өгөх зөвлөлгөө** гэсэн хялбарчилсан чиглэлийг нийтэлсэн ба түүнийг ЧУ-ын Эрүүл мэндийн яамны интернетийн хуудсанд нийтэлсэн – http://www.mzcr.cz эхний оршил хуудсанд ойлгомжтойгоор(► /Rádce pacienta/Өвчтөнд өгөх зөвлөлгөө).

Эрүүл мэндийн даатгалын хэлбэрүүд

ЧУ-д хоёр хэлбэрийн эрүүл мэндийн даатгал байна:

- **Бүх нийтийн эрүүл мэндийн даатгал**, үүнд хамрагдах нь шууд 48/1997 тоот хуулийн болзлыг биелүүлсэнээр эсвэл бусад холбогдох хууль дүрмээр (шилжүүлэх хэлбэр);
- **Зорчигчийн эрүүл мэндийн даатгал**, энэ нь даатгалын гэрээ байгуулсанаар үүснэ:
  - **богино хугацааны**
  - **удаан хугацааны**

7. 1. Бүх нийтийн эрүүл мэндийн даатгал

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж **үүсгэн байгуулах нь**, ялангуяа:

48/1997 тоот хуулиар:

- ЧУ-ын нутаг дэвсгэрт **байнга оршин суугч**;
- ЧУ-ын нутаг дэвсгэрт ажлын газартай эсвэл байнга оршин суух зөвшөөрөлтэй **ажиллуулагчийн ажилчин**;

эсвэл

1231/10 тоот Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн тушаалыг үндэслэн:

- **Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн 883/04 тоот тушаал болон, түүний 987/09 тоот гүйцэтгэх тушаалд хамаарагдахгүй гуравдагч орны иргэдийн, зөвхөн тэдний улсын иргэншлээс шалтгаалж,** ЧУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөлтэй тэдний гэр бүлийн гишүүдэд болон тэднээс үлдсэн гэр бүлийн гишүүдэд ЧУ-ын нутаг дэвсгэрт бүхий л байдалд хязгаарлахгүйгээр даатгуулж болно.

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсаныг хүчингүй болгох нь, ялангуяа:

48/1997 S тоот хуулиар:

- **нас барсан,** даатгуулагч нас барсан эсвэл нас барсанаар тооцогдсон;
- ЧУ-ын нутаг дэвсгэрт **байнга оршин суух зөвшөөрлөө хүчингүй болгосон**;
- ЧУ-д **ажлынхаа гэрээг цуцласан** (ЧУ-д байнга оршин суух зөвшөөрөлгүй тохиолдолд);

эсвэл

Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн 883/04 тоот тушаалаар болон, түүний 987/09 тоот гүйцэтгэх тушаалаар (Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн 1231/10 тоот тушаалтай хамаарагдан):

- Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн 883/04 тоот тушаал болон, түүний 987/09 тоот гүйцэтгэх тушаалд хамаарагдах гуравдагч орны иргэдэд**,** ЧУ-ын нутаг

дэвсгэрт оршин суух зөвшөөрөлтэй тэдний гэр бүлийн гишүүдэд болон тэднээс үлдсэн гэр бүлийн гишүүдэд **чехийн нийгмийн хангамжийн хуулийн дүрэм үйлчлэхгүй болсон** үед (бас эрүүл мэндийн даатгал).

➢ **Даатгал төлөгчид**

Даатгал төлөгчид нь:

– **даатгуулагч,** 48/1997тоот хуулинд дурьдсан(3бүлэгт ангилна:
– ажилчид,
– хувиараа аж ахуй эрхлэгч (ХААЭ),
– цалингийн татваргүй хүмүүс);
– **ажиллуулагч**;
– **улс**.

Ажилчидийн даатгалын 1/3-хувийг ажилчид, 2/3-хувийг ажиллуулагч төлнө. Ажилчны даатгуулсан даатгалын газар даатгалыг төлнө. Ажиллуулагч нь ажилчныг ажилд орсон өдрөөс найм хоногийн дотор эрүүл мэндийн даатгалын газар мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв ажилчин нь эрүүл мэндийн даатгалын газарт ажиллуулагч мэдэгдээгүйг мэдсэн тохиолдолд, өөрөө яаралтай энэ байдлыг холбогдох эрүүл мэндийн даатгалын газарт мэдэгдэх ёстой.

Улс даатгал төлөх, улсын сангаас эдгээр даатгуулагчидад төлнө:

– өөрийгөө тэжээх чадваргүй /цалингүй/ (26 хүртэл насны),
– ЧУ-ын тэтгэвэрийн даатгалыг ашиглаж буй тэтгэвэрийнхэнд,
– жирэмсний болон эцэг эхийн амралттай эмэгтэйчүүдэд, эцэг эхийн тэттгэмж авагчидад
– хөдөлмөрийн товчоонд бүртгүүлсэн ажил хайгчидад.

Даатгал нь улсаас төлөгчидийн бүх ангилалыг 48/1997 тоот хуулийн 7-р зүйлд дурьдсан).

➢ **ЧУ-д гадаадын иргэдийн эрүүл мэндийн даатгал ашиглах эрх үүрэг**

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан гадаадын иргэд нь ЧУ-ын нутаг дэвсгэрт эрүүл мэндийн хангамжийг ашиглахдаа ЧУ-ын иргэдтэй адил эрхийг эдлэнэ. Ялангуяа эдгээр **эрхүүд нь**:

– эрүүл мэндийн даатгалын газрыг сонгох (эрүүл мэндийн даатгалын газраа зөвхөн 12 сард нэг удаа өөрчилж болно, энэ нь хуанлийн гурван сар бүрийн эхний өдөр);
– холбогдох эрүүл мэндийн даатгалын газартай гэрээтэй эмч болон эрүүл мэндийн газрыг сонгох (даатгуулагч нь энэ эрхээ гурван сард нэг удаа ашиглаж болно);
– шууд төлбөргүй эрүүл мэндийн хангамж (бүх нийтийн эрүүл мэндийн даатгалаас төлөгддөггүй үйл ажиллагаанаас бусад);
– эрүүл мэндийн даатгалаас төлөгддөг эмчилгээний бэлдмэлүүд болон тусгай эмчилгээний зориулалттай хүнсний зүйлүүдийн төлбөрүүд, хэрэв төлбөрийн болзолтой хамааралтай эмчилгээний бэлдмэлүүд болон тусгай эмчилгээний зориулалттай хүнсний зүйлүүдийн төлбөрүүд.

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гадаадын иргэнд мөн **үүрэг** ноогдно, эдгээр үүрэгт, ялангуяа:

– холбогдох эрүүл мэндийн даатгалын газарт төлбөрөө төлөх (48/1997тоот хуулинд өөрөөр тусгагдаагүй бол);
– эрүүл мэндийн хангамжийн үед даатгалтай гэдгээ даатгалынхаа үнэмлэхээр нотлох;
– өөрийнхөө эрүүл мэндийн даатгалын газарт ажилд орсон, ажлаас халагдсанаа 8 хоногийн дотор мэдэгдэх (ажиллуулагч мэдэгдээгүй тохиолдолд) мөн хувиараа эрхлэх үйл ажиллагаа эхлэсэн буюу дуусан, байнга оршин суух зөвшөөрөл олгогдсон, эрүүл мэндийн даатгалын газраа өөрчилсөн, улсын даатгалд хамрагдаж эхэлсэн болон дуусан, хүүхэд төрсөн(хүүхдийн эх даатгалынхаа газарт зөвхөн хүүхдийн төрсөн өдрийг мэдэгдэнэ), даатгалын үнэмлэх гээгдсэн эсвэл гэмтсэн зэргийг мэдэгдэх;
– эрүүл мэндийн даатгалаа дуусаны дараа, эрүүл мэндийн даатгалынхаа газраа өөрчилсөн эсвэл удаан хугацаагаар гадаадад байрлах тохиолдолд даатгалынхаа үнэмлэхийг буцааж өгнө;

– хувийн мэдээлэл болон оршин суух өөрчлөгдсөн тохиолдолд мэдэгдэнэ (өөрчлөлт болсноос хойш 30 хоногийн дотор);
– эмчид үзүүлхэд 30 корун, эмнэлэгт хэвтэж эмчлүүлхэд ор хоногийн төлбөр 60 корун (2011 оноос эхлэн 100 корун болгох төлөвлөгөөтэй байгаа), жижүүрийн эмчид үзүүлхэд 90 корун төлнө.

Эрүүл мэндийн хангамж нь сэтгэл хангалуун бус тохиолдолд даатгуулагч нь эмнэлгийн газрын дарга удирдлагуудад хандаж болно. Хэрэв эмчийн зүгээс хангалттай бус хандлага хүлээсэн бол даатгуулагч Чехийн эмчийн танхим, Чехийн стоматологийн (шүдний эмч)-ийн танхим, Чехийн эмийн сангийн танхим, өөрийн даатгалтай эрүүл мэндийн даатгалын газарт хандаж болох ба ийм тохиолдолд улсын байгууллага тухайн эмнэлгийн газрыг бүртгэж авна.

➢ **Даатгалын газраас төлөгдөх эрүүл мэндийн хангамжийн хүрээ**

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын газраас төлөгдөх эрүүл мэндийн хангамж

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалаас эрүүл мэндийн хэрэгцээг бүрэн төлсөн байдаг ба үүнд, амбулторийн болон эмнэлгийн үйлчилгээ, жижүүрийн болон түргэн тусламжийн алба, урьдчилан сэргийлэх эмчилгээ, тусгай эмчилгээ, эмийн бэлдмэлээр хангах, эрүүл мэндийн хэрэгцээгээр болон стоматологийн (шүдний) бүтээгдхүүнээр хангах, рашаан сувилгааны эмчилгээ, хүүхдийн мэргэжлийн эмчилгээ, үйлдвэрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эмчилгээ, өвчтөнгүүдийг зөөвөрлөх, (даатгуулагчийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалж), замын зардлын нэхэмжлэл, шинжээ тодорхойлолтын үйл ажиллагаа, (тодорхой хэмжээнд), нас барагчидын үзлэг болон задлан шинжилгээ зэрэг зүйлүүд хамрагдана.

Даатгуулагч нь зарим хуулиар тогтоогдсон хэмжээнээс хэтэрсэн **зарим нэгэн эмчилгээ, эмийн бэлдмэлүүд, зарим эрүүл мэндийн хэрэглэгээ** зэрэгт нэмж төлнө. Үүнд жишээ нь: зарим нэгэн стоматолог (шүдний эмч)-ийн үйл ажиллагаа, рашаан сувилалын эмчилгээний талыг, ялангуяа зарим нэгэн эмийн бэлдмэлүүд болон эрүүл мэндийн хэрэгслүүд байна. Эмийн бэлдмэл болон эрүүл мэндийн хэрэгслэлүүдийн даатгал төлөх хэсгээ бүрэн төлөх ба үлдсэн хэсгийг өвчтөн гүйцээж төлнө. Эрүүл мэндийн даатгалаас төлөгдхөөр тогтооогдоогүй эмийн бэлдмэлүүдийг өвчтөн өөрөө бүтнээр нь төлнө. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байх үеийн эмчилгээ болон эрүүл мэндийн хэрэгслүүд нь даатгалаас бүрэн төлөгдөнө. **Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд хамаарагдахгүй**, жишээ нь **өвчтөн бүрэн төлөх** эрүүл мэндийн хангамжууд нь мөн хуулинд хамаарагдахгүй (жишээ нь: стоматолог (шүдний эмч) – ийн эсвэл акипунктура (зүү эмчилгээ) – ний үйл ажиллагаанууд).

7. 2. Зорчигчийн эрүүл мэндийн даатгал

Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын болзлыг хангаагүй гадаадын иргэд нь зорчигчийн эрүүл мэндийн даатгалын гэрээг /VZP, a.s./Бүх нийтийн эрүүл мэндийн даатгал, /Victoria Volksbanken, a.s./Викториа Волксбанкен, /Slavia, a.s./Славиа, /Maxima/Максима, /UNIQA/ УНИКА зэрэг даатгалын газруудтай хийж болно.

Эрүүл мэндийн хангамжийн төлбөрийн Чехийн үндэсний банкын вэб хуудаснаас – http://www.cnb.cz (► /Dohled nad finančním trhem/Санхүүгийн зах зээлийн хяналт ► / Seznamy a evidence/Танилцуулга, бүртгэл ► /Seznamy regulovaných a registrovaných subjektů finančního trhu/Санхүүгийн зах зээлийн тохиргооны болон бүртгэгдсэн субъект ► / Přímé vyhledávání subjektu finančního trhu/Санхүүгийн зах зээлийн субъектын шууд хайлт), даатгуулхыг хүсэж буй даатгалын газар тань даатгалын үйл ажиллагаа явуулах эрхтэй эсхийг мэдэж болно.

1. Богино хугацааны зорчигчийн эрүүл мэндийн даатгал (365хоног хүртэл)

Энэ даатгал нь ЧУ-ын нутаг дэвсгэрт богино хугацаагаар оршин суух үед даатгуулхад тохиромжтой, жнь: аялал жуулчиллаар эсвэл ажлаар. Даатгалаас зөвхөн яаралтай шаардлагатай анхан шатны эрүүл мэндийн хангамж, яаралтай шүдний үзлэг зэргийг төлнө. Даатгалын хүрээ болон болзлыг даатгалын гэрээгээр тогтооно. Даатгалыг өдөр бүрээр хийх ба хамгийн бага хугацаа нь гурван өдөр байна.

2. Удаан хугацааны эрүүл мэндийн даатгал

Энэ даатгал нь Чех улсын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суугчидад тохиромжтой – зургаан сараас дээш хугацаагаар, энэ нь даатгалын гэрээний хамгийн бага хугацаа юм. Даатгалын хугацаа нь гэрээ байгуулсан өдрөөс эхлэх ба гэрээний хугацаа дууссан, даатгалын гэрээний тухай хуулинд заасан бусад шалтгааны хугацаа дууссан өдрөөр дуусна. Энэ даатгал нь бүх нийтийн эрүүл мэндийн даатгалаас бага хүрээг хамрана. Даатгалын хүрээ буюу болзлыг байгуулсан гэрээ болон даатгалын болзлоор тогтооно.

Удаан хугацааны эрүүл мэндийн даатгал нь бие даасан даатгалын болзлын дагуу 70 наснаас доош насны даатгуулагчидтай, даатгалын газрын тогтоосон эмнэлгийн газрын эмчийн үзлэгийг үндэслэн гэрээ хийнэ. Даатгалын гэрээг бүтэн сараар 6 сараас 24 сарын хугацаатай хийнэ, хугацаа дуусангуут дахин 24 сараар хийж болно. Төлбөрийг чех мөнгөн тэмдэгтээр хийх ба урьдчилан даатгалын хугацааг бүтнээр нь төлнө. Даатгалын гэрээнд даатгалын хүрээ, даатгуулагчийн болон даатгагчийн эрх үүрэг, даатгалын төлбөрийн хэлбэр зэргийг даатгалын болзлоор тогтоосон байх ба энэ нь даатгал болон даатгалын гэрээний тухай хуультай зохицож байх ёстой. Бас ЧУ-д гадаадын иргэд оршин суух тухай болзлыг хангасан байх шаардлагатай.

➢ **Даатгал төлөгчид**

Гэрээт эрүүл мэндийн даатгал дахь даатгуулагчид нь, даатгалтай даатгалын гэрээ хийсэн (даатгуулагч гэж нэрлэсэн), одоогийн байдлаар мөн даатгал төлөгчид.

➢ **ЧУ-д гадаадын иргэд эрүүл мэндийн хангамж ашиглах эрх үүрэг**

Эрүүл мэндийн хангамж нь зүй ёсны бус эсхэд эргэлзсэн даатгуулагч нь эмнэлгийн газрын дарга удирдлагуудад хандаж болох ба, хэрэв эмчийн зүгээс хангалттай бус хандлага хүлээсэн бол Чехийн эмчийн танхим, Чехийн стоматологийн (шүдний эмч)-ийн танхим, Чехийн эмийн сангийн танхим, өөрийн даатгалтай эрүүл мэндийн даатгалын газарт хандаж болох ба ийм тохиолдолд улсын байгууллага тухайн эмнэлгийн газрыг бүртгэж авна.

➢ **Төлөгдөх эрүүл мэндийн хангамжийн хүрээ**

Удаан хугацааны гэрээт даатгалаас төлөгдөх эрүүл мэндийн хангамж

Удаан хугацааны гэрээт эрүүл мэндийн даатгалаас төлөгдөх эрүүл мэндийн хангамжийн хүрээ нь даатгалын болзлоор тогтоогдсон ба болзолд энэ датгалаар төлөгдөх эрүүл мэндийн хангамжаас гадна төлөгдөхгүй хангамжуудыг агуулсан. Ийм учраас энэ гэрээг хийхээс өмнө даатгалын болзолтой нарийн танилцах хэргэтэйг зөвлөж байна.

Энэ бүлгийн гэрээт даатгалын төлөгдөх хүрээнд диагноз /оношлогоо/, эмчилгээ, амбулторийн болон эмнэлгийн эмчилгээ, эмийн болон эрүүл мэндийн хэрэглэгээний зардлууд (хэд хэдэн бага тусгай боломжтой бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд даатгуулагчтай адилхан хүрээтэй), эмнэлгэт хүргүүлэх тээврийн зардал зэргүүд багтана.

Богино хугацааны гэрээт даатгалаас төлөгдөх эрүүл мэндийн хангамж

Богино хугацааны гэрээт эрүүл мэндийн даатгалаас төлөгдөх эрүүл мэндийн хангамжийн хүрээ нь тухайн даатгалын болзлоор тогтоогдсон байдаг.

Олон улсын гэрээг үндэслэсэн төлбөргүй эрүүл мэндийн хангамж

ЧУ-ын нутаг дэвсгэрт мөн (бүх нийтийн эрүүл мэндийн даатгалаас өөр) гадаад улсын иргэдэд эрүүл мэндийн хангамжийг доорхи нөхцлийг үндэслэн олгоно:

1. **төлбөргүй эрүүл мэндийн хангамжаар хангах тухай хоёр талын гэрээ нь**, ЧУ болон тухайн иргэний харьяат улс хоёрын хооронд байгуулсан гэрээ юм. Энэ нь ЧУ-д шаардлагатай эрүүл мэндийн төлбөргүй хангамжийг тогтоосон гэрээг агуулсан. Энэ эрүүл мэндийн хангамжийн эрхийг эдлэхдээ гадаадын иргэн нь ихэнхдээ гадаад паспортаараа нотолдог. Энэ эрүүл мэндийн хангамжийг ЧУ-ын Эрүүл мэндийн яамнаас төлөгдсөн байдаг. Одоогийн байдлаар эдгээр улсуудтай хүчинтэй гэрээтэй байна: Емен, Куб, Ливи, Мароко, Босни Герцегонив.
2. **эрүүл мэндийн даатгалыг хамарсан нийгминй хангамжийн тухай хоёр талын гэрээ**. Энэ гэрээний хангамж нь шаардлагатай, хойшлуулашгүй хангамж нь хязгаарлагдмал байна гэж хэлж болох ба, дээр дурьдсан тухайн эрүүл мэндийн даатгал нь онцгой хангамжтай

өргөн хүрээтэй байж болох юм. Эдгээр гадаадын даатгуулагчидаас үзүүлхийн өмнө ЧУ дахь эрүүл мэндийн даатгалын тусламжаар гадаадын институцээр олгогдсон маягтыг шаардах ба гадаадын даатгалын газар нь *Бүртгэлийн тодорхойлолт* эсвэл *ЧУ-д оршин сууж буй гэрээт улсын даатгуулагчийн даатгалын үнэмлэхийг* олгоно. Эдгээр гэрээнүүдийг доорхи улсуудтай хийсэн: Хорват, Македон, Турк, Серб, Черна Хора, Израил (тайлбар: Израил улстай хийсэн гэрээ нь ЧУ-ын нутаг дэвсгэрт зөвхөн гэнэтийн төрөлт, ажлын гэмтэл зэргийн шаардагатай эрүүл мэндийн тусламжийн үед үйлчилнэ).

!!! АНХААРУУЛГА !!!

Хэрэв эрүүл мэндийн байдал тань яаралтай, шаардлагатай тусламж хэрэгтэй болсон тохиолдолд хамгийн ойрхон эмнэлгийн газар даатгалын картгүйгээр эрүүл мэндийн хангамжаар хангана. Эдгээр тохиолдолд эмч болгон тусламж үзүүлнэ. Энэ эрүүл мэндийн хангамжийн төлбөр нь бүх нийтийн эрүүл мэндийн даатгалд даатгагдсан эсэх, хувийн даатгалын газар даатгагдссан эсэх, эрүүл мэндийн даатгалгүй зэргээс шалтгаалж өөр өөр байх ба даатгалгүй тохиолдолд бүх төлбөрийг өөрөө төлнө.

7. 3. Заавал хийгдэх урьдчилан сэргийлэх тарилгууд

Заавал хийгдэх урьдчилан сэргийлэх тарилга нь ялангуяа хүүхдүүдэд хамааралтай. Тарилгын хугацааг хүүхдийн тань эмч, өрхийн тань эмч энгийн үзлэгийн үеэр анхааруулж сануулна. Урьдчилан сэргийлэх тарилгын тарианы төлбөрийг улс төлнө. Тарианы зүүг бүх нийтийн эрүүл мэндийн даатгал төлнө.

7. 4. ЧУ дахь эрүүл мэндийн хангамжийн байгууллагуудын систем

ЧУ-ын нутаг дэвсгэрт улсын болон улсын бус эмнэлгийн газрууд байдаг. Ихэнх эмнэлгийн газрууд ямар нэгэн даатгалын газартай гэрээ хийсэн байдаг ба тухайн даатгалын газрууд нь өвчтөнг шууд төлбөр хийхгүй боломжоор хангана. Энэ байдлыг эмчид үзүүлхээсээ өмнө асууж мэдэх хэрэгтэй (тухайн эмч өөрийн тань даатгалтай гэрээтэй эсхийг асууна).

Чех улсад 1998 оноос Холбооны акредитачны комис ажиллаж байна. Энэ холбоо нь акредитацыг ихэвчлэн эмнэлгийн хэвтэж эмчлүүлэх газарт хийгдэж байх ба 2010 онд анхны акредитацын амбулторийн эмнэлгийн газар байгуулагдсан. Өвчтөн нь эмнэлгийн газрыг акредитны эсэх, эрүүл мэндийн хангамж нь хангалттай чанарлаг үйлчилгээтэй эсхийг харгалзан эмнэлгийн газрыг сонгох боломжтой. Эрүүл мэндийн хангамж нь үйл ажиллагааны стандарт хангасан, чанарын өндөр түвшинтэй, аюулгүй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангасан акредитын эмнэлгийн газруудыг Холбооны акредитны комисын интернет хуудаснаас мэдэж болно http://www.sakcr.cz (► /Akreditovaná zařízení/Акредитны эмнэлгийн газар).

Олон улсын Joint Commission International (JCI) акредитацыг хамгаалсан Чех улс дахь эмнэлгүүдэд Праг дахь Цэргийн төв эмнэлэг (ЦТЭ), Хомолцэ дахь Эмнэлэг, Остравагийн нэгдсэн эмнэлэг, Праг дахь хематологийн болон цус эмчилгээний хүрээлэн зэргүүд багтана.

➢ **Амбулторийн эмчилгээ**

Өвчтөн ихэвчлэн эхлээд эмчид хандаж **анхан шатны** эмчилгээг хийлгэдэг ба энэ нь өөрийнх нь оршин суудаг газрын ойролцоо байдаг. Эдгээр нь хүний их эмч, Хүүхэд залуучуудын эмч, Шүдний эмч, Эмэгтэйчүүдийн эмч нар юм. Хэрэв өвчтөн нь ямар нэгэн байдлаас шалтгаалж эмч эсвэл эмнэлгийн газрыг мэдэхгүй тохиолдолд хотын болон суурингийн захиргаанаас асууж болно. Мөн эрүүл мэндийн даатгалын газраас зөвлөлгөө авах эсвэл эмчийн Утас:ны жагсаалтыг асууж болно. Эмчийг сонгохдоо өөрийнхөө даатгалтай гэрээтэй эмчийг сонгох хэрэгтэй. Бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын газарт даатгуулсан өвчтөн анхан шатны эмчилгээ хийлгэхдээ эхлээд эмчид бүртгүүлсэн байх шаардлагатай. Бүртгүүлсний дараа эмч нь тогтмол эмчилгээг хийх ба энэ нь үндсэн эмчилгээ (мөн өвчтөнгийн байгаа газар очиж) хийнэ, мөн хэрэгцээний дагуу мэргэжлийн эмчид үзүүлэх эсвэл эмнэлэгт хэвтэх арга хэмжээг авна. Гэрээт эрүүл мэндийн даатгалд даатгуулагч нь эмчид бүртгүүлэх шаардлагагүй ба тэдний үзлэгийг даатгагчийн гэрээт эмч хийнэ.

***Эмч өвчтөнийг бүртгэхээс татгалзаж болох** ба энэ зөвхөн түүнийг бүртгэж авснаар ажилд нь хүндрэл учирч, одоогийн бүртгэлтэй байгаа өвчтөнгүүдэд чанартай эмчилгээ хийхэд садаа болхуйц үед татгалзана. Харин эмч нь яаралтай шаардлагатай эмчилгээг татгалзаж болохгүй (гэмтэл, гэнэтийн өвчлөлт). Ийм нөхцөлд татгалзсан тохиолдолд өвчтөн нь эмчээс татгалзсаныг бичгээр өгхийг шаардах эрхтэй. Хэрэв эргэлзээтэй хандлага гарсан тохиолдолд шалгаж үзэх талаар өргөдөл бичиж эрүүл мэндийн даатгалын газарт хандаарай.*

Хэрэв өвчтөнгийн эрүүл мэндийн байдал мэргэжлийн эмчийн тусламж хэрэгтэй болсон тохиолдолд анхан шатны эмч, өвчтөнгийн даатгалын газартай гэрээтэй **мэргэжлийн эмнэлгт**, мэргэжлийн эмчилгээ эсвэл үзлэг хийх өргөдөлтэй хамт хүргэнэ. Өвчтөнгийн эрүүл мэндийн байдал мэргэжлийн эмчид яаралтай шаардлагатай эмчилгээ хэрэгтэй болсон тохиолдолд бүртгэлтэй эмчээс өргөдөл хүсэлтийн бичиг байх шаардлагагүй. Мэргэжлийн эмчлэгч эмч өвчтөнгийн бүртгэлтэй эмчид өөрийн оношлолон эмчилгэний явц, өвчтөнгийн ажлын актны талаар зэргийг мэдээлнэ.

➢ **Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх**

Хэрэв өвчтөнгийн байдал шаардлагатай бол анхан шатны эмчлэгч эмч эсвэл амбулторийн мэргэжлийн эмч эмнэлэгт хэвтүүлхийг шийдэх ба эсвэл өөрөө шийдвэрлэнэ. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлж дууссаны дараа өвчтөнг эмнэлгээс гаргаж, өөрийнх нь үздэг эмчид эмнэлэгт эмчилж байсан эмчилгээний тухай мэдээ мөн дараагийн эмчилгээ хийх зөвлөлгөөтэй цуг илгээнэ. Хэвтэж эмчлүүлдэг эмнэлгийн хажууд мэргэжлийн эмчилгээний байгууллагуудын сүлжээ эмчилгээгээр хангаж байна

➢ **Жижүүрийн болон түргэн тусламжийн алба**

Энэ эрүүл мэндийн алба нь бүртгэлтэй эмчийн байхгүй үед эсвэл ажлын бус цагаар гэнэтийн өвдөлт эсвэл гэмтсэн, мөн гэнэт хүнд өвчин тусаж эрүүл мэнд нь улам дордох эсвэл амь насанд нь аюул учирч болзошгүй үед өвчтөн өөрөө эмчид эсвэл түргэн эмнэлгийн тусламж авах эмнэлгт хүрч чадахгүй тохиолдлуудад эдгээр үйлчилгээр хангана (5. 5-р бүлэг).

➢ **Эмийн сангууд**

Эмийн сангууд нь өвчтөнд эмчийн бичгээр эсвэл чөлөөтэйгөөр эмийн бэлдмэлүүд, эрүүл мэндийн хэрэгслүүдээр хангана. Эмийн сангууд нь өвчтөнд рецептээр даатгалаас төлбөргүй, бүрэн төлсөн эсвэл хагасыг нь төлсөн нэмэлт төлбөртэй байдлаар эм олгоно. Рецептээр бичсэн эмүүдийн зарим нь даатгаалаас төлөгдсөн байдаг ба түүнд хэдэн ч эм бичсэн байсан 30 корун төлнө. Жижүүрийн эмчийн рецептийг бичсэн өдрөөс хуанлийн 1 өдрийн дотор төлбөрийг хийнэ, антибиотик, антимикробиотик, хемотераутик зэргийг 5 хуанлийн өдрийн дотор, бусад эмийн рецептийг 14 хуанлийн өдрийн дотор төлбөрийг хийнэ. Эмийн сан нь зарим нэгэн эрүүл мэндийн хэрэгслэлүүдийг бичгээр өгч болно. Эдгээр хэрэгслэлүүдийг даатгалын газартай гэрээ хийснээр олгох ба эмчийн бичгийг үндэслэн өвчтөнгийн зүгээс төлбөргүй эсвэл тал төлбөртэй эсвэл даатгалын газраас бүрэн төлбөртэйгөөр олгоно. Холбогдох эрүүл мэндийн даатгалын газар өөрийн даатгуулагчидад зарим эрүүл мэндийн хэрэгслэлүүдийг зээлээр олгож болно.

7. 5. Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон дэмжлэг үзүүлэх

ЧУ дахь эрүүл мэндийн хангамжийн системтэй мөн бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон дэмжих систем хамааралтай байдаг.

Энэ хүрээний эрх үүргийг 258/2000 тоот бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах тухай хуулиар тогтоогдсон байдаг. Энэ хууль болон түүний дагалдах дүрмүүд нь жнь: **олон нийтийг хамарсан болон халдварт өвчнүүдийн хүрээ тэлхээс** хамгаалах тухай ба мөн ажил хөдөлмөрийн үеийн эрүүл мэндийг хамгаалах, усны болон усны нөөцийн ариун цэврийн шаардлага, хүүхдүүдийн амралт сувиллын арга хэмжээний шаардлага, сургуулийн байрны болон сургуулийн бусад байр тоног төхөөрөмжийн ариун цэврийн шаардлага, нийгмийн хүмүүжлийн үйл ажиллагааны болон яаралтай шаардлагатай тусламж хэрэгтэй хүүхдүүдэд зориулсан байр тоног төхөөрөмжийн ариун цэврийн

шаардлага, халдварт өвчин судлалын үйл ажиллагаа, бусад хоол хүнс хариуцдаг үйлчилгээнүүдийн шаардлага зэргүүдийг хамруулсан болно. Энэ хүрээн дэх бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах улсын захиргааны байгууллагуудад дээр дурьдсан хуулиар бас Эрүүл мэндийн яам, крайн ариун цэврийн станц, зарим нэгэн бусад яамнууд, крайн захиргаанууд багтана. Бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах байгууллагаас гадна эрүүл мэндийн хүрээлэн бас бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалхыг хариуцаж байдаг. Праг дахь Эрүүл мэндийн хүрээлэнгийн салбар газрууд бүх нийтийн эрүүл мэндийн анхан шатны урьдчилан сэргийлэх болон дэмжих үйл ажиллагаанд чиглэгдсэн, ялангуяа эрүүл мэндийг сахих болон зөвлөлгөөний үйл ажиллагааг хариуцаж байдаг. Улсын эрүүл мэндийн хүрээлэнгийн үйл ажиллагааны болон бусад мэдээллүүдийг, жишээ нь цэцгийн тоосны мэдээлэл зэргийг дэлгэрэнгүйгээр энэ интернет хуудаснаас мэдэж болно – http://www.szu.cz. Зарим нэгэн эрүүл мэндийн хүрээлэнгүүд лабораторын болон шинжэлгээний ажлаас ХДХВ-ийн урьдчилан сэргийлэх тарилга болон сорилыг хийж байдаг. Эрүүл мэндийн хүрээлэн тус бүрийн тодорхой үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллүүдийг түүний интернет хуудаснаас олж болно. ЧУ-ын Эрүүл мэндийн яамны интернет хуудаснаас эрүүл мэндийн хүрээлэнгийн танилцуулга болон холбогдох контактыг мэдэж болно– http://www.mzcr.cz (► /Veřejné zdraví/Бүх нийтийн эрүүл мэнд ► /Zdravotní ústavy/Эрүүл мэндийн хүрээлэнгүүд).

7. 6. ЧУ дахь шалзан хорхойн тархалт

Чех улсад чөлөөт байгальд болон зарим үед цэцэрлэг сааданд маш жижиг 0,8 - 5 миллиметрийн хэмжээтэй, хар өнгөтэй, шимэгч шалзны төрлийн хорхой байдаг (энгийн яриагаар шүрүүбэн хорхой гэж нэрлэдэг) ба энэ нь амьтан болон хүнд хамгийн их өвчин халдаагч хорхой юм. Энэ нь жижиг шимэгчийн бүлэгт багтана. Зэрлэг амьтадын болон хүний цусыг сордог. Энэ шалзанд хазуулхад өвдөхгүй. Шалз нь өвчтэй амьтадын цусыг сорсноор өвчин халдаж, дараа нь хүний цусыг сорохдоо цусанд нь халдварт өвчин халдаана. Тэгхээр халдвар авсан шалз нь халдварын голомт болно. Ингэж шалзаар халдсан вирусын өвчин енцефалитида (тархины үрэвсэл) – ийн халдварын эсрэг урьдчилан сэргийлэх тарилга хийж болно. Бактерын өвчин борелиоза – энэ өвчний эсрэг урьдчилан сэргийлэх тарилга тус болохгүй. Ийм учраас энэ шалзанд хазуулхаас маш болгоомжлох хэрэгтэй. Хэрэв хазуулсан тохиолдолд яаралтай салгаж авах хэрэгтэй.

Шалз нь навчит болон холимог ой, бутлаг ургамал, өндөр өвстөй газрууд, мөн цэцэрлэг эдлэн газар ажиллаж байх үед ч гэсэн тохиолдодно. Шалзны онцгой үе нь орон нутгийн байдлаас шалтгаалж гурван сарын дундаас арван нэгэн сарын дунд үеийг хүртэл үргэлжлэнэ. Хамгийн дээд үе нь таван сараас долоон сарын хооронд. Шалз нь газраар мөлхөж явдаг ба дээшээ ургамалаар дамжиш гарч ирнэ. Явж байгаа амьтан буюу хүнд өөрийнхөө хөлний дэгээний тусламжаар наалдана.

Хэрэв шалз элбэг байдаг газруудаар явахдаа урт өмд, урт ханцуйтай цамц, шавьж дайжуулах бодис ашиглан, газар сууж, хэвтэхгүй, өндөр өвс бутаар явхаас зайлсхийж, тэр газраас эргэж ирснийхээ дараа биедээ сайтар үзлэг хийх хэрэгтэй. Шалз ихэвчлэн ордог газрууд нь өвдөгний доорхи хонхор, суга, чихний ар тал хүүхдүүдийн толгойнд (үсэнд). Шалз нь хүний биед ерөнхийдөө хаа ч орж болзошгүй, нууцлаг газруудад хүртэл шигдэг. Хэрэв биедээ шалз байвал яаралтай салгаж хаях хэрэгтэй. Шалз шигдсэн газрыг эхлээд иодоор буюу ариутгалын бодисоор ариутгана. Шалзыг эргүүлж, шахаж, мөн тос болон түрхлэг тосоор хөнөөж болохгүй – ингэснээр гэдсэн доторхийг шахаж халдвар үүсгэж болзошгүй. Нойтон даавуугаар – жишээ нь: гарын алчуураар – хөнгөн хоёр тийш (ганхуулж) хөдлөгөнө, 2–3 минутын даараа сулрана. Зарим тохиолдолд шалзыг хямсаагаар болгоомжтой хавчиж сугалаж авч болно. Мөн хувиараа хийсэн хуванцар картан хавчуургыг ашиглаж болно. Шалзыг сугалаж авсны дараа жорлонгийн цаасанд боож жорлонд хийж усыг татна. Сүүлд нь гараа савандан угааж шалз хазсан газрыг ариутгалын бодисоор ариутгана. Шалзыг татаж авхад бүтнээр нь бус шалзны амны хэсэг үлдэх байдал тохиолдож болзошгүй. Энэ нь тийм ч их аюултай зүйл биш, хоёр гурав хоногийн дараа хазсан газрын ул мөртэй цуг арилна.

Дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас мэдэж болно http://www.szu.cz (► /Témata zdraví a bezpečnosti/Эрүүл мэнд аюулгүй байдлын сэдэв ► /Nemoci a jejich prevence/Өвчин ба түүний

урьдчилан сэргийлэлт ► /Infekční nemoci/Халдварт өвчин ► /Nemoci přenášené hmyzem a členovci/Шимэгч хорхойгоор халдах өвчин ► /Jak se chránit před napadením klíšťaty/Шалзны эсрэг яаж хамгаалах вэ).

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- Эрүүл мэндийн яамны интернет хуудаснаас эрүүл мэндийн даатгалын хаяг http://www.mzcr.cz (► /Ministerstvo zdravotnictví/Эрүүл мэндийн яам ► /Zdroje informací/Мэдээллийн ишлэл ► /Zdravotní pojišťovny/Эрүүл мэндийн даатгал)
- Чехийн ардын банкны вэб хуудаснаас эрүүл мэндийн даатгал хийх эрх бүхий даатгалын газруудыг мэдэж болно– http://www.cnb.cz (► /Dohled nad finančním trhem/Санхүүгийн зах зээлийн хяналт ► /Seznamy a evidence/Танилцуулга, бүртгэл ► /Seznamy regulovaných a registrovaných subjektů finančního trhu/Санхүүгийн зах зээлийн тохиргооны болон бүртгэгдсэн субъект►/Přímé vyhledávání subjektu finančního trhu/Санхүүгийн зах зээлийн субъектын шууд хайлт).
- Эрүүл мэндийн хангамж нь үйл ажиллагааны стандарт хангасан, чанарын өндөр түвшинтэй, аюулгүй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангасан **акредитын эмнэлгийн газруудыг** Холбооны акредитны комисын интернет хуудаснаас мэдэж болно http://www.sakcr.cz (► /Akreditovaná zařízení/Акредитны эмнэлгийн газар).
- **Өчтөнд өгөх зөвлөлгөө** нийтлэлийг ЧУ-ын Эрүүл мэндийн яамны интернетийн хуудсанд нийтэлсэн http://www.mzcr.cz–эхний оршил хуудсанд ойлгомжтойгоор Өвчтөнд өгөх зөвлөлгөө (► /Ministerstvo zdravotnictví/Эрүүл мэндийн яам ► /Odborník zdravotník/Эрүүл мэндийн мэргэжилтэн ► /Portál kvality a bezpečí/Чанрын болон аюулгүйн портал ► /Veřejná část laická/Нийтэд зориулсан хэсэг)
- Чехийн эмчийн танхимын интернет хуудас – http://www.lkcr.cz
- Чехийн эмийн сангийн танхимын интернет хуудас– http://www.lekarnici.cz
- Европын парламентын болон (ЕШ)-ний Зөвлөхийн 883/04 тоот тушаалаар даатгагдсан, нийгмийн хангамжийн тухай хоёр талын гэрээтэй улсын иргэдийн даатгалын тухай мэдээллүүдийг http://www.cmu.cz (► /Pro pojištěnce/Даатгуулагчидад ► /Smluvní státy/Гэрээт улсууд)
- Максима даатгал, х.х.к. – Даатгагдсан гадаадын иргэд http://www.maxima-as.cz (► /Pojištění/Даатгал ► /Pojištění nutné a neodkladné péče – cizinců nebo Komplexní zdravotní pojištění cizinců/Шаардлагатай эрүүл мэндийн хангамж – гадаадын иргэд эсвэл гадаадын иргэдийн Комплексний эрүүл мэндийн даатгал)
- Бүх нийтийн эрүүл мэндийн даатагл х.х.к.. – гадаадын иргэдийн даатгал http://www.pvzp.cz/cs/ (► /Pojištění cizinců/ Гадаадын иргэдийн даатгал)
- Славиа даатгал, х.х.к. – Даатгагдсан гадаадын иргэд http://www.pojistovna-slavia.cz (► /Osobní pojištění/Хувийн даатгал ► /Zdravotní pojištění cizinců/Гадаадын иргэдийн эрүүл мэндийн даатгал)
- УНИКА даатгал – Даатгагдсан гадаадын иргэд http://www.uniqa.cz (► /Občané/Иргэд ► /Zdraví/Эрүүл мэнд ► /Pojištění pro cizince/Гадаадын иргэдийн даатгал)
- ВИКТОРИА -ВОЛКСБАНКЕН даатгал, х.х.к. – Даатгагдсан гадаадын иргэд http://www.victoria.cz (► /Privátní klienti/Хувийн клент ► /Zdravotní pojištění cizinců WELCOME/Гадаадын иргэдийн WELCOME эрүүл мэндийн даатгал)
- Улсын эрүүл мэндийн хүрээлэнгийн үйл ажиллагааны болон бусад мэдээллүүдийг, жишээ нь цэцгийн тоосны мэдээлэл зэргийг дэлгэрэнгүйгээр энэ интернет хуудаснаас мэдэж болно– http://www.szu.cz.

- Эрүүл мэндийн яамны интернет хуудаснаас бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах хууль дүрмийн мэдээлэл болон Крайн ариун цэврийн станц, Эрүүл мэндийн хүрээлэнгийн тухай болон ишлэлүүдийг олж болно http://www.mzcr.cz (► /Ministerstvo zdravotnictví/Эрүүл мэндийн яам ► /Legislativa/Хуульчлал эсвэл ► /Veřejné zdraví a dále/Бүх нийтийн эрүүл мэнд болон цаашид ► Krajské hygienické stanice/Крайн ариун цэврийн станц эсвэл ► /Zdravotní ústavy/Эрүүл мэндийн хүрээлэн)

8. АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ

Чех улсад гадаадын иргэд ажиллах талаархи бүх мэдээллүүдийг хөдөлмөрийн товчооноос болон ХНХЯ-ны интеграчилсан порталаас мэдэж болно http://portal.mpsv.cz/sz

Гадаадын иргэд нь ЧУ-д **ажиллах** эсвэл **хувиараа гэсэн** хоёр үндсэн шалтгаанаар хөдөлмөр эрхлэж болно (хувиараа эрхлэх тухай 9-р бүлэгт үз).

8. 1. Гадаадын иргэдийг ажиллуулах – явц

ЧУ-ын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийг ажиллуулах болзол нь ажил хөдөлмөр эрхлэх тухай 435/2004 тоот хуулиар (цаашид зөвхөн хөдөлмөрийн хууль) тогтоогдсон. Европын холбооны улсын иргэн, Европын холбооны аж ахуйн орнуудын (ЕХАО)иргэд, Швейцар улсын иргэд болон тэдний гэр бүлийн гишүүд Чех улсын нутаг дэвсгэрт ажил хөдөлмөр эрхлэхэд зөвшөөрөл хэрэггүй.

Гуравдагч орны гадаадын иргэд доорхи болзлуудад ажил эрхлэж болно

- **Гадаадын иргэн нь хүчинтэй ажлын зөвшөөрөлтэй байх,** хэрэв хөдөлмөрийн хууль өөрөөр заагаагүй бол ажлын шалтгаантай удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй байх **эсвэл**
- **ногоон карт эзэмшигч** (Дотоод явдлын яамны 461/2008 тоот тогтоолоор тогтоогдсон улсын иргэдэд ажлын шалтгаанаар тусгай байдлаар удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгоно) – дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас мэдэж болно http://portal.mpsv.cz/sz/zahr_zam/zelka,
- **хөх карт эзэмшигч** (дээд мэргэжлийн шаардалагтай ажлын байранд ажиллуулах шалтгаантай шинэ оршин суух хэлбэр) – дэлгэрэнгүй мэдээллүүдийг энэ хаягаас мэдэж болно http://portal.mpsv.cz/sz/zahr_zam/modka.

➢ **Ажиллах зөвшөөрөл**

Гадаадын иргэн нь ЧУ-ын нутаг дэвсгэрт зөвхөн ажил хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй, **ЧУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөлтэй, ногоон эсвэл хөх картыг эзэмшсэн байх ёстой**. Энэ журмаас үндэслэж **хэлтрүүлэлт байна** (хөдөлмөрийн хуулийн 98-р зүйлд дурьдсан); энэ үүрэг нь, ялангуяа байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд, цагаачлагчидад, байнга оршин суух зөвшөөрөл буюу цагаачлал олгогдсон гадаадын иргэдийн гэр бүлийн гишүүд ЧУ-ын нутаг дэвсгэрт гэр бүлийн шалтгаанаар удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд хамаарагдахгүй. Ажлын зөвшөөрөл нь Чех улсын нутаг дэвсгэрт өдрөөр буюу ичнээгээр суралцагчидад, ЧУ-ын нутаг дэвсгэрт дунд болон дээд сургууль төгсөгчидөд, сургалт боловсролын ажил гүйцэтгэж байгаа багшийн мэргэжилтэй хүмүүст, дээд сургуулийн болон эрдмийн академын ажилтан, эрдэм шинжилгээний болон хөгжлийн ажилтанд шаардлагагүй. Мөн ЧУ-ын нутаг дэвсгэрт ажлын зөвшөөрлөөр эсвэл хамгийн багаар 12 сарын хугацаатай ногоон карт эзэмшиж байсан, Европын холбоонд байнга оршин суух хэлбэртэй удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний гэр бүлийн гишүүд, гэр бүлийн шалтгаанаар удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд мөн ажлын зөвшөөрөл шаардагдахгүй.

Европын холбоонд байнга оршин суух хэлбэртэй удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй, хөх карт эзэмшиж байсан гадаадын иргэдийн гэр бүлийн гишүүд, гэр бүлийн шалтгаанаар удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдэд мөн ажлын зөвшөөрөл шаардагдахгүй.

Гадаадын иргэн нь ЧУ-ын нутаг дэвсгэрт хэд хэдэн ажил зэрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд ажил тус бүрд зөвшөөрөл байх шаардлагатай. Ажиллах гэдэгт бас **хуулийн этгээд компаний нэрэн доор өөрийнхөө үүргийг гүйцэтгэх,** худалдааны компаний хэргээр хууль зүйн байгууллага эсвэл хууль зүйн байгууллагын гишүүн байгууллага эсвэл худалдааны компаний **бусад** худалдааны компаниуд эсвэл хууль зүйн байгууллагын гишүүн байгууллага эсвэл бусад хоршооллын байгууллагууд, эдгээрийн гүйцэтгэх үйл ажиллагаануудыг бас ажиллахад тооцно.

Дотоодын байгууллагатай буюу ажиллуулагч хувь хүнтэй гадаадын ажиллуулагч байгууллага гэрээ хийж тэр гэрээний үндсэн дээр гадаадын иргэн ЧУ-ын нутаг дэвсгэрт ажил гүйцэтгэх тохиолдолд мөн ажлын зөвшөөрөөл шаардагдана.

Чех улсад цагаачлалын өргөдөл өгсөн гадаадын иргэнд өргөдөл өгсөн өдрөөс 12 сарын дотор ажлын зөвшөөрөл гаргаж болохгүй.

Гадааын иргэний ажил гүйцэтгэх газрын харъяа **хөдөлмөрийн товчоо** ажлын зөвшөөрөл олгоно. Гадаадын иргэн нь итгэмжлэлийн үндсэн дээр ажлын зөвшөөрлийн өргөдлийг өгөх үеэр ажиллуулагч болон өөр хүнээр өөрийгөө төлөөлүүлж болно. Ажлын гэрээ олгох өргөдлийн албан ёсны төлбөр нь 500 корун байна.

Хөдөлмөрийн товчоо нь ажлын зөвшөөрөлийг **ажлын сул байрны мэдэгдэл**-ийг үндэслэн олгоно (энэ нь ажлын сул байр байгааг ажиллуулагч хөдөлмөрийн товчоонд мэдэгдсэн нөхцөлд). Хөдөлмөрийн товчоо нь тухайн ажлын сул байранд мэргэжил мэргэшлээс, ажиллах хүчээс шалтгаалан ЧУ-ын, Европын холбооны, Европын аж ахуйн орнуудын эсвэл Швейцар улсын ажил хайгч иргэд орж ажиллах сонорхолгүй, нилээд хугацаагаар сул байсны дараа түүнд гадаадын иргэдийг ажиллуулах зөвшөөрөл олгоно. Зарим нэгэн ажлын байранд хөдөлмөрийн товчоо нь хөдөлмөрийн биржийн байдлыг харгалзахгүй гадаадын иргэдэд зөвшөөрөл олгоно (жнь: өөрийн дадлага мэргэшлээ дээшлүүлэх зориолттой гадаадын иргэдэд тодорхой нэг жилийн хугацаатай зөвшөөрөл олгох ба энэ хугацааг сунгаж болно). Ажлын зөвшөөрөл нь шилжүүлж өөрчилж болохгүй, тэгхээр зөвхөн шийдвэрт дурьдагдсан ажиллуулагч л ажиллуулж болно. Энэ нь мөн **ажил гүйцэтгэх газарт** бас хамааралтай. ЧУ-ын нутаг дэвсгэрт ажлын зөвшөөрлийг **тодорхой заасан хугацаагаар олгох ба хамгийн дээд хугацаа нь 2** жилээр олгоно. Ажлын зөвшөөрөл дуусхаас өмнө гадаадын иргэн нь холбогдох хөдөлмөрийн товчоонд шинэ ажлын зөвшөөрлийн өргөдлийг өгөх үүрэгтэй. Хэрэв ажлын зөвшөөрлийн хугацаанаас өмнө ажлын гэрээг дуусгавар (ажлын гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ) болговол **оршин суух зөвшөөрөл мөн дуусна**.

Хөдөлмөрийн товчоо нь хөдөлмөрийн биржийн байдлаас шалтгаалж гадаадын иргэний **ажлын зөвшөөрлийг сунгаж** болох ба давтан дурьдхад, хамгийн дээд тал нь **2 жилээр.** Холбогдох хөдөлмөрийн товчоонд ажлын зөвшөөрлийг сунгах өргөдлийг одоогийн зөвшөөрлийн хугацаа дуусхаас өмнө хамгийн эрт 3 сарын өмнө, хамгийн цаад хугацаа нь 30 хоногийн өмнө өгнө. Ажлын зөвшөөрлийг одоогийн ажиллаж байгаа газар, ажиллуулагч, **гүйцэтгэж байгаа ажлынхаа байранд** сунгуулах болзолтой. Ажлын зөвшөөрлийг сунгуулах өргөдөл нь ажлын зөвшөөрөл олгох өргөдөлтэй адил шаардлагатай. Өргөдөлтэй цуг зөвхөн ажиллуулагч гадаадын иргэнийг цаашид ажиллуулна гэсэн тодорхойлолтыг өгнө. ЧУ--ын нутаг дэвсгэрт ажиллах зөвшөөрлийн сунгалттай Дотоод Явдлын Яамны холбогдох байгууллагад очиж ажлын шалтгаантай 90 хоногоос дээш хугацаатай удаан хугацааны визийн эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн сунгалтын өргөдлийг өгнө. Энэ өргөдлийг одоогийн 90 хоногоос дээш хугацааны буюу удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусхаас өмнө **хамгийн эрт 120** хоногийн өмнө, **хамгийн цаад хугацаа нь 14** хоногийн өмнө өгнө.

Гадаадын иргэн нь ажлын зөвшөөрөлгүйгээр эсвэл ажлын зөвшөөрөл олгох хуультай зохицохгүй ажил гүйцэтгэвэл зөрчил гаргасанд тоцогдож 10 000 корун хүртэл торгуулж болзошгүй**.**

Ажиллуулагч нь (энэ нь байгууллага компани мөн хувиараа эрхлэж байгаа хувь хүн), гадаадын иргэдийг **зөвшөөрөлгүй ажиллуулвал захиргааны зөрчил үйлдэж 5 000 000 коруны торгууль хүлээнэ.** Энэ торгууль нь мөн зөвшөөрөлгүй ажиллуулсан хувь хүнд ч гэсэн ноогдоно.

➢ **Хамгаалах хугацаа**

Хэрэв ажлын гэрээ харьцаа дууссан тохиолдолд хөдөлмөрийн хуулийн зарим нөхцлүүдийн дагуу хугацаа дууссанаас хойш **60 – Өдрийн хамгаалах хугацааг ашиглаж болно,** энэ нь доорхи нөцлүүдэд:

- Ажлын гэрээ харьцаа тань хөдөлмөрийн хуулийн 52-р зүйлийн а)-гаас е)[2] хүртэлх зүйлүүдийн дагуу дуусан, эсвэл хөдөлмөрийн хуулийн 56[3]-р зүйлээр даруй дуусан тохиолдолд;
- ажлын гэрээ дуусах хүртэл ажлын шалтгаанаар оршин сууж байсан тохиолдолд:
  - 1 жилийн хугацаанд, энэ хугацаа нь ажлын гэрээ харьцаа дуусахтай тохирч байгаа, эсвэл
  - 1 жилээс бага хугацаанд, ажлын гэрээ харьцаа дуусах өдрийг хүртэл тасралтгүй 3 жил оршин суусан; тасралтгүй оршин суусан хугацаанд 90 хоногоос дээш хугацааны виз болон удаан хугацаагаараар оршин суух зөвшөөрөл зэргийг тооцно;

Ногоон карт эзэмшигчидэд, 60-өдрийн хамгаалах хугацаа үйлчлэх ба харин ажлын гэрээ харьцаа хөдөлмөрийн хуулийн 52-р зүйлийн а)-гаас е) хүртэлх зүйлүүдийн дагуу дуусан, эсвэл хөдөлмөрийн хуулийн 56-р зүйлээр даруй дуусан нөхцлүүд хамаарахгүй.

Хөх карт эзэмшигч нь, ажлийн гэрээ харьцаа дуусанаас хойш 3 сарын дотор өөр ажиллуулагчийг хайж олох хэрэгтэй. Хэрэв хөх картны хугацааг давтан хэтрүүлсэн тохиолдолд Дотоод Явдлын Яам хөх картыг хүчингүй болгоно. Энэ нь ажлын гэрээ харьцаа хөдөлмөрийн хуулийн 52-р зүйлийн а)-гаас е) хүртэлх зүйлүүдийн дагуу дуусан, эсвэл хөдөлмөрийн хуулийн 56-р зүйлээр даруй дуусан тохиолдолд хамаарахгүй.

8. 2. Ажил хууль эрхийн харилцаа

Ажил хууль эрхийн харилцаа нь ажилчин болон ажиллуулагчийн хоорондох харьцаа ба олон хууль дүрмээр, ялангуяа хөдөлмөрийн хуулиар мөрдөгдөж байдаг (262/2006 тоот хууль).

➢ **Ажлын харьцаа**

Ажлын харьцаа нь ЧУ-ын нөхцөлд хамгийн нийтлэг хамгийн их хөдөлмөрийн хуулийн харилцаа юм. Түүний агуулгыг харилцан эрх үүргээр ажилчин ажиллуулагч хоёр үүсгэдэг. Ажлын харьцааг ЧУ-д **ихэвчлэн ажлын гэрээгээр үүсгэдэг**. Ажлын харьцааг **хугацаа заасан эсвэл хугацаа заагаагүй** гэсэн хэлбэрээр хийдэг. Ажлын гэрээнд мөн дадлагын хугацааг оруулж болох ба, хэрэв энэ хугацааг богиноор тохиролцоогүй тохиолдолд **гурван сарын** хугацаатай байдаг.

Ажлын харьцаа доорхи нөхцлүүдэд дуусна:

- **тохиролцоогоор** ажлын харьцааг цуцлах;
- **халагдах** (ажиллуулагч буюу ажилчны зүгээс, ажиллуулагчийн зүгээс халахдаа зөвхөн хөдөлмөрийн хуулийн дагуу байна; халагдах өргөдлийг үндэслэн халагдах өргөдлийн хугацааг дуусгаад ажлын харьцааг дуусгавар болгох ба энэ халагдах өргөдлийн хугацаа хамгийн бага нь 2 сар байна, энэ нь ажиллуулагч ажилчин хоёрт адилхан үйлчилнэ);

*2 **52-р зүйлийн** дагуу ажиллуулагч нь ажилчидаа зөвхөн эдгээр шалтгаанаар хална:*

a. ажлын газрыг болон түүний хэсгийг хүчингүй болгосон тохиолдолд,

b. ажлын газрыг болон түүний хэсгийг шилжүүлсэн тохиолдолд,

c. ажилчны гүйцэтгэж байсан ажил нь ажиллуулагчидад болон бусад байгууллагуудад шаардлагагүй болсон, техникжүүлсэн, ажлын нөлөөг дээшлүүлэх зорилгоор ажилчидыг цомхотгосон, эсвэл зохион байгуулалтын бусад өөрчлөлт болсон тохиолдуудад,

d. үйлдвэрийн урьдчилан сэргийлэх үзлэгээр эсвэл эмчийн үзлэгийн дагуу холбогдох байгууллагаас ажилчнийг ажил хийхийг хориглосон, мөн ажлаас шалтгаалсан гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчин, эсвэл тухайн ажлын байранд хэмжээнээс хэтэрсэн эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй зөрчил илэрсэн нөхцөлд бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах байгууллага ажилчнийг ажил хийхийг хориглосон зэрэг тохиолдуудад,

e. одоогийн ажиллаж байгаа газраа удаан хугацаагаар ажиллаж, үйлдвэрийн урьдчилан сэргийлэх үзлэгээр болон эмчийн үзлэгийн дагуу холбогдох байгууллага эрүүл мэндээр тэнцэхгүй гэдгийг шийдвэрлэсэн нөхцөлд ажлаас халагдах тохиолдолд).

*3 **56-р зүйлийн дагуу** ажиллуулагч нь ажлын гэрээ харьцааг даруй дуусгана, хэрэв,*

a. үйлдвэрийн урьдчилан сэргийлэх үзлэгээр болон эмчийн үзлэгийн дагуу холбогдох байгууллага эрүүл мэндээр тэнцэхгүй гэдгийг шийдвэрлэсэн нөхцөлд үргэлжлүүлэн ажиллаж болохгүй ба шийдвэр гарснаас хойш 15 хоногийн дотор ажиллуулагч нь тохирох ажил хийх боломжийг олгоогүй тохиолдолд, эсвэл

b. ажиллуулагч нь ажилчинд олгох хугацаа дуусанаас хойш 15 хоногийн дотор цалин хөлс, эсвэл цалин хөлсийн орлуулалт, эсвэл цалин хөлсний хэсгийг олгоогүй тохиолдолд (141-р зүйл 1-р догол мөр).

– **даруй цуцлах** (ажиллуулагчийн мөн ажилчны зүгээс байж болно, харин зөвхөн маш бага нөхцөлд);
– **дадлагын хугацааны үеэр цуцлах** (ямар ч шалтгаангүйгээр ажиллуулагчийн мөн ажилчны зүгээс байж болно);
– **хугацаа дуусcаны дараа,** хэрэв ажлын харьцаа нь заасан хугацаатай хийгдсэн.
– гадаадын иргэдийн хувьд ЧУ-ын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөл нь дуусаж гүйцэтгэх шийдвэрийн дагуу оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон, мөн албадан гаргах шийтгэлийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөр ажлын харьцааг цуцлана.

Ажлын харьцааны хэлэлцээний эрх үүргийн тогтоолд **ажлын гэрээ** нь маш чухал зүйл юм. Гэрээ байгуулхаас өмнө ажиллуулагч нь таны ажлын гэрээний эрх үүрэг болон ажил гүйцэтгэхэд үндэслэгдэх ажлын болон цалингийн болзол зэргийг танилцуулсан байх ёстой. Ажлын харьцааг хэрэгжүүлэх үеэр ажиллуулагч нь тэгш эрхийг баримтлаж, ажлын харьцаанаас үүдэн гарах эрх үүргээ буруу ашиглаж ялгаварлан гадуурхах хориотой.

Ажлын гэрээ нь тодорхой хэлбэр болон агуулгын **шаардлагыг** биелүүлсэн байх ёстой. Ялангуяа **бичгэн хэлбэрээр** хийгдсэн байх ёстой**.** Ажлын гэрээнд ажиллуулагч нь ажилчинтай **чухал зүйлүүдийг** тохиролцох үүрэгтэй ба энэ нь ажлын төрөл, ажил гүйцэтгэх газар болон ажилд орох өдөр гэх мэтийг тохиролцсон байх ба эдгээргүйгээр гэрээ хүчингүй байж болох юм.

Ажлын гэрээнд оролцогчидын хүсэлтээр бусад болзлуудыг оруулж болно. Ажлын гэрээнд хууль дүрмийн эсрэг зүйл байвал тэр хэсэг нь хүчингүйд тооцогдоно. Хүчингүйд тооцогдох зүйлүүд нь, жишээ нь ажилчин нь урьдчилан өөрийнхөө зарим эрхээс татгалзсан тохиолдолд.

➢ **Ажлын харьцаанаас гадуурхи гүйцэтгэх ажлын гэрээ тохиролцоо**

Энгийн ажлын гэрээнд тодорхой **нэмэлт** оруулж болно. Ажилчин нь энэ ажлын үеэр гэрээт ажлын эрхтэй адил эрхийг эдлэхгүй, жнь: амралт авах. Үндсэн ажиллуулагчтай (үндсэн гэрээт ажлаас гадуурхи ажлын хүрээнд), эсвэл өөр бусад ажиллуулагчтай ч гэсэн гэрээт ажлын харьцаатай хамт явагдаж болох юм. Ажлын тохиролцоо (энэ нь, тодорхой ажиллуулагчтай хамгийн дээд хугацаа нь ажлын долоо хоногийн хагастай тэнцэх хугацаагаар) болон ажил гүйцэтгэх тохиролцоо (нэг ажиллуулагчтай хуанлийн жилд хамгийн дээд тал нь 150 цагийн ажлын хүрээтэй (ажил гүйцэтгэх) байхаар тохиролцоог хийнэ) хоёр нь хоорондоо ялгаатай.

8. 3. Ажилчны эрх үүрэг

Хөдөлмөрийн хуулинд **ажиллуулагч нь бүх ажилчидтайгаа адил тэнцүү байдлаар харьцахыг тогтоосон ба энэ нь, ажлын болзол, цалин хөлс, мэргэжлийн бэлтгэл болон албан тушаал, эсвэл бусад ажлын явцад хандах хандлага зэргүүд юм. Хориотой зүйлүүд нь, ажилд авхадаа болон ажлын харьцааны явцад хүйс, ижил хүйсний хэлбэр, хэл яриа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон өөр шалтгаануудаар ялгаварлан гадуурхах зэргүүд юм.** Адил тэнцүү харьцах эрх үүрэг хөндөгдсөн эсвэл ялгаварлан гадуурхах байдалд хүрсэн тохиолдолд ажилчин нь эдгээр зөрчлийг зогсоож, эдгээрээс үүдсэн байдлыг арилгаж, зүй ёсоор харьцахыг шаардах эрхтэй. Энэ шаардлага хангалттай бус, ажилчны нэр хүнд байр суурь мэдэгдхүйц буурсан тохиолдолд ажилчин нь хөрөнгийн бус хохиролын мөнгөн нэхэмжлэл гаргах эрхтэй. Нэхэмжлэлийн хэмжээг шүүх тогтооно.

Хөдөлмөрийн хуулиар (79-р зүйл) **долоо хоногийн ажлын цагийн** хамгийн дээд хэмжээг **40 цагаар** тогтоосон. Амралтын үндсэн хэмжээ (цалингаар орлуулж болох ажлын амралт) ЧУ-д **дөрвөн долоо хоног**.

Хөдөлмөрийн хөлсийн хамгийн доод хэмжээг хөдөлмөрийн хууль эрх зүйн харьцаанд байдаг. Түүний үндсэн хуулийн заалт нь хөдөлмөрийн хуулиар тогтоогдсон байдаг (262/2006 тоот хууль). Цалингийн доод хэмжээ, ажиллуулагчийн ажлын ашиглах нөлөөний хэмжээний дагуу бусад төлбөрт (гэнэт халагдсан) цалингийн доод хэмжээ, доод хэмжээний цалин олгох болзол зэргийг 567/2006 тоот төр засгийн тушаалаар цалингийн доод хэмжээний тухай, доод түвшингийн баталгаат цалингийн тухай, хүнд ажлын нөхцлийн заагийн тухай болон хүнд ажлын нөхцлийн нэмэлт цалингийн хэмжээний тухай зэргийг тогтоосон.

Доод хэмжээний цалин нь ажлын харьцаатай байгаа бүх ажилчидад хамааралтай, эсвэл хуулийн харьцаагаар байгуулагдсан ажлын харьцаанаас гадуурхи ажлын тохиролцоонд хамааралтай (ажлын тохиролцоо болон ажил гүйцэтгэх тохиролцоо). Ажлын харьцааны хугацаа заасан эсвэл хугацаа заагаагүй зэрэг нь ялгаагүй. Доод хэмжээний цалин авах эрх нь бүх ажлын харьцаанд эсвэл хуулийн харьцаагаар байгуулагдсан ажлын харьцаанаас гадуурхи ажлын харьцаанд тусдаа үүснэ.

Бохир цалингийн үндсэн доод тогтоогдсон хэмжээ нь долоо хоногийн ажлын 40 цагт одоогийн байдлаар цагийн **48,10 корун эсвэл сарын 8 000 корун** байна.

567/2006 тоот төр засгийн тушаал нь цалингийн доод хэмжээнээс гадна мөн доод хэмжээний баталгаат цалингийн хэмжээг тогтоосон. Доод хэмжээний цалин нь хувиараа эрхлэх байгууллагуудын хүрээндэх ажилчидын хамт олны цалингийн талаархи тохиролцооны ганц цалингын хэмжигдхүүн гэж тооцогдож байна.

Хувиараа эрхлэх бус хүрээнд (нийтийн үйлчилгээ болон албан газрууд) болон хувиараа эрхлэх бусад байгууллагуудын хүрээнд хамт олны гэрээ байгуулагдаагүй эсвэл хамт олны гэрээнд цалингийн болзол тусгагдаагүй бол доод цалингаас гадна **баталгаат цалингийн доод түвшин** хүчинтэй байдаг. Ажил хууль эрхийн харилцааны ажилчидыг цалинжуулах хүрээндэх шалгалтын үйл ажиллагааг Улсын хөдөлмөрийн байцаан шалгах байгууллагаар удирдлагатай ажил эрхлэж буй газрын орон нутгийн хөдөлмөрийн байцаан шалгах товчоо шалгана (хөдөлмөрийн байцаан шалгах тухай 251/2005 тоот хуулийг үндэслэн).

Эмэгтэйчүүд эхчүүдийг ажиллуулахдаа тэдний бие организмаас шалтгаалж тусгай хуулиар хангасан ба ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, эхчүүдэд ажил хууль эрхийн харилцаанд **өндөржүүлсэн хамгаалах хангамжаар** хангасан. Зарим нэгэн ажил эмэгтэй хүн хийх бүрэн хориотой.

➢ **Жирэмсний амралт**

Ажиллуулагч нь ажилчин эмэгтэйчүүдээ төрөлт болон төрөлтийн дараах хүүхэд асрахтай холбогдуулан 28 долоо хоног ба хоёр болон түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмгтэйчүүд, эсвэл өрх толгойлсон эмгтэйчүүд төрсөн тохиолдолд 37 долоо хоног ажлаас чөлөөлөх үүрэгтэй (жирэмсний амралтын ерөнхий хугацаа).

Төрөлттэй холбоотой жирэмсний амралт нь 14 долоо хоногоос богино байж болохгүй, мөн ямар ч тохиолдолд төрснөөс хойш зургаан долоо хоногийн дотор дуусгах буюу тасалдуулж болохгүй.

Жирэмсний амралт болон эцэг эхийн чөлөө эдлэх үеэр эх/эцгүүдэд нөхөн цалин олдохгүй. Энэ хугацаанд эрүүл мэндийн даатгалын тухай дүрмийн болзлоор (жирэмсний амралтын мөнгөн тэтгэмж, мөнгөн тэтгэмж), буюу улсын нийгмийн тэтгэмжийн(эцэг эхийн тэтгэмж) тухай хуулиар, эд материалын хангамж хэлбэрээр эрүүл мэндийн даатгалын болон улсын нийгмийн тэтгэмжийн хангамж авна. Дэлгэрэнгүйгээр 10. 4.-р бүлэгт

➢ **Эцэг эхийн чөлөө**

Эцэг эхийн чөлөө нь

– ажилчин эмэгтэйчүүдэд – хүүхдийн эхэд жирэмсний амралт дуусаны дараа

– ажилчин эрэгтэйчүүдэд – хүүхдийн эцэгт хүүхэд төрсөн өдрөөс

ба энэ нь ямар хүрээнд авхаас шалтгаална, харин хүүхэд гурван нас хүрснээс хойш байж болохгүй. Мөн эцэг эхийн чөлөө нь хувь хүний хувьд ажлын том саад болдог бөгөөд ажиллуулагч нь ажлаас чөлөөлөх үүрэгтэй. Жирэмсний амралт болон эцэг эхийн чөлөөг ажилчин эмэгтэй, ажилчин эрэгтэй хамтдаа авах эрхтэй.

Хөдөлмөрийн хууль болон гүйцэтгэгч дүрмүүдэд ажлын харилцаанаас үүдсэн ажилчидын холбогдох эрхийг нарийвчлан заасан байдаг. Ажлын харилцаан дахь хууль эрхийн дүрмээс үүдсэн эрх үүргийн биелүүлэлтийг тухайлбал, ажилчидыг цалинжуулах, цалин хөлсийг нөхөн олгох, ажлын болон амралтын цаг, хөдөлмөр хамгаалал болон техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, залуучуудыг болон хүүхэд асарч байгаа хүнийг ажиллуулах зэргийг **Улсын хөдөлмөрийн байцаан шалгах байгууллага** (www.suip.cz) болон түүний салбар орон нутгийн хөдөлмөрийн байцаан шалгах газрууд шалгана. Дээр дурьдсан үүрэг зөрчигдсөн тохиолдолд эдгээр захиргааны байгууллагуудад хандаж гомдол гаргаж болно.

8. 4. Ажил зуучлах болон ажиллуулахтай холбоотой бусад үйлчилгээнүүд

Ажил хөдөлмөр эрхлэх эрхийг хэрэгжүүлэх үүргийг **хөдөлмөрийн товчоо** гүйцэтгэнэ. Энэ зүгийн хамгийн чухал албууд нь (үнэ төлбөргүй) ажил зуучлах, зөвлөх ба мэдээлэх алба, мэргэшил эзэмшүүлэх хангамж, ажилгүйдлийн болон мэргэшил эзэмшүүлэх тэтгэмж олгох зэргүүд юм.

❖ **Эрх бүхий хүмүүсийн хүрээ:**
Ажиллах эрх нь ЧУ-д байнга оршин суух зөвшөөрөлтэй болон цагаачлал олгогдсон гадаадын иргэд ЧУ-ын иргэнтэй адил байна.

Хөдөлмөрийн товчоо нь **ажил хайгчидын бүртгэлийг** удирдан явуулна. Энэ бүртгэлд ажлын харьцаагүй, хувиараа аж ахуй эрхлээгүй, суралцаагүй хүмүүс хамрагдах эрхтэй. Ажил хайгч нь хөдөлмөрийн товчоотой ажил хайх үеэр хамтран ажиллах үүрэгтэй. Ажил хайгч нь онцгой шалтгаангүйгээр боломжтой ажилд орхыг татгалзсан, мэрэгшүүлэх сургалтыг татгалзсан, ганцаарчилан ажиллах төлөвлөлт ажлыг хэрэгжүүлхэд хамтран ажиллаагүй, хөдөлмөрийн товчооноос тогтоосон болзлыг биелүүлээгүй эсвэл хөсөрдүүлсэн зэрэг тохиолдлуудад бүртгэлээс хасагдана (жнь: олж өгсөн ажлын газар тогтоосон хугацаанд хүрэлцэн ирээгүй, хөдөлмөрийн товчооны тогтоосон хугацаанд хүрэлцэн ирээгүй).

Ажил хайгч нь тогтоосон болзлын дагуу **ажилгүйдлийн тэтгэмж** авах эрхтэй. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг сүүлийн ажиллаж байсан газрын сарын цэвэр цалингийн дунджаар хувичалж тогтооно. Ажилгүйдлийн тэтгэмжийн дээд хэмжээ нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2,5 дахин үржүүлсэнтэй тэнцэнэ.

2007 оны 1 сарын 1-нээс амьжиргааны доод түвшингийн тогтолцоот институтид өөрчлөлт орсоноос шалтгаалж, мөн ажиллах тухай хуулийн энэхүү институт ашиглаж байсан тэр хэсэгт өөрчлөлт орсон. 2007 оны 1 сарын 1-нээс эхлэн ажилгүйдлийн тэтгэмжийн дээд хэмжээ хуанлийн жилийн эхний гурван сараас дараа жилийн гурав дахь гурван сар хүртэл ажилгүйдлийн өргөдөл өгсөн өдрөөс эхлэн ардын аж ахуйн цалингийн дундажийг 0,58 дахин үржүүлсэн хэмжээтэйгээр тогтоогдсон.

Хөдөлмөрийн товчоо нь ажлын сул байрны бүртгэлийг удирдаж явуулдаг ба, ХНХЯ-ны интеграчиллын порталаас олж мэдэж болно – http://portal.mpsv.cz/sz

Ажил хайхдаа хөдлмөрийн товчооноос гадна Хөдөлмөр Нийгэм Хангамжийн Яамнаас зөвшөөрөлтэй ажлын агентуруудын үйлчилгээг ашиглаж болно. Хэрэв агентурт „Чех улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийг зуучлах зөвшөөрөл олгогдсон бол", ЧУ-ын нутаг дэвсгэрт түр оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдийг зуучилж болно. Ажлын агентурууд ажил зуучлахдаа үнэ төлбөргүй зуучлах ба **ажилд зуучилсан хувь хүнээс төлбөр авч болохгүй.** Ажлын зарыг **зарын сонингуудаас** болон **интернетийн хайгчаас** олж болно**.**

Гадаадын иргэдэд боломжтой ажил хайхдаа ХНХЯ-ны вэб порталаас www.praceprocizince.cz эсвэл http://portal.mpsv.cz/sz/zahr_zam/prociz. олж болно. Энэ хуудас нь гадаадынханд „ажлын сул байрны мэдээлэл агуулагч"-д ажил хайх боломжийг олгох ба энэ нь ЧУ-ын бүх хөдөлмөрийн товчоонуудын мэдээллүүдийг ашиглаж байдаг. Энэ хуудсанд ажил хайхад гадаадын иргэдэд автоматаар сул ажлын байр сонгох боломжийг олгох ба эдгээр ажлын байранд ажиллуулагч нь гадаадын иргэнийг ажиллуулах боломжтой буюу эсвэл удаан хугацаагаар сул байсан ажлын байр байх болно– хөдөлмөрийн товчоонд 3 сараас дээш хугацаагаар бүртгэлд байсан ажил (хайх үеэр тааруулж болно). Хайлт нь Чех, Украйн, Англи хэлүүдээр байна.

8. 5. Ажилчидын холбоо

Ажилчид нь ажилчидын холбоонд элсэх эрхтэй, энэ холбоо нь тэдний эрхийг хамгаалж ажиллуулагчтай хамгийн боломжтой ажлын болзлын хэлэлцээр хийнэ. Хөдөлмөрийн хууль болон бусад хууль дүрмүүд нь ажилчидын холбоонд олон төрлийн хуулийн эрх олгож байдаг.

Ажилчидын холбоо нь жнь: ажлын-хууль эрх зүйн дүрмийн мөрдөлт буюу ажилчидын нэр дээр байгуулагдсан хамт олны гэрээ, байгууллагын болон үйлдвэрийн бүх салбаруудын ажилчидын үндэслэсэн эрэлт шаардлага зэргийг харж хянаж байдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- ЧУ-д **гадаадын иргэдийг ажиллуулах талаархи дэлгэрэнгүй мэдээллийг** Хөдөлмөр Нийгэм Хангамжийн Яамны интеграчилсан порталаас олж мэдэж болно – http://portal.mpsv.cz/sz (► / Zahraniční zaměstnanost/Гадаадын ажил)
- **Ажлын зөвшөөрөл хэрэггүй гадаадын иргэдийн** ангилалын жагасаалтыг ХНХЯ-ны интеграчилсан порталаас олж мэдэж болно – http://portal.mpsv.cz/sz (► Zahraniční zaměstnanost/ Гадаадын ажил ► /Zaměstnávání cizinců/Гадаадын иргэдийг ажиллуулах ► /Zvláštní případy/Тусгай тохиолдлууд)
- Хөдөлмөрийн биржийн байдлыг харгалзахгүй ажлын зөвшөөрөл хэрэгтэй гадаадын иргэдийн ангилалын жагасаалтыг ХНХЯ-ны интеграчилсан порталаас олж мэдэж болно – http://portal.mpsv.cz/sz (► Zahraniční zaměstnanost/ Гадаадын ажил ► /Zaměstnávání cizinců/ Гадаадын иргэдийг ажиллуулах ► /Zvláštní případy/Тусгай тохиолдлууд)
- Хөдлөмөрийн товчооны жагсаалт – http://portal.mpsv.cz (► /Zaměstnanost/Ажиллуулах ► /Informace z úřadů práce/Хөдөлмөрийн товчооны мэдээллүүд)
- Ажлын зөвшөөрлийн өргөдлийн загвар болон бусад хэрэгтэй маягтуудыг ХНХЯ-ны интеграчилсан порталаас татаж авч болно – http://portal.mpsv.cz/sz (► /Zahraniční zaměstnanost/ Гадаадын ажил ► /Formuláře ke stažení/Татаж авч болох маягтууд)
- Ажлын хууль эрхийн дүрмийн одоогийн мөрдөж байгаа жагсаалтыг Хөдөлмөр Нийгэм Хангамжийн яамны интернет хуудаснаас мэдэж болно – http://www.mpsv.cz (► /Práce a právo/ Ажил болон эрх)
- **Ажил хайгчийг бүртгэлд хамруулах тухай** өргөдлийн болон ажилгүйдлийн тэтгэвэр олгох өргөдлийн хэвлэмэл хуудсуудыг аль ч хөдөлмөрийн товчооноос авч болно эсвэл энэ хаягаас татаж авч болно http://portal.mpsv.cz (► Zaměstnanost ► /Pro občany/Иргэдэд ► /Formuláře ke stažení/Татаж авах маягт)
- **Ажлын агентуурруудын жагсаалтыг** ХНХЯ-ны интеграчилсан порталаас татаж авч болно – http://portal.mpsv.cz (► /Zaměstnanost/ Ажиллуулах ► /Pro občany/ Иргэдэд ► /Agentury práce/ Ажлын агентуурруд ► /„hledat“/ „хайх“дээр дар = бүх ажлын агентуурруудын жагсаалт гарч ирнэ)
- Ажилчидын холбоонуудын болон бие даасан ажилчидын холбооны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Чехморавын ажилчидын холбооны интернет хуудаснаас олж болно – http://www.cmkos.cz
- http://www.mpsv.cz (►/Příjmy a životní úroveň/Цалин болон амьжиргааны түвшин), энд **доод цалингийн** талаархи мэдээллүүдийг дурьдсан

9. ЧУ-д ХУВИАРАА ЭРХЛЭХ

Хувь хүн ямар нэгэн үйл ажиллагааг хувиараа эрхлэх, буюу хувиараа ашигт үйл ажиллагаа эрхлэхийг **хувиараа аж ахуй эрхлэгч** (товчилбол **ХАУАЭ**) гэж нэрлэнэ.

9. 1. Хувиараа аж ахуй эрхлэх

ЧУ-д хувиараа аж ахуй эрхлэхэд хувиараа ашигт үйл ажиллагаа эрхлэх тухай 455/1991 тоот хуулийг мөрдлөг болгоно (цаашид зөвхөн „хувиараа эрхлэх тухай хууль“). Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлгүй хувь хүн, эсвэл Чех улсын нутаг дэвсгэрт суурьшилгүй байгууллага (цаашид зөвхөн „гадаадын хувь хүн“) зэрэг нь хувиараа эрхлэх тухай хууль эсвэл өөр тусгай хуулиар өөрөөр заагаагүй бол Чех улсын нутаг дэвсгэрт хувиараа эрхлэх үйл ажиллагаа явуулхад Чехийн оршин суугчидтай адил болзолтой, адил хүрээтэй байна. Чехийн оршин суугч гэдэгт Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй хувь хүн эсвэл Чех улсад суурьшилтай байгууллага зэргийг тооцно. **Байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд, нэмэлт хамгаалалтаар цагаачлал олгогдсон гадаадын иргэд нь Чехийн иргэдтэй адил болзлоор хувиараа эрхлэх үйл ажиллагааг явуулна.** Европын холбооны, Европын аж ахуйн холбооны тухай гэрээт улсуудын, Швейцарын иргэн бус гадаадын иргэд нь Чех улсын нутаг дэвсгэрт хувиараа үйл ажиллагаа эрхлэх үед Хувиараа эрхлэгчидийг хариуцах байгууллагад (živnostenský úřad) оршин суух зөвшөөрлөө өгөх хэрэгтэй (90 хоногоос дээш хугацааатай виз, удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл, доор дурьдсаны дагуу).

Гадаадын хувь хүн хувираа үйл ажиллагаа эрхлэх эрх нь дараагийн ерөнхий болон тусгай болзлуудтай холбогдон үүснэ. Ерөнхий болзлууд нь:

– 18 нас хүрсэн байх;
– хуулийн үйл ажиллагааны талаар мэдлэгтэй;
– гэмт хэрэг үйлдэж байгаагүй;

Хувиараа үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах тусгай болзлууд нь хувиараа эрхлэх тухай хууль болон өөр тусгай хууль дүрмээр шаардагдсан мэргэжлийн болон бусад болзол шаардлагууд юм.

Хуулийн хүчин төгөлдөр болох нь:

– **хувиараа эрхлэх мэдэгдэл** (энэ нь хувиараа аж ахуй эрхлэх эрхийг олгосныг хувиараа эрлхлэх байгууллагаас мэдэгдсэн ба хувиараа эрхлэх бүртгэлээс гэрчилгээ олгоно),
– **хувиараа эрхлэх концесси**, энэ нь хувиараа эрхлэх концессийг олгох ба хувиараа эрхлэх бүртгэлээс гэрчилгээ олгоно.

Мэдэгдлийн эсвэл **концессийн өргөдлийг** өөрөө (бичгээр, интернетээр, буюу холбогдох албан байгууллаар дамжуулан) **ямар ч хамаагүй хотын хувиараа эрхлэхийг хариуцсан байгууллагад** (хот суурингийн хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцсан байгууллага нь хотын захиргааны хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцсан газар юм) эсвэл Czech POINT үйлчилгээгээр дамжуулан өгч болно (3. 5.-р бүлэгт үз). Өргөдөлтэй цуг өгөх ЕХ-ны улсын иргэний ЕХ-ны улсаас олгогдсон бичиг баримтаас бусад бичиг баримт нь Чех хэлээр бус тохиолдолд орчуулагч болон шинжээч дүгнээчидийн бүртгэлд бүртгэгдсэн албан ёсны орчуулагчаар орчуулагдсан байх ба нотратаар батлагдсан байх шаардлагатай (дээд зэрэглэлийн хуулийн хүчин төгөлдөр болгох эсвэл апостилле хийлгэх 4. 4-р бүлгээс үз). ЕХ-ны улсын иргэний болон ЕХ--ны улсаас олгогдсон бичиг баримт нь гадаадын ностирфикац хийлгэсэн байх шаардлагатай (6. 5-р болон 6. 7-р бүлгүүдэд үз). ЕХ-ны улсын иргэний болон ЕХ-ны улсаас олгогдсон бичиг баримтыг зөвшөөрөх байгууллагаар (Үйлдвэр худалданы яам) мэргэжил мэргэшлийг хүлээн зөвшөөрөх тухай 18/2004 тоот хуулийн 2005/36/ES тоот удирдамжийг удирдлага болгон мэргэжлийг зөвшөөрөх үйл ажиллагааг ашиглаж болох ба эсвэл ЕХ-ны үйлдвэрлэлийн хувиараа эрхлэх болон зарим нэгэн хувиараа эрхлэх үйл ажиллагаатай холбогдогдох болон концессийн бичиг баримтыг хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцсан байгууллагад шууд өгч болно.

Хувиараа эрхлэх мэдэгдлийг Хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцсан байгууллага удирдаж явуулах ба хуулиар тогтоосон болзлыг биелүүлсэн тохиолдолд мэдэгдэл хүлээн авсан өдрөөс 5 хоногийн дотор хувиараа эрхлэх бүртгэлд бүртгэж, бүртгэгдсэн бичиг олгоно. Хувиараа эрхлэх үйл ажиллагаа хариуцах байгууллага нь концессийн өргөдөл хүлээн авснаас 60 хоногийн дотор шийдвэр

гаргах ба хуулиар тогтоосон болзлыг биелүүлсэн тохиолдолд концесс олгох шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс 5 хоногийн дотор хувиараа эрхлэх бүртгэлд бүртгэж, бүртгэгдсэн бичиг олгоно.

Хувиараа эрхлэх тухай болон концессийн мэдэгдлийн өргөдлийг гадаадын иргэн – гадаадын хувь хүн өгсөн тохиолдолд, хувиараа эрхлэх тухай хуулийн 5-р зүйлийн 5-р догол мөрд зааснаар 90 хонгоос дээш хугацаатай виз, удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг хувиараа эрхлэхийг хариуцсан байгууллагад өгөх ба хувиараа эрхлэх тухай хуулийн 47-р зүйлийн 7-р догол мөрд зааснаар хувиараа эрхлэхийг хариуцсан байгууллага оршин суух зөвшөөрлийн үйл ажиллагаанд зориулж хувиараа эрхлэх тухай бүртгэлийн бичгийг үйлдэж өгөх ба энэ бичиг нь хувиараа эрхлэх үйл ажиллагааны эрхийг орлохгүй. Энэ бичгээр гадаадын иргэн нь төлөөний газар/гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн газар хувиараа эрхлэх шалтгаанаар ЧУ-д 90 хоногоос дээш хугацааны виз/удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн шалтгааныг нотлож болно. **Оршин суух зөвшөөрөл хүлээн авсныхаа дараа гадаадын иргэн нь ажлын 3 өдрийн дотор Чех улсад оршин суух газраа бүртгүүлсэн мэдэгдлийг, оршин суух зөвшөөрлийн үйл ажиллагаанд зориулж үйлдсэн хувиараа эрхлэх бүртгэлийн бичигтэй хамт, бүртгэлийн бичгийг олгосноос 6 сарын дотор хувиараа эрхлэхийг хариуцсан байгууллагад өгнө**. Оршин суух зөвшөөрлийг хүлээн авснаас 5 хоногийн дотор Хувиараа эрхлэхийг хариуцсан байгууллага нь хувиараа эрхлэх бүртгэлийн бичгийг олгоно. Хувиараа эрхлэх үйл ажилллгааны мэдэгдэл болон концесс олгосон хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцах байгууллагад удаан хугацааны виз эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн нотлох бичгийг өгсөн өдрөөс эхлэн гадаадын иргэнд хувиараа эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх үүснэ. Хэрэв гадаадын иргэн нь тогтоосон хугацаанд оршин суух зөвшөөрлөө хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцсан байгууллагад өгөөгүй тохиолдолд тухайн байгууллага нь мэдэгдэл/өргөдөл гаргагч нь хувиараа эрхлэх болзол биелүүлээгүй шийдвэр гаргана.

Жилийн цалин нь 15 000 корунаас дээш гарсан хэмжээтэй **хувь хүн бүр цалингийн татварын тайланг** өгнө. Холбогдох жилийн татварын тайланг орон нутгийн холбогдох санхүүгийн байгууллагад 3 сарын 31 хүртэл, эсвэл санхүүгийн зөвлөгч маягт бөглөж өгч байгаа тохиолдолд 6 сарын 30-ныг хүртэл өгнө. Хувиараа эрхлэх үйл ажиллагааны тань татварын талаархи асуултуудыг хувиараа эрхлэх үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийнхаа санхүүгийн байгууллагад хандаж болно.

9. 2. Худалдааны компаниуд

Худалдааны компаниудын хуулийг худалдааны хуулийн 513/1991 тоот хуулиар мөрдлөг болгоно. Худалдааны компани нь хуулийн этгээд юм.

ЧУ-ын нутаг дэвсгэрт гадаадын иргэд хувиараа эрхлэх эрх нь тухайн иргэнийг, түүний байгууллага бүтэц бүрэлдхүүн, хувиараа эрхлэх зүйлийн хүрээ зэргийг худалдааны бүртгэлд бичигдсэн өдрөөс эхлэнэ. Гадаадын иргэдэд худалдааны компаниар дамжуулан **хуулийн этгээдийн байр суурийг эзлэх шалтгаантай оршин суух эрхийг олгоно** (90 хоногоос дээш хугацаатай виз/удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг өгөх үеэр гадаадын иргэн нь худалдааны бүртгэлийн бичиг, эсвэл хувиараа эрхлэх аж ахуйн бүртгэлийн бичиг зэргээр оршин суух зөвшөөрлийнхөө шалтгааныг нотолно).

Дээр дурьдсан оршин суух эрхийн талаархи бичгийг зөвхөн Хуулийн этгээдийн хууль зүйн байгууллагын гишүүдэд олгоно. 90 хоногоос дээш хугацаатай виз эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг хуулийн этгээдийн зөвхөн хамтрагч эсвэл гишүүн болон хууль зүйн байгууллагын гишүүн бус гадаадын иргэдэд олгохгүй. Эдгээр гадаадын иргэдэд хөдөлмөрийн товчооноос ажлын зөвшөөрөл олгосон тохиолдолд „ажиллах“ шалтгаантай оршин суух зөвшөөрөл олгогдоно. Хууль зүйн байгууллагын хамтрагч бус эсвэл хоршооллын болзлыг хангахгүй гадаадын иргэн нь худалдааны компанид эсвэл хоршоололдоо өөрийнхөө харилцааны эрх үүргийг Компаний Ерөнхий Ассамблейн чуулган эсвэл хоршооллын гишүүдийн зөвлөлгөөнд оролцох зорилгоор Чех улсын нутаг дэвсгэрт богино хугацааны айлчлал хийж эдлэнэ.

Худалдааны бүртгэл

Худалдааны бүртгэл нь худалдааны компаний байрласан газрын харъяа крайн шүүхээр удирдлагатай нийтэд хүрхүйц нийтийн танилцуулга юм (бүртгэлийн шүүх хэмээгч). Энэ

бүртгэлд бүртгэгдсэн бүх хуулийн этгээд нь, энэ бүртгэлтэй танилцаж, эдгээрийн хуулбарыг болон ишлэлийг авах эрхтэй. Хувиараа эрхлэгчийн талаархи хуулиар тогтоогдсон мэдээллийг үүнд бичнэ. Худалдааны бүртгэлд: a) худалдааны компани болон хоршоолол, b) 21-р зүйл 4-р догол мөрийн дагуу гадаадын хувь хүн, c) Чех улсад хувиараа эрхлэдэг болон байрладаг хувь хүн болон 21-р зүйл 5-р догол мөрийн дагуу Чех улсын нутаг дэвсгэрт хувиараа эрхлэж буй хувь хүн, d) бусад хүмүүс, тэдний бүртгэлийн үүргийг тусгай хууль дүрмээр тогтоосон бол.

ЧУ-д хувиараа эрхлэх эрхтэй байхын тулд, ерөнхийдөө гадаадын хувь хүнийг худалдааны бүртгэлд бичих шаардлагагүй. Энэ эрх нь тэдэнд хувиараа эрхлэх аж ахуйн эрх олгогдоноос үүснэ. 21-р зүйл 5-р догол мөрийн дагуу худалдааны бүртгэлд гадаадын хувь хүнийг бичих шаардлагагүй, эдгээр нь:

a) Европын холбооны улсын, Европын холбооны аж ахуйн орнуудын, эсвэл Швейцар улсын иргэн,
b) Чех улсад оршин суух эрхтэй a)-д бичигдсэн иргэдийн гэр бүлийн гишүүд,
c) Европын холбооны гишүүн орнуудаар зөвшөөрөгдсөн, удаан хугацаагаар оршин суусан хуулийн байршилтай, байнгын оршин суух зөвшөөрөлтэй гуравдагч орны иргэд,
d) Чех улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгогдсон c)-д бичигдсэн иргэдийн гэр бүлийн гишүүд,
e) a)-гаас d)-д хүртэл бичигдсэн иргэдээс бусад, хувиараа аж ахуй эрхлэх хуулиар хувиараа эрхлэх эрх нь үүсэх иргэд.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

ЧУ-д гадаадын иргэд **хувиараа эрхлэх үйл ажиллагааны болзлын** дэлгэрэнгүй мэдээллүүд:

- Албан байгууллагуудын портал – http://portal.gov.cz (► /Životní situace/Амьдралын байдал ► /Podnikatel/Хувиараа эрхлэгч ► /Živnostníci/Хувиараа аж ахуй эрхлэгчид);
  - хувиараа эрхлэх үйл ажиллагааг хариуцах байгууллага бүрд, тэдний нэрсийн жагсаалтыг мөн Албан байгууллагын порталаас олж болно – http://portal.gov.cz (► /Adresář/Хаяг);
  - Үйлдвэр худалдааны яамны интернет хуудаснаас – http://www.mpo.cz (► /Podpora podnikání/Хувиараа эрхлэх үйл ажиллагааг дэмжих ► /Živnostenské podnikání/Хувиараа аж ахуй эрхлэх ► /Průvodce živnostenským podnikáním/Хувираа аж ахуй эрхлэх танилцуулга);
  - *„Чех улсын нутаг дэвсгэрт хувиараа эрхлэх тухай хуулийн дагуу хувиараа аж ахуй эрхлэж буй гадаадын иргэдийн мэдээллийн материал“*-ын талаар Үйлдвэр худалдааны яамны интернет хуудсанд байна – http://www.mpo.cz (► /Podpora podnikání/Хувиараа эрхлэх үйл ажиллагааг дэмжих ► /Živnostenské podnikání/Хувиараа аж ахуй эрхлэх ► /Integrace cizinců/Гадаадын иргэдийн интеграчлал►/Projekt č. 1/2011/ Төсөл №1/2011).
- **Санхүүгийн байгууллагуудын хаягийг** Албан байгууллагын порталаас олж болно – http://portal.gov.cz (►/Adresář/Хаяг► /podle druhu/ангилалаар►/Daňová správa/Татварын мэдээ)
- **Татварын тайлангийн маягт** болон бусад хэвлмэл бичгүүдийг санхүүгийн байгууллагаас авч болох ба эсвэл Санхүүгийн яамны интернет хуудаснаас татаж авч болно – http://www.mfcr.cz (► /Daně a cla/Татвар болон гаалийн татвар ► /DaněТатвар ► /Daňové tiskopisy/Татварын хэвлмэл маягтууд)
- Czech POINT-ын газрын салбарууд болон үйлчилгээний талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг (3-р, 5-р бүлгүүдэд үз) – http://www.czechpoint.cz
- Шүүх яамны интернет хуудсанд Худалдааны бүртгэлийн талаар
  Ерөнхий нүүр:
  - http://www.justice.cz

  эсвэл дэлгэрэнгүй хайлт:
  - http://www.justice.cz/xqw/xervlet/insl/index?sysinf.@typ=or&sysinf.@strana=searchSubject

10. НИЙГМИЙН ХАНГАМЖ

Иргэд нь (ЧУ-ын иргэд, нийгмийн хангамж эдлэх эрхтэй гадаадын иргэд) нйигмийн хангамжийн (хамгаалагдсан) гурван системтэй:

нийгмийн даатгал	улсын нийгмийн тэтгэмж	нийгмийн тусламж

Эдгээр гурван систем нь харилцан холбоотой бүрэн бүрэлдхүүнийг бүрэлдүүлдэг.

10. 1. Нийгмийн хангамжийн байгууллагын удирдлага зохион байгуулалт

Нийгмийн даатгалын олголт → Нийгмийн хангамжийн захиргаа, Праг-д Прагийн НХЗ

Нийгмийн даатгалын олголтын талаархи үйл ажиллагааны болон шийдвэрлэх байгууллагууд нь, Окресний нийгмийн хангамжийн захиргаа (ОНХЗ), Праг-д Прагийн нийгмийн хангамжийн захиргаа (ПНХЗ), түүний орон нутгийн салбар газрууд болон Праг дахь Чехийн нийгмийн хангамжийн захиргаа зэргүүд юм. Энэ нь ОНХЗ, ПНХЗ-нуудын үйл ажиллагааг удирдах буюу хянаж байдаг. Нийгмийн хангамжийн тэтгэмжийг хөдөлмөрийн товчооноос олгодог ба онцгой байдлын тусламжын тэтгэмжийг оршин сууж буй хот суурингийн захиргаа олгоно.

Улсын нийгмийн тэтгэмж → Хөдөлдмөрийн товчоо

Онцгой байдлын тэтгэмж → Суурингийн захиргааны нийгмийн хангамжийн газар

10. 2. Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын системд өвчлөлтийн даатгал, тэтгэвэрийн даатгалууд хамарсан байдаг. Энэ ситемийн хүрээнд нийгмийн даатгалаас гадна улсын ажилгүйдлийн тэтгэмж авдаг.

➢ **Өвчлөлтийн даатгал**

Нийгмийн хангамжийн нэг хэсэг нь өвчлөлтийн даатгал юм **(187/2006 тоот хууль). Өвчлөлтийн даатгал нь хувиараа үйл ажиллагаа эрхлэгчидэд зориулалттай ба өвчний улмаас үйл ажиллагаанд нь саатал гарсан тохиолдолд мөнгөн тэтгэмж олгогдоно** – энэ нь өвчлөлт, гэмтэл, карантен, гэр бүлийн гишүүдийг эмчид үзүүлэх, жирэмслэлт, жирэмсний амралт, хүүхэд асрах зэргүүдээс шалтгаалж хугацаатайгаар аждаас чөлөөлөгдөх юм. Өвчлөлтийн даатгалын зориулалтанд өвчлөлтийн даатгалын тухай хуулиар даатгуулагчидын улсын иргэншил шийдвэрлэхгүй.

❖ **Эрх бүхий даатгуулагчидын хүрээ:**
Өвчлөлтийн даатгалд **ажилчид**, тэдэнтэй адил байр суурьтай (өвчлөлтийн даатгалын хуульд ажилчнаар тооцогдсон) болон **хувиараа үйл ажиллагаа эрхлэгчид**.

Чех улсын өвчлөлтийн даатгалын систем нь эдгээр зарчмаар үүссэн:

- өвчлөлтийн даатгалд зөвхөн даатгуулагчидын хүрээнд хамрагдах, энэ даатгалын үндсэн хамралтын хүрээнд ажиллаж буй даатгуулагчид,
- өвчлөлтийн үеэр даатгуулагч нь даатгалд хамрагдсан байх эсвэл тэр үеэр ажлаа дуусгавар болгосон бол хамгаалах хугацаа үргэлжилж байх,
- өвчлөлтийн тэтгэмж хүсэгч нь тогтоосон хууль дүрмийн болзлыг хангасан байх шаардлагатай,

- олголтын хэмжээг нийгмийн хангамжийн даатгалаас гарах тэтгэмж хүсэгчийн цалингаас шалтгаалж тогтооно.

Өчлөлтийн даатгаалаас **ажилчидад** (тэд өвчлөлтийн даатгалд **хамрагдах үүрэгтэй** байдаг) 4 чиглэлээр олгоно:

- актны мөнгө,
- асрах, сувилах,
- жирэмслэлтийн үеийн буюу жирэмсний амралтын тэгшитгэсэн тэтгэмж,
- жирэмсний амралтын мөнгөн тусламж.

Актны мөнгө

Ажилчин нь өвчлөлтийн даатгалд хамрагдсанаар актны мөнгө авах эрхтэй байдаг ба ажилчин нь ажил хөдөлмөр эрхлэх чадваргүй эсвэл карантелагдсан гэсэн тодорхой хугацааг эмчийн тодорхойлолттой байна. Актны мөнгийг акт авсан өдрөөс хамгийн дээд тал нь 380 хуанлийн хоногт олгоно (380 хуанлийн хоногт өмнөх акттай байсан хугацааг мөн тооцно).

2011 оны 1 сарын 1-нээс актыг 22 дахь хуанлийн өдрөөс эхлэн тооцдог болсон. Акт авсан өдрөөс 21 хуанлийн өдөр ажилчин нь өвчлөлтийн даатгалыг үндэслэсэн ажлын харьцаатай байх ба энэ хугацааны нөхөн олгох цалинг ажиллуулагч олгоно. Нөхөн олгох цалин нь ажлын өдрүүдээс хамааралтай ба акт авсан 4 дөх ажлын өдрөөс эхлэн тоологдоно (карантены үеэр ажлын 1 өдрөөс).

Актны мөнгө нь бас тодорхой байдлаас шалтгаалах ба хэрэв акттай байх хугацаанд ажлаа дуусгавар болгосон бол үүнийг **баримтлах хугацаа** гэж нэрлэнэ. Баримтлах хугацаанд актны мөнгийг ажил дуусгавар болгосон өдрөөс **7 хуанлийн өдөр** олгоно.

Асрах, сувилах

Ажилчны асрах сувилах эрх нь

- 10 наснаас доош насны хүүхдээ асрах, эсвэл бусад гэр бүлийн гишүүнээ асарч сувилах шаардлагатай тул ажиллах боломжгүй,
- асарч байгаа хүнтэйгээ нэг гэрт цуг амьдарч байгаа эсэх; энэ болзол нь 10 хүрээгүй асарч (сувилж) байгаа хүүхдийн эцэг эх бол шалгахгүй.

Хэрэв асаргаа (сувилгаа) удаан хугацаагаар үргэлжилбэл асрах сувилах хугацааны тэтгэмжийг эхний 9 хуанлийн өдрүүдэд олгоно (ганц бие ажилчидад хамгийн дээд тал нь 16 хуанлийн өдөр).

Жирэмсний амралтын мөнгөн тусламж

Ажилчин эмэгтэйчүүдийн жирэмсний амралтын тусламж авах эрх нь

- жирэмсний амралт эхлэх өдрөөс өмнө сүүлийн хоёр жилд 270 хоног өвчлөлтийн даатгалд хамрагдсан байх, (жирэмсний амралтын мөнгөн тусламжийг эхний 8 дахь долоо хоногоос төрхөөс өмнөх 6 дахь долоо хоног хүртлэх хугацаанд олгоно).
- жирэмслэлт нь төрөлтөөр дуусна
- тэтгэмж авч байгаа ажлын газраа ажиллахгүй

Жирэмсний амралтын мөнгөн тусламжийг 28 долоо хоногийн турш, хэрэв хоёроос дээш хүүхэд төрүүлсэн, хоёроос дээш хүүхэд асарч байгаа эмэгтэйчүүдэд 37 долоо хоногийн турш олгогдоно. Төрхөөс өмнөх 6-гаас 8 долоо хоногоос эхлэн олгогдоно.

Өвчлөлтийн даатгал нь хүүхдийн эх түүний нөхөр буюу хүүхдийн эцэг хоёр хүүхдийг ээлжлэн асрах боломжийг олгох ба эцэг эх хоёр хоёуулаа өвчлөлтийн даатгалын хуулиар тогтоогдсон жирэмсний амралтын үеэр олгох мөнгөн тусламжийн болзлыг хангасан байх шаардлагатай. Төрсөн өдрөөс 7 долоо хоногийн дараагаас эхлэн ээлжилж болох ба ээлжлэлтийн тоо нь хязгаарлагдмал бус. Цалин хөлсний болзлыг хангаж байгаа тохиолдолд хүүхдийг ээлжилж асарч эхлэхэд эхийн жирэмсний амралтын тусламжийг дуусгавар болгож хүүхдийн эцэгт өвчлөлтийн даатгалаас мөнгөн тусламж төлөгдөж эхлэх ба эсвэл эсэргээр төлөгдөнө.

Эмэгтэйчүүдийн жирэмслэлтийн үеэр даатгалтай байсан ажил нь дуусгавар болсон тохиолдолд түүний сүүлийн ажиллаж байсан газраа хэдэн хуанлийн өдөрт жирэмсний амралтын мөнгөн тусламж авах эрхтэй байсан төдий хугацаагаар хамгаалах хугацаа гэгч үүсэх ба энэ нь хамгийн дээд тал нь 180 хуанлийн өдөр байна.

Жирэмслэлтийн үеийн буюу жирэмсний амралтын тэгшитгэсэн тэтгэмж

Жирэмслэлтийн буюу жирэмсний амралтын үеэр ажилчин эмэгтэйчүүдийн тэгшитгэсэн тэтгэмж авах эрх нь,

- жирэмслэлт, жирэмсний амралт, хөхүүл зэргээс шалтгаалан өөр ажилд шилжсэн,
- шилжсэнээс шалтгаалж цалингийн хэмжээ буурсан.

Жирэмслэлтийн болон жирэмсний амралтын үеийн тэгшитгэх тэтгэмжийг хамгийн цаад хугацаа нь ажилчин эмэгтэйчүүдийг жирэмсний амралт авсан өдрөөс болон түүний дуусаны дараа хамгийн цаад хугацаа нь төрснөөс хойш есөн сар хүртлэх хугацаанд олгоно, хэрэв хөхүүлээс шалтгаалж шилжсэн тохиолдолд энэ бүхий л хугацаанд тэтгэмж авах эрхтэй.

Өвчлөлтийн даатгал нь **хувиараа аж ахуй эрхлэгчид** (цаашид ХААЭ)-ийн хувьд **сайн дурын** асуудал ба ХААЭ-ийн өвчлөлтийн даатгалд хамрагдах бүртгэлийн хэвлэмэл маягтыг бөглөж бичсэнээс үндэслэж үүснэ. Хамрагдах нь бүртгэлд тусгагдсан өдрөөс; окресний нийгмийн хангамжийн захиргаанд өгсөн өдрөөс эхлэнэ. ХААЭ-ийн өвчлөлтийн даатгал нь ХААЭ-нь даатгалынхаа төлбөрийг хийгээгүй сарын эхний өдрөөс эхлэн хүчингүй болно.

Өвчлөлтийн даатгалтай хувиараа аж ахуй эрхлэгчидэд хамаарагдах зүйлүүд нь:

- актны мөнгө
- жирэмсний амралтын үеийн мөнгөн тусламж

Өвчлөлтийн даатгалын тэтгэмжийг ХААЭ-д олгохдоо ажилчидад олгохоос доорхи ялгавартай олгогдоно:

- ХААЭ-нь актны хугацаа эхлэхээс 3 сарын өмнө даатаглд хамрагдсан байх. Энэ болзлын биелэлтэнд даатгалд хамрагдсан хугацаа нь хувиараа эрхлэх үйл ажиллагааг эхлэсэн өдрөөс эсвэл дахин эхлэсэн өдрөөс эхлэсэн байх шаардлагыг тавихгүй,
- өвчлөлтийн даатгалын төлбөрийг хийсэн байх,
- ХААЭ-ийн жирэмсний амралтын үеийн мөнгөн тусламж авах эрх нь амралтын хугацаа эхлэснээс 180 хоногийн хугацаанд уг даатгалд хамрагдсан байхыг шаардана,
- ХААЭ-нь хувиараа ашигт үйл ажиллагаа эрхлэж болохгүй.

Эрх эдлэх

Өвчлөлтийн даатгалын тэтгэмжийн эрхийг даатгуулагч нь эмчийн бичгээ өгснөөр эдлэнэ. Тэтгэмжийн өргөдлийг ажилчин нь ажиллуулагчидаа өгнө. Ажиллуулагч нь өөрийнхөө ажилчидаас тэтгэмжийн өргөдлийг хүлээж авна. ХААЭ-нь тэтгэмжийн өргөдлийг өөрийнхөө байнга оршин сууж буй эсвэл хувиараа үйл ажиллагаа эрхлэж байгаа газрын харъяа окресний нийгмийн хангамжийн захиргаанд өгнө (ХААЭ-нь ЧУ-д байнга оршин суурьшилгүй тохиолдолд).

Өвчлөлтийн даатгалын тэтгэмжийн олголт

Өвчлөлтийн даатгалын тэтгэмжийг окресний нийгмийн хангамжийн захиргаанаас олгогдоно. Окресний нийгмийн хангамжийн захиргаа нь өргөдөл хүлээн авсан өдрөөс нэг сарын дотор тэтгэмжийг олгоно. Даатгуулагч нь тэтгэмжийг олгох байдлыг сонгох боломжтой. Чех улсын банкин дахь **өөрийнхөө дансаар** авах тохиолдолд тэтгэмж авах өргөдөлдөө дансныхаа дугаарыг бичсэн байх ёстой. Хоёр дахь боломж нь **бэлнээр** олгох (шуудан холбоогоор); **энэ тохиолдолд шуудангийн төлбөр төлөх ёстой.**

Актны мөнгө, асрах сувилах, жирэмснмй амралтын мөнгөн тусламж зэргийн **хэмжээг** цалингийн хэмжээг харгалзан тогтооно. Дэлгэрэнгүйгээр www.mpsv.cz (► /Nemocenské pojištění/Өвчлөлтийн даатгал ► /Výpočet dávek nemocenského pojištění/Өвчлөлтийн даатгалын тэтгэмжийн тооцоо).

Өвчлөлтийн даатгалын талаархи бусад мэдээллүүдийг: www.cssz.cz (► /Nemocenské pojištění/ Өвчлөлтийн даатгал)

➢ **Тэтгэвэрийн даатгал**

❖ **Эрх бүхий даатгуулагчидын хүрээ:**
ЧУ-д үндсэн тэтгэвэрийн даатгал нь **албан ёсны үүрэгт** байдаг ба бүх эдийн засгийн ашигт үйл ажиллагаат хүмүүс хамрагдана.

Үндсэн тэтгэвэрийн даатгалаас өндөр насны, тахир дутуугийн, бэлэвсрэлийн, өнчрөлийн зэрэг даатгалууд олгогдоно (155/1995 тоот хууль). Тэтгэвэр нь хоёр хэсгээс бүрдэх ба энэ нь үндсэн хэсэг (даатгалын хугацаа, авч байсан цалингийн хэмжээний зөрүү зэргийг харгалзахгүй бүх төрлийн тэтгэвэрийг адил хэмжээгээр тогтоосон) болон хувиар тогтоосон хэмжээ. Тэтгэвэр авах эрх, тэтгэвэрийн хэмжээ, тэтгэвэр олгох зэргийг Праг дахь Чехийн нийгмийн хангамжийн захиргаа шийдвэрлэнэ (582/1991 тоот хууль).

Даатгуулагч нь **ерөнхий өндөр насны тэтгэвэрийг** авах эрх нь, хэрэв:

– даатгалд орсноос хойш хамгийн бага нь 25 жил, 2010 оноос өмнө өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн (цаашид зөвхөн „тэтгэвэрийн нас“), эсвэл
– 15 жил даатгалын хугацаатай болон 2010 оноос өмнө 65 нас хүрсэн.

2010 оны нэг сарын 1-нээс даатгалын шаардлагатай хугацааг сунгасан ба энэ нь жилд нэг жилээр эцсийн байдал нь даатгалын орлосон хугацаатай (даатгал төлөгдөөгүй хугацаа) нийлээд 35 жил эсвэл даатгалын орлосон хугацаагүйгээр 30 жил байхаар мөрдөж байна. Үүнтэй адилаар аажмаар богино хугацааны даатгалтай өндөр насны тэтгэвэрт гарах хугацааг сунгасан (2010 оны нэг сарын 1-нээс өмнө 15 жил даатгалтай) ба энэ нь 20 жил даатгалтай байсан, өндөр насны тэтгэвэр авах шаардлагатай насны хэмжээг нэмсэн ба энэ нь 65 наснаас 2010 оны нэг сарын 1-нээс өмнө таван жилээр тэтгэвэрийн наснаас өндөр байна.

Ерөнхий тэтгэвэрийн нас нь одоохондоо зарим нэгэн даатгуулагчидын ангилалаас шалтгаалж 1996 оноос аажмаар дээшилж байгаа ба энэ нь эрэгтэйчүүдэд жилд 2 сараар, эмэгтэйчүүдэд жилд 4 сараар. Одоогийн байдлаар эрэгтэйчүүд, хүүхэдгүй эмэгтэйчүүд, нэг хүүхэд өсгөсөн эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах нас нь 65, өсгөсөн хүүхдүүдийн тооноос шалтгаалж эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах нас нь 62-оос 64 нас хүртэл байна.

Ерөнхий өндөр насны тэтгэвэр авагчид нь ямар ч ажил хийж болно.

Даатгуулагч нь өндөр насны тэтгэвэрийн насанд хүрхээс өмнө тэтгэвэрт гарах эрхтэй ба энэ нь гурван жилийн өмнө байж болох бөгөөд үүнийг **хугацаанаас өмнөх өндөр насны тэтгэвэр** гэж нэрлэнэ. 2010 оны нэг сарын 1-нээс эхлэн тэтгэвэрийн насыг дээшлүүлж байгаа мөн хугацаанаас өмнөх өндөр насны тэтгэвэрт гарах нас дээшилж байгаагаас үүдсэн арга хэмжээг баримтлаж байна. Гурван жил хүртэл хугацаанаас өмнө тэтгэвэрт гарах боломж байдаг ба энэ нь 63 нас болон түүнээс доош; 63 наснаас дээш тэтгэвэрийн нас нь хугацаанаас өмнө тэтгэвэрт гарах боломжийг уртасгадаг, энэ нь тэтгэвэрийн насны 65 насанд 5 жилээр байдаг.

Хугацаанаас өмнөх өндөр насны тэтгэвэр ашиглагч нь тэтгэвэрийн нас хүртэл ашигт үйл ажиллагаа эрхлэж болох ба зөвхөн түүний ашгийн хүрээ нь даатгалд хамрагдахгүйгээр байх ёстой. Хугацаанаас өмнөх тэтгэвэрийн ажиллаж буй ашиглагч нь тэтгэвэрийн насанд хүрснээс хойш ерөнхий өндөр насны тэтгэвэрийн ажиллаж буй ашиглагчтай адил дүрэм журмыг сахина.

Тахир дутуугийн тэтгэвэрийг даатгуулагч нь, хэрэв:

– тахир дутуу болсон буюу шаардлагатай даатгалын хугацааг эзэмшсэн эсвэл
– ажлын гэмтлээр тахир дутуу болсон тохиолдолд авна.

Даатгуулагч нь тахир дутуу, түүний ажлын чадвар хамгийн бага нь 35%иар буурсан.

Даатгуулагчийн ажлын чадварын бууралтуудаас шалтгаалж

a) хамгийн багаар 35 %, хамгийн ихээр о 49 %, тахир дутуугийн нэгдүгээр груп,
b) хамгийн багаар 50 %, хамгийн ихээр о 69 %, тахир дутуугийн хоёрдугаар груп,
c) хамгийн багаар 70 %, тахир дутуугийн гуравдугаар груп гэх мэтэээр олгогдоно.

Тахир дутуугийн тэтгэвэр авч байхдаа ашигт үйл ажиллагаа эрхлэж цалин авч болно, учир нь тэтгэвэрийн хуулиар үүнийг хориглоогүй.

Бэлэвсрэлийн тэтгэвэрийг даатгуулагч нь, хэрэв:

– нас барсан нөхөр нь өндөр насны эсвэл тахир дутуугийн тэтгэвэр ашиглагч байсан, эсвэл
– нас барсан өдрийг хүртэл тахир дутуугийн болон өндөр насны тэтгэвэрийн хугацааны болзлыг биелүүлсэн,
– эсвэл ажлын гэмтлээс шалтгаалж нас барсан (мэргэжлээс шалтгаалах өвчнөөр) зэрэг нөхцлүүдэд авна.

Бэлэвсрэлийн тэтгэвэр нь нөхөр (эхнэр) нь нас барснаас хойш нэг жилийн дараа хамааралтай болж эхлэнэ. Энэ хугацаа дууссаны дараа доорхи болзлуудын нэгийг биелүүлсэн тохиолдолд бэлэвсрэлийн тэтгэвэр авах эрхтэй:

– өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд асарч байгаа,
– өөр хүний асрамж зайлшгүй шаардлагатай II – IV групын хүүхэд асарч байгаа,
– өөр хүний асрамж зайлшгүй шаардлагатай II – IV групын нэг гэрт хамт амьдарч байгаа өөрийнхөө болон нөхрийнхөө эцэг эхийг асарч байгаа,
– өөрөө тахир дутуугийн гуравдугаар группэй,
– эрэгтэйчүүдийн тэтгэвэрийн тогтоосон нас 4 насаар бага, хэрэв тэтгэвэрийн нас бага байвал түүнтэй төрсөн өдөр нь адил эсвэл адил настай.

Дээр дурьдсан зарим болзлуудаар урьдны татгалзсан шалтгаан таван жилийн дотор үгүй болсон тохиолдолд бэлэвсрэлийн тэтгэвэр нь дахин үүсэж эдлэх эрхтэй болно.

Өнчрөлийн тэтгэвэрийг өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд авах эрхтэй ба, хүүхдийн эцэг эх (үрчлэгч) эсвэл эцэг эхийг орлож хүүхдийг асарч байсан хүн нас барсан, эцэг эх хүүхдээ асрах чадваргүйн улмаас өөр хүнд асрамжуулж байсан хугацаанд тэр асарч байсан хүн нь нас барсан; эцэг эх (үрчлэгч) болон энд дурьдсан хүн зэрэг нь бэлэвсрэлийн тэтгэвэрийн болзолтоой адил болзлыг хангана. Эцэг эх хоёр хоёуулаа нас барсан тохиолдолд өнчрөлийн тэтгэвэр нь хоёуулангаас нь олгогдоно.

Чехийн тэтгэвэр нь ерөнхийдөө удаан хугацааны болзолтой байдаг ба (ялангуяа өндөр насны тэтгэвэр), тэтгэвэрт гарахаса өмнөх ЧУ-д амьдарч байсан нь тэтгэвэрийн болзлыг хангахгүй тохиолдол үүдэж магадгүй. Энэ талаар Чех улс нь хоёр талын нийгмийн хангамжийн тухай олон улсын гэрээ байгуулж туслаж байна. Эдгээр нь аль аль нь ижил агуулгатай, олон янзын нийгмийн салбарыг, хамгийн гол нь тэтгэвэрийн талаар хамарсан. Эдгээр гэрээний шаардлагатай хугацааг хоёр улс харилцан тодорхойлцгооно. Хэрэв даатгалын шаардлагатай хугацаа биелэгдсэн бол хоёр улсаас хоёуулангаас нь бүрэн хэмжээний тэтгвэр олгогдоно. Тэгхээр ЧУ-аас хэсэгчилсэн тэтгэвэр авхаас гадна, нөгөө талын гэрээт улсад ажиллаж амьдарч нийгмийн даатгалд нь даатгагдаж байсан хугацааныхаа тэтгэвэрийг тэр улсаас бас авна.

ЕХ-ны дүрмээр мөрдөгдөж байгаа 30 улсаас гадна Чех улстай хоёр талын гэрээ байгуулсан улсууд нь: Босни Герцегонив, Чил, Хорват, Израил, Япон, Канад, Куебек, Солонгос улс, Македон, Серб, Черна Хора, Турк, Украйн, АНУ (одоогийн байдлаар Австрали, Энэтхэг, Оросын холбооны улс, Молдав, Монгол улсуудтай гэрээ хийхээр бэлдэж байна).

Бүх тэтгэвэрийн өргөдлийг окресний нийгмийн хангамжийн захиргаанд өгнө.

Энэ хуудсанад үз www.mpsv.cz эсвэл www.cssz.cz (► /Důchodové pojištění/Тэтгэвэрийн даатгал).

Улсын тэтгэмжтэй тэтгэвэрийн даатгал нь (42/1994 тоот хууль) улсын үүрэгт тэтгэврийн даатгалаас тодорхой байдлаар илүү үр ашигтай ба удаан хугацаагаар даатгуулсны дараа даатгалаасаа нэмэлт тэтгэвэр авах боломжтойгоор хийгдсэн. Энэ тэтгэвэрт хамрагдагч нь 18-аас дээш настай хувь хүн, ЕХ-ны бусад улсад оршин суудаг ба хэрэв Чех улсын тэтгэвэрийн даатгалд хамрагдсан эсвэл уг даатгалаас тэтгэвэр авдаг, эсвэл ЧУ-ын эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсвэл хамрагдсан, тэтгэвэрийн фондтой гэрээ байгуулсан байна.

Үүнд хамрагдах нь сайн дурын, Чех улсын зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй аль нэгэн тэтгэвэрийн фондтой байгуулсан гэрээг үндэслэн байгуулна. Тэтгэвэрийн фонд нь системд мөнгө хадгалах байдлаар болон түүнээс тэтгэвэр олгох байдлаар явагдана. Тэтгэвэрийн фондыг тэтгэвэрийн төлөвлөгөөгөөр удирдаж явуулна. Хамрагдагч нь гэрээнд гарын үсэг зурхаас өмнө тэтгэвэрийн төлөвлөгөө болон тогтоол дүрэмтэй танилцсан байх шаардлагатай.

Тэтгвэрийн даатгалаас өндөр насны тэтгэвэр (байнга гэрээтэй байх шаардлагатай), тахир дутуугийн тэтгэвэр, цэрэг цагдаагийн байгууллагад ажиллаж байсны тэтгэвэр, бэлэвсрэлийн тэтгэвэр, нэг удаагийн тэгшитгэсэн тэтгэвэр зэргээр хангана.

➢ **Нийгмийн хангамжийн даатгал болон улсын ажлын бодлогын тэтгэмж**

Нийгминй хангамжийн даатгал нь тэтгэвэрийн даатгал болон өвчлөлтийн даатгалуудыг хамарсан ба 589/1992 тоот хуулиар улсын ажилгүйдлийн бодлогын тэтгэмжтэй хамт байдаг.

Даатгалын үндсэн хэмжээ нь:

a) ажилчид 25 %; – үүнээс 2,3 % өвчлөлтийн даатгал, 21,5 % тэтгэвэрийн, 1,2 % улсын ажилгүйдлийн бодлогын,
(2011 оны 1 сарын 1-нээс дунджаар 26 ажилчнаас бага ажилчинтай ажиллуулагч нь болзол хангасан тохиолдолд „бага даатгал“ төлж болно. Энэ нь 26 % – ийн оронд 25 % – ийг төлнө гэсэн утгатай),
b) ажилчид 6,5 %; үүнээс 6,5 % тэтгэвэрийн даатгалд
c) хувиараа аж ахуй эрхлэгчид 29,2 %тэтгэвэрийн даатгал болон улсын ажилгүйдлийн; - үүнээс 28 % тэтгэвэрийн даатгалд 1,2 % улсын ажилгүйдлийн даатгалд,
d) ХААЭ-д нь өвчлөлтийн даатгал нь сайн дурынх 2011 оны 1 сарын 1-нээс 2,3 % өвчлөлтийн даатгалд,
e) сайн дураар тэтгэвэрийн даатгалд хамрагдагсад 28 % тэтгэвэрийн даатгалд.

10. 3. Амьжиргааны доод түвшин

Нийгмийн системд амьжиргааны доод түвшингийн тухай 110/2006 тоот хуулиар тогтоогдсон амьжиргааны доод түвшин нь чухал үүрэгтэй байдаг. Үүнийг ялангуяа **онцгой байдлын тусламжийн хүрээнд** (онцгой байдлын тусламжийн тухай 111/2006 тоот хуулийн дагуу) онцгой байдлыг шийдвэрлэх буюу нийгмийн- хамгаалах хэмжигдхүүн болгон хэрэглэдэг. Түүний түвшингээс тогтоосон болзлыг үндэслэн **амьжиргааны тэтгэмжийн** хэмжээг тогтооно.

Амьжиргааны доод түвшинг **улсын нийгмийн даатгалын тэтгэмжийн хүрээнд** бас ашиглах ба (улсын нийгмийн тэтгэмжийн тухай 117/1995 тоот хуулиар), ялангуяа **хүүхдийн нэмэгдэл тэтгэмж болон нийгмийн тэтгэмжинд** хэрэглэнэ. Гэр бүлийн орлоготой, амьдралын тогтоосон доод түвшингийн хэмжээг харьцуулах нь эдгээр тусламж тэтгэмжийг авах эрхтэй эсхийг тогтоож, хүүхдүүдтэй гэр бүлд тогтоосон нийгмийн байдалд тусламж үзүүлэх ба амьжиргааны доод түвшин, түүний үндсэн тооцоог гаргана.

Амьжиргааны доод түвшин нь нийгмээр доод хэмжээгээр тогтоогдсон амьдралын хэрэглэгээ болон бусад хувийн хэрэглэгээний мөнгөн орлогын хязгаар юм.

Амьжиргааны доод түвшинг эдгээр хэсгүүдэд ялгана:

– нэг хүнд,
– гэр бүлийн анхны гишүүнд,
– гэр бүлийн хоёр дахь болон бусад насанд хүрсэн гишүүдэд(өөрийгөө тэжээх чадваргүй хүүхдээс бусад),
– өөрийгөө тэжээх чадваргүй хүүхдэд (насны гурван ангилалтай).

Амьжиргааны доод түвшин нь гэр бүлийн гишүүд тус бүрийн амьжиргааны доод түвшингийн нийлбэр дүн юм.

Амин зуулгын доод түвшин нь мөнгөн орлогын доод хязгаар ба үүгээр амьдралын хүнд үеэс гарах амьдралын шаардлагатай зүйл болон бусад хувийн хэрэглэгээнүүдийг авхад зориулна. Амин зуулгын доод түвшингийн тэтгэвэрийг өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд, өндөр насны тэтгвэр авагч, гуравдугаар группэй тахир дутуугийн тэтгэвэр авагч, 68-аас дээш насны авагчид авч болохгүй.

Амьжиргааны болон амьдралын доод түвшин нь орон байрны зардлыг хамрахгүй. Орон байрны талаар улсын нийгмийн даатгалын орон байрны зардлын тусламж олгох системийн хүрээнд болон онцгой байдлын орон байрны зардлын нэмэгдэл олгох системийн хүрээнд шийдвэрлэнэ.

Амьжиргааны болон амьдралын доод түвшингийн тухай 110/2006 тоот хуулиар **амьжиргааны болон амьдралын доод түвшингийн сарын корунаар тогтоосон хэмжээг** үзүүлбэл:

- амьжиргааны доод түвшингийн сарын корунаар тогтоосон хэмжээ
- нэг хүнд 3 126 корун
- гэр бүлийн нэгдүгээр гишүүнд 2 880 корун
- хоёр дахь болон өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд бус гэр бүлийн гишүүдэд 2 600 корун
- өөрийгөө тэжээх чадваргүй хүүхдүүдэд
    - 6 нас хүртэл 1 600 корун
    - 6-гаас15 нас хүртэл 1 960 корун
    - 15-аас 26 нас хүртэл 2 250 корун

Амьжиргааны доод түвшин нь гэр бүлийн гишүүд тус бүрийн амьжиргааны доод түвшингийн нийлбэр дүн юм.

амин зуулгын доод түвшингийн сарын корунаар тогтоосон хэмжээ

- амьдралын доод түвшингийн хэмжээ 2 020 корун

Амьжиргааны болон амьдралын доод түвшингийн хэмжээг тохиргооны болзлыг үндэслэн хэрэглэгээний бодит үнийн өсөлтийн дагуу төр засгийн тушаалаар өсгөж болно (амьжиргааны болон амьдралын доод түвшингийн тухай 110/2006 тоот хуулиар).

10. 4. Улсын нийгмийн тусламж

❖ **Эрх бүхий хүмүүсийн хүрээ:**

Улсын нийгмийн хангамжийн тэтгэмжийн болзлын шаардлагыг (тэтгэмж авхад орлогын болон хамт хэлцэгдэх хүний талаархи тодорхойлолт байна) хангасан хүмүүс:

- ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суугч (ЧУ-ын иргэн)
- **ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суугч гадаадын иргэд**
- Европын холбооны дүрэмд хамааралтай иргэн
- **ЧУ-д оршин суугаа гадаадын иргэд** (Дотоод Явдлын Яамны байрлах төвд байрлаж байгаа олон улсын хамгаалалтанд орох өргөдөл гаргагчаас бусад), энэ нь бүртгүүлсэн өдрөөс 365 хоногийн дараа
- **ЧУ-д төрсөн 1 настай ЧУ-д оршин суух бүртгэлтэй гадаадын иргэн** (Дотоод Явдлын Яамны байрлах төвд байрлаж байгаа олон улсын хамгаалалтанд орох өргөдөл гаргагчаас бусад)
- ЧУ-д эцэг эхийг нь орлосон асран тэжээгчтэй эсвэл асрамжийн газар байгаа **насанд хүрээгүй гадаадын иргэн**
- ЕХ-ны улсад байнга оршин суугч, ЧУ-д удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй, ЧУ-д байрладаг болон түүний гэр бүлийн гишүүд зэрэг гадаадын иргэд
- **эрдэм шинжилгээний ажлын шалтгаанаар ЧУ-д удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгогдсон** гадаадын иргэд
- **нэмэлт хамгаалалт** олгогдсон гадаадын иргэд
- өндөр мэргэшлийн ажлын шалтгаанаар ЧУ-ын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаадын ирэгд (хөх карт).

Улсын нийгмийн хангамжийн газраар дамжуулан ялангуяа хүүхэдтэй, өөрсдийнх нь хүч болон хэрэглэгээ нь гэр бүлийнхээ амьдралд хангалттай бус гэр бүлүүдэд улс тусламж үзүүлнэ. Улсын нийгмийн тэтгэмжийн систем нь **улсын нийгмийн тэтгэмжийн тухай 117/1995 тоот хуулиар** мөрдөгдөж байдаг.

Энэ хуулиар доорхи тэтгэмжүүд олгогдоно:

- хүүхдийн нэмэгдэл
- эцэг эхийн тэтгэмж
- нийгмийн нэмэгдэл тэтгэмж

- байрны зардлын тусламж
- үрчлэгч асран тэжээгчийн нэмэгдэл
- төрөлтийн
- оршуулгын

Тэтгэмж авах шийдвэрийг тодорхойлход гэр бүлийн хөрөнгийг шалгадаггүй, орлогыг зөвхөн зарим нэгэн тэтгэмжүүдийг авхад л шалгуулна. Тэтгэмж авах өргөдлийг өөрийн оршин суугаа газрынхаа харьяа хөдөлмөрийн товчоон дээр хэвлэмэл маягт бөглөж өгнө (маягтыг хөдөлмөрийн товчооноос эсвэл энэ хаягаас татаж авч болно http://forms.mpsv.cz/sspforms/).

Хүүхдийн нэмэгдэл нь хүүхдүүдтэй гэр бүлд удаан хугацаагаар олгогддог үндсэн тэтгэмж юм. **Амьжиргааны доод түвшин 2,4-өөр үржигдсэн** хүртлэх хэмжээтэй орлоготой гэр бүлд олгогдоно. Хүүхдийн нэмэгдэл нь хүүхдийн насны ангилалаас шалтгаалж сард гурван янзаар олгогдоно 500 корун (6 нас хүртэл), 610 корун (6-гаас 15 нас хүртэл), 700 корун (15-аас 26 нас хүртэл).

Эцэг эхийн нэмэгдэл тэтгэмжийг гэрбүлийн хамгийн бага хүүхдийг хуанлийн бүтэн сар өөрөө бүтэн өдөр асардаг эцэг эхүүдэд олгоно. Эцэг эх уг тэтгэмжийг **хоёр жилээр, гурван жилээр, дөрвөн жилээр** авхаа сонгоно. Тэтгэмж авах хугацааг сонгоход үүнтэй уялдаж тэтгэмжийн мөнгөн хэмжээ тогтоогдсон байдаг үүнд:

- **богино хугацаанд** тэтгэмж авах – жирэмсний амралтын мөнгөн тусламж авч дуусаны дараа (цаашид зөвхөн ЖАМТ) ихэсгэсэн хэмжээгээр (11 400 корун) хүүхдийг 24 сар хүртэл; энэ байдлаар зөвхөн ЖАМТ-ыг хуанлийн 1 өдөрт 380 коруныг авах эрхтэй эцэг эх өргөдөл гаргаж болно;
- **энгийн хугацаанд** – ЖАМТ-ыг авч дуусаны дараа энгийн хэмжээнд (7 600 Kč) хүүхдийг 36 сар хүртэл; энэ байдлаар зөвхөн ЖАМТ-ыг авах эрхтэй эцэг эх өргөдөл гаргаж болно;
- **удаан хушацаанд** – ЖАМТ-ын дараа эсвэл хүүхэд төрсөн өдрөөс эхлэн (ЖАМТ аваагүй тохиолдолд) энгийн хэмжээнд (7 600 Kč) хүүхдийг 9 сар хүртэл мөн багасгасан хэмжээнд (3 800 Kč) хүүхдийг 48 сар хүртэл.

Эцэг эхийн нэмэгдлийн тэтгэмжийн өргөдлийн маягт бөглөн холбогдох орон нутгийн улсын нийгмийн хангамжийн газар (хөдөлмөрийн товчоо) тогтоосон хугацаанд өгнө. Хүчин төгөлдөр болсон шийдвэр гарснаас хойш өөрчлөлт хийх боломжгүй. Эрүүл мэндийн доголдолтой хүүхдүүдийн эцэг эх хүүхдийг удаан хугацааны эрүүл мэндийн доголдолтой эсвэл удаан хугацаагаар хүнд эрүүл мэндийн доголдолдтой гэсэн шийдвэр гарсан өдрөөс эхлэн энгийн хэмжээгээр (7 600 Kč) хүүхдийг 7 нас хүртэл, энэ нь урьд нь эцэг эхийн тэтгэвэр авхаар сонгож байсан нь хамаарахгүй (хүүхдийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлхоос өмнө). Хэрэв ийм хүүхдэд тэтгэмж шаардлагатай бол (нийгмийн албаны тухай хуулийн дагуу), хүүхдийн эцэг эх хагасаар илүү эцэг эхийн тэтгэмж авах эрхтэй. Хэрэв эцэг эх удаан хугацааны эрүүл мэндийн доголдолтой эсвэл удаан хугацаагаар хүнд эрүүл мэндийн доголдолдтой хүүхэд асарч байгаа, тэр хүүхэд нь асрамжийн тэтгэмж авдаггүй тохиолдолд эцэг эхийн бага хэмжээний тэтгэмж шалтгаалж (3 000 корун) хүүхдийг 7-гоос 15 нас хүртэл авна.

Хүүхдэд бүтэн өдрийн бүрэн асрамж хэрэгтэй тохиолдолд эцэг эхийн тэтгэмж авах эрхтэй. Үүнээс гадна өөр боломж байдаг – хүүхэд хязгаарлагдмал хүрээтэй сургуулийн өмнөх болон тахир дутуу хүмүүсийн дасгал хийх газруудад явж болно. Төрсөн эцэг эхийг шалгах шаардлагагүй. Эцэг эх тэтгэмж авч байх үедээ гэр бүлийнхээ эдийн засгийн байдлыг дээшлүүлж болох ба харин тэр үеэр өөр насанд хүрсэн хүнээр хүүхдээ асруулах арга хэмжээ авч болно.

Нийгмийн нэмэгдэл тэтгэмж нь бага орлоготой, эрүүл мэндийн доголдолтой хүүхэд асарч байгаа, өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд асарч байгаа гэр бүлүүдэд туслах зорилготой юм. Нийгмийн нэмэгдэл тэтгэмжийг удаан хугацааны өвчтэй, удаан хугацааны эрүүл мэндийн доголдолтой эсвэл удаан хугацаагаар хүнд эрүүл мэндийн доголдолдтой хамгийн бага нь нэг хүүхэд асарч байгаа, эсвэл эцэг эх хоёрын нэг нь удаан хугацаагаар хүнд эрүүл мэндийн доголдолдтой эсвэл удаан хугацаагаар эрүүл мэндийн доголдолдтой, удаан хугацаагаар өвчтэй өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд асарч байгаа гэр бүлүүд авах эрхтэй. Тэтгэмж авхад мөн гэр бүлийн тогтоосон орлогын хязгаар хамааралтай ба өнгөрсөн гурван сарын орлого нь

амьжиргааны доод түвшингөөс хоёр дахин бага байсан тохиолдолд олдоно. Авах тэтгэмжмйн хэмжээ нь гэр бүлийн орлого дээшлэх тусам багасах ба мөн хүүхдийн болон эцэг эхийн тахир дутуугийн групын түвшин өөрчлөгдхөд мөн хамаарна.

Орон байрны зардлын тэтгэмжийг улсаас бага орлоготой гэр бүл болон ганц бие хүмүүст олгоно. Байрны тэтгэмжийг байрны эзний болон хөлслөгчийн байрыг хөлсөлж байгаа байрны зардал нь гэр бүлийн орлогын 30 % (Праг-д 35 %) хангалттай бус мөн энэ 30 % (Праг-д 35 %) гэр бүлийн орлого нь хуулиар тогтоосон нормт зардлаас бага байгаа тохиолдолд олгоно.

Төрөлтийн тэтгэмжийг анхны хүүхэд нь төрсөн бага орлоготой гэр бүлд нэг удаагаар олгоно. Төрөлтийн тэтгэмж нь анхны амьд нэг буюу түүнээс дээш тооны хүүхэд төрүүлснээс шалтгаалж олгогдоно. Хэрэв эмэгтэй нь төрөлтийн дараа нас барж, төрөлтийн тэтгэмж өөр хүн авах болзлыг хангасан тохиолдолд тэтгэмж хүүхдийн эцэгт олгогдоно. Төрөлтийн тэтгэмж нь гэр бүлийн тогтоосон орлогын хэмжээ шалтгаалах ба өмнөх хүүхэд төрсөн хуанлийн гурван сарын орлого нь гэр бүлийн амьжиргааны түвшингөөс 2,4 дахин бага байсан тохиолдолд олгогдоно. Төрөлтийн тэтгэмжийн хэмжээ нь анхны амьд хүүхэд төрсөн тохиолдолд 13 000 корун нэгээс дээш тооны амьд хүүхдүүд төрсөн тохиолдолд 19 500 корун байна.

Оршуулгын тэтгэмж нь нас барах өдрөө ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй байсан өөрийгөө тэжээх чадваргүй хүүхэд, эсвэл өөрийгөө тэжээх чадваргүй хүүхдийн эцэг эх зэргийн оршуулгын үйл ажиллагааг хариуцсан хүнд олгогдоно. Оршуулгын тэтгэмжийн хэмжээ нь 5 000 корун.

Үрчлэгчийн асрамжийн тэтгэмжийг (хүүхдийн хэрэглэгээний зардлын тэтгэмж, үрчилж авсан урамшуулал, хүүхэд хүлээн авсан зардлын тэтгэмж, моторт тээврийн хэрэгсэл худалдаж авхад тэтгэмж) эцэг эх нь асарч чадахгүй эсвэл хүсээгүй хүүхдийг үрчлүүлсэн хүүхдийг асрахтай холбоотой олгогдоно. Хүүхэд үрчилж авсан үрчлэгчидэд нийгмийн хангамжийн нэмэлт тэтгэмжээс бусад улсын нийгмийн тусламж олгогдоно, жнь: эцэг эхийн нэмэгдэл тэтгэмж, хүүхдийн нэмэгдэл тэтгэмж гм.

Дэлгэрэнгүй мэдээллүүдийг хөдөлмөрийн товчоон дээр эсвэл дараах интернет хуудаснаас мэдэж болно: portal.mpsv.cz/sz/local, http://portal.mpsv.cz, www.uradprace.cz.

10. 5. Нийгмийн тусламж

Нийгмийн тусламж нь, ялангуяа онцгой байдлын тусламж, нийгмийн хангамжийн үйлчилгээгээр хангах, тахир дутуу хүмүүст нийгмийн тэтгэвэр тэтгэмж олгох зэргийг хамруулсан.

Онцгой байдлын тусламжийн систем

- Онцгой байдлын тусламжийн тухай 111/2006 тоот хуулиар мөрдөгдөнө
- Орчин үеийн хэлбэрээр амьдралын хэрэгцээнд хангалтгүй цалинтай хүмүүст туслах хэлбэр. Ажил хийж байгаа хүн болгон нь ажилгүй болон ажил хийхээс зайлсхийсэн хүмүүсээс илүү байдаг гэсэн зарчмыг баримтлана.
- Хүн болгон нь одоогийн асуудлыг шийдвэрлээд зогсохгүй тохиолдох онцгой байдлыг шийдвэрлэнэ гэсэн үндсэн мэдээллээр хангагадах эрхтэй гэдгийг тогтоосон. Онцгой байдлын тусламжийн салшгүй хэсэг нь нийгмийн ажилчид үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллах юм.

Онцгой байдал гэдэг нь хувь хүн болон гэр бүл нь хангалттай бус орлоготой түүний нийгмийн болон хөрөнгийн нийлбэр нь олон нийтийн амьдралын үндсэн түвшинд хүрэлцхүйц бус байдалтайг хэлнэ. Энэ орлогыг ямар нэгэн байдлаар өөрчилж (ажил олж, тэтгэмж болон өр төлбөрөө ашиглах, эсвэл хөрөнгөө зарах болон ашиглах) болон өөрийн хүчээр шийдвэрлэж болохгүй.

Онцгой байдлын тусламж тэтгэмжүүд нь: амин зуулгын тэтгэмж, байрны зардлын тэтгэмж болон яаралтай тусламж зэргүүд юм. Онцгой байдлын тусламжийн тэтгэмжийг итгэмжлэгдсэн суурингийн захиргаа шийдвэрлэх болон олгоно.

Амин зуулгын тэтгэмж

- Онцгой байдлын тусламжийн үндсэн тэтгэмжийг хангалтгүй орлоготой хувь хүн болон гэр бүлд олгогдоно.

- Амин зуулгын тэтгэмжийг авах эрх нь хувь хүн болон гэр бүлийн орлогоос байрны зардлыг хасхад үлдсэн цалин нь амьжиргааны хэрэглэгээнд хангалтгүй тохиолдолд үүснэ.
- Амин зуулгын хэмжээ нь хүн тус бүрд тэдний боломжоор тогтоогдоно. Гэр бүлийн амин зуулгын хэмжээг тогтоохдоо хүн тус бүрийн амин зуулгын хэмжээг тооцно. Амин зуулгын хэмжээ нь амьжиргааны болон амьдралын доод түвшингийн хэмжээг үүсгэнэ.
- Амин зуулгын тэтгэмжийн хэмжээг гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдийн амин зуулгын түвшин ба орлогын зөрүүг тооцон, түүнээс хүн тус бүрийн байрны зардлыг хасан тогтооно. (Байрны зардлын хэмжээ нь хамгийн дээд тал нь хувь хүний болон гэр бүлийн орлогын 30 %, Праг-д 35 % байна).

Байрны нэмэгдэл тэтгэмж

- Онцгой байдлын хоёр дахь тусламж нь хувь хүн болон гэр бүлийн орлого, улсын нийгмийн хангамжийн тэтгэмжийн системээс олгогдож байгаа тэтгэмж зэрэг нь байрны зардалд хангалттай бус тохиолдолд олгогдоно.
- Тэтгэмжийг амин зуулгын тэтгэмж болон байрны зардлын тэтгэмж авах эрх бүхий байр хөлслөгч болон байрны эзэнд олгогдоно. Хууль өөр онцгой байдалд байрны тэтгэмжээр хангах боломжийг олгох ба эдгээр өргөдөл гаргагч нь амин зуулгын тэтгэмж авах эрхгүй, байр хөлслөхөөс өөр маягаар байрлаж байгаа байрны тэтгэмж авах эрхгүй зэрэг нөхцлүүдэд.
- Байрны нэмэгдэл тэтгэмжийн хэмжээг хувь хүнд болон гэр бүлд байрны зардал төлсний дараа (эдгээр нь: байрны хөлс, байрлах болон үйлчилгээтэй холбоотой цахилгааны зардал) амин зуулгын зардал үлдхээр тогтоогдоно.

Онцгой шаардлагатай тусламж

Хойшлуулашгүй шаардлагатай тусламж хэрэгтэй хүнд олгогдоно. Хууль таван ийм байдлыг тогтоосон:

1. Эрүүл мэндэд нь хүнд гэмтэл учрах аюул тулгарсан, тусламж аваагүй онцгой байдлын болзлыг биелүүлээгүй хүнд. Ийм хүнд амьдралын доод түвшингийн хэмжээгээр тэтгэмж олгоно (өөрийгөө тэжээх чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингөөр).
2. Онцгой хүнд байдлаас хохирсон (байгалийн гамшиг, салхи шуурганы аюул, екологийн сүйрэл, гал түймэр гм…) Хүн тус бүрд амьжиргааны доод түвшингийн хэмжээг 15 дахин үржүүлсэн хэмжээгээр тэтгэмж олгоно, энэ нь 46 890 корун хүртэл.
3. Нэг удаагийн төлбөр хийх чадваргүй, жнь: биеийн байцаалтыг орлосон хуулбар хийлгэх эсвэл мөнгөө гээсэн гм.. Тэтгэмжийг энэ нэг удаагийн төлбөрийн хэмжээгээр олгоно.
4. Өөрийгөө тэжээх чадваргүй хүүхдийн хэрэглэгээ болон сурч боловсроход зориулалттай зүйлийг худалдан авах эсвэл засварлуулах мөнгөн чадвар хангалтгүй тохиолдолд. Тэтгэмжийг энэ төлбөрийн хэмжээгээр, хуанлийн жилд хүн тус бүрд амьжиргааны доод түвшингээс 10 дахин их хэмжээгээр, энэ нь 31 260 корун хүртэл.
5. Нийгмийн анхаарлаас суллагдсан. Энэ нь жнь: шоронгоос суллагдсан, хүүхдийн асрамжийн газар болон үрчлэлтийн асрамжаас насанд хүрсний улмаас гарсан эсвэл донтсон эмчилгээг дуусгасан зэрэг. Тэтгэмжийг 1 000 корун хүртэл олгож болно. Жилийн турш тэтгэмжийг давтан олгож болох ба харин амьжиргааны доод түвшинг 4 дахин үржүүлсэн хэмжээнээс дээш байж болохгүй энэ нь 12 504 корун хүртэл.

Тэтгэмж олгох үйл ажиллагаа нь хэвлэмэл өргөдөл бөглөж өгсөнийг үндэслэн эхлэх ба энэ өргөдлийн маягтыг итгэмжлэгдсэн суурингийн захиргаанаас эсвэл энэ интернет хуудаснаас авч болно http://portal.mpsv.cz/ (► /Formuláře/Маягт ► /Formuláře pro pomoc v hmotné nouzi/Онцгой байдлын тусламжийн маягт). Онцгой байдлын тэтгэмжийн өргөдлийг оршин сууж буй газрынхаа итгэмжлэгдсэн суурингийн захиргааны нийгмийн хангамжийн хэлтэст өгнө. Үйл ажиллагааны явцад өргөдөл гаргасан хувь хүн (гэр бүл) үнэхээр онцгой хүнд байдалд байгаа, уг тэтгэмжийг авах болзлыг хангасан эсхийг шалгаж тодорхойлно. Эцэст нь тэтгэмжийн хэмжээг тогтооно.

Эрх бүхий хүмүүсийн хүрээ

Амин зуулгын тэтгэмж, байрны нэмэгдэл тэтгэмж зэргийн хуулиар тогтоосон болзлууд

а) ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суугчаар бүртгэгдсэн эсвэл ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суугч

b) цагаачлал болон нэмэлт хамгаалалт олгогдсон хүн
c) ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлгүй гадаадын иргэнийг олон улсын гэрээгээр батлан даасан
d) ЧУ-ын нутаг дэвсгэрт 3 сараас дээш хугацаагаар байрлахаар бүртгэгдсэн ЕХ-ны гишүүн улсын иргэн, түүнд Европын холбооны дүрмээр нийгмийн хангамжийн боломж олгогдохгүй иргэн болон адил болзолтой түүний гэр бүлийн гишүүд
e) ЕХ-ны дүрмийг шууд ашиглан нийгмийн хангамжийн боломж олгогдох эрх бүхий иргэн
f) Европын холбоонд байнга оршин суух хуулийн байр суурьтайгаар зөвшөөрөгдсөн ЕХ-ны бусад гишүүн оронд удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй, ЧУ-ын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлтэй болон ЧУ-ын нутаг дэвсгэрт байрладаг гадаадын иргэн болон түүний гэр бүлийн гишүүд.

Онцгой шаардлагатай тусламжийг дээр дурьдсан иргэдэд олгохоос гадна ЧУ-ын нутаг дэвсгэрт байрлаж байгаа бусад иргэдэд олгогдоно.

Нийгмийн үйлчилгээ

Нийгмийн үйлчилгээний хүрээ нь 108/2006 тоот нийгмийн үйлчилгээний тухай хуулиар мөрдөгддөг ба 2007 оны нэг сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон. Нийгмийн таарамжгүй байдалд орсон хүмүүст туслах тэтгэмжийн болзол нь энэ хуулиар мөрдөгдөж байдаг.

❖ **<u>Эрх бүхий хүмүүсийн хүрээ (нийгмийн үйлчилгээний тухай хуулийн 4-р):</u>**

Нийгмийн үйлчилгээ болон асрамжийн тэтгэмжүүд нь болзол хангаснаар энэ хуулиар тогтоогдсон байдаг:

– Чех улсад **байнга оршин суугчаар** бүртгэгдсэн,
– **цагаачлал** олгогдсон иргэн,
– ЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлгүй гадаадын иргэнийг олон улсын гэрээгээр батлан даасан,
– ЧУ-ын нутаг дэвсгэрт 3 сараас дээш хугацаагаар байрлахаар бүртгэгдсэн ЕХ-ны гишүүн улсын иргэн, түүнд Европын холбооны дүрмээр нийгмийн хангамжийн боломж олгогдохгүй иргэн
– ЧУ-ын нутаг дэвсгэрт 3 сараас дээш хугацаагаар байрлахаар бүртгэгдсэн ЕХ-ны **гишүүн улсын иргэний гэр бүлийн гишүүдэд** Европын холбооны дүрмээр нийгмийн хангамжийн боломж олгогдохгүй иргэн
– Европын холбоонд байнга оршин суух **хуулийн байр суурьтайгаар зөвшөөрөгдсөн ЕХ-ны бусад гишүүн оронд удаан хугацаагаар оршин суух** зөвшөөрөлтэй, ЧУ-ын нутаг дэвсгэрт 3 сараас дээш удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлтэй гадаадын иргэн

Сонгомол нийгмийн үйлчилгээнүүд нь болзол хангасан тохиолдолд нийгмийн үйлчилгээний тухай хуулиар мөрдөгдөж байдаг ба ЧУ-ын нутаг дэвсгэрт албан ёсоор оршин сууж байгаа гадаадын иргэд бас энэ үйлчилгээгээр хангагдаж байдаг бөгөөд шинэ байгуулалтууд нь: цагаачлалын газрууд, харилцах төв, онцгой байдлын төв, хамгаалах төв, нам босгот өдрийн төв, хүүхэд залуучуудад зориулсан нам босгот төв, хоноглох газар болон явуулын програм. Эдгээр үйлчилгээнүүдийн талаар тодорхой мэдээллүүдийг нийгмийн үйлчилгээний тухай хуулийн 57, 59–63, 69-р зүйлүүдээс мэдэж болно.

Асрамжийн талаархи тэтгэмжийг удаан хугацаагаар эрүүл мэндийн доголдолтой хүнд олгогдоно.

Асрамжийн талаархи тэтгэмжийг **Европын холбооны улсаас өөр улсын иргэдэд** олгохдоо нийгмийн үйлчилгээний тухай 108/2006 тоот хуулийн 4-р зүйлд заасны дагуу олгоно.

Нийгмийн үйлчилгээний талаархи мэдээллүүдийг хот суурингийн, эсвэл крайн захиргаанаас (нийгмийн хангамжийн хэлтэс), иргэний болон өөр мэргэжлийн зөвлөх газраас эсвэл шууд нийгмийн үйлчилгээгээр хангах газраас авч болно. Тэтгэмж тусламжийн талаархи мэдээллүүдийг тэтгэмж олгох талаархи шийдвэрийг гаргадаг холбогдох хотын захиргаанаас мэдэж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- **Өвчлөлтийн даатгалын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг** Хөдөлмөр нийгмийн хангамжийн яамны интернет хуудаснаас– http://www.mpsv.cz (► /Nemocenské pojištění/Өвчлөлтийн даатгал) эсвэл Окресний нийгмийн хангамжийн захиргааны хуудаснаас http://www.cssz.cz (► /Kontakty/ Контакт) мэдэж болно.
- **Тэтгэвэрийн даатгалын** болон тэтгэвэр тус бүрийн талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг ЧНХЗ-ны – http://www.cssz.cz (► /Důchodové pojištění/Тэтгэвэрийн даатгал) болон ХНХЯ-ны – http://www.mpsv.cz (► /Důchodové pojištění/Тэтгэвэрийн даатгал) интернет хуудаснуудаас мэдэж болно.
- **Улсын нийгмийн тэтгэвэр тэтгэмжийн талаархи** дэлгэрэнгүй мэдээллүүдийг өөрийнхөө оршин сууж буй газрын харьяат хөдөлмөрийн товчооноос (контактыг 17-р 2-р бүлгүүдээс олж болно) болон Хөдөлмөр Нийгэм Хангамжийн Яамны интернет хуудаснаас http://www.mpsv.cz (► /Státní sociální podpora/Улсын нийгмийн тэтгэмж)
- **Онцгой байдлын тэтгэмж** болон эрүүл мэндийн доголдолтой хүмүүст олгох нийгмийн хангамжийн тэтгэмжийн талаархи дэлгэрэнгүй мэдээллүүдийг:
  - итгэмжлэгдсэн суурингийн захиргаанаас болон өөрийнхөө оршин сууж буй газрын харьяа хот суурингийн захиргаанаас, Праг-д хотын дүүргийн захиргаануудаас
  - ХНХЯ-ны интернет хуудаснаас – http://www.mpsv.cz
- Амьжиргааны доод түвшингийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг ХНХЯ-ны интернет хуудаснаас – http://www.mpsv.cz (► /Příjmy a životní úroveň/Цалин болон амьжиргааны түвшин) тус тус олж мэдэж болно.

11. БАЙРЛАХ

11. 1. Хувийн байранд болон байшинд байрлах

Байр болон байшин худалдан авч хувийн болгож байрлах нь нэг хэлбэрийн байрлах боломж юм (амьдралд ихэвчлэн „osobní vlastnictví“гэсэн буруу хэллэг хэрэглэж байна). Чех улсад гадаадын иргэд үл хөдлөх хөрөнгө эзэмших талаар арилжааны хуулийн 219/1995 тоот хуулиар мөрдлөг болгоно.

❖ **Эрх бүхий хүмүүсийн хүрээ:**

Арилжааны хуулийн дагуу 2011 оны таван сар хүртэл гадаадын иргэд байр байшин хувийн болгох нь хязгаарлагдмал байсан ба зөвхөн дотоодынхонд– энэ нь Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч хувь хүн эсвэл Чех улсын нутаг дэвсгэрт байршилтай байгууллага зэрэг юм, гадаадынханд арилжааны хуулийн 17-р зүйлд дурьдсан. 2011 оны 7 сарын 19-ны өдөр нийтэд хүргэгдсэн, хуулийн эмхтгэлийн 206/2011 (хэсэг 73) тоотод дугаарлагдсан **Арилжааны шинэ хуулиар, гадаадын иргэдэд хязгаарлагдмал бусаар байр байшин үл хөдлөх хөрөнгө хувийн болгох эрхийг олгосон**. 2011 оны таван сарын 1-нээс катастрын газар гадаадын иргэдийн үл хөдлөх хөрөнгийг бүртгэж эхлэсэн ба учир нь энэ өдрөөр ЧУ-д урьд өмнө нь хязгаарлагдмал байсан 2 дахь үе шат дууссан.

Энэ өөрчлөлтөнд Чех улсын улсын хөрөнгөнд хамаарагдах **хөдөө аж ахуйн газар хөрс болон ой мод хамаарагдахгүй** ба эдгээр нь хөдөө аж ахуйн газар хөрс ой модыг улсын хөрөнгнөөс өөр эзэмшигчид шилжүүлэх тухай 95/1999 тоот, Чех улсын Газрын фондын тухай 569/1991 тоот, үл хөдлөх хөрөнгийг өвлөх, бэлэглэх, шилжүүлэх тухай 357/1992 тоот хуулиудаар мөрдөгдөнө.

Байр болон байшин худалдаж авхад худалдаж байгаа тал болон худалдан авагч иргэний хуулийн (40/1964 тоот хууль) дагуу худалдааны гэрээг үндэслэн хэрэгжүүлнэ. Гэрээ нь бичгээр хийгдсэн байх ба өөрөөр хучингүй. Худалдан авагч нь үл хөдлөх хөрөнгийн катастрын газар бүртгэгдсэн үеэс эхлэн **байр болон байшингийн эзэмшигч болно**. Байр болон байшин худалдаж авах бүх процес нь худалдааны гэрээнд гарын үсэг зурснаас эхлээд үл хөдлөх хөрөнгийн катастрын бүртгэлд бүртгэж эзэмшигчийн эрхийг авах хүртлэх үйл ажиллагаа ба зарим үед төвөгтэй хэдэн сараар ч үргэлжлэх магадлалтай. Ийм учраас үл хөдлөх хөрөнгийн хүрээн дэх хуульч- өмгөөлөгч, үл хөдлөх хөрөнгийн брокер зэрэг мэргэжилтэнгүүдэд хандах нь зүйтэй.

11. 2. Хөлсний байранд байрлах

Дараагийн байрлах асуудал нь байр хөлслөх юм. Энэ нь байр болон байшин худалдан авч эзэмшин байрлахаас илүү өргөн боломжтой юм. Байр хөлслөх талаархи хуулийн мөрдлөг нь мөн иргэний хуулинд багтсан байдаг. Иргэний хууль нь мөн хөлсний байрыг бүхэлд нь эсвэл нэг хэсгийг бас хөлсөж болох боломжийг олгодог, харин байр хөлслөгчийн зөвшөөрөл байх хэрэгтэй.

Байр хөлслөх нь байрны эзэн болон хөлслөгч хоёрын байр хөлслөх гэрээг үндэслэн үүсэх ба бас иргэний хуулиар мөрдөгдсөн өөр хууль эрхийн үндэслэлээр үүснэ жнь: байр хөлслөлтийг шилжүүлэх. **Хөлсний гэрээ нь бичгээр үйлдэгдсэн байх ба үндсэн хэргцээт зүйлүүдээс гадна (жнь: гэрээний хуудас болгоныг тэмдэглэсэн), иргэний хуулийн тусгай хэсэгт заасан хэрэгцээт зүйлүүдийг агуулсан байх шаардлагатай** (байрыг тэмдэглэсэн, түүний тавилга хэрэгслэл, тэднийг ашиглах хүрээ, хөлсийг тооцох хэлбэр, байр ашиглах үед гарах зардлын төлбөр болон хэмжээ), **өөрөөр хучингүй**. Хэрэв гэрээнд байр хөлслөх хугацааг заагаагүй бол энэ нь хугацаагүйгээр хийгдсэн гэсэн утгатай.

Байр хөлслөх талаархи эрх үүрэг нь иргэний хуулиар болон байрны гэрээгээр мөрдөгдөнө.

Байр хөлслөхийг хэд хэдэн хэлбэрээр дуусгавар болгож болно**:**

– **бичгэн хэлбэрээр** байр хөлслүүлэгч хөлслөгч хоёрын хооронд байгуулсан гэрээгээр,

– **хугацаа дуусан**, энэ хугацаанд гэрээ хийгдсэн,

– **хөлслөгчийн бичгэн өргөдөл (шалтгааныг дурьдах шаардлагагүй), эсвэл хөлслүүлэгчийн бичгэн өргөдөл (иргэний хуулиар дурьдагдсан шалтгааныг заавал дурьдах).** Гэрээ дуусгах өргөдлийн шалтгааны шинж чанараас шалтгаалж хөлслүүлэгч нь шүүхийн оролцоогүй эсвэл шүүхийн оролцоотой байдлаар гэрээг дуусгавар болгоно. Гэрээ дуусгах хугацаа нь 3 сараас богино байж болохгүй ба заавал хуанлийн сарын эцсийн өдрөөр дуусгавар болгоно.

Хэрэв хөлслүүлэгч нь шүүхийн оролцоогүйгээр дуусгавар болгох тохиолдолд хөлслөгч нь жар хоногийн дотор байр хөлслөхийг дуусгавар болгох өргөдлийг хүчингүйд тооцох талаар шүүхэд давж заалдаж болно. Байр хөлслөх гэрээг дуусгавар болгох өргөдлийг хүчингүйд тооцох талаархи үйл ажиллагааны шийдвэр нь шүүхээр хуулийн хүчин төгөлдөр болоогүй тохиолдолд хөлслөгч нь заавал байрыг суллах шаардлагагүй. Баргалж бүх л тохиолдолд хөлслөгчийг өөр байр олох хугацааг хүртэл өргөдлийн асуудлыг шийдвэрлэдэг.

11. 3. Хоршооллын байранд байрлах

Хоршооллын байрыг хөлслөх нь тусгай тодорхой байдалтай. Байрны хоршоолол бүр нь олон байртай нэг болон түүнээс дээш байшинг түүний гишүүд эзэмшинэ. **Хоршооллын гишүүн нь** байр ашиглахдаа **хоршоололтой байгуулсан байрны гэрээг** үндэслэнэ. Хоршооллын байрны хөлслөх харьцааны агуулгын талаархи асуудлыг шийдвэрлэхдээ (энэ нь хөлсний гэрээ байгуулах, байрны хоршоолол болон хөлслөгчийн эрх үүрэг гм..) худалдааны хуулийн заалтаар **хоршоолол** харгалзан тогтооно.

11. 4. Цахилгаан ашиглах, хог хаягдлын төлбөр болон байрны бусад үйлчилгээ

Байр болон байшинг хөлслөх буюу эзэмших үеэр цахилгаан, хий ашиглах, хог тээвэрлэх зэрэг талаар бүртгүүлэх шаардлагатай. Хэрэв зарим нэг үйлчилгээг хөлслүүлэгч хэрэгжүүлээгүй тохиолдолд хөлслөгч нь өөрөө эзэмшигчийн адилаар эдгээр үйлчилгээнүүдийг хэрэгжүүлнэ.

Зарим нэгэн хот суурин газар орон нутгийн тусгай журмын дагуу хог тээвэрлэх төлбөрийг авна. Энэ төлбөрийг орон нутгийн төлбөрийн тухай 565/1990 тоот хуулиар хэрэгжүүлнэ. Төлбөрийн хэмжээг суурин газар болгон өөр өөр тогтооно – энэ нь хамгийн дээд тал нь жилд нэг хүний 500 коруныг тухайн бүртгэлтэй оршин сууж буй газраа төлөх ба мөн гадаадын иргэд хамааралтай. Үүнээс 3 хүртэл насны хүүхдүүд чөлөөлөгдөнө. Тухайн хүний хаягдал хогны хэмжээ нь төлбөртэй хамааралгүй. Хогний төлбөрийг цаг тухайд нь хийгээгүй тохиолдолд төлбөр нь хүн тус бүрээр 1 500 корун болон өснө. 2012 оноос хогний төлбөр хамгийн дээд тал нь (500 корунаас) 1 000 корун болж өсөх төлөвлөгөөтэй байна.

11. 5. Байргүй болох

Хэрэв байргүй болж төрөл төрөгсөд, танил найз нөхдийндөө байрлах боломжгүй тохиолдолд энэ талаар тусладаг зарим нэгэн хүмүүнлэгийн байгууллагуудад хандаж болно. Эдгээр хүмүүнлэгийн байгууллагуудад Armáda spásy, Charita ČR болон бусад байгууллагууд багтана. Эдгээр байгууллагууд нь Чех улсын бүх газар нутагт салбаруудтай, нийтийн байр, ихэвчлэн цагаачлалын байр гэж нэрлэгддэг байруудыг ажиллуулдаг. Хэрэв хүүхэдтэй эхчүүдэд төвөгтэй асуудал тулгарвал зарим нэг хотод байдаг хүүхэдтэй эхчүүдэд зориулсан цагаачлалын байранд хандаж болно. Эдгээр нийтийн байр болон байранд зөвхөн түр зуур (онцгой нөхцөлд) байрлуулдаг гэдгийг санах хэрэгтэй. Өөрийнхөө зардлаар хувийн нийтийн байрнуудыг ашиглаж болох ба эдгээрийн үнэ нь том хотуудад их өндөр байдаг. Эдгээрийн хаягийг Утас:ны жагсаалтаас, интернетээс олж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг нийгмийн үйлчилгээний тухай 10. 5-р бүлгээс олж болно

11. 6. Бусад ашигтай мэдээллүүд

➢ **Барьцаат зээллэг**

Барьцаат зээллэг нь (хыпотека гэж нэрлэнэ) байр болон байшинг худалдаж авах, барьж байгуулах, засварлах зэргүүдэд зориулсан зээллэг юм. Барьцаат зээллэгийг хувь хүн болон байгууллага зээлж болно. Барьцаат зээллэгийг банк олгох ба олгох үеэр олон янзын болзлуудыг тавина. Барьцаат зээллэгийн барьцаанд үл хөдлөх хөрөнгө байх ба мөн гүйцээж бариагүй барилга мөн барьцаанд байж болно. Барьцаат зээллэгийг төлөх хугацаа нь 30 жил байж болно. Барьцаат зээллэгийн талаархи мэдээллийг банк тус бүрдээ олгоно.

➢ **Барилгын даатгал**

Барилгын даатгал нь байр байшин худалдаж авах, барьж босгох, засварлах зэргийн санхүүгийн зардлыг олох боломжуудын нэг юм. Барилгын даатгалд Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч, регистрийн дугаартай хүн бүр даатгуулж болно. Барилгын даатгалын ашигтай талыг мөн (улсын тэтгэмж) ЧУ-д байнга оршин суугч гадаадын иргэд ашшиглаж болно. Барилгын даатгалын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг барилгын даатгалын газар болгон өгнө.

➢ **Даатгал**

Ямарч байр болон байшинг гал түймэр, үер, хулгай зэрэг аюулуудаас 100% хамгаалах боломжгүй байдаг. Эдгээр хохиролыг багасгахын тулд байр болон байшинг даатгуулдаг. Даатгалын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг даатгалын газар болгон өгнө.

Иргэний хуулийн хүрээнд *байр хөлслөх, байр болон байшин эзэмших, байр эзэмшихэд холбоотой үйлчилгээ зэргүүдийн талаар* ***чухал өөрчлөлтүүдийг*** *хийхээр бэлтгэж байна. Эдгээр хуулийн шинэчлэлүүд нь* ***2014 оноос эхлэн хэрэгжих төлөвтэй байна****.*

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- **Үл хөдлөх хөрөнгийн катастр** энэ интернет хаягаар дамжуулан нэвтэрч болно http://www.cuzk.cz
- **ЧУ-д байрлах талаархи мэдээллийг** Орон Нутгийн Хөгжлийн Яамны интернет хуудаснаас мэдэж болно – http://www.mmr.cz (► /Bytová politika/Байрны бодлого)
- Хэд хэдэн хэлээр бичигдсэн „**Гадаадын иргэдийн байрлах**“ мэдээллийн товхимолыг энэ интернет хуудаснаас олж болно http://www.cizinci.cz (► /Informační materiály a příručky/ Мэдээллийн материал болон гарын авлага)

12. ЗАМ ТЭЭВЭР

12. 1. Хотын тээвэр

Хотын нийтийн хүн тээвэрт ялангуяа (систем нь хотын хэмжээнээс болон хөдөлгөөнөөс шалтгаалан өөр өөр байна) **автобус**, **трамбай**, **тролейбус** эсвэл **метро** (зөвхөн Прагад) зэргүүд хамрагдана. Хотын тээвэр нь **төлбөртэй**, хот болгон өөр өөрийн тарифны системтэй. Хэрэв төлбөргүй тээвэрлэх болзол хангаагүй тохиолдолд ачаа болон нохойнд заавал тээврийн хөлс төлнө. **Тээврийн хөлс төлсөн эсхийг шалгана, төлбөрөө хийгээгүй зорьчсон тохиолдолд өндөр торгууль хүлээнэ.**

Тээврийн төлбөрийн хэмжээг утсаар болон тээврийн байгууллага тус бүрийн интернет хуудаснаас мэдэж болно.

Чех улсын зарим хотуудад нийтийн тээврийг **интеграчилсан** байдаг, энэ нь тодорхойлсон бүсэнд хотын тээврийн тасалбараар хотын захын ойролцоох хотуудаар болон хот хооронд зорчиж болно гэсэн утгатай. Интеграчилсан тээврийн системд нийтийн тээврийн төрөл тус бүр (автобус, галт тэрэг гм.) хамтран ажиллаж нэг тарифтай, нэг болзолтой холбогдсон шугам болон шугам хоорондын холбоос, цагийн хувиар зэргийг харилцан үүсгэж байдаг.

12. 2. Хот хоорондийн тээвэр

Чех улсын хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслэлд ихэвчлэн **автобус** эсвэл **галт тэрэг** байдаг. Дотоодын нисэх онгоцны тээврийг зөвхөн хамгийн том хотуудын хооронд хэрэглэдэг (Праг, Брно, Острава).

Хот хоорондын автобусан тээврийг Чех улсын нутаг дэвсгэрт олон автобусны тээврийн байгууллагууд болон компаниуд ажиллуулж байна. Эдгээр тээврийн байгууллага тус бүрдээ өөр өөрийн тарифны системтэй ба **нэг удаагийн зорчих тасалбар** бас **урьдчилан төлбөртэй үнэмлэх** зэргийг олгодог. Хотын нийтийн тээврийн байгууллагууд, ихэвчлэн автобус тээврийнхэн адил төстэйгөөр зарим зорчигчидодоо **хямдрал** олгодог (жнь: оюутнууд, тахир дутуу хүмүүст, тэтгэвэрийнхэн, тодорхой заасан насны хүүдүүд гм.). Тасалбарын үнэ, хямдралын төрөл, болзлууд, тээврийн цагийн хувиар зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүдийг http://www.idos.cz энэ интернет хуудаснаас эсвэл тээврийн байгууллага тус бүрийн мэдээллийн төвөөс, автобусны төв буудлуудаас (жнь: ÚAN Florenc Praha, ÚAN Zvonařka Brno, ÚAN Ostrava, гм..) мэдэж болно.

Төмөр замын тээврийг ЧУ-ын нутаг дэвсгэрт ихэвчлэн Чехийн төмөр замын байгууллага гүйцэтгэдэг (http://www.cd.cz). Энэ тээврийн байгууллага нь өөрийнхөө тарифны системийн хүрээнд зорчигчидыг өргөн хүрээгээр хамруулсан олон төрлийн хямдрал олгодог. Зарим нэгэн тодорхой хэсэгт өөр хувийн тээврийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа ба эдгээр нь өөрсдийнхөө тарифыг ашигладаг.

Төмөр замын, автобусны эсвэл хотын нийтийн тээврийн хүрээн дэх хувиаруудыг энэ интернет хуудаснаас олж болно http://www.idos.cz. Энэ интернет хуудас нь тээврийн төрөл болгоны хувиаруудыг тус тусад нь эсвэл хооронд нь хослуулан хайх боломжтой.

Хотуудын интеграчилсан тээврийн систем:
Праг *– Прагийн интеграчилсан тээвэр (ПИТ) http://www.ropid.cz*
Брно *– Өмнөд Моравын крайн Интеграчилсан тээвэрийн систем (ӨМИТС) http://www.idsjmk.cz*

12. 3. Жолооны эрх

Чех улсын нутаг дэвсгэрт моторт тээврийн хэрэгсэл жолоодход жолооны эрх заавал байх шаардлагатай ба үүнийг жолооны үнэмлэхээр нотлоно. Жолооны үнэмлэхийг олгоход жолооны сургуульд амьдрал дээр сургууль дасгал хийж, онолын хичээл үзэж суралцах ба мэргэжлийн чадварын шалгалт өгнө. Жолооны эрх эзэмшисний дараа жолооны үнэмлэхийг Чех улсын холбогдох хот суурингийн захиргаан дээр олгоно. **Жолооны үнэмлэх эзэмшигч нь моторт**

тээврийн хэрэгсэл жолоодож байх үедээ жолооны үнэмлэхээ биедээ авч явж шалгалтын үеэр заавал шалгуулах үүрэгтэй.

Чех улсад олгогдсон жолооны үнэмлэхийг эзэмшигч нь энэ үнэмлэхийг хүлээн зөвшөөрдөг гадаад улс руу зорчих эрхтэй. Өөрөөр бол **олон улсын жолооны үнэмлэхийг** авах шаардлагатай**.** Олон улсын жолооны үнэмлэхний өргөдлийг зөвхөн хүчинтэй үндэсний жолооны үнэмлэхийг эзэмшигч өгч болно. Бусад мэдээллүүдийг доорхи 12. 4-р бүлэгт дурьдсан

Чех улсын нутаг дэвсгэрт моторт тээврийн хэрэгсэл жолоодход бас Европын холбооны гишүүн орнуудаар олгогдсон, 1949 онд Женевт байгуулагдсан зам тээврийн гэрээгээр, 1968 онд Вена хотод байгуулагдсан зам тээврийн гэрээний дагуу гадаад улсуудаар олгогдсон жолооны үнэмлэх болон олон улсын жолооны үнэмлэх зэргийг ашиглах эрхтэй. Хэрэв таны жолооны үнэмлэх дээр дурьдсан гэрээт улсуудын болзлыг хангах эсхэд эргэлзээтэй тохиолдолд өөрийнхөө Чех улсын нутаг дэвсгэрт оршин сууж буй газрынхаа хот суурингийн захиргаанд хандаж асууж болно. Жолооны үнэмлэхийг солих талаархи мэдээллийг доор дурьдсан 12. 4-р бүлэгт үзэж болно

Чех улсын нутаг дэвсгэрт өөрийнхөө **машиныг** жолоодож ашиглана гэж шийдвэрлэсэн хүн бүр (Чех улсын нутаг дэвсгэрт холбогдох хуанлийн жилд 185 хоногоос бага хугацаанд байх тохиолдолд энэ болзлоос чөлөөлөгдөнө), хот суурингийн захиргаанд заавал **бүртгүүлэх** ёстой.

Чех улсад бүртгэгдсэн зам тээврийн хэрэгсэл нь албан ёсны даатгал хийгдсэн, техникийн үзлэгт орж, утааны хэмжүүр хийгдсэн байх шаардлагатай. Техникийн үзлэгт орсон, утааны хэмжүүр хийлгэсэн бичиг баримтыг техникийн үзлэгийн газар, утааны хэмжүүр хийдэг газар олгоно.

Чех улсад их зам болон хурдны замаар явхад төлбөртэй байдаг. Их замын төлбөрийг **их замын тасалбар** тэмдгээр нотлоно. Их замын тасалбар тэмдгийг шатхуун түгээгүүрийн газрууд, Чех улсын шуудан холбооны газар, улсын хил дээр, автоклубуудаас худалдан авч болно. Энэ тэмдгийг жилийн, сарын, арван өдрийн хугацаатайгаар авах боломжтой.

Чех улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөн хамгийн дээд хурдууд

Хот дотор: 50 km/цаг
Хотоос гадна: 90 km/цаг
их замд: 130 km/цаг

Чех улсад жолооч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний дараа моторт тээврийн хэрэгсэл жолоодох хориотой!

12. 4. Гадаадын жолооны үнэмлэхийг ЧУ-ын жолооны үнэмлэхээр солих[4]

Гадаад улсын жолооны үнэмлэх, Европын холбооны жолооны үнэмлэхийг ЧУ-ын жолооны үнэмлэхээр солих асуудлыг хотын хөдөлгөөний тухай 361/2000 тоот хуулиар болон зарим нэгэн хуулиудаар (замын хөдөлгөөний тухай хууль) удирдлага болгоно.

Солилтыг доорхи байдлаар ангилна:

- **Европын холбооны улсуудаар олгогдсон жолооны үнэмлэхийг солих[5]**

Европын холбооны жолооны үнэмлэх эзэмшигч гадаадын иргэн Чех улсын нутаг дэвсгэрт суурших үед уг жолооны үнэмлэхээ Чех улсын жолооны үнэмлэхээр солихын шаардлагагүй. Европын холбооны гишүүн орны гадаадын иргэн нь Чех улсын нутаг дэвсгэрт 185 хоногоос дээш түр хугацаагаар байрлахдаа өөрийнхөө Европын холбооны жолооны үнэмлэхээ Чех улсын жолооны үнэмлэхээр солих өргөдөл өгч болно.

4 Энэ бүлгийн мэдээллүүдийг Өмнөд Моравын крайн орон нутгийн хөгжлийн хэлтэс, Өмнөд Моравын крайн Гадаадын иргэдэд туслах орон нутгийн интеграчны төвүүдийн бэлтгэсэн мэдээллийн хуудаснаас мөн ЧУ--ын Тээврийн Яамны мэдээллүүдээс авсан.

5 Эдгээрт хамрагдах улсууд нь ЕХ-ны гишүүн орнууд, Исланд, Лихтенштейн, Швейцар, Норвег.

ЧУ-ын жолооны үнэмлэх нь ЕХ улсуудад олгож байгаа жолооны үнэмлэхний хэлбэрийг бүрэн хангаж байдаг:

➢ **гадаад улсуудад олгогдсон жолооны үнэмлэхийг солих**

Европын холбооны улсын иргэн бус, Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлтэй, 1 жилээс дээш хугацаатай удаан хугацааны визийн түр оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн нь байнга оршин суух зөвшөөрөл, удаан хугацааны визийн түр оршин суух зөвшөөрөл зэргийг хуулийн хүчин төгөлдөр болсноос 3 сарын дотор гадаад улсын жолооны үнэмлэхийг хот суурингийн захиргаанд солих өргөдөл гаргах үүрэгтэй.

Зөвхөн 1968 оны Венийн, 1949 оны Женевийн **Зам тээврийн хөдөлгөөний гэрээний дагуу тогтоогдсон хэлбэрээр гадаад улсуудаар олгогдсон жолооны үнэмлэхийг солино** – доор дурьдсаныг үз.

Гадаадад олгогдсон жолооны үнэмлэх болгоныг (Европын холбооноос бусад орны), ЧУ--ын жолоны үнэмлэхээр солих боломжгүй, учир нь гадаадад олгогдсон жолооны үнэмлэх нь дээр дурьдсанаар тогтоосон хэлбэрийн, ялангуяа Зам тээврийн хөдөлгөөний гэрээний болзлыг хангасан байх шаардлагатай (Вена 1968) – энэ жолооны үнэмлэхийн хэлбэрийг доор дурьдсан. Үүнтэй олон улсын жолооны үнэмлэх цуг байж хүчин төгөлдөр болох тохиолдол байдаг. Зөвхөн Япон болон Өмнөд Солонгосын жолооны үнэмлэхүүд өөр болзолтой, эдгээрийн солилт нь тусгай журам болон тусгай жолооны эрхийн ангилал дүрмээр явагддаг (жолооны үнэмлэхний тухай болон жолоочийн бүртгэлийн тухай 31/2001 тоот тогтоолоор мөрдөгдөнө) – энэ тохиолдолд олон улсын жолооны үнэмлэхийг албан бичгийг орлуулан хамт биедээ авч явж жолоодож болно.

Замын хөдөлгөөний гэрээгээр тогтоосон жолооны үнэмлэхний хэлбэр (Вена 1968)

- Улсын жолооны үнэмлэх нь албан ёсны бичиг баримтын хэлбэртэй байна.
- Үнэмлэх нь хуванцар болон цаасан материалуудаар хийгдсэн байх ёстой. Хуванцар материалаар хийгдсэн жолооны үнэмлэх нь 54×86 мм хэмжээтэй байна. Өнгө нь ягаан.
- Үнэмлэхний нүүрэн талд „Жолооны үнэмлэх“ гэсэн үндэсний хэлээр эсвэл үнэмлэх олгосон улсын хэлээр бичсэн байна.
- Жолооны үнэмлэх нь доорхи мэдээллүүдийг агуулсан, доорхи байдлаар дугаарлагдсан байх ёстой.

1. Овог;
2. Өөрийн нэр, бусад нэр;
3. Төрсөн он сар өдөр, газар (улсын хуульд зааснаар өөр мэдээлэл байж болно);

4.(a) Олгосон он сар өдөр;
4.(b) Хүчинтэй хугацаа дуусах он сар өдөр;
4.(c) Үнэмлэх олгосон байгууллагын нэр болон тамга;
5. Үнэмлэхний дугаар;
6. Эзэмшигчийн гэрэл зураг;
7. Үнэмлэх эзэмшигчийн гарын үсэг;
9. Үнэмлэхний ангилал;
12. Нэмэгдэл мэдээ болон хязгаарлагдмал ангилалуудын кодоор тэмдэглэсэн тэмдэглэгээнүүд.

- Хэрэв тухайн улсын хуулиар шаардлагатай өөр мэдээллүүдийг үнэмлэх дээр дурьдсан бол доорхи байдлаар дугаарласан:

4.(d) 5 тоотын 4-р догол мөрд дурьдсанаас өөр регистрийн дугаарын зориулалттай хувийн дугаар

8. Оршин суугаа газар
10. Ангилал тус бүрийг олгосон он сар өдөр;
11. Ангилал тус бүрийн дуусах олгосон он сар өдөр;
13. Оршин суугаа газар өөрчлөлтийн бүртгэлийн зориулалттай мэдээлэл;
14. Бүртгэлийн эсвэл өөр мэдээллийн зориулалттай замын аюулгүй хөдөлгөөний талаар холбоотой мэдээлэл.

- Жолооны үнэмлэхэн дээрх мэдээллүүд нь бүгд латин үсгээр бичигдсэн байх ба хэрэв өөр үсгээр бичигдсэн бол мөн латин үсгэнд хөврүүлж бичсэн байх шаардалагтай.

Хэрэв гадаадад олгогдсон жолооны үнэмлэх нь дээр дурьдсан „Гэрээний“ болзлыг хангахгүй тохиолдолд тэр үнэмлэхээр Чех улсын нутаг дэвсгэрт моторт тээврийн хэрэгсэл жолоодох хориотой ба мөн Чех улсын жолооны үнэмлэхээр солих боломжгүй. Ийм тохиолдолд, түүнийг эзэмшигч нь Чех улсын нутаг дэвсгэрт моторт тээврийн хэрэгсэл жолоодохыг шийдвэрлэсэн нөхцөлд жолооны сургуульд суралцаж, мэргэжлийн шалгалт өгч, дараа нь жолооны эрхийн өргөдлийг өгнө.

Гадаад улсад олгосон жолооны үнэмлэх, Европын холбоогоор олгогдсон жолооны үнэмлэхийг солих талаархи ерөнхий мэдээ

Жолооны үнэмлэхний солих өргөдлийг өөрийнхөө Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин сууж буй, 185 хоногоос дээш түр байрлаж байгаа, 1 жилээс дээш хугацаатай удаан хугацааны визээр түр оршин сууж буй газрынхаа хот суурингийн захиргаанд өгнө. Жнь: Брнод Брно хотын захиргаа-зам тээврийн хэлтэс-захиргааны үйл ажиллагаа.

Хот суурингийн захиргаа нь гадаад улсад, Европын холбоогоор олгогдсон жолооны үнэмлэхний хүчинтэй эсхэд эргэлзээтэй байвал тухайн улсын төлөөний газраар дамжуулан хүчинтэй эсхийг шалгаж үзнэ.

Солих дараалал:

Гадаадын улсаас, Европын холбоогоор олгогдсон жолооны үнэмлэхийг үндэслэсэн жолооны үнэмлэх олгох бичгэн өргөдөл, бөглөсөн маягтыг хувиараа болон өөр хүнээр төлөөлүүлэн хот суурингийн захиргаанд өгнө. Жолооны үнэмлэх олгох өргөдлийн маягт нь хот суурингийн захиргаан дээрээс эсвэл (бөглөх заавартай) ЧУ-ын Тээврийн Яамны интернет хуудаснаас авч болно:
http://www.mdcr.cz/NR/rdonlyres/321FBCAB-7CA4-4E01-B30C-53F06F195515/0/vzornew.pdf)

Холбогдох захиргаанд өгөх зүйлүүд:

- жолооны үнэмлэх олгох өргөдөл,
- хүчинтэй биеийн байцаалт болон бичиг баримт (гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл, зарим тохиолдолд иргэний үнэмлэх, гадаад паспорт иргэний үнэмлэхний тодорхойлолттой хамт ба энэ тодорхойлолтыг холбогдох байгууллага үнэмлэхэнд өөрчлөлт орох, гээгдэх, гэмтээх зэрэгт өгнө),
- гадаадад олгогдсон эсвэл Европын холбоогоор олгогдсон жолооны үнэмлэх,
- үнэмлэхний нэг гэрэл зураг (одоогийн байдалтай адилхан, 3,5×4,5 см хэмжээтэй, эгц урдаас харсан, нүднээс эрүү хүртэл хамгийн бага нь 13 мм, иргэний хувцастай, бараан өнгийн нүдний шилгүй, толгойны бүрхүүлгүй),
- тодорхой нөхцлүүдийн талаархи бусад бичиг баримтууд (мэдээллийг жолоочийн бүртгэлийн газрын ажилтнууд өгнө).

Жолооны үнэмлэх олгох өргөдөл өгснөөс 20 хоногийн дотор жолооны үнэмлэхийг олгоно.

Албан татвар:

- жолооны үнэмлэхийг 20 хоногийн дотор **50,- коруны албан татвар** авч олгоно. Энэ албан татварыг бас жолооны эрхийг өргөжүүлэх, жолооны үнэмлэх гээгдүүлсэн, гэмтээсэн, устгагдсан, алдагдсан тохиолдлуудад дахин олгох мөн олон улсын үнэмлэх олгох зэрэгт авна,
- **500,- коруны албан татвар** төлсөн тохиолдолд жолооны үнэмлэхийг ажлын 5 хоногийн дотор олгоно,
- жолооний үнэмлэх олгох албан татвараас II. эсвэл III. группэй тахир дутуу хүмүүс чөлөөлөгдөнө,

- 361/2000 тоот хуулийн 134-р зүйлийн дагуу солигдож байгаа жолооны үнэмлэхийг үнэгүй солино, Чех улсад 2001. 01. 01.–2002. 12. 31. хооронд олгогдсон (2012. 12. 31. хүртэл солигдсон байх шаардлагатай), 2003. 01. 01.–2004. 04. 30. хооронд олгогдсон (2013. 12. 31. хүртэл солигдсон байх шаардлагатай) үнэмлэхүүдийг үнэгүй солино,
- 361/2000 тоот хуульд хамраалтай гадаад улсад олгогдсон жолооны үнэмлэхийг бас үнэгүй солино.

Жолооны эрх эзэмшигч нь жолооны үнэмлэхийг биеэрээ болон түүний баталгаат итгэмжлэлийг үндэслэсэн итгэмжлэгч хот суурингийн захиргаанаас ирж авна. Үнэмлэхний хугацаа нь жолоочийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалж хязгаарлагдмал богино хугацаатай бус тохиолдолд олгосон өдрөөс 10 жилийн хүчинтэй хугацаатай.

Хэрэв өргөдөл гаргагчийн хүсэлтийг хүлээн авч хэрэгжүүлсэн тохиолдолд хуулийн хэрэгцээ тогтоогдоогүй. Хэрэв өргөдлийг авч хэлэлцэж хэрэгжүүлээгүй тохиолдолд шийдвэрийн хуулийн танилцуулгатай уялдуулан давж заалдаж болно.

Олон улсын жолооны үнэмлэх

Олон улсын жолооны үнэмлэх нь үндэсний жолооны үнэмлэхний нэмэлт хавсралт болно. Энэ нь зөвхөн олон улсын замын хөдөлгөөнд моторт тээврийн хэрэгсэл жолоодход зориулагдсан ба заавал үндэсний хүчинтэй жолооны үнэмлэхтэй цуг шалгуулна. Олон улсын жолооны үнэмлэхийг ЕХ-ны орнуудаас бусад улсуудад заавал биедээ авч явах ба хэрэв сүүлийн үеийн ЧУ-ын үнэмлэхтэй бол ЕХ-ны улсад энэ олон улсын үнэмлэхийг биедээ авч явах шаардлагагүй.

Олон улсын жолооны үнэмлэх нь олгосон улсдаа хүчин төгөлдөргүй, учир нь зөвхөн олон улсын замын хөдөлгөөнд л зориулалттай ба заавал үндэсний жолооны үнэмлэхтэй цуг хүчин төгөлдөр байна.

Хоёр төрлийн олон улсын жолооны үнэмлэх байдаг:

- *Венийн* хэлбэр
  Зам тээврийн хөдөлгөөний тухай гэрээ (Вена, 1968) – энэ гэрээнд хамрагдсан улсуудад олгосон өдрөөс гурван жил хүчинтэй.[6]
- *Женевийн* хэлбэр
  Зам тээврийн хөдөлгөөний тухай гэрээ (Женев, 1949) – энэ гэрээнд хамрагдсан улсуудад олгосон өдрөөс нэг жил хүчинтэй.[7]

Энэ хоёр хэлбэрийн олон улсын жолооны үнэмлэхүүд нь цагаан саарал өнгөтэй, хоёр хуудас хавсралт эсвэл хоёр хуудастай хавсралт хэлбэртэй байх ба олон улсын жолооны үнэмлэхний

6 *Энэ **Венийн хэлбэрийн** олон улсын жолооны үнэмлэх нь эдгээр улсуудад Гэрээний дагуу батлагаатай эсвэл шаардлагатай: Албани, Арабын нэгдсэн Емират, Армен, Азербайжан, Бахам, Бахрайн, Бельги, Беларусь, Босни Герцегонив, Бразил, Болгар, Черна Хора, Чех улс, Дани, Эстони, Филиппин, Финлянд, Франц, Гүрж, Гайна, Хорват, Иран, Итал, Израел, Өмнөд Африкын бүгд найрамдах улс, Югослав, Казахстан, Киргизстан, Ардчилсан Конго улс, Куба, Кувейт, Либери, Литва, Латви, Люксембург, Унгар, Македон, Марокко, Молдав, Монако, Монгол, Герман, Нигэр, Норвеги, Пакистан, Перу, Слоны эргийн улс, Польш, Австри, Румын, Орсын холбоо, Грек, Сан Марино, Сейшелийн арлууд, Сенегал, Словак, Словен, Серб, Төв Африкын бүгд найрамдах улс, Швед, Швейцар, Тажикстан, Тунис, Туркменстан, Украйн, Уругвай, Узбекстан, Зимбабвэ.*

7 *Энэ **Женевийн хэлбэрийн** олон улсын жолооны үнэмлэх нь эдгээр улсуудад Гэрээний дагуу батлагаатай эсвэл шаардлагатай: Албани, Алжир, Арабын нэгдсэн Емират, Аргентин, Австрали, Бангладэш, Барбадос, Бельги, Бенин, Ботсвана, Болгар, Буркина Фасо, Черна Хора, Чех улс, Дани, Доминикан улс, Египет, Еквадор, Фижи, Филиппин, Финлянд, Франц, Гана, Гүрж, Гватемал, Гайти, Голланди, Чили, Энэтхэг, Ирланд, Исланд, Итал, Израел, Ямайк, Япон, Өмнөд Африкын бүгд найрамдах улс, Иордан, Кампучи, Канад, Киргизстан, Конго, Ардчилсан Конго улс, Солонгос улс, Куба, Кипр, Лаос, Лесото, Ливан, Люксембург, Мадагаскар Унгар, Малави, Малайз, Мали, Мальт, Марокко, Монако, Намиби, Нигэр, Нигери, Норвег, Шинэ Зеланд, Папуа-Шинэ Гвиней, Парагвай, Перу, Слоны эргийн улс, Польш, Португали, Австри, Румын, Орсын холбоо, Руанда, Грек, Сан Марино, Сенегал, Сиерра Леона, Сингапур, Словак, Америкийн нэгдсэн улс, Серб, Шри Ланка, Төв Африкын бүгд найрамдах улс, Сири, Испани, Швед, Тайланд, Того, Тринидад ба Тобаго, Тунис, Турк, Уганда, Ватикан, Их Британи, Венесуэл, Зимбабвэ.*

ЧУ-д миний жолооны үнэмлэх хүчинтэй юу? ЧУ-ын жолооны үнэмлэхээр сольж болох уу?/шаардлагатай юу?



ЖҮ – жолооны үнэмлэх
ЕХ – Европын холбоо

Тайлбар: Гадаадын ЖҮ-ийг ЧУ-ын Жү-ээр солих нь гадаадын иргэдэд ашигтай жнь: ЖҮ-ээ гээсэн тохиолдолд. Хэрэв гадаадын иргэн нь Чехийн жолооны үнэмлэхийг эзэмшиж байгаад гээсэн тохиолдолд ЧУ-ын нутаг дэвсгэрт өөрийнхөө оршин сууж буй газрын харьяа хот суурингийн захиргаанд дахин шинээр жолооны үнэмлэх олгох өргөдөл гаргаж болно. Гадаадын үнэмлэхийг гээсэн тохиолдолд дахин олгох боломжгүй.

мэдээллүүдийг дэлхийн хэлээр бичсэн байна. Зарим улсууд энэ хоёр төрлийн жолооны үнэмлэхний зөвхөн нэгийг хүлээн зөвшөөрөх учраас эзэмшигч нь аль улсад ашиглахаа мэдэгдэх нь зүйтэй.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- **Жолооны үнэмлэхний талаархи** мэдээллүүдийг Тээврийн Яамны хуудаснаас олж болно http://www.mdcr.cz (► /Silniční doprava/Зам тээвэр ► /Řidičské průkazy, Autoškoly/Жолооны үнэмлэх,Авто сургууль ► /Řidičské průkazy/Жолооны үнэмлэх)
- **Тээврийн хэрэгслэлийн бүртгэлийн талаархи** мэдээллүүдийг Тээврийн Яамны хуудаснаас олж болно http://www.mdcr.cz (► /Silniční doprava/ Зам тээвэр ► /Dovoz, registrace a schvalování vozidel/Гадаадаас машин оруулж ирэх, түүний бүртгэл зөвшөөрөл ► /Schvalování vozidel/ Машины зөвшөөрөл)
- **Бүртгэлийн газруудын танилцуулгыг** Тээврийн Яамны хуудаснаас олж болно http://www.mdcr.cz (► /Silniční doprava/Зам тээвэр ► /Dovoz, registrace a schvalování vozidel/Гадаадаас машин оруулж ирэх, түүний бүртгэл зөвшөөрөл ► /Registrace vozidel/Машины бүртгэл ► /Přehled registračních míst/Бүртгэлийн газрууд)
- **Техникийн үзлэгийн газар, утааны хэмжүүр хийдэг газруудын талаархи** мэдээллүүдийг Тээврийн Яамны хуудаснаас олж болно http://www.mdcr.cz (► /Silniční doprava/ Зам тээвэр ► / STK a SME/ Техникийн үзлэгийн газар, утааны хэмжүүрийн газар)
- Хоёр төрлийн олон улсын үнэмлэхний талаархи мэдээллүүдийг Тээврийн Яамны хуудаснаас олж болно http://www.mdcr.cz (► /Silniční doprava/Зам тээвэр ► Řidičské průkazy, autoškoly/ Жолооны үнэмлэх,Авто сургууль► /Řidičské průkazy/Жолооны үнэмлэх ► /Vydání mezinárodního řidičského průkazu/Олон улсын жолооны үнэмлэх олгох ► /Dva vzory/Хоёр хэлбэр)

13. ГЭР БҮЛ, ГЭРЛЭЛТ, АМЬДРАЛЫН ҮЙЛ ЯВДЛУУД

Гадаадын иргэдийн гэр бүлийн харилцаа нь Чех улсын хууль дүрмээс өөрөөр явагддаг байж болох юм. Олон улсын хувийн эрх болон процесийн тухай 97/1963 тоот хуулиар гадаад улсын иргэдийн гэр бүлийн харьцааг мөрдлөг болгон тогтооно. Энэ хуулиас үүдэж доорхи бодит байдал үүсдэг:

- *тухайн иргэний харъяат улсын хуулиар гэр бүл болох болзол болон түүний хүчин төгөлдөр болох зэргийг удирдлага болгодог*
- *гэр бүл болох хэлбэрийг гэр бүл болж байгаа газрын хуулиар удирдлага болгоно*
- *гэр бүл бологсодын хувийн болон хөрөнгийн харьцааг эхнэр нөхрийн харъяат улсын хуулиар шийднэ; хэрэв эхнэр нөхөр хоёр өөр өөр улсын иргэд байвал Чехийн хуулиар шийднэ*
- *гэр бүл цуцлах үйл ажиллагааны эхлэх үеэр эхнэр нөхөр хоёр аль улсын иргэн байсан, тэр улсын хууль дүрмээр шийднэ; хэрэв эхнэр нөхөр хоёр өөр өөр улсын иргэд байвал Чехийн хууль дүрмээр шийднэ; хэрэв гадаад улсын хууль нь гэр бүл цуцлахыг зөвшөөрөхгүй эсвэл энэ хууль дүрмийг ашиглахад маш хүндрэлтэй, эхнэр нөхөр хоёрын аль нэг нь Чех улсад удаан хугацаагаар амьдарч байгаа тохиолдолд Чехийн хуулийг ашиглаж болно*
- *эцэг эх болон хүүхдүүдийн хоорондох харьцаа, хүмүүжил, тэжээн тэтгэх зэрэг асуудлыг хүүхдийн харъяат улсын хуулиар шийднэ; хэрэв хүүхэд Чех улсад амьдарч байгаа ба хүүхдийн эрх ашгийн тулд байвал Чехийн хууль эрхээр шийдэж болно.*

Энэ хуулийн тогтоолыг Чех улстай холбоотой олон улсын хуулиас өөр ямар нэгэн зүйл тогтоогоогүй нөхцөлд ашиглаарай.

Гэр бүлийн хүрээндэх хууль эрхийн талд бусад хууль болзолд заасанчилан эхнэр нөхөр хоёр адил тэнцүү эрхтэй ба гэр бүлийн асуудлыг хамтран шийдэх ёстой. Эхнэр нөхөр хоёр амьдралын адил түвшитэй.

Хүүхэд хүмүүжүүлэх талаар эцэг эх хоёр адил тэгшээр хуваалцана. Эцэг эх өөрсдийнхөө хүүдүүдийг **тэжээн тэтгэх үүрэгтэй**. Энэ үүрэг нь хүүхэд биеэ дааж өөрийгөө тэжээх чадвартай болтол үргэлжилнэ. Эцэг эх хоёр хүүхдүүдээ тэжээн тэтгэхдээ өөр өөрсдийнхөө чадал, хөрөнгө бололцоогоороо оролцох ёстой. Төрсөн болон дагавар хүүхдүүд Чехийн хуулинд адил тэгш эрхтэй.

13. 1. Иргэний бүртгэл мэдээллийн товчоо түүний үйл ажиллагаа

Иргэний бүртгэл мэдээлэл нь Чех улсын нутаг дэвсгэр дэх төрөлт, гэр бүл бололт, хамтран амьдрагчидын бүртгэл, нас баралт зэргийг мөн Чех улсын иргэн гадаад улсад төрсөн, гэр бүл болсон, нас барсан зэрэг тохиолдолд бүртэгдэг. Иргэний бүртгэл мэдээллийн газар төрөлтийг төрсний бүртгэлийн дэвтэрт, гэрлэлтийг гэр бүл болсны бүртгэлийн дэвтэрт, хамтран амьдрахаар бүртгүүлсэн тохиолдолд хамтран амьдрагчидын бүртгэлийн дэвтэрт, нас нөхчсөн тохиолдолд нас барагчидын бүртгэлийн дэвтэрт тус тус бичнэ.

Иргэний бүртгэлийн дэвтэрт бусад бодит байдлуудыг бичих ба эдгээрийг сольж нэмж хасаж бичиж болно.

Бүртгэлд бүртгэлийн дэвтэрт бүртгэсний дараа **иргэний бүртгэлийн бичиг баримтыг** олгоно, эдгээр нь төрсний гэрчилгээ, гэрлэлтийн батлагаа, нас нөхцсөний гэрчилгээ, хамтран амьдрагчидын гэрчилгээ зэрэг юм.

Иргэний бүртгэл мэдээллийн газар нь суурингийн захиргаанууд ба нийслэл хот Прагад хотын хэсэг тус бүрийн захиргаанууд, орон нутгийн гишүүнчилсэн хотуудын дүүргийн захиргаанууд эсвэл Дотоод Явдлын Яам хууль дүрмээр зааглан үүсгэсэн хотын хэсэг дэх цэргийн бүс газрын захиргаа зэргүүд юм.

13. 2. Гэрлэлт (шаардлагууд); хамтран амьдрагчидын бүртгэл (шаардлагууд)

а) Гэр бүл болох нь эр эм хоёр иргэний бүртгэлийн байгууллагад, сүйт хоёрын аль нэг нь байнга оршин суудаг газрынхаа захиргаанд, тусгай эрх дүрэмтэй шашны байгууллагуудад эрх чөлөөтэйгөөр өөрсдийнхөө сайн дурын үндсэн дээр гэр бүл болцгоохоо илэрхийлцгээдэг. Гэр бүл болох нь нийтэд нээлттэй, ёслолын байдалтай, хоёр гэрчээр гэрчлүүлэн явагдана.

Сүйт хоёр маягт бөглөж иргэний бүртгэлийн газар өгөх ба уг газар нь гэр бүл болсныг хүлээн зөвшөөрнө. Хэвлэмэл бөглөсөн маягттай цуг шаардлагатай бичиг баримтыг хавсаргана. Гэр бүл бологчид нь гэр болох бүхий л хуулийн шаардлагыг хангасан гэдгийг нотолсны дараа шашны байгууллага нь гэр бүл болсныг зөвшөөрнө. Нотлох бичиг баримт нь гурван сараас хуучин байж болохгүй ба тэдний гэр бүл болсон газрын харъяаны иргэний бүртгэлийн газар энэ бичиг баримтыг хийж өгнө.

Гэр бүл болход эхнэртэй, нөхөртэй, төрлийн урд хойд үе хоорондоо, төрсөн ах эгч дүү нар хоорондоо, үрчлэгдсэн үрчилсэн хоорондоо гэр бүл болж болохгүй. Мөн насанд хүрээгүй 16 хүртэл настай хүүхэд, шүүхийн шийдвэрээр эрхээ хязгаарлуулсан хүн, хуулийн хариуцлага хүлээх чадваргүй, гэр бүл болход бичдэг хэвлэмэл маягтыг бичих чадваргүй сэтгэцийн хүнд доголдолтой хүн гэр бүл болж болохгүй.

Хэрэв шаардлагатай бичиг баримтууд нь гадаад хэл дээр байвал Чех хэлэнд албан ёсны орчуулга хийгдэж баталгаажуулсан байх ёстой (4. 4-р бүлгийг үз). Хүнд төвөгтэй байдлаар баталгаажуулагдах бичиг баримтыг иргэний бүртгэлийн газар хэлтрүүлж болно.

Гадаадын иргэн нь иргэний бүртгэлийн газар гэр бүл болхоосоо өмнө Чех улсын Цагдаагийн байгууллагаас Чех улсын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрлийн тодорхойлолтыг авч өгнө; энэ нь хэрэв Европын холбооны иргэн, Европын аж ахуйн гэрээний орнуудын иргэн эсвэл тэдний гэр бүлийн гишүүдэд хамаарахгүй. Энэ тодорхойлолт нь гэр бүл болох өдрийг хүртэл 7 ажлын өдрөөс хуучин байж болохгүй.

b) 2006 оны долоон сарын 1-нээс зарим нэг хуулийн өөрчлөлттэй хамааралтай хамтран амьдрагчидыг бүртгэх тухай 115/2006 тоот хууль хүчин төгөлдөр болсон. **Хамтран амьдрагчидын бүртгэл нь** (цаашид „хамтран амьдрах“), *ижил хүйсний хоёр* эрх чөлөөтэйгөөр, өөрсдийнхөө сайн дураар хамтран амьдрахаа илэрхийлцгээснээс үүснэ. Холбогдох иргэний бүртгэлийн газруудыг (14) Дотоод Явдлын Яамны тогтоолоор тогтоосон.

Хамтран амьдрахыг хүссэн иргэд нь хэвлэмэл маягтыг бөглөж холбогдох иргэний бүртгэлийн газар өгнө. Хэвлэмэл бөглөсөн маягттай цуг шаардлагатай бичиг баримтыг хавсаргана. Хэрэв шаардлагатай бичиг баримтууд нь гадаад хэл дээр байвал Чех хэлэнд албан ёсны орчуулга хийгдэж баталгаажуулсан байх ёстой (4. 4-р бүлгийг үз).

Гадаадын иргэн нь Чех улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлгүй тохиолдолд иргэний бүртгэлийн газар хамтран амьдрахаа бүртгүүлхээсээ өмнө Чех улсын Цагдаагийн байгууллагаас Чех улсын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрлийн тодорхойлолтыг авч өгнө; энэ нь хэрэв Европын холбооны иргэн, Европын аж ахуйн гэрээний орнуудын иргэн эсвэл тэдний гэр бүлийн гишүүдэд хамаарахгүй. Энэ тодорхойлолт нь хамтран амьдрахаа бүртгүүлэх өдрийг хүртэл 7 ажлын өдрөөс хуучин байж болохгүй.

Хамтран амьдрахаа хуулиар хориглогдоогүй хүн бүр бүртгүүлж болно. Хамтран амьдрагчидын нэг нь Чех улсын иргэн байх шаардлагатай. Шууд төрлийн холбоотой болон төрсөн ах эгч дүү нар хоорондоо хамтран амьдрахаа бүртгүүлж болохгүй. Мөн 18 нас хүрээгүй, хуулийн хариуцлага хүлээх чадваргүй, урьд өмнө нь албан ёсны гэр бүлтэй байсан, урьд өмнө нь хамтран амьдрахаа бүртгүүлж байсан, эсвэл үүнтэй адил байдлаар гадаадад ижил хүйсний холбоотой, эдгээр гэр бүл болон хамтран амьдрах нь хүчин төгөлдөр хэвээр байгаа хүмүүс хамтран амьдрахаа бүртгүүлж болохгүй.

Эмэгтэйчүүдийн овог нь Чехийн хууль дүрмээр хамааралтай үүснэ. Гэр бүл болох эсвэл хамтран амьдрах бүртгэлийн мэдэгдлийг бичихдээ хэрэв гадаадын эмэгтэй байвал гэрлэлтийн баталгаа буюу хамтран амьдрагчидын бичиг баримтан дээр овгийг эр хүйсний байдлаар бичиж болно.

13. 3. Салалт

Чех улсад гэр бүл салалт байж болно. Гэр бүл шүүхээр сална. Гэр бүл салах шийдвэрийг гаргахаас өмнө шаардлагатайгаар насанд хүрээгүй хүүхдийн асрах талаар шийднэ. Чех улсад хоёр төрлийн салалт байдаг ба, эдгээр нь маргаангүй (нэхэмжлэлгүй) салалт, маргаантай (нэхэмжлэлтэй) салалт.

Маргаангүй салалтын процес нь амархан, хурдан явагддаг. Хэрэв

– гэр бүл бололцсон хугацаа нь богино байсан,
– эхнэр нөхөр салалтаа харилцан зөвшөөрөлцөцгөөсөн,
– хамгийн багаар зургаан сар цуг амьдраагүй
– хөрөнгө болон хүүхдийн талаар шийдвэрлэж харилцан тохиролцоцгоосон,

зэрэг тохиолдлуудад шүүх гэр бүл нь маш ихээр зөрчилдөөнтэй эсхийг шалгаж үзхийн шаардлагагүйгээр гэр бүлийг салгана.

Хэрэв **маргаантай** салатын үйл ажиллагааг (эхнэр нөхөр хоёрын нэг нь салалтыг зөвшөөрөхгүй, эхэр нөхөр хоёр салалтын дараах харьцаанд харилцан эвлрэх чадваргүй) шүүх эхнэр нөхөр хоёрын аль нэгний саналаар зөвхөн гэр бүл нь удаан хугацаагаар, гүнзгий эвдрэлцсэн тохиолдолд л гүйцэтгэнэ. Шүүх хүүхдийн эцэг эх болон хүүхдийн харж хандах батлан даагчийг зарлан дуудаж энэ үйл ажиллагааны тусгай тогтоосон хэсэг болох хэлэлцээг хийсний дараа шийдвэрийг гаргана. Тодорхой онцгой тохиолдолд шүүх гэр бүлийг салгах шаардлагагүй.

Шүүх насанд хүрээгүй хүүхдийн эцэг эхийн салалтыг шийдвэрлэхээс өмнө хүүхдийн эцэг эхэд салалтын дараах хүүхдэд хандах эрх үүргийг ноогдуулж, хүүхдийг хэний асрамжинд үлдээх, хүүхдийн тэтгэмжийг яаж төлөх зэрэг үүргүүдийг тогтооно. Хэрэв эцэг эх хоёр хоёуулаа хүүхдийн асрамж хүмүүжилд оролцох хүсэлтэй, энэ нь хүүхдийн эрх ашигт зохицож, түүний хэрэгцээг хангаж байвал шүүх хүүхдийг хамтран, эсвэл ээлжлэн асарч хүмүүжүүлэх боломжийг олгоно.

Гэр бүл салалтаар хүүхдийг асарч тэжээх үүрэг дуусгавар болохгүй. Хэрэв эцэг эхийн аль нэг нь хүүхдийн асарч тэжээх үүрэг хангалтгүй гэж үзэж байвал шүүхэд хандаж энэ байдлыг сайжруулах өргөдөл гаргаж болно. Хүүхдийн асарч тэтгэх асуудлыг зөвхөн гэр бүл салалтын үеэр шийдвэрлэх бус эцэг эх хоёрын аль нэг нь гэр бүл үргэлжилж байх үеэр энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд мөн шийдвэрлэнэ.

Шүүх эцэг эх хоёрын аль нэгнийх нь асрамжинд хүүхдийг үлдээсэн ч, мөн хүүхдийг хариуцуулаагүй эцэг эх хоёрын аль нэгтэй нь, эсвэл хүүхдийн өвөг эцэг, эмэг эх, эсвэл хүүхдийн ах, эгч дүү нартай нь түүний хүмүүжлийн эрх ашиг болон гэр бүлийнх нь харьцаа шаардагдаж байгаа тохиолдолд харьцаатай байхаар шийдвэрлэж болно. Эцэг эхийн хоорондын тохиролцоог шүүхийн шийдвэрээс түрүүлж тавих ба үүнийг шүүхээр зөвшөөрөх шаардлагагүй. Хүүхдүүд тэдний эцэг эхтэй адил амьдралын түвшингийн эрхтэй. Шүүхэд хүүхдийн асран тэжээх талаар насанд хүрээгүй хүүхдийн гэр бүл бололцоогүй эцэг эх хандаж болно.

Гэр бүлийн салсан хоёр (эмэгтэй, эрэгтэй)-ын аль нэг нь өөрийгөө тэжээх чадваргүй тохиолдолд нөгөөхөөсөө өөрийнхөө чадал, бололцоо, хөрөнгөнийхөө байдлаар тохируулан туслахыг хүсэж болно.

13. 4. Гадаадын иргэний хүүхэд төрөх

Хүүхдийн төрснийг Иргэний бүртгэл мэдээллийн газарт хүүхдийн төрсөн эмнэлгийн байгууллага мэдэгдэнэ; төрөлт нь эмнэлгийн байгууллагад биш тохиолдолд төрхөд болон төрснөөс хойш анхны тусламж үзүүлсэн эмч мэдэгдэнэ. Хүүхдийн төрсөн газрын харъяат иргэний бүртгэлийн газар хүүхдийг бүртгэж төрсний бүртгэлийн дэвтэрт бичнэ. Иргэний бүртгэлийн ажилтан төрсний бүртгэлийн дэвтэрт бичиж хүүхдэд төрсний гэрчилгээ олгоно. Иргэний бүртгэлийн газар төрсөн хүүхдийг оршин суугчидын бүртгэлд мэдэгдэнэ.

Хэрэв Чех улсын иргэний хүүхэд, түүний эх нь гадаад улсын иргэн байгаа нөхцөлд, хүүхдийн эцэг эх өөрөөр тохиролцоогүй тохиолдолд хүүхдийн төрсөн газрын харъяат холбогдох байгууллагын хаяг газар нь түүний байнга оршин суух газар болно.

Албан ёсны зөвшөөрөлтэй оршин суугч гадаадын иргэний хүүхдийг төрсний дараа түр хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэйд тооцно. Энэ түр хугацааны оршин суух зөвшөөрөл нь

хугацаатай байдаг учраас хүүхдийг төрснөөс хойш 60 хоногийн дотор эцэг эх өөрийнхөө хүүхдэд виз/уданн хугацаагаар оршин суух зөвшөөрөл, байнга оршин суух зөвшөөрөл зэргийн өргөдлийг өгөх хэрэгтэй. Эцэг эх нь ЧУ-ын нутаг дэвсгэрт визээр оршин сууж байгаа тохиолдолд хүүхдээ мөн адил төрлийн визийн өргөдөл өгнө. Хэрэв богино хугацааны визтэй байгаа тохиолдолд оршин суухаа бүртгэгдсэн газрынхаа харъяат цагдаагийн газар визийн өргөдлийг өгнө. Хэрэв удаан хугацааны визээр оршин сууж байгаа тохиолдолд өргөдлийг Дотоод Явдлын Яаманд өгнө. Хэрэв заасан хугацаанд байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл өгсөн тохиолдолд хүүхдийн төрсөн өдрөөс эхлэн байнга оршин сууж байгаагаар тооцно. Хэрэв хүүхэд эцэг эхтэйгээ ЧУ-ын нутаг дэвсгэрээс гарах болсон тохиолдолд түүний оршин суухыг түр хугацааныхаар тооцно.

ЧУ-ын нутаг дэвсгэрт визээр оршин сууж байгаа (ялангуяа 90 хоногоос дээш удаан хугацааны визээр) гадаадын иргэд нь ажлын шалтгаанаар эрүүл мэндийн даатгалтай ч гэсэн тэдний төрсөн хүүдүүд нь нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй.

Ийм тохиолдолд гадаадын иргэдийн тухай хуулийн 180j-р зүйлийн 5 болон 7-р догол мөрүүдэд заасан зорчигчийн эрүүл мэндийн датгалын хүрээ үйлчлэх ба үүнд комплексний эрүүл мэндийн хангамжийн болзол агуулагдсан байгаа. Энэ комплексний эрүүл мэндийн даатгал нь бас эхийн жирэмслэлттэй болон хүүхдийн төрөлттэй холбоотой хангамжийг агуулсан байх болно.

Хэрэв хүүхэд нь ямар ч даатгалгүй төрсөн тохиолдолд дараах байдлаар явагдана. Хүүхэд төрсний дараа гэрээт эрүүл мэндийн даатгал хийгдэнэ (энэ нь мэдээжийн хэрэг даатгалын гэрээг хийх эсвэл эрүүл мэндийн хангамжийг бүгдийг бэлнээр төлөх зэрэг нь эцэг эхээс шалтгаална). Энэ даатгалтай гэрээ хийвэл хүүхэд анхан шатны эрүүл мэндийн үзлэгт орох ба энэ үзлэгийн зардлыг эцэг эх төлнө. Энэ анхан шатны үзлэгийг үндэслэж хүүхдийн эрүүл мэндийн даатгалын гэрээг байгуулах даатгалын төлбөрийг тогтооно. Дараа нь даатгалын газар хүүхдэд даатгалын үнэмлэх олгоно. Хүүхдийг төрхөд байх хугацааны эрүүл мэндийн хангамжийг бэлнээр төлнө, учир нь хүүхэд анхан шатны үзлэгт орсны дараа даатгалтай гэрээ байгуулна.

13. 5. Ойр төрлийнхөний нас баралт

Нас барсныг бүртгэж нас барсны бүртгэлийн дэвтэрт харъяат нутаг дэвсгэрт нь тухайн хүн нас барсан Иргэний бүртгэл мэдээллийн газар үйлдэнэ. Нас барсныг Иргэний бүртгэл мэдээллийн газарт нас барсан хүнд үзлэг хийсэн эмч бичгээр мэдэгдэнэ, энэ бичгийг үндэслэж иргэний бүртгэл мэдээллийн ажилтан нас барагчидын дэвтэрт бүртгэж нас нөхцсөн гэрчилгээг нас барагчийн – гэр бүлийн гишүүдэд (эхнэр нөхөрт, эцэг эхэд, хүүхдүүдэд, өвөг эцэг эмэг эхэд, ач гучад), эсвэл түүний ах эгч дүү нарт нь, эсвэл итгэмжлэгдсэн төлөөний хүнд нь өгнө. Нас нөхцсөний гэрчилгээг гадаадын иргэнд, хэрэв улсын байгууллагуудад, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад түүний эрхийг зайлшгүй ашиглах шаардлагатай болсон үед олгоно.

Оршуулгыг зохион байгуулж байгаа этгээд нь нас барагчийг Чех улсаас авч явах тохиолдолд оршуулгыг өөрөө бүгдийг зохицуулна.

Дэлгэрэнгүй мэдээллийн ишлэл

- **Иргэний бүртгэлийн газрын** талаархи дэлгэрэнгүй мэдээллийг оршин сууж буй газрын тань хот суурингийн захиргаа өгнө, эсвэл энэ порталаас мэдэж болно
  - Албан газрын портал – http://portal.gov.cz (► /Životní situace/Амьдралын байдал ► /Občan/Иргэн ► /Občan a stát/Иргэн ба улс►/Osobní údajeХувийн мэдээ ► /Matriky/Иргэний бүртгэл), мөн үүнээс иргэний бүртгэлийн бичиг баримтыг яаж олгох, иргэний бүртгэлийн дэвтрийг үзэх, иргэний бүртгэлийн дэвтэрт бичигдсэн тодорхойлолт олгох зэргийг мэдэж болно.
  - Дотоод Явдлын Яамны интернет хуудас – http://www.mvcr.cz (► /Služby pro veřejnost/Нийтийн үйлчилгээ ► /Rady a službyЗөвлөлгөө ба үйлчилгээ ► /Občan na úřadě/Иргэн захиргааны байгууллагад ► /Matriky – matriční úřady/Иргэний бүртгэлийн газар)
- **Гэр бүл болох** талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хамгийн ойрхон иргэний бүртгэлийн газар өгнө, эсвэл энэ интернет хуудаснаас мэдэж болно:

- Дотоод Явдлын Яамны интернет хуудас – http://www.mvcr.cz /Rady a služby/Зөвлөлгөө ба үйлчилгээ ► /Občan na úřadě/Иргэн захиргааны байгууллагад ► /Manželství/Гэрлэлт)
- Албан газрын портал – http://portal.gov.cz (► /Životní situace/Амьдралын байдал ► Cizinec/Гадаадын иргэн ► /Manželství/Гэрлэлт эсвэл ► /Občan/Иргэн ► /Rodina/Гэр бүл ► /Manželství/Гэрлэлт), мөн үүнээс яаж гэр бүл болох, иргэний байдлаар гэр бүл болох, шашны байдлаар гэр бүл болох, гадаадын иргэнтэй гэр бүл болох зэрэг зааварчилгаануудыг мэдэж болно.

14. ЧЕХИЙН АРД ТҮМНИЙ ТУХАЙ СОНГОМОЛ МЭДЭЭЛҮҮД

Энэ бүлэг нь энэхүү нийтлэл дэх бүх хэлээр нийтлэгдсэн ба ялангуяа хөгжил соёлоороо хол зөрөлдөөнтэй нийтийнх нь амьдрал уламжлал нь мэдэгдхүйц ялгаатай гадаадын иргэдэд зориулсан. Хөгжил сёолоороо, газар нутгаараа ойр улсын иргэдэд шинэ сонин зүйл бус байж болох юм, учир нь тэдний амьдралын хэлбэр нь ЧУ-тай төстэй байна. Зарим гадаадын иргэдэд энэ нийтлэл дэх бүх хэлээр хэвлэгдсэнээс шалтгаалж энэ мэдээлэл нь илүүдэл зүйл мэт байж магадгүй.

14. 1. Ярианы болон харилцааны онцлог

Ерөнхий харьцаа нь хүмүүжилтэй, соёлтой, зөрчил маргаангүй, хүлээцтэй харьцаатай (харьцаанд оролцогчидод ярих боломжийг олгож, бодол саналыг нь сонсож, түүнийг нь зөвшөөрөхгүй тохиолдолд идэвхгүй байдлаар хүлээж авна).

Чехүүд ихэнхдээ олон нийтийн газар чанга дуугаар харьцдаггүй. Хүлээцтэй, зөөлөн, өөрийгөө авч явах чанарыг эрхэмлэдэг. Чанга дуутай харьцаа нь орчин тойрны анхаарлыг татдаг.

Харьцаанд *(найзуудтайгаа ярихаас бусад)* ***тохирожмгүй зүйлүүд:***
– зөрчил маргаантай сэдэв хөндөх;
– бусад ярианд оролцогчидыг хүндэтгэхгүй, ярианд таслах (ярианд дундуур орох);
– хэтэрхий хурдан ярих;
– үгээ буруу хэлэх;
– маш ихээр дохиж зангаж ярих;
– хэтэрхий өрөвдөлтэй байдал гаргах (хиймэл дүр эсгэх);
– бүдүүлэг үг, хараал, хошигнол хэлэх;
– хүн муулах гм..
Зохисгүй харьцаанд мөн марзганасан, гараа халаасандаа хийж ярих, амандаа бохитой (тамхитай) ярих зэргүүд багтана.

Албан ёсны ярианд албаны хэлээр ярих нь зохимжтой. Эмэгтэйчүүд адил тэгш эрхтэй харьцаатай. Гадаадын хүн ярьж (эсвэл ярихыг хичээж байгаа) байгааг нутгийн хүн дүгнэлт хийнэ.

Ерөнхий ярих ярианы санал бодлын зөрөлдөөнтэй, хэтэрхий нэг чиглэлийг баримтласан бус (жнь: улс төр, шашин шүтлэгийн талаар ярьж байгаа бол) сэдвийг сонгох нь дээр. Яригч нь олны өмнө өөрийгөө магтах, өөрийнхөө амжилтын тухай, эд хөрөнгийн талаар ярих нь зохимжгүй. Хэтэрхий сониучирхах, хувь хүний, гэр бүлийн, ажлын асуудалтай байдлын талаар бодлогогүй асуулт тавих. Үүнтэй адил байдалд зөвхөн тухайн хүн болон найз нөхдүүдийн дунд ийм асудлыг ярьж болно.

<u>Яригч нь</u>
– эмэгтэй хүнтэй ярьж байгаа үедээ насыг нь асуудаггүй,
– цалин (хөлсний) хэмжээг асуухгүй,
– эд хөрөнгийн үнэ цэнийг асуухгүй,
– нууцлаг байдалтай мэдээллүүдийг асуухгүй (регистрийн дугаар),
– болж өнгөрсөн золгүй байдлыг хөндөж ярих (нас баралт, салалт гм.).
Ярилцаж байгаа сэдвээс гарах арга нь цаг агаар,гэр бүл,хүүхдийн тухай ярих юм.

Зөвшөөрхийг толгойогоо дээш доош нь дохино, зөвшөөрөхгүй байгаагаа толгойгоо барун зүүн тийш хөдөлгөх маягаар илэрхийлнэ. Хүн рүү эсвэл ямар нэгэн юм руу хуруугаараа заах, гайхаж байгаа үедээ амаа ангайх, ярилцаж байгаа хүнийхээ ханцуйнаас татах зэрэг нь тохиромжгүй. Олон нийтийн унаанд явж байх үедээ шахалдан суух (шаардлагагүй тохиолдолд), цуг явж байхдаа наалдан явах, ярьж байх үедээ гараараа хүрэх зэрэг нь энгийн зүйл биш.

Ялангуяа энэ нь эрэгтэй хүн эмэгтэй хүнтэй харьцаж байх үед эвгүй зүйл юм. Ярилцаж байгаа хоёрын хооронд ойролцоогоор нэг метр зайг баривал зүгээр. Ярьж байхдаа ярилцаж байгаа хүнийхээ нүд рүү нь харж ярих хэрэгтэй (үргэлж ширтэж ярихгүйгээр). Нүдний хөдөлгөөнөөр буруу, зөв, тодорхой ярьж байгаа эсхийг мэдэрч болох юм.

Мэндлэх, танилцах зэрэгт гар баридаг. Харин ямар ч хамаагүй харьцаанд, танихгүй хүнтэй ямар ч зорилгогүй, танилцах/танилцуулах зорилгогүй байж гар барихгүй. Гар барих нь энгийн ажлын байдлаар уулзхад байж болно. Зөвхөн гэр бүлийн гишүүд, сайн найзууд (эсрэг хүйсний) л уулзах болон үдэлцэхдээ хацар дээр үнсэж болно.

Гар барихдаа
- *гарыг чанга богино хугацаагаар атгах;*
- *баруун гараа барилцана;*
- *гараа хирээсэлж барьцгаахгүй;*
- *эхлээд гараа эмэгтэй нь эрэгтэйдээ, удирдлага нь доод тушаалынхаа хүндээ, ахмад нь залуудаа өгнө;*
- *богино хугацаагаар нүд рүү нь харах дагалдана.*

14. 2. Өдөр тутмын дэглэм

Худалдааны хэлэлцээнд боломжтой бол цагтаа очих, тохиролцсон програм болон айлчлалд цагаа баримтлах, хэрэв ямар нэгэн өөрчлөлт гарвал цаг тухайд нь мэдэгдэх хэрэгтэй. Хэн нэгэн хүнийг 15 минутаас дээш хугацаагаар хүлээлгэх нь зохисгүй зүйл.

Өдөрт ажлын цаг нь Чехэд бусад олон Европын орнуудаас эрт эхлэдэг. Жижиг дэлгүүрүүд 7:00 цагт, том дэлгүүрүүд 8:00 цагт онгойно, ихэнх ажилчид 6:00–7:00 цагийн хооронд эхлэнэ, ерөнхий болон дунд сургуулиуд ихэнхдээ 8:00 цагт, захиргаа албан байгууллагууд 8:00–9:00 цагийн хоорнд эхлэдэг. Захиргаа албан байгууллагууд нь даваа лхагва зарим онцгой үед өөр өдрүүдэд нийтэд үйлчилдэг.

Энэ ажлын дэглэм нь өөр олон нөхцлөөс гадна Чехүүдийн өдөр тутмын дэглэм болон олон нийтийн өдрийн хоолны хувиар зэрэгт нөлөөлнө. Ихэнхдээ 11:30–13:30 цагийн хоорнд үдийн хоол, 18:00–20:00 цагийн хооронд оройн хоол иддэг, 22:00 цагаас шөнө дундын хооронд унтаж эхлэдэг.

Рестаронууд болон зоогийн газрууд оройн 10:00 цаг, шөнө дунд хүртэл онгорхой байдаг, олон бар, клубууд өшөө орой хаадаг. Театрын тоглолт концертууд 19:00–20:00 цагийн хооронд эхлэдэг.

14. 3. Чех хоол

Чехүүд хоол идэх үеэрээ тодорхой ёс заншлыг баримталдаг. Хоол идхийнхээ өмнө *сайхан хооллоорой* гэж хэлцгээнэ. Бүгд хоолны ширээнд суугаагүй тохиолдолд хоолоо эхлэж иддэггүй. Чехийн олон нийт эмэгтэй эрэгтэй нэг ширээнд сууж хооллоно.

Чехийн уламжлалт үдийн хоол шөлөөр эхлэнэ гол хоол нь ихэвчлэн мах хачиртай (бүх төрлийн мах, ихэнхдээ гахай, үхрийн мах, хонины махыг хамгийн бага хэрэглэнэ, шувууны махыг их хэрэглэж эхлэж байна, Чехийн уламжлалт хоолнуудад жнь: *гахайн жигнэсэн мах мантуу байцаатай, галуу нугасны мах мантуутай байцаатай, үхрийн гуляш мантуутай)*, дараа нь салат эсвэл компот байдаг. Үндэсний хоолонд мөн жнь: *төмсний гамбир* (төмсийг түүхийгээр нь үрүүлээр үрж тосонд шарах), *утопенци* (хиамыг сонгинотой цуг уксусанд дарах), *Оломоуцын тваружкы* (Моравын бяслаг).

<u>Доорхи зүйлүүдийг сануулхад</u>

- *Энгийн ресторанд зочин нь өөрөө сул суудал олж сууна, дээд зэрэглэлийн ресторанд үйлчлэгч олж өгнө;*
- *Чехийн хоол идэх хэрэгслэлүүд нь ихэнхдээ халбаг, сэрээ, хутга юм;*
- *сэрээг зүүн гартаа, хутга шөлний халбагыг баруун гартаа барина;*
- *зочин нь сэрээ хутгыг тавган дээр зэрэгцүүлэн тавьсан бол тавгийг авч явж болно; хоёууланг нь зөрүүлэн буюу хөндлөн тавьсан бол хоолоо дуусгаагүй үргэлжлүүлнэ гэснийг илэрхийлнэ;*
- *илүү гар дээр тавих мөнгө нь заавал үүрэгт бус харин төлбөртэй цуг байна;*
- *илүү мөнгийг ширээн дээр тавина, үйлчлэгчийн гарт өгхийн шаардлагаүй;*

14. 4. Ёс заншил уламжлал

Хамгийн дэлгэрэнгүй ёс заншилд Христос шашинтны хоёр баяр байдаг, эдгээр нь Зул сарын баяр, Улаан өндөгний баяр бөгөөд мөн уламжлалт хурим багтдаг.

Зул сарын баяр

Арван хоёр сарын 24.–26-ны хооронд (Чех улсад ажлын өдөр) Есүс Христосын төрсөн өдрийг тэмдэглэж ёслодог баяр юм. Зул сарын баяр болхоос өмнө их цэвэрлэгээ хийж, баярын амттангуудыг жигнэдэг (яг өглөгийн өдрийн өмнөх өдөр ваночка буюу баярын талхыг жигнэдэг), арван хоёр сарын 24-ний орой бэлэг өгцгөөнө, баярын чимэглэл хийнэ. Зул сарын баярын бэлэг тэмдгийн нэг нь баярын сүлд мод чимэглэх юм. Өглөгийн өдрийн уламжлалт зоог нь загасны шөл, шарсан мөрөг загас төмсний салаттай. Зул сарын баяраар олон дадал заншлыг мөрддөг. Эхнэр нөхрүүд (хосууд) борз мөчрийн доор үнсэлдэх, алим хуваах, хушга самрын ясанд лаа асааж угаалтуурт хөвүүлэх зэрэг заншлуудыг үйлддэг.

Улаан өндөгний баяр

Улаан өндөгний баяр нь Есүс Христосыг цовдлуулж нас барсан өдрийг ёслож тэмдэглэдэг ба байгаль дэлхий дахин сэргэж байгааг билэгдэж өндөг буддаг. Улаан өндөгний баярын янз бүрийн өнгөөр будаж, төрөл бүрийн аргаар чимэглэсэн өндгийг *краслицэ* гэж нэрлэнэ. Жил бүр худалдааны газруудад улаан өндөгний баярын уламжлалт чимэглэл хэрэгслүүдийг зардаг. Мазанец гэсэн нэртэй талх, улаан өндөгний баярын хонь хэлбэртэй болон бусад гурилан жигнэмэгүүдийг жигнэж, бургасны мөчир вааранд хийж цэцэглүүлнэ. Эрэгтэйчүүд хөвгүүд бургасаар „помлазкы“ сүлжиж (эсвэл худалдан авч) Улаан өндөгний баярын өглөө эмэгтэйчүүд охидуудаа „ороолгох“ маягаар ёслол үйлдэнэ. Улаан өндөгний баяраар ерөнхийдөө сүшиг бишрэлийг бага баримтладаг, Их баасан гариг ажлын өдөр байдаг.

Шинэ жил

Хуанлийн жил өөрчлөгдөж, энэ баяраар согтуруулах ундаа хэрэглэж дуу шуугиантай тэмдэглэж, ирж буй ондоо муу зуршлаа орхих зэргээр тэмдэглэдэг хамгийн дуртай баярын нэг юм.

Хурим

Хосууд гэр бүл болхоор шийдвэрлэсэн тохиолдолд сүйт эр цэцэг барин сүйт бүсгүйнхээ эцэг эхэд нь очиж **хурим** хийх зөвшөөрөл хүсдэг. Чехэд иргэний хурим *(энгийн хурим)* нь хот суурингийн газрын хуримын танхимд (бас шилтгээнд) болдог. Мөн хосууд шашны хэлбэрээр сүмд гэр бүл болж болно *(шашны хурим)*.

Шинэ гэр бүл бологчид нь хуримын урилгыг найз танил нөхдүүддээ тарааж хуримын ёслолд урина. Хуримын өдөр хуримын торт, сүйт бүсгүйд болон хоёр эхэд хуримын цэцэг захиалаж, хуриманд орлцогчид энгэртээ цэцэг хатгана. Сүйт бүсгүй ихэвчлэн цагаан өнгөтэй хуримын даашинз өмсөнө. Хосууд нь гэр бүл болгочийн өмнө хуримынхаа бөгжийг солилцож, эхэр нөхөр болсон анхны үнсэлтээ билэгдэцгээж хоёр гэрчтэйгээ цуг хуримын портоколд гарын үсэг зурна. Сүйт эмэгтэй ихэвчлэн өөрийнхөө овгийг орхиж нөхрийнхөө овгоор овоглоно. Шинэ гэр бүлийн хоёрыг хуримын ёслолын танхимаас гарч ирхэд зочид цаасан ширхэг эсвэл будаа цацна. Хуримын зочлолын газрын өмнө ирхэд сүйт эрийн өмнө сүйт эмэгтэй таваг эсвэл шилэн

аяга хагалаж, аз жаргал авчирна гэдгийг билэгддэг. Хоёуул хагархайг цэвэрлэнэ. Үдийн хоолон дээр нэг тавганд шөл хийж өгхөд хоёуул бие биедээ харилцан халбагадан өгнө. Шинэ гэр бүл бологчид хуримын билэг авч, хуримын аянд явна.

14. 5. Шашин шүтлэг

Чех улсын Захиргааны байгууллага нь **Үндсэн эрх болон эрх чөлөөний бичиг**- шашин шүтлэгийн эрхийг бататгаж байдаг (3-р, 15-р, 16-р бүлгүүд) ба энэ нь ЧУ-ын захиргааны журмын нэг хэсэг юм. Шашин шүтлэгийн холбооны тухай 3/2002 тоот хуулиар шашны асуудлыг удирдлага болгож байдаг. Энэ хууль нь шашин шүтлэгийн эрх чөлөө, шашны дотоод өөртөө засах (автономи) эрх болон шашин шүтлэгийн холбоог баримтлан сахих, улс нь шашин болон шашны холбооны тууштай эрхээ эдлэх боломжийг олгох зэрэг талаар зохиогдсон.

Шашны асуудал нь холбогдох зүйлүүдээс шалтгаалж Соёлын Яамны шашны хэлтэст хамаарагдана. Энэ хэлтэс нь улс шашин болон шашны холбооны хоорондын харьцаа, Чех улсад чөлөөт шашны ухагдхууныг хэрэгжүүлэх удаан хугацааны ойлголт ухагдхууныг болвсруулж байдаг. Шашны хэлтэс нь шашин болон шашны холбооны, шашин болон шашны холбооны нэгдэлийн бүртгэл, үндсэн бичиг баримтыг өөрчлөх, тэднийг бүртгэлээс хасах зэрэг ажлуудыг хариуцаж байдаг. Мөн шашин болон шашны холбоогоор байгуулагдсан хуулийн байгууллагын бүртгэлийг хийж шаардлагатай үед түүнийг хүчингүй болгох ажлыг гүйцэтгэнэ.

Шашны болон шашны холбооны тухай 3/2002 тоот хуулиар шашин болон шашны холбоог бүртгүүлэх санал хүсэлтээ өгч болох ба энэ нь Чех хэлээр хоёр хувь үйлдэгдсэн байх ёстой. Шашин болон шашны холбоог бүртгүүлэх саналыг хамгийн бага нь гурван хувь хүн, 18 наснаас дээш настай, хуулийн хариуцлага хүлээх чадвартай, Чех улсын иргэн эсвэл Чех улсад байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн өгөх ёстой. Шашин болон шашны холбоог бүртгүүлэх өргөдөлд шашин болон шашны холбоонд элсхийг хүссэн 300-гаас дээш Чех улсын иргэд эсвэл Чех улсад байнга оршин суугч гадаадын иргэдийн гарын үсэгтэй хуудсыг хавсрагасан байх шаардлагатай.

Чех улсад шашин болон шашны холбооны тухай 3/2002 тоот хуулиар шашны холбоо Соёлын Яаманд бүртгэлгүйгээр эрх чөлөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж болно.

Шашин болон шашны холбооны талаархи мэдээллүүдийг www.mkcr.cz (► /Oblasti ministerstva /Яамны салбарууд ► /Církve a náboženské společnosti/Шашин болон шашны холбоо).

Бүртгэгдсэн шашин болон шашны холбоо, бусад шашны байгууллагын талаархи мэдээллүүдийг энэ хуудаснаас үзэж болно http://www3.mkcr.cz/cns_internet/.

14. 6. Үндсэн соёлын байдал

➢ **Үндэсний соёлын дурсгал**

Чех улсад дэлхийн өнцөг булан бүрээс маш олон жуулчид ирж үздэг түүх дурсгалын газрууд байдаг ба арван хоёр хамгийн сонирхолтой түүх дурсгал болон түүх дурсгалын үзэсгэлэнт газрууд дэлхийн түүх соёлын UNESCO-гийн бүртгэлд бүртгэгдсэн байдаг.

Түүх соёлын дурсгалын болон музьен талаархи мэдээллийг Соёлын Яамны интернет хуудаснаас олж болно http://www.mkcr.cz.

Хамгийн чухал соёлын болон боловсролын институтэд Карлын Их Сургууль, Ардын театр, Ардын музье зэргүүд юм.

➢ **Чехийн алдарт уран бүтээлчид, зохилчид, сэтгэгчид**

Чех улсаас олон алдарт уран бүтээлчид төрөн гарсан. Ялангуяа зарим нэгэн хөгжмийн зохиолчид (жнь: **Бедрших Сметана**, **Антонин Дворшак** эсвэл **Леош Яначек**) дэлхийд нэр алдар нь түгсэн.

➢ **Түүхэн зохиолчид болон сэтгэгчид**

- Містр **Ян Хус** (ойролцоогоор 1369/1370–1415 онуудад)-нь дундад зуунд Чехийн шашин шүтлэгийн сэтгэгч, шинэчлэгч, номлолч байсан.
- **Ян Амос Коменскы нь (Comenius)** (1592–1670) дэлхийд нэрд гарсан Чехийн зохиолч сурган хүмүүжүүлэгч байсан.

➢ **Сүүлийн хоёр зуун жилийн Чехийн зохиолчид**

– **Божена Немцова** (1820–1862), феминист нийцэлтэй үргэлжилсэн үгийн зохиолын зохиолч, үндэсний уран зохиолын сэргэн мандалтыг тэргүүлэгч
– **Карел Хынек Маха** (1810–1836), шүлэгч, үргэлжилсэн үгийн зохиолч, Майгийн зохиогч, бадрангуй үзлийн болон Чехийн шинэ үеийн уран зохиолын чухал хүмүүсийн нэг
– **Карел Яромир Ербен** (1811–1870), шүлэгч, ардын аман зохиол судлаач, Кытице зохиосон, К. Х. Махатай хамт бадрангуй үзлийн зохиолын тэргүүлэгч
– **Ян Неруда** (1834–1891), сэтгүүлч, шүлэгч, Майгийн өгүүлэгч, Малостранскын өгүүллэгийн зохиолч
– **Томаш Гариг Масарык** (1850–1937), философич, түүхч, 1918 оны үеийн Чехийн түүхэн дэх чухал хүмүүсийн нэг, Чехословак улсын анхны ерөнхийлэгч
– **Ярослав Хашек** (1883–1923), үргэлжилсэн үгийн зохиолч, сэтгүүлч, Эрэлхэг цэрэг Швек хэмээгч алдарт зохиолыг бичсэн
– **Франз Кафка** (1883–1924), Австри Унгарын царын засаглалын үеийн Прагийн болон Германы зохиолчидын хүрээний зохиолч, хийсвэр болон бодит үргэлжилсэн үгийн зохиолын анхдагч
– **Карел Чапек** (1890–1938), дорно дахины энэрэнгүй үзлийн үргэлжилсэн үгийн зохиолч, сэтгүүлч, орчуулагч
– **Витезслав Незвал** (1900–1958), Чехийн яруу найраг болон сюрреализмын тэргүүлэгч, шүлэгч, үргэлжилсэн үгийн зохиолч, жүжгийн зохиолч, нийтлэлч
– **Ярослав Сейферт** (1901–1986), Чехийн ганцхан уран зохиолын Нобелийн шагналтан, яруу найргийн шүлэгч
– **Бохумил Храбал** (1914–1997), яруу найраг болон сюрреализмын нөлөө бүхий өгүүлэгч, дэлхийд нэрд гарсан олон арван үргэлжилсэн үгийн зохиолыг зохиогч
– **Арношт Лустиг** (1926), яруу найрагч, сэтгүүлч, хоёр дугаар дайны бөөнөөр нь устгасан талаархи сэдвийг судлагч
– **Милан Кундера** (1929–2011), яруу найрагч, нийтлэлч, Чехийн орчин үеийн уран зохиолыг үндэслэгчидийн нэг
– **Вацлав Хавел** (*1936), олон арван нийтлэлийн болон театрын жүжгийн зохиолч, Чехийн уран зохиолын хийсвэр жүжгийн үндэслэгч, 1989 онд ЧУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон
– **Михал Виевегх** (*1962), нэрт роман бичигч, 1989 оноос хойшхи Чехийн хамгийн шилдэг яруу найрагчийн нэг
– **Яхым Топол** (*1962), орчин үеийн үргэлжилсэн үгийн зохиолч, 70, 80 оны үеэр дотоодын Андергранд хөгжмийн стилээс нэрд гарсан

Соёлын талаархи, ялагуяа соёлын хүрээн дэх ашигт бус байгууллагуудын талаархи мэдээллүүдийг Уран бүтээлийн институт – Театрын байгууллагын интернет хуудаснаас мэдэж болно www.mezikulturnidialog.cz. Энэ портал нь хэлэлцэх зай, үзэл бодлыг нийтэд хүргэх, хэд хэдэн харилцан ажиллагааны хэсэгтэй зохион байгуулагчийн мэдээлэл болон суртчилгаа зэргийг бүрдүүлнэ. Үүнээс гадна соёл урлагийн сэдвээр ажилладаг, энэ сэдвийн төсвийг дэмждэг байгууллагуудын өргөн хүрээтэй хаягийг эндээс олж мэдэж болно. Портал нь шуурхай мэдээллүүдийг хадгалж, бүртгэгдсэн сонирхогчидод илгээж байдаг редакцын системээр тоноглогдсон.

15. ИНТЕГРАЧНЫ ТӨВҮҮД

Гадаадын иргэдийн интеграчлалыг дэмжих төв (цаашид зөвхөн Интеграчны төв эсвэл Төв)-нь Дотоод Явдлын Яамнаас удирдлагатай олон жилийн Европын фондын гуравдагч орны иргэдийг интеграчлах програмыг үндэслэн үүссэн. 2009 оноос Моравскослезский, Өмнөд Моравын, Пардубицын, Плзений, Устын, Злиний крайнуудад интеграчны төвүүд үйл ажиллагаагаа эхлэцгээсэн, 2010 онд Өмнөд Чехийн, Либерецийн, Оломоуцын, Карловарын крайнуудад байгуулагдсан. Дараагийн жилүүдэд Интеграчны төвүүд ЧУ-ын бүх бүс нутгуудад байгуулагдах төлөвлөгөөтэй байна.

Эдгээр төвүүдээс найм нь улсын байгууллагад хамрагдаж Дотоод Явдлын Яамнаас удирдагдан явагдаж байна. Өмнөд Моравын төвийн удирдлага нь Өмнөд Моравын край, Интеграчны төвийг край нь таван хамтрагчидтай хамтран ажиллуулж байна. Устын край дахь Төв нь интеграчлалын зөвлөх газрыг ажиллуулж байна.

Интеграчны төв нь ЧУ-д удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух зөвшөөрөлтэй гуравдагч орны (ЕХ-ны бус) гадаадын иргэдийг хариуцна. Интеграчны төвийн үйл ажиллагаа нь хариуцагч иргэдээ үйлчилгээгээр хангах, олонхийн болон түүний институдын үйл ажиллгаанд чиглэгдэж байна.

Төвүүд нь дурьдсан бүс нутгууд дахь гадаадын иргэдийг нийгмийн, хуулийн, хэлний гачигдлаас чөлөөлөх талаар дэмжих ажлыг санаачлагчаар, зохион байгуулагчаар, хэрэгжүүлэгчээр байх ёстой. Интеграчны төвүүдийн үйл ажиллагаа нь бүс нутгийн болон орон нутгийн байгууллага болон институдтэй, мөн бусад субьектүүдтэй, төрийн бус ашигт бус байгууллагуудтай шууд хамтран явагдаж байна.

Төвүүдийн гол үйл ажиллагаанд:

1. Интеграчны төвүүдийн үйлчлүүлэгчидэд хангах үйлчилгээ

- **Зөвлөлгөө болон мэдээллийн үйл ажиллагаа**
  - оршин суух талаархи шаардлагууд, нийгмийн тэтгэмж, нийгмийн тусламж, эрүүл мэндийн хангамж, эрүүл мэндийн даатгал, байрлах, хөдөлмөрийн бирж, сургууль боловсрол, амьдралын асуудлыг шийдвэрлэх, хүүхэд төрөх, хурим, ойр төрлийн хүмүүсийн нас баралт зэргүүдийн талаар мэдээллээр хангана.
  - шаардлагатай үед гадаадын иргэдийг холбогдох байгууллага болон захиргааны газартай зуучилж туслах.
- **Хуулийн зөвлөлгөөгөөр хангах:**
  - Төв бүрд тодорхой цагт хуулийн зөвлөлгөөгөөр хангаж байдаг хуульчид ажиллаж байдаг
  - ялангуяа ажиллах-хуулийн харьцаатй оршин суух болон визийн талаар зөвлөлгөөгөөр хангана
- **Гадаадын иргэдэд зориулсан Чех хэлний курс:**
  - ерөнхий курс нь – маш бага Чех хэлний мэдлэгтэй үйлчлүүлэгчидэд зориулсан, үйлчлүүлэгчид урьдчилан бүртгүүлэх шаардлагагүй
  - эрчимт – Чех хэлний давуу мэдлэгтэй үйлчлүүлэгчидэд зориулсан, үйлчлүүлэгчид нь курст тогтмол суралцана

  Курс нь Чех хэлний суурь мэдлэгийг олгохоос гадна, байнга оршин суух зөвшөөрлийн шалгалтанд (А1 түвшингийн) бэлтгэх мэдлэгийг олгоно. Курс нь ганц бие хүмүүс болон хүүхэдтэй эхчүүдийг сургах ба сургалтын үеэр хүүхэд харах асуудлыг шийдвэрлэнэ.
- **Нийгэм соёлын курс**
  - энэ курс нь Чех улстай танилцах, ялангуяа нийгмийн, эрүүл мэндийн, боловсролын системийн талаархи мэдлэгийг эзэмших зориулалттай
  - амархан жишээ татаж өдөр тутмын амьдралтай яаж харьцах жнь: нутгийн хүмүүстэй яаж харьцах, яаж юм худалдаж авах, ресторан зоогийн газар яаж хоол захиалах зэргийг суралцана.
  - ажиллуулагчтай болон албан газартай харьцах, Чех улсын түүх, уламжлал, баяр ёслолын талаар илүү дэлгэрэнгүйгээр мэдэх мэдлэгийг эзэмшүүлэх зорилготой

➢ **Тогтмол ажиглалтын байдал**

– тооны өөрчлөлт, байр суурь, үндэстэн ястны бүрдэл зэрэгт ажиглалт хийх.

2. Олонхийн хэсэг,түүний институдыг чиглэсэн Интеграчны төвийн ажиллагаа

➢ **Мөрийн хөтөлбөрийн тогтмол танилцуулгыг хэрэгжүүлэх**

– бүс нутгийн мөрийн хөтөлбөрийн тогтмол уулзлалтыг крайн Интеграчны төв нь өөрөө зохион байгуулах эсвэл түүнд оролцдог. Уулзлалтын утга нь бүс нутгийн интеграчны оролцогчидыг холбох, интеграчны процесийн саад тотгорыг тодорхойлох, оролцогч тус бүрийн амьдралд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үеэрх үүрэг ролийг богино болон урт хугацаагаар батлаж, нарийн тогтоох зэрэг юм.

➢ **Гэгээрэл, соёлын болон нийтийн арга хэмжээний хэрэгжүүлэлт**

– край тус бүрд олонхи үндэстний төлөөлөгчид Интеграчны төвөөр дамжуулан хэрэгжүүлнэ. Интеграчны төв нь нийтийн болон спортын арга хэмжээ болон гэгээрлийн үйл ажиллагаа, ялангуяа сургуульд болон нийтийн институдэд зохион байгуулж эсвэл дэмжиж байдаг.

Интеграчны төвүүдийн болон тэдний үйл ажиллагааны талаархи мэдээллүүдийг www.integracnicentra.cz. энэ интернет хуудаснаас мэдэж болно.

15. 1. Интеграчны төвүүдийн контактууд

➢ **Цагаачлалын газраас үйл ажиллагааг нь хэрэгжүүлдэг Интеграчны төвүүд:**

Цагийн хуваарь *(бүгд цагаачлалын газруудад адил)*

Даваа	12:00–19:00
Мягмар	– нийтэд ажиллахгүй
Лхагва	12:00–19:00
Пүрэв	8:00–12:00
Баасан	8:00–12:00

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – ПАРДУБИЦЫН КРАЙ
Boženy Němcové 2625, 530 02 Pardubice
Магистр Ивона Бакликова
төвийн дарга
Гар утас: +420 725 148 519
Утас: +420 466 736 124
Утас/факс: +420 466 952 066
э-майл: icpardubice@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – ПЛЗЕНИЙН КРАЙ
Americká 3 (2. patro), 301 00 Plzeň
Магистр Зузана Сермешова
төвийн дарга
Гар утас: +420 725 874 976
Утас: +420 377 223 157
Факс: +420 377 224 430
э-майл: icplzen@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – ЗЛИНИЙ КРАЙ
Lorencova 3791, 760 01 Zlín
Бакалавр Бернард Шулак
төвийн дарга
Гар утас: +420 725 148 515
Утас: +420 577 018 651
Факс: +420 577 018 062
э-майл: iczlin@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – МАРОВСКОСЛЕЗСКИЙН КРАЙ
Českobratrská 2227/7, 702 00 Ostrava
Бакалавр Камил Вывода
төвийн дарга
ICQ: (600-235-100)
Skype: (cpic_ostrava)
Гар утас: +420 607 860 812
Утас: +420 596 112 626
Факс: +420 596 112 124
э-майл: icostrava@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – ӨМНӨД ЧЕХИЙН КРАЙ
Kněžskodvorská 2296 (Чех даатгал банкны хойд хэсэг, Прагийн гудамжийн дагуу, 1-р давхарт)
370 04 České Budějovice
Магистр Маркета Ийндрова
төвийн дарга
Утас: +420 387 202 508
Факс: +420 387 735 285
э-майл: icceskebudejovice@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – КАРЛОВАРЫН КРАЙ
Závody Míru 876/3a (1-р давхарт), 360 17 Karlovy Vary
Павлина Ханкова
төвийн дарга
Утас: +420 353 892 559
Факс: +420 353 892 560
э-майл: ickarlovyvary@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – ЛИБЕРЕЦИЙН КРАЙ
Hanychovská 622 (хуучин талхны үйлдвэр, 1-р давхар), 460 10 Liberec
Петра Совода
төвийн дарга
Утас: +420 482 313 064
Факс: +420 482 313 825
э-майл: icliberec@suz.cz
www.integracnicentra.cz

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – ОЛОМОУЦЫН КРАЙ
Tř. Kosmonautů 1085/6, 779 00 Olomouc
Магистр Ян Мохтяк
төвийн дарга
Утас: +420 585 204 686
Факс: +420 585 242 383
э-майл: icolomouc@suz.cz
www.integracnicentra.cz

➢ **Өмнөд Моравын крайгаар хэрэгжүүлэгдэж байгаа Интеграчны төв:**

ӨМНӨД МОРАВЫН бүс нутгийн гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв
Mezírka 1 (3-р давхар), 602 00 Brno
Бакалавр Вероника Колларова, DiS.
төвийн дарга
Утас: +420 533 433 540
э-майл: cizincijmk@centrum.cz
http://www.cizincijmk.cz/
Цагийн хуваарь
Даваа–пүрэв 9:00–20:30
Баасан 9:00–17:00

➢ **Интеграчлалын зөвлөлгөө өгөх газраар хэрэгжүүлэгдэж буй Интеграчны төв:**

Гадаадын иргэдийн интеграчлалд туслах төв – УСТЫН КРАЙ
Velká Hradební 33 (Ардын байшин дотор), 400 21 Ústí nad Labem
Ян Кубичек
төвийн дарга
Утас: +420 475 216 536
э-майл: usti@centrumcizincu.cz
www.centrumcizincu.cz
Цагийн хуваарь
Даваа 9:00–18:30
Мягмар 9:00–17:00
Лхагва 9:00–18:30
Пүрэв 9:00–17:00
Баасан 9:00–15:00

16. гадаадын иргэдийн интеграчлалын хүрээнд ажиллаж байгаа төрийн бус ашигт бус байгууллагуудтай (тбаб) харьцах контактууд

ГАДААДЫН ИРГЭДЭД ЗӨВЛӨЛГӨӨГӨӨР ХАНГАХ ТБАБ

Анхааруулга: Зарим нэгэн зөвлөлгөө өгөх газрууд өдөр бүр зөвлөлгөө өгөхгүй. Утсаар болон Э-майлаар урьдчилан захиалах хэрэгтэй. ҮНЭГҮЙ зөвлөлөгөө өгнө.

НИЙСЛЭЛ ХОТ ПРАГ + ТӨВ ЧЕХИЙН КРАЙ

Arcidiecézní charita Praha – Středisko migrace

Дүрвэгсэд, цагаачлагчидад зөвлөлгөө өгөх газар

Прагад зөвлөлгөө өгхөөс гадна бас Төв Чехээр явуулын үйлчилгээ ажиллуулж байгаа, ялангуяа Млада Болеслав, Пршибрам,Мелник, Подебрад зэрэг хотуудад.

Pernerova 20, 186 00 Praha 8

даваа, пүрэв 10:00–16:00 эсвэл

утсаар захиална

Утас: 224 813 418

Гар утас: 737 282 803, 605 268 444

э-майл:uprchlici@charita-adopce.cz

вэб: www.charita-adopce.cz

Komunitní Centrum InBáze Berkat

Legerova 50, 120 00 Praha 2

Утас: 739 037 353, 224 941 415

э-майл: info@inbaze.cz

вэб: www.inbaze.cz

Гадаадын иргэдийн интеграчлалын төв (ГИИТ)

Праг: Kubelíkova 55, 130 00 Praha 3

Утас: 222 713 332, 222 360 452

Колин: Zahradní 46

Утас: 312 310 322

ГИИТ-нь бүх ЧУ-ын өнцөг булан бүрээс ирэгсэдэд зөвлөлгөө өгнө, нийгмийн талаархи зөвлөлгөөг Прагад ТИИТ-ийн конторт өгнө, Колинд мөн тодорхой цагуудад Кутна Хорад, Млада Болеславд эсвэл (жнь: байрлаж байгаа газар, байгууллага дээр).

Явуулын үйлчилгээ нь Моравкослезскийн, Оломоуцын, Злиний, Өмнөд Моравын крайнуудад үйлчлэхгүй

э-майл: info@cicpraha.org

вэб: www.cicpraha.org

Diakonie Českobratrské církve evangelické

Středisko celostátních programů a služeb

